

ХИМИЙН ХОРТ БОЛОН АЮУЛТАЙ БОДИС

Гарын авлага

Улаанбаатар хот 2010 он

Олон улсын химийн бодисын менежментийн стратеги (SAICM)-ийн санхүүжилтээр хэвлэв.

Химийн хорт болон аюултай бодисын бодлого зохицуулалтын асуудал эрхэлсэн Үндэсний зөвлөл,

Байгаль орчин, аялал жуулчлалын яам

Эмхтгэсэн: Л.Жаргалсайхан
Б.Алтангадас

Хаяг:
14201. Улаанбаатар хот
Чингэлтэй дүүрэг
Нэгдсэн үндэстний гудамж 5/2
Засгийн газрын 2 дугаар байр
Тел/Факс: 976-51-266528
е-майл: altangadas@mne.gov.mn
Цахим хуудас: www.mne.mn/chemical

Гарчиг

I. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

Монгол Улсын Үндсэн Хууль	9
Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын Үзэл баримтлал	9
Байгаль орчныг хамгаалах тухай хууль	12
Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль	43
Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай	53
Эрүүгийн хууль	55

II. ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ, КОНВЕНЦИ

Удаан задардаг органик бохирдуулагчдийн тухай Стокгольмын конвенц	57
---	----

Зарим аюултай химийн бодис болон пестицидийг олон улсын хэмжээнд худалдаалахад хэрэглэх урьдчилан мэдээлж, зөвшилцөх журмын тухай Роттердамын конвенци	102
--	-----

Аюултай хог хаягдлыг хил дамжуулан тээвэрлэх, зайлуулахад хяналт тавих тухай Базелийн конвенц	129
---	-----

Озоны үе давхаргыг задалдаг бодисын тухай Монреалын протокол	167
--	-----

III. ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

“Удаан задардаг органик бохирдуулагчдийн тухай” Үндэсний хөтөлбөр	203
---	-----

Озоны үе давхаргыг хамгаалах Үндэсний хөтөлбөр	218
--	-----

**IV. ХИМИЙН ХОРТ БОЛОН АЮУЛТАЙ БОДИСЫН БОДЛОГО
ЗОХИЦУУЛАЛТЫН АСУУДАЛ ЭРХЭЛСЭН
ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ**

Химийн хорт болон аюултай бодисын бодлого, зохицуулалтын асуудлаар мэргэжлийн санал, дүгнэлт гаргах зөвлөлийн бүрэлдэхүүн	225
---	-----

Химийн хорт болон аюултай бодисын бодлого, зохицуулалтын асуудлаар мэргэжлийн санал, дүгнэлт гаргах Үндэсний зөвлөлийн дүрэм	226
--	-----

V. ЖУРАМ

Химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх болон үйлдвэрлэх, худалдах журам 231

Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам 237

Пестицид, химийн бордоо, ахуйн хортон шавж, мэрэгч устгалын болон ариутгал, халдваргүйтгэлийн бодисыг турших, ашиглах журам 252

Озон задалдаг бодисыг импортлох, ашиглах зөвшөөрөл олгох журам 257

VI. АНГИЛАЛ, ЖАГСААЛТ

Монгол улсад ашиглахыг хориглосон химийн хорт болон аюултай бодисын жагсаалт 260

Монгол улсад ашиглахыг хязгаарласан химийн хорт болон аюултай бодисын жагсаалт 271

Химийн аюултай бодисын ангилал 274

Химийн хорт болон аюултай бодисын ангиллыг ашиглах аргачлал 276

Химийн хорт болон аюултай бодисын ангиллын жагсаалт 298

VII. ХОР, АЮУЛЫН ЛАВЛАХ МЭДЭЭЛЭЛ

Давсны хүчил 361

Хүхрийн хүчил 363

Азотын хүчил 370

Натрийн гидроксид 377

Мөнгөн ус 382

Натрийн цианид 387

Аммиак 394

ӨМНӨХ ҮГ

Орчин үеийн нийгэм, эдийн засгийн хөгжилд химийн бодисын үүрэг их боловч зөв харьцаж, зохистойгоор хэрэглээгүйгээс үүсэх аюул, учрах хохирол нь түүнээс дутахгүй их билээ.

Олон улсын болон дотоодын түвшинд химийн бодисын зохистой менежментийг бий болгож, хамтран ажиллах нь тогтвортой хөгжлийг хангах, хүний эрүүл мэнд, байгаль орчныг химийн бодисын бохирдол, хор аюулаас хамгаалахад чухал үүрэгтэй гэдгийг дэлхийн улс орнууд хүлээн зөвшөөрч, хэд хэдэн гэрээ, конвенц, тунхаг бичгийг гарган, хэрэгжүүлэхээр хамтран ажиллаж байна.

Монгол Улсын Үндсэн хуулиар иргэн хүн “Эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй” гэсэн заалт сүүлийн үед үйлдвэржилт, уул уурхайн салбарын хөгжил, хүн амын төвлөрөл, хотжилттой холбоотойгоор зөрчигдөх тохиолдлууд нэлээд гарах боллоо.

Байгаль орчны багц хуулийн өөрчлөлтийн хүрээнд “Химийн хорт бодисоос хамгаалах тухай” хуулийн шинэчилсэн найруулага болох “Химийн хортой ба аюултай бодисын тухай хууль”-ийг Монгол Улсын Их хурал 2006 онд батласан ба уг хуулийг хэрэгжүүлэх чиглэлээр холбогдох яам, агентлагууд тодорхой ажлуудыг хийж байна.

Химийн бодистой холбоотой үйл ажиллагааг зохицуулдаг журам, ангилал, жагсаалтуудыг олон улсад тавигдаж буй шаардлагад нийцүүлэн шинэчлэн боловсруулж, мөрдүүлж эхлээд байна.

Химийн бодист тавигдах хяналтыг сайжруулах зорилгоор химийн бодис нэвтрүүлэх боомтын тоог цөөлж, зөвшөөрлийн системийг өөрчлөн, химийн бодистой холбоотой үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж болон тэдгээрийн ашигладаг бодисын бүртгэл мэдээлэл бий болсноор түүнд тавигдах шаардлага өндөрсөж, хяналт сайжирч байгаа боловч хууль бус хэрэглээ, импортыг бүр мөсөн таслан зогсоож чадахгүй байна.

Мөн олон нийтэд хандсан химийн бодисын талаархи мэдээлэл хангалтгүй, химийн бодистой харьцаж ажилладаг хүмүүсийн түүнтэй харьцах, өөрийгөө хамгаалах мэдлэг хангалтгүй байгаагаас хүний эрүүл мэнд хохирох, байгаль орчин бохирдох тохиолдлууд гарсаар байгаа юм.

Иймээс химийн бодистой холбоотой үйл ажиллагаанд хяналт тавьдаг эрх бүхий байгууллагын ажилтнууд болон аж ахуйн нэгж, байгууллага, олон нийтэд системтэй мэдээлэл өгөх, сурталчлан таниулах

зорилгоор www.mne.mn/chemical цахим хуудсыг нээж, энэхүү гарын авлагыг хэвлэн гаргалаа.

Та бүхнийг эдгээр хууль эрхзүйн баримт бичгүүдийг амьдрал практикт нийцүүлэн боловсронгуй болгоход цаашид бидэнтэй хамтран ажиллаж, санал бодлоо хуваалцана гэдэгт итгэж байна.

Монгол эх орны маань агаар нь цэнгэг, ус нь ариун, хөрс нь цэвэр, ард иргэд нь эрүүл саруул байх болтугай.

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД БӨГӨӨД
ХИМИЙН ХОРТ БОЛОН АЮУЛТАЙ БОДИСЫН БОДЛОГО
ЗОХИЦУУЛАЛТЫН АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ҮНДЭСНИЙ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Л.ГАНСҮХ



I. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ

(хэсэгчлэн авав)
ХОЁРДУГААР БҮЛЭГ
ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨ
Арван зургадугаар зүйл

Монгол улсын иргэн дараахь үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ:

2/ эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй;

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

(Монгол Улсын Их Хурлын 1994 оны 56 дугаар тогтоол)
(хэсэгчлэн авав)

Х. ЭКОЛОГИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

52. Экологийн аюулгүй байдал гэж байгаль, цаг уурын өөрчлөлт болон байгалийн нөөцийг зохистой ашиглах, хамгаалах бодлогын харьцаа алдагдсанаас хүний амьдрах орчин, эдийн засагт үүсэх сөрөг нөлөөллөөс сэргийлэх нөхцөл хангагдсан байдлыг хэлнэ.

53. Экологийн аюулгүй байдлыг хангахад сөрөг нөлөөлж болох гадаад хүчин зүйлүүд:

1/дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийн улмаас цөлжилт эрчимжих, хур тунадасны хэмжээ, хуваарилалт өөрчлөгдөх, ган, зудтай жилийн тоо нэмэгдэх, озоны давхарга нимгэрэх;

2/хил дамжин агаар, усаар орж ирэх цацраг идэвхжил, химийн бохирдол, хүчиллэг бороо ихсэх, хүн амьтныг олноор хөнөөх өвчин тахал гарах, ой мод, бэлчээр, ургамлыг устгах хортон мэрэгчид, хорхой шавьж олшрох;

3/мансууруулах болон хүний оюун ухаан, эрүүл мэндэд хортойгоор нөлөөлөх бодисын түүхий эд бэлдэх түшиц газар болон хувирах.

54. Экологийн аюулгүй байдлыг хангахад сөрөг нөлөөлж болох дотоод хүчин зүйлүүд:

1/экологийн тэнцвэрт тогтолцоо алдагдах, хөрсний элэгдэл эвдрэл ихсэх, ургамал, амьтны удмын сан хомсдох;

2/ургамлын нөмрөг ядуурч ойн нөөц хомсдон мөрөн, гол нуур, газрын доорхи ус татарч ширгэх, нутаг бэлчээр гандан хуурайших;

3/байгалийн нөөц баялгийг сорчлох, цөлмөх байдлаар ашиглах;

4/хаягдал ихтэй техник, технологи хуримтлагдах хортой хог хаягдал гаргадаг үйлдвэрлэл бөөгнөрөх, гадаад орны хортой хог хаягдал булшлах газар болох.

55. Экологийн аюулгүй байдлыг хангах арга зам:

1/байгаль орчноо хайрлан хамгаалдаг ардын уламжлал, ёс заншлыг сэргээж бүх нийтэд түгээн төлөвшүүлэх ажлыг төрийн бодлогын хэмжээнд тавих;

2/байгалийн нөхөн сэргээгдэх нөөцийн хүрээнд амьдралын хэрэгцээг бүрэн хангах, үл нөхөгдөх буюу удаан сэргэдэг нөөцийг зөвхөн улс орны хөгжлийн ашиг сонирхлын үүднээс нэмэлт хүчин зүйл болгож ашиглах зарчим баримтлах;

3/эдийн засгаа экологийн баримжаатайгаар хөгжүүлж ЭКОМАРК бүхий бүтээгдэхүүнээр дэлхийн зах зээлд тодорхой байр суурь эзлэх бодлого баримтлах;

4/газар нутгийн зарим шаардлагатай хэсгийг дархлан хамгаалж, бусдыг нь экологийн тэнцвэрийг барих бодлого, хөшүүрэгтэйгээр аж ахуйн эргэлтэд аажмаар оруулах;

5/газрыг чөлөөтэй эзэмших хэлбэрээр эзэнгүүдүүлэх буюу хүн бүрд хувь оноох хэлбэрээр тасдан хуваахаас зайлсхийх, бэлчээрийг эргэж буцалтгүй талхагдалд оруулахаас сэргийлэх;

6/эдийн засгийн дэд бүтэц, байгалийн нөөцийн иж бүрдлийг багтаасан байгаль орчны тэнцвэрийг хангахуйц цогцолбор бүрдүүлэх зорилгоор засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн өнөөгийн хуваарилалтыг цаашид задалж жижигрүүлэхгүйгээр экологи-эдийн засгийн бүс бий болгох чиглэл баримтлах;

7/хот, суурин газрыг төлөвлөх, байгуулахдаа хүн амыг хэт бөөгнөрүүлж тухайн бүс нутагт байгаль орчин тэнцвэр алдагдах голомт болохоос зайлсхийх;

8/элс тогтоох, ус шингээн хадгалах бутлаг ургамлыг түлшинд хэрэглэхийг хязгаарлаж, модон материалын хэрэгцээг хангахад хөрш зэргэлдээ орнуудын боломжийг ашиглах бодлого баримтлах.Ой модыг

нөхөн сэргээх, гал түймрийн аюулаас сэргийлэх, булаг, шанд, гол горхийн эхийг ойжуулах, тариалангийн талбайд хамгаалалтын ойн зурвас байгуулах зэрэг цогцолбор арга хэмжээг үндэсний стратегийн зорилт болгон хэрэгжүүлэх;

9/доройтсон орчныг ургамалжуулах, ургамлын нөмрөгийн хэмжээг жилээс жилд нэмэгдүүлэх;

10/үндэсний “Улаан ном”-ыг байнга сэргээн баяжуулж дэлхийд ховордсон болон Монгол орны ховор ховордсон үлдэц, устгах аюулд орсон буюу орж болзошгүй бичил биетний удмын санг хамгаалах цэгцтэй бодлого явуулах;

11/эмийн болон хүнсний түүнчлэн техникийн үнэт ургамлыг нутагшуулах, тарималжуулах замаар үйлдвэрлэлийн хэмжээнд ашиглах, монголын унаган болон ховордсон, аж ахуйн чухал ач холбогдол бүхий амьтан, ургамлын гаралтай олзворын зүйлийг эдийн засгийн ашиг сонирхлын үүднээс гадаадад гаргахыг хязгаарлах;

12/Монгол Улсын тус улсын нутаг дэвсгэрт байгаа нуур мөрөн гол, уст цэгүүд, усны нийт нөөц төр, ард түмний хамгаалалтад байж, усны нөөцийг хэмнэлттэй зарцуулах, хуримтлуулах, хур тунадасны ус хураах сан байгуулах, ахуйн болон үйлдвэрлэлийн хэрэглээний цэвэр усны нөөц чанарын хяналтын тогтолцоо бүрдүүлэх;

13/Монгол Улсын нутаг дэвсгэрт болон түүний хилийн ойролцоо газарт цөмийн зэвсэг турших, байрлуулахын эсрэг идэвхтэй үйл ажиллагааг оновчтой арга хэлбэрээр явуулах;

14/байгаль орчинд халтай нөлөө бүхий аж ахуй эрхлэх явдлыг эрх зүйн болон эдийн засгийн хөшүүргээр хязгаарлах чиглэл баримтлах;

15/озоныг саармагжуулах үйлчилгээ бүхий хий гаргадаг үйлдвэрлэл явуулахгүй байх, ийм төрлийн бүтээгдэхүүнийг хязгаарлах;

16/байгалийн гамшиг, гэнэтийн аюулаас сэргийлэх, тэмцэх тогтолцоо бий болгох;

17/хуурай буюу цөлжсөн бүс нутагт хүн ардынхаа амьдралыг хангах үндэсний уламжлалт технологийг судалж, уур амьсгалын болзошгүй өөрчлөлтийн аливаа тохиолдолд үндэснийхээ амьдрах чадварыг хангах бэлтгэлтэй байх;

18/Монгол орны амьд биетний бүрдлийн өвөрмөц голомт, шимт мандлын зангилгаа цэгүүдийг дархан газрын сүлжээнд бүрэн хамруулахын хамт тэдгээрийн заримыг нь олон улсын статустай болгож дэлхийн соёлын өвд багтаах арга хэмжээ авах;

19/Монгол Улсын нутаг дэвсгэрийг олон улсын хамгаалалттай экологийн бүс нутагт хамруулах бодлого явуулах;

20/байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх асуудлаар олон улсын гэрээ, хэлэлцээр байгуулах, олон улсын байгууллагууд хандивлагч орнуудтай хамтран экологийн чиглэлийн төслүүд хэрэгжүүлэх замаар тэргүүний технологи оруулах, болзошгүй аливаа аюулаас урьдчилан сэргийлж ямар ч нөхцөлд хохирол багатай даван туулах тогтолцоо бий болгох.

БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬ

1995 оны 3 дугаар сарын 30-ны өдөр

Улаанбаатар хот

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, нийгэм, эдийн засгийн хөгжлийг байгаль орчны тэнцэлтэй уялдуулах, өнөө болон ирээдүйн үеийнхний ашиг сонирхлын үүднээс байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, жам ёсны боломжтойг нь нөхөн сэргээхтэй холбогдож төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж

1. Байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөзаасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Хуулиар хамгаалах объект, түүнтэй холбогдсон нэр томъёо

1. Энэ хуулиар байгалийн дор дурдсан объектыг байгаль орчинд хортой нөлөөлж болзошгүй үйл ажиллагаанаас хамгаалж, байгаль орчны тэнцэл алдагдахаас сэргийлнэ:

- 1/ газар, түүний хөрс;
- 2/ газрын хэвлий, түүний баялаг;
- 3/ ус;
- 4/ ургамал;
- 5/ амьтан
- 6/ агаар.

2. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

1/ “байгаль орчин” гэдэгт хүний амьдрал, үйл ажиллагаанд шууд болон шууд бусаар нөлөөлдөг.

Монгол Улсын нутаг дэвсгэрийн чулуун мандал, усан мандал, шим мандал, агаар мандлын харилцан шүтэлцээт хүрээлэл хамаарна;

2/ “ус” гэдэгт Монгол Улсын нутаг дэвсгэр дэх мөрөн, гол, горхи, булаг, шанд, рашаан, мөнх цас, мөс, мөсөн гол, байгалийн болон хиймэл нуур, цөөрөм зэрэг газрын гадаргын болон газрын доорхи ус хамаарна;

3/ “ургамал” гэдэгт Монгол Улсын нутаг дэвсгэрт ургадаг байгалийн болон таримал ой, мод, бүх төрлийн дээд, доод ургамал хамаарна;

4/ “амьтан” гэдэгт Монгол Улсын нутаг дэвсгэрт байнга буюу түр нутагшсан хөхтөн, шувуу, мөлхөгч, хоёр нутагтан, загас, хавч хэлбэртэн, шавьж, зөөлөн биетэн, эгэл биетэн хамаарна;

5/ “агаар” гэдэгт Монгол Улсын нутаг дэвсгэрийн хийн бүрхэвч хамаарна;

6/ “байгаль орчинд хортой нөлөөлөх” гэдэгт байгаль орчин, түүний баялгийг бохирдуулах, муутгах, гэмтээх, сүйтгэх, сөнөөж мөхөөх үйлдэл / эс үйлдэхүй/ хамаарна.

7/ “байгаль орчныг хамгаалах” гэдэгт байгаль орчныг бохирдохоос урьдчилан сэргийлэх, байгалийн баялгийг жам ёсоороо нөхөн сэргэх боломжийг нь алдагдуулахгүйгээр, байгалийн даацад нь тохируулан зохистой ашиглах, нөхөн сэргээх, тэдгээрт хяналт тавих ажиллагаа хамаарна;

8/ “байгаль орчныг хамгаалах иргэдийн нөхөрлөл” гэдэгт /цаашид “нөхөрлөл” гэх/ иргэд тухайн нутаг дэвсгэртээ байгаа байгалийн тодорхой төрлийн баялгийг хамгаалах, гэрээгээр зохистой ашиглах, эзэмших зорилгоор Иргэний хуулийн 481.1-д заасны дагуу зохион байгуулагдаж, энэ хуульд зааснаар гэрээ байгуулан үйл ажиллагаа явуулж байгаа иргэдийн сайн дурын байгууллага хамаарна;

9/ “байгаль орчны мэдээллийн сан” /цаашид “мэдээллийн сан” гэх/ гэж байгаль орчны өгөгдөл, мэдээллийг бүрдүүлэх, цуглуулах, дамжуулах, боловсруулах, ашиглах, хадгалах, баяжуулах, өөрчлөх, шинэчлэх, хамгаалах зэрэг үйл ажиллагааг хангах мэдээллийн технологийн иж бүрдлийг;

10/ “мета мэдээлэл” гэж мэдээний эх сурвалж, хариуцах этгээд, формат, масштаб, чанар, хамрах хүрээ, хугацаа, ашиглалт зэрэг

өгөгдлийн талаархи мэдээллийн багцыг.

3. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан объект, тэдгээрийн баялгийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбогдсон харилцааг тусгай хуулиар зохицуулна.

4 дүгээр зүйл. Байгаль орчныг хамгаалах талаархи иргэний эрх, үүрэг

1. Иргэн байгаль орчныг хамгаалах талаар дараахь эрхийг эдэлнэ:

1/ гэм буруутай этгээд байгаль орчинд хортой нөлөөлснөөс эрүүл мэнд, эд хөрөнгөндөө учирсан хохирлыг түүгээр нөхөн төлүүлэхээр нэхэмжлэх;

2/ байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийн зөрчилтэй тэмцэх болон байгаль орчинд хортой нөлөөлсөн этгээдэд хариуцлага хүлээлгэхийг шаардах;

3/ байгаль орчныг хамгаалах олон нийтийн байгууллага байгуулах, хөрөнгийн сан үүсгэх нутгийн иргэд сайн дурын үндсэн дээр нэгдэж байгалийн баялгийг арчлан хамгаалах, нөхөн сэргээх, түүний ашиг шимийг хүртэх;

4/ холбогдох байгууллагаас байгаль орчны тухай үнэн, зөв мэдээлэл авах;

5/ байгаль орчинд хортой нөлөөлөх аливаа үйл ажиллагааг хязгаарлах, таслан зогсоох шийдвэр гаргахыг болон байгаль орчинд хортой нөлөөлж болзошгүй аж ахуйн нэгж, байгууллагыг шинээр байгуулах зөвшөөрөл олгохгүй байхыг холбогдох эрх бүхий байгууллагаас шаардах;

6/ сайн дурын үндсэн дээр зохион байгуулалтад орж, энэ хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 8 дахь заалтад заасан нөхөрлөл байгуулах замаар оршин суугаа нутгийнхаа байгалийн тодорхой төрлийн баялгийг хамгаалах, холбогдох хууль тогтоомжийн дагуу гэрээгээр ашиглах, эзэмших.

2. Иргэн байгаль орчныг хамгаалах талаар дараахь үүрэг хүлээнэ:

1/ байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийг сахин биелүүлэх;

2/ байгаль орчныг хамгаалах үндэсний уламжлал, зан заншил эзэмшиж хэрэглэх, үр хүүхэддээ экологийн хүмүүжил олгох;

3/ байгаль орчинд хортой нөлөөлөхөөс сэргийлэх, өөрийн буруугаас учруулсан хортой нөлөөлөл, түүний хохирлыг арилгах буюу нөхөн төлөх.

4/ байгалийн баялгийг хууль бусаар ашигласан, гэмтээсэн,

хөнөөж сүйтгэсэн үйлдлийг олж мэдсэн иргэн тэр тухайгаа тухайн орон нутгийн Засаг дарга, улсын байцаагч, байгаль хамгаалагчид нэн даруй мэдэгдэх.

5 дугаар зүйл. Байгаль орчныг хамгаалах талаархи төрийн чиг үүрэг, зарчим

1. Төр нь хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах зорилгоор байгаль орчинд хортой нөлөөлөхөөс болон байгаль орчны тэнцэл алдагдахаас сэргийлэн хамгаалах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

2. Төр нь байгаль орчныг хамгаалах чиг үүргээ хэрэгжүүлэхдээ дараахь зарчим баримтална:

1/ хүний амьдрах, хөдөлмөрлөх, амрах байгаль орчны тааламжтай нөхцөл бүрдүүлэх ;

2/ экологийн баримжаатай эдийн засгийг хөгжүүлж байгаль орчны тэнцлийг хангах;

3/ байгалийн баялгийг шинжлэх ухааны үндэслэлтэй зохистой ашиглах нөхцөлийг хангах;

4/ байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг ашиглах шийдвэр, үйл ажиллагаа ил тод байх.

6 дугаар зүйл. Байгалийн баялгийг өмчлөх

1. Газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байх бөгөөд Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн өмч мөн.

2. Хуульд өөрөөр заагаагүй бол Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, гадаадын иргэн, хуулийн этгээд байгалийн баялгийг зохих төлбөр, хураамжийг төлж, гэрээ, тусгай зөвшөөрөл буюу эрхийн бичгийн дагуу ашиглаж болно.

3. Хууль, гэрээнд заасан журмын дагуу иргэн өмчийн болон эзэмшлийн, аж ахуйн нэгж, байгууллага эзэмшлийн газар дээрээ өөрийн хөрөнгөөр тарьж ургуулсан ургамал, ой мод, өсгөж үржүүлсэн амьтан болон хурын усыг хуримтлуулах замаар байгуулсан усан сан, нуур, цөөрмийг өмчилж болно.

4. Байгалийн баялгийг энэ хуулийн 6 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу бий болгосон эсэх талаар мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллагын дүгнэлт, орон нутгийн засаг захиргааны болон байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын тодорхойлолтыг үндэслэн тэдгээрт өмчлүүлэх асуудлыг хуулийн дагуу шийдвэрлэнэ.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

БАЙГАЛЬ ОРЧНЫ ҮНЭЛГЭЭ, СУДАЛГАА,
ШИНЖИЛГЭЭ

7 дугаар зүйл. Байгаль орчны үнэлгээ

1. Байгаль орчны унаган төрхийг хадгалах, түүний тэнцэл алдагдахаас сэргийлэх арга хэмжээ боловсруулж хэрэгжүүлэх, байгалийн баялгийн ашиглалтыг зохицуулах зорилгоор байгалийн баялгийн нөөцийн үнэлгээ болон байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг тус тус хийнэ.

2. Байгалийн баялгийг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглахыг хүсч байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллага энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үнэлгээг өөрийн зардлаар хийлгэх буюу үнэлгээг урьд нь тогтоосон бол түүнийг гүйцэтгэсний зардлыг төлнө.

3. Байгаль орчны үнэлгээг энэ зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу эрх олгосон аж ахуйн нэгж, байгууллага хийж тухайн төрлийн байгалийн баялгийг хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

4. Аж ахуйн нэгж, байгууллагад байгалийн баялгийн нөөцийн үнэлгээ хийх эрхийг тухайн төрлийн байгалийн баялгийг хамгаалах, зохистой ашиглах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ хийх эрхийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага / цаашид “төрийн захиргааны төв байгууллага” гэх/ олгоно.

5. Дараахь шаардлага хангасан аж ахуйн нэгж, байгууллагад байгаль орчны үнэлгээ хийх эрх олгоно:

1/ үнэлгээний багийн бүрэлдэхүүний гуравны нэгээс доошгүй нь орон тооны мэргэжлийн боловсон хүчин байх;

2/ хэмжилт, судалгааны багаж, хэрэгсэл, тоног төхөөрөмжтэй байх;

3/ магадлан итгэмжлэгдсэн мэргэжлийн байгууллагаас батлагдсан байгаль орчны үнэлгээ хийх арга зүйтэй байх;

4/ үнэлгээ хийх асуудлаархи мэдээллийн сантай байх.

8 дугаар зүйл. Байгалийн баялгийн нөөцийн үнэлгээ

1. Байгалийн тодорхой төрлийн баялгийн хэмжээг тоо, чанар болон мөнгөн үзүүлэлтээр тодорхойлсныг байгалийн баялгийн нөөцийн үнэлгээ гэнэ.

2. Үнэлгээгээр байгалийн баялгийн нөөцийн хэмжээ, тухайн

баялгийг хамгаалах, зохистой ашиглах, жам ёсны боломжтойг нь нөхөн сэргээх арга хэмжээг тогтоож, байгаль орчны улсын нэгдсэн мэдээллийн санд бүртгэнэ.

3. Байгалийн баялгийн нөөцийн мөнгөн үнэлгээг экологи, эдийн засгийн ач холбогдлыг харгалзан төрийн захиргааны төв байгууллага холбогдох бусад байгууллагатай хамтран тогтооно.

4. Нөөцийн мөнгөн үнэлгээг тухайн баялгийн нөөц ашигласны төлбөр, хураамж, байгальд учруулсан хортой нөлөөлөл, шууд хохирлын нөхөн төлбөрийн хэмжээг тогтоох үндэс болгоно.

9 дүгээр зүйл. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ

2. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээтэй холбогдсон харилцааг хуулиар зохицуулна.

3. Нөлөөллийн үнэлгээний зардлыг захиалагч этгээд санхүүжүүлнэ

4. Нөлөөллийн үнэлгээгээр тогтоогдсон шаардлагыг төсөл хэрэгжүүлэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага биелүүлэх үүрэгтэй.

10 дугаар зүйл. Байгаль орчны төлөв байдлын хяналт-шинжилгээ

1. Байгаль орчны төлөв байдлын хяналт-шинжилгээнд байгаль орчны төлөв байдал, түүний хувьсал өөрчлөлтөд байнгын ажиглалт, хэмжилт, судалгаа, шинжилгээ хийж дүгнэлт гаргах, илэрсэн сөрөг өөрчлөлтийг зогсоох, арилгах арга хэмжээ боловсруулах үйл ажиллагаа хамаарна.

2. Төрийн захиргааны төв байгууллага энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан ажлыг хэрэгжүүлэх зорилгоор байгаль орчны төлөв байдлын хяналт-шинжилгээний сүлжээ /цаашид “хяналт-шинжилгээний сүлжээ” гэх/-г зохион байгуулж ажиллуулна.

3. Хяналт-шинжилгээний сүлжээгээр дараахь ажлыг хэрэгжүүлнэ:

1/ байгаль орчинд гарах физик, хими, биологийн хувьсал өөрчлөлт, бохирдолтын түвшинд байнгын ажиглалт, хэмжилт, судалгаа хийж байгаль орчны төлөв байдлын өөрчлөлтийг тогтоох, үнэлгээ өгөх;

2/ байгаль орчин, түүний баялгийн талаар хүн ам, сонирхогч аж ахуйн нэгж, байгууллагыг мэдээллээр хангах;

3/ хүний эрүүл мэнд, байгаль орчинд учруулах хортой нөлөө, байгалийн аюул гамшгаас урьдчилан сэргийлэх, хор уршгийг арилгах арга хэмжээний төсөл боловсруулах.

11 дүгээр зүйл. Байгаль орчны судалгаа, шинжилгээ, түүний санхүүжилт

1. Улсын болон бүс нутгийн хөгжлийн баримжааг тодорхойлох,

нэн ховордсон амьтан, ургамлыг нөхөн сэргээх, өсгөн үржүүлэх, хөрс, ус, агаарыг хамгаалах болон хүн амын эрүүл, аюулгүй орчинд амьдрах талаархи судалгаа, шинжилгээний ажлыг улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ.

2. Төрийн захиргааны төв байгууллага, зохих шатны Засаг дарга нь эрдэм шинжилгээний болон холбогдох мэргэжлийн байгууллагад байгаль орчны судалгаа, шинжилгээний ажил хийх, төсөл боловсруулах захиалга өгч зохих төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэхээс гадна сонирхогч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад өөрийн хөрөнгөөр судалгаа, шинжилгээ хийхэд нь дэмжлэг үзүүлнэ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТАЛААРХИ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН БҮРЭН ЭРХ

13 дугаар зүйл. Улсын Их Хурлын бүрэн эрх

Улсын Их Хурал байгаль орчныг хамгаалах талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/ байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх төрийн бодлогыг тодорхойлох;

2/ Засгийн газрын өргөн мэдүүлснээр байгаль орчныг хамгаалах, экологийн аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөр батлах;

3/ байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийг батлах тэдгээрийн биелэлтэд хяналт тавих;

4/ байгалийн баялгийн нөөцийг ашигласны болон орчныг бохирдуулсны төлбөр, хураамжийн дээд, доод хэмжээг тогтоох;

5/ устах аюулд орсон амьтан, ургамлын жагсаалтыг батлах, өөрчлөх, байгалийн зарим объектыг улсын тусгай хамгаалалтад авах;

6/ хуульд заасан бусад бүрэн эрх.

14 дүгээр зүйл. Засгийн газрын бүрэн эрх

Засгийн газар байгаль орчныг хамгаалах талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/ байгаль орчныг хамгаалах, экологийн аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

2/ байгалийн баялгийг ашиглах, импортлох, экспортлох хэмжээг хуульд заасан үндэслэлээр хязгаарлах буюу тодорхой хугацаагаар хориглох;

3/ иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүн амын эрүүл

мэнд,байгаль орчинд хортой нөлөөлөл бүхий үйлдвэрлэлийн болон бусад үйл ажиллагааг төрийн захиргааны төв байгууллага болон аймаг, нийслэлийн Засаг даргын саналыг харгалзан өмчийнх нь хэлбэрийг үл харгалзан зогсоох;

4/ амьтан, ургамал, түүнчлэн байгалийн гаралтай түүхий эд экспортлох, импортлоход хил, гааль, хорио цээрийн хяналтыг зохион байгуулах;

6/ иргэдэд экологийн боловсрол, хүмүүжил олгох ажлыг зохион байгуулах;

7/ хуульд заасан бусад бүрэн эрх.

15 дугаар зүйл. Төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

1. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага байгаль орчныг хамгаалах талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/ байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх, байгаль орчны тэнцлийг хангах төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

2/ байгаль орчныг хамгаалах тодорхой асуудлаар төрийн захиргааны бусад төв байгууллага, аймаг, нийслэлийн хэмжээнд мөрдөх шийдвэр, дүрэм, журам батлаж биелэлтийг хангуулах;

3/ байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх талаар салбар дундын болон бүс нутаг хоорондын зохицуулалт хийх, байгаль орчны чадавхийн хэм хэмжээ, стандартыг боловсруулж, эрх бүхий байгууллагаар батлуулах буюу төрийн захиргааны холбогдох төв байгууллагатай хамтран баталж, биелэлтийг зохион байгуулах;

4/ хууль тогтоомжийн дагуу жил бүр ашиглаж болох ой, ургамал, амьтны тоо хэмжээг тодорхойлж, экологийн шаардлага, нөөцийг харгалзан тухайн бүс нутагт байгалийн зарим төрлийн баялгийн ашиглалтыг хязгаарлах буюу тодорхой хугацаагаар хориглох;

5/ байгаль орчныг хамгаалах талаар улсын захиалга өгч судалгаа, шинжилгээ, зураг төслийн ажил гүйцэтгүүлэх, өөрийн харьяа судалгаа, шинжилгээ, зураг төслийн болон мэргэжлийн байгууллагын үйл ажиллагааг удирдах;

6/ байгаль орчны тухай мэдээллээр иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг хангах биологийн болон генетикийн нөөцийг тогтвортой ашиглахад чиглэгдсэн уламжлалт мэдлэг, шинэ санаа, амьдралын туршлагыг хэрэглэснээр гарах үр ашгийг тэгш, шударгаар ашиглах явдлыг дэмжих;

7/ байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх талаар төрийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагад аргачилсан туслалцаа үзүүлэх;

8/ байгаль орчныг хамгаалах асуудлаар гадаад улс, олон улсын байгууллагатай хамтран ажиллах;

11/ байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх, экологийн боловсрол, хүмүүжил олгох ажилд санхүүгийн дэмжлэг үзүүлэх.

12 / идэвхтэн байгаль хамгаалагч ажиллуулах, ажлын үр дүнгээр урамшуулах журам боловсруулан батлах;

13/ байгаль орчны мэдээллийн сангийн үйл ажиллагааны талаархи хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг нэгдсэн удирдлагаар хангаж, хэрэгжилтэд нь хяналт тавих;

14/ хуульд заасан бусад бүрэн эрх.

2. Төрийн захиргааны бусад төв байгууллага байгаль орчныг хамгаалах талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/ салбарынхаа хөгжлийн чиг баримтлалд байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээг тухайлан тусгаж хэрэгжүүлэх;

2/ салбартаа байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулж үр дүнг жил бүр Засгийн газарт тайлагнах.

16 дугаар зүйл. Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон Засаг даргын бүрэн эрх

1. Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал байгаль орчныг хамгаалах талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/ нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ, төсөв баталж, биелэлтэд хяналт тавих;

2/ нутаг дэвсгэртээ тухайн жилд ашиглах байгалийн баялгийн нөөцийн дээд хэмжээг энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу тогтоох;

3/ байгаль орчны улсын тусгай хамгаалалтад ороогүй объектыг орон нутгийн хамгаалалтад авах шийдвэр гаргаж, түүний хилийн зааг, хамгаалалтын дэглэм тогтоож, биелэлтэд нь хяналт тавих;

4/ хот, тосгон, бусад суурин болон амралт, сувиллын газар, гол, мөрний эх, нуур, рашаан, булаг, шанд, уст цэгийн орчинг хамгаалах, эрүүл ахуйн шаардлагыг хангах тусгай бүсийн заагийг тогтоох;

5/ байгаль орчны төлөв байдал, мэдээллийн сангийн тухай Засаг

даргын мэдээлэл, тайланг хэлэлцэх.

2. Аймаг, нийслэлийн Засаг дарга байгаль орчныг хамгаалах талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/ байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах;

2/ нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ боловсруулж, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх, гарсан шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах;

3/ байгаль орчны мэдээллийн сангийн мэдээ, баримтыг төрийн захиргааны төв байгууллагад хугацаанд нь ирүүлэх;

4/ нутаг дэвсгэрийнхээ аж ахуйн нэгж, байгууллагын байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг ашиглах, нөхөн сэргээх үйл ажиллагаанд харьяалал харгалзахгүйгээр хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах, шаардлагатай бол тухайн аж ахуйн нэгж, байгууллагын байгаль орчинд хортой нөлөөлж буй үйл ажиллагааг өөрөө түдгэлзүүлэн зогсоох буюу уг асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

5/ нутаг дэвсгэртээ ажиллах байгаль орчны улсын ахлах болон улсын байцаагчийг энэ хуульд заасны дагуу ялгах тэмдэг, дүрэмт хувцас, бие хамгаалах зэвсэг, техник хэрэгсэл, уналгаар хангах;

6/ аймаг, нийслэлийн байгаль орчны албаны даргыг байгаль хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөж томилох, чөлөөлөх.

3. Аймаг, нийслэлийн байгаль орчны албаны даргыг байгаль орчны мэргэжилтэй, тухайн салбарт 3-аас доошгүй жил ажиллаж байгаа төрийн албан хаагчдаас Төрийн албаны тухай хуулийн 17.1-д заасны дагуу сонгон шалгаруулж томилно.

17 дугаар зүйл. Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн

Хурлын болон Засаг даргын бүрэн эрх

1. Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал байгаль орчныг хамгаалах талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/ нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ, төсөв баталж, биелэлтэд хяналт тавих;

2/ нутаг дэвсгэртээ тухайн жилд ашиглах байгалийн баялгийн нөөцийн хэмжээг хууль тогтоомжид заасан үндэслэл, журмын дагуу тогтоох;

4/ байгаль орчныг хамгаалах талаар Засаг даргын ажлын тайлан

хэлэлцэх.

5/ нутаг дэвсгэрийнхээ байгалийн тодорхой төрлийн баялгийн хамгаалалт, ашиглалт, эзэмшилтийг энэ хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 8 дахь заалтад заасан нөхөрлөлд хариуцуулах асуудлыг баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлын саналыг үндэслэн шийдвэрлэх.

2. Сум, дүүргийн Засаг дарга байгаль орчныг хамгаалах талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/ нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж, иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, дээд шатны байгууллагын шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах;

2/ иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад байгалийн баялгийн нөөц ашиглах эрхийн бичгийг хууль тогтоомжийн дагуу олгох;

3/ иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын байгалийн баялгийн ашиглалтад хяналт тавьж, тэдний ургуулсан ой, ургамал, өсгөн үржүүлсэн амьтан, сэргээн сайжруулсан, засаж тохижуулсан газар, уст цэгийг хүлээн авах;

4/ нутаг дэвсгэрийнхээ аж ахуйн нэгж, байгууллагын байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх үйл ажиллагаанд харьяалал харгалзахгүйгээр хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах, шаардлагатай бол тухайн аж ахуйн нэгж, байгууллагын байгаль орчинд хортой нөлөөлж буй үйл ажиллагааг өөрөө түдгэлзүүлэн зогсоох буюу уг асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

5/ байгаль хамгаалагчийн ажлыг удирдан чиглүүлэх, албан үүргээ гүйцэтгэхэд нь шаардагдах ялгах тэмдэг, дүрэмт хувцас, бие хамгаалах зэвсэг, техник хэрэгсэл, уналгаар орон нутгийн төсөвтөө тусган хангах, шаардлагатай бусад туслалцаа үзүүлэх;

6/ аж ахуйн нэгж, байгууллагын хог хаягдлын цэг тогтоох, бохирдлыг багасгах арга хэмжээ авах.

7/ энэ хуулийн 17 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалтад заасан шийдвэрийг үндэслэн иргэдийн нөхөрлөлд хариуцуулах байгалийн тодорхой төрлийн баялгаас нь зохих болзол, хугацаатайгаар хууль, журмын дагуу хамгаалуулах, ашиглуулах, эзэмшүүлэх гэрээ байгуулж, биелэлтэд нь хяналт тавих.

18 дугаар зүйл. Баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал болон Засаг даргын бүрэн эрх

1. Баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал байгаль орчныг хамгаалах талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/ бусдын эзэмшил, ашиглалтад олгоогүй хадлан, бэлчээр, уст

цэгийг хамгаалах, ашиглах хуваарь гаргаж зохицуулах;

2/ нийтийн ашиглалтын байгалийн баялгийн хамгаалалт, ашиглалтад хяналт тавих;

3/ байгаль орчныг хамгаалах талаархи Засаг даргын ажлын тайлан сонсох.

2. Баг, хорооны Засаг дарга байгаль орчныг хамгаалах талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/ байгаль орчныг хамгаалах талаархи хууль тогтоомж, иргэдийн Нийтийн Хурал болон дээд шатны байгууллагын шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах

2/ нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах ажлыг удирдан чиглүүлж орчны бохирдол, хог хаягдлыг цэвэрлэх жил бүрийн ажилд иргэдийг татан оролцуулах;

3/ хууль тогтоомжид заасан тохиолдолд байгалийн баялгийн нөөц ашиглах эрхийн бичиг олгох;

4/ нутаг дэвсгэртээ орчны эрүүл ахуй, ариун цэврийн шаардлагыг хангуулах, нийтийн хог хаягдлын цэг тогтоох.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, БАЙГАЛИЙН БАЯЛГИЙГ АШИГЛАХ, НӨХӨН СЭРГЭЭХ НИЙТЛЭГ АРГА ХЭМЖЭЭ

19 дүгээр зүйл. Байгаль орчныг хамгаалах нийтлэг арга хэлбэр

1. Монгол Улс санхүүгийн баталгаа бүхий “Байгаль орчныг хамгаалах, экологийн аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөр”- тэй байна.

2. Төр, түүний байгууллага, албан тушаалтан дараахь нийтлэг арга хэлбэрээр байгаль орчныг хамгаална:

1/ нэн ховор амьтныг агнах, барих, ургамлыг бэлтгэж ашиглахыг хориглох;

2/ нэн ховор, ховор амьтан, ургамлыг Монгол Улсын улаан номонд бүртгэж хамгаалах;

3/ байгаль орчинд үзүүлэх хортой аюултай нөлөөллийн хэм хэмжээ, стандарт тогтоож мөрдүүлэх;

4/ хүн амд экологийн боловсрол, хүмүүжил олгох, үндэсний өв уламжлалыг эзэмшүүлэх;

5/ хоргүй, аюулгүй, бохирдолгүй, хаягдалгүй технологи нэвтрүүлэн ашиглахыг урамшуулах;

6/ хот, тосгон, бусад суурин газрын орчинд болон гол, мөрөн, нуур, рашаан, булаг, шандын эх, ундаргын орчныг хамгаалах, эрүүл ахуйн бүс тогтоох.

7/ нөхөрлөлд гэрээний дагуу байгалийн тодорхой төрлийн баялгийн хамгаалалт, ашиглалт, эзэмшилтийг хариуцуулах.

20 дугаар зүйл. Байгаль орчны чадавхийн хэм хэмжээ

1. Хүн амын эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангах, байгаль орчныг хамгаалах зорилгоор байгаль орчинд гаргах хортой, аюултай бодисын агууламж, үзүүлэх сөрөг нөлөөллийн түвшний хэм хэмжээ /цаашид “байгаль орчны чадавхийн хэм хэмжээ”гэх/ -г дараахь үзүүлэлтээр тогтооно:

1/ агаар, ус, хөрс дэх хими, биологийн хортой аюултай бодисын хүлцэх хэм хэмжээ;

2/ байгаль орчинд хаяж болох хортой, аюултай бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ;

3/ чимээ, шуугиан, чичиргээ, цахилгаан соронзон талбай болон физикийн бусад хортой нөлөөллийн хүлцэх хэм хэмжээ;

4/ цацраг идэвхжлийн хүлцэх хэм хэмжээ;

5/ газар тариалан, бэлчээр хамгаалахад хэрэглэх агрохимийн бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ;

6/ хүнсний бүтээгдэхүүн дэх химийн бодисын зөвшөөрөх дээд агууламж;

7/ байгаль орчны даацын болон нөөцийн ашиглалтын зөвшөөрөгдөх дээд хэмжээ:

2. Энэ зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2, 3, 4, 6-д заасан хэм хэмжээг стандартчиллын байгууллага тогтооно.

3. Байгаль орчны чадавхийн тогтоосон хэм хэмжээг хэтрүүлэн байгаль орчинд хорт бодис гаргасан, хортой нөлөөлөл үзүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллага байгаль орчинд учруулсан хохирлыг өөрөө арилгах буюу мэргэжлийн байгууллагаар арилгуулж гарсан зардлыг нөхөн төлнө.

21 дүгээр зүйл. Байгаль орчныг бохирдохоос хамгаалах

1. Байгаль орчны чадавхийн тогтоосон хэм хэмжээнээс хэтрүүлж үйлдвэрлэлийн болон ахуйн хог хаягдал хаяхыг байгаль орчныг бохирдуулах гэнэ.

2. Бохирдуулах эх үүсвэрийн улсын нэгдсэн бүртгэлийг төрийн захиргааны төв байгууллага хөтөлнө.

3. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага үйлдвэрлэлийн болон ахуйн хог хаягдлаар байгаль орчныг бохирдуулахгүй байх талаар

дараахь үүрэгтэй:

1/ хортой, аюултай бодис болон хог хаягдлыг гагцхүү тусгайлан тогтоосон зориулалтын газар зөвшөөрөгдсөн аргаар булаах, устгах;

2/ хог хаягдлыг ялган, зориулалтын саванд цуглуулан, тусгайлан тоноглогдсон тээврийн хэрэгслээр зөөж тогтоосон цэгт хаях;

3/ оршин суугаа /оршин байгаа/ орчноо болон нүүхдээ бууцаа цэвэрлэж, шаардлагатай бол ариутгаж байх;

4/ хашаа, байрныхаа орчны хог хаягдлыг тогтмол цэвэрлэх.

4. Цацраг идэвхт болон химийн хортой, аюултай бодис, тэдгээрийг агуулсан нэгдлийг үйлдвэрлэх, хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журмыг хуулиар, үйлдвэрлэл, ахуйн хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, хоргүйжүүлэх, халдваргүйжүүлэх, боловсруулах, булаах, устгах журмыг Засгийн газар тус тус тогтооно.

22 дугаар зүйл. Байгалийн гамшиг, гэнэтийн аюул бүхий газар нутаг

1. Хүний үйл ажиллагаа болон байгалийн үйл явцаас шалтгаалан байгаль орчин, хүн ам, мал, амьтан, ургамал, тэдгээрийн удмын санд хөнөөл учруулахуйц хортой нөлөөлөл, өөрчлөлт үүссэн нутаг дэвсгэрийг байгалийн гамшиг, гэнэтийн аюул бүхий газар нутаг гэнэ.

2. Байгалийн гамшиг, гэнэтийн аюул бүхий газар нутагт хамрах бүсийн заагийг төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно.

3. Байгалийн гамшиг, гэнэтийн аюулаас сэргийлэх, түүний эх үүсвэрийг хязгаарлах, хор уршгийг арилгах, байгаль орчныг засаж сайжруулах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээг төрийн захиргааны төв байгууллага, иргэний хамгаалалтын алба, бүх шатны Засаг дарга, холбогдох бусад байгууллага хамтран авч хэрэгжүүлнэ.

4. Байгалийн гамшиг, гэнэтийн аюулын хор уршгийг арилгах зардлыг улсын төсвөөс гаргаж, учруулсан хохирлын шалтгааныг тогтоосны дараа түүнийг гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлнэ.

23 дугаар зүйл. Онц байдал тогтоосон үед байгаль орчныг хамгаалах

Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар онц байдал тогтоосон нутаг дэвсгэрт байгалийн гамшиг, гэнэтийн аюулыг сааруулах, түүний хор уршгийг арилгах, байгаль орчин, түүний баялгийг хамгаалах арга хэмжээг онц байдлын тухай болон онц байдал зарласан хуульд заасан үндэслэл, журмын дагуу авч хэрэгжүүлнэ.

24 дүгээр зүйл. Байгалийн баялгийн нөөцийн ашиглалтын дээд хэмжээ

1. Байгалийн баялгийн нөөцийг түүний даац, нөхөн сэргэх чадварыг харгалзан тодорхой хугацаанд ашиглаж болох хэмжээг байгалийн баялгийн нөөцийн ашиглалтын дээд хэмжээ гэнэ.

2. Байгалийн баялгийн нөөцийн ашиглалтын дээд хэмжээг байгалийн тухайн баялгийг хамгаалах, зохистой ашиглах тухай хуульд заасны дагуу тогтооно.

25 дугаар зүйл. Байгалийн баялгийг нөхөн сэргээх

1. Байгалийн баялгийг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага байгаль орчны тэнцлийг хангах зорилгоор дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

1/ ховордсон амьтан, ургамлын ашиглалтыг хязгаарлах, тэдгээрийг үржүүлэх, нутагшуулах, тэжээлээр хангах зэргээр нөөцийг нь нэмэгдүүлэх;

2/ байгалийн баялаг ашигласан газар, орчныг засаж сайжруулах, тохижуулах.

2. Монгол Улсын нутаг дэвсгэрт байдаггүй амьтныг үржүүлэх, нутагшуулах ургамлыг тарималжуулах, эгэл биетнийг өсгөвөрлөх ажлыг төрийн захиргааны төв байгууллага, эрх бүхий бусад байгууллагын зөвшөөрөл, хяналтын дор гүйцэтгэнэ.

ТАВДУГААР БҮЛЭГ

БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТ

26 дугаар зүйл. Байгаль орчны хяналт

1. Байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээхэд тавих хяналтыг мэргэжлийн хяналтын байгууллага хэрэгжүүлнэ.

2. Хил, гааль, мал эмнэлэг, эрүүл ахуй, халдвар судлал, уул уурхайн зэрэг хяналтын байцаагч буюу хуульд зааснаар энэхүү хяналтыг хэрэгжүүлэх үүрэг бүхий ажилтанд байгаль орчны улсын байцаагчийн эрх олгож, хяналтын үүрэг гүйцэтгүүлж болно.

3. Мэргэжлийн хяналтын албанд байгаль орчны улсын ерөнхий байцаагч, улсын ахлах байцаагч, улсын байцаагч, аймаг, нийслэлд улсын ахлах байцаагч, улсын байцаагч, сум, дүүрэгт улсын байцаагч /цаашид “улсын байцаагч” гэх/ болон байгаль хамгаалагч тус тус ажиллана.

4. Улсын байцаагчийг дараахь байдлаар томилж, чөлөөлнө:

1/ улсын ахлах байцаагч, улсын байцаагчийн эрхийг Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 3, 4 дэх хэсэгт заасны дагуу олгоно.

4/ байгаль хамгаалагчийг энэ хуулийн 26 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт заасан нормативын дагуу сум, дүүргийн улсын байцаагчийн

саналыг харгалзан сум, дүүргийн Засаг дарга.

5. Байгаль орчны хяналтын улсын байцаагчаар экологи, байгаль хамгаалал, байгаль орчны хяналт, үнэлгээнийн чиглэлийн мэргэжилтэй, эсхүл энэ чиглэлээр мэргэшиж дадлагажсан дээд боловсролын зэрэгтэй иргэнийг томилно.

6. Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас байгаль орчны чиглэлээр сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий сургуулийн мэргэжлийн сургалтанд хамрагдаж төгссөн иргэнийг байгаль хамгаалагчаар ажиллуулна.

7. Нэг байгаль хамгаалагчийн хариуцан ажиллах талбайн хэмжээ нь өндөр уулын бүсэд 100.0, ойг хээрийн бүсэд 120.0, тал хээрийн бүсэд 500.0, цөлөрхөг хээрийн бүсэд 600.0, цөлийн бүсэд 800.0 мянга хүртэл га, улсын төсвийн хөрөнгөөр зориудаар тарьж ургуулсан ойн зурваст 30 км тутамд нэг байгаль хамгаалагч байх ба энэ нормативийг хот орчмын ногоон бүсэд 70 хувиар багасгаж тооцно. Тухайн бүсчлэлд хамрагдах сумдын нэрийн жагсаалт, дархан цаазат болон байгалийн цогцолборт газарт нэг байгаль хамгаалагчийн хариуцах талбайн хэмжээг тухайн тусгай хамгаалалттай газрын ангилал, хамгаалах дэглэм, онцлог, ачаалал зэргийг харгалзан Засгийн газар тогтооно.

8. Тухайн орон нутагт байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээхэд тавих хяналтыг хэрэгжүүлэхэд туслах үүрэг бүхий идэвхтэн байгаль хамгаалагчийг томилон ажиллуулж болно.

27 дугаар зүйл. Улсын байцаагчийн эрх, үүрэг

1. Улсын байцаагч дараахь эрхтэй байна:

1/ иргэн, аж ахуйн нэгж, байгууллага байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийг хэрхэн биелүүлж байгаад харьяалал харгалзахгүйгээр хянан шалгах;

2/ хяналтад шаардагдах мэдээ, баримтыг холбогдох иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаар гаргуулах;

3/ хууль тогтоомж, стандарт, зөвшөөрөгдөх дээд хэмжээг зөрчиж байгаль орчинд хортой нөлөөлөл үзүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад уг зөрчлийг арилгахыг шаардах, тодорхой хугацаагаар үйл ажиллагааг нь түдгэлзүүлэн зогсоох;

4/ хяналт, шалгалт хийхээр аж ахуйн нэгж, байгууллагад нэвтрэн орох, сорьц, дээж авах, тэдгээрийг өөрийн хяналтын дор шинжлүүлэх

5/ байгалийн гамшиг, гэнэтийн аюулын үед шаардлагатай бол нийтийн тээврийн хэрэгслээр дараалал харгалзахгүйгээр зорчих, бусад тээврийн хэрэгслийг дайчилж хөлсийг нь төлөх;

6/ байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хянах явцдаа тухайн иргэний болон тээврийн хэрэгслийн баримт бичгийг шалгах, зөрчил илэрсэн тохиолдолд баримт бичиг, хууль бусаар агнасан, түүсэн, бэлтгэсэн, олборлосон байгалийн баялаг, ашигласан техник, тоног төхөөрөмж, багаж, хэрэгслийг хураах

7/ байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд хуульд заасан захиргааны шийтгэл ногдуулах;

8/ байгаль хамгаалагчийн ажлыг шалгах, заавар өгөх.

9/ноцтой зөрчил гаргах үед ашигласан тээврийн хэрэгслийг хураах.

10/хууль тогтоомж, технологийн зөрчил гаргаж байгаль орчинд хохирол учруулсан аж ахуйн нэгж, байгууллагын лицензи, зөвшөөрөл, байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулах эрхийг хүчингүй болгуулах, үйл ажиллагааг түр болон бүрмөсөн зогсоох саналаа тухайн эрх олгосон байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

11/байгаль орчны тухай хууль тогтоомжийг зөрчсөн шийдвэр гаргасан байгууллага, албан тушаалтны шийдвэрийг хүчингүй болгохыг шаардах, эсхүл дээд шатны байгууллагад гомдол гаргаж, шийдвэрлүүлэх.

2. Улсын байцаагч дараахь үүрэгтэй байна:

1/ байгаль орчныг хамгаалах үүргээ биелүүлэхдээ хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан дүрэм, журмыг чанд сахин биелүүлэх;

2/ байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийн зөрчлийн шинж байдал /зөрчил гаргагчийн нэр, хаяг, үйлдлийн шинж байдал, учруулсан хохирол, хөнгөрүүлэх болон хүндрүүлэх нөхцөл/-ын тухай тэмдэглэл хөтлөн зөрчил гаргагчийн гарын үсэг зуруулах буюу зурахаас татгалзсан бол энэ тухай тайлбар тэмдэглэл хийх;

3/ иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад захиргааны шийтгэл ногдуулах, тэдгээрийн хууль бус үйл ажиллагааг түдгэлзүүлэн зогсоохдоо түүний үндэслэл, шалтгааныг хууль тогтоомжийн зүйл, заалтын дагуу тодорхойлж, баталсан загвараар үйлдсэн акт буюу торгуулийн хуудаст тэмдэглэх;

4/ илрүүлсэн зөрчлийг таслан зогсоох, арилгах арга хэмжээ авахдаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх, үйлдвэрлэлийн нууцыг хадгалах;

5/ зөрчил гаргагчаас хуульд заасан үндэслэлээр хураан авсан зүйл, зэвсэг, хэрэгсэл, түр хураасан бичиг баримтын бүртгэлийг үйлдэж эзэнд нь үлдээж, зэвсэг, хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хангаж эрх

бүхий байгууллагад хугацаанд нь шилжүүлэх.

6/ байгаль орчныг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, хяналт тавих үйл ажиллагаанд орон нутгийн иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, тэдний идэвх санаачлагыг өрнүүлэх, зөвлөн туслах, зохион байгуулах, хамтарч ажиллах.

28 дугаар зүйл. Байгаль хамгаалагчийн эрх, үүрэг

1. Байгаль хамгаалагч дараахь эрхтэй байна:

1/ нутаг дэвсгэртээ энэ хуулийн 27 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1,4, 5-д заасан улсын байцаагчийн эрхийг хэрэгжүүлэх;

2/ нутаг дэвсгэртээ энэ хуулийн 2 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6, 7-д заасан улсын байцаагчийн эрхийг хуульд тусгайлан заасан тохиолдолд хэрэгжүүлэх.

2. Байгаль хамгаалагч энэ хуулийн 27 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаас гадна дараахь үүрэгтэй байна:

1/ хариуцсан нутаг дэвсгэртээ байгаль орчинд учирч болзошгүй аюулаас сэргийлэх, байгалийн баялгийг хамгаалах арга хэмжээ авах;

2/ хууль тогтоомжид заасан тохиолдолд байгалийн баялгийн нөөц ашиглах эрхийн бичиг олгох;

3/ иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад гэрээ, тусгай зөвшөөрөл, эрхийн бичгийн дагуу тухайн баялгийг ашиглах газрыг зааж өгөх, хяналт тавих;

4/ хариуцсан нутаг дэвсгэртээ байгалийн баялгийн өөрчлөлтийн ажиглалт хийж, мэдээг мэдээллийн санд тусгуулах;

5/ байгалийн гамшиг, гэнэтийн аюул гарсан даруйд зохих шатны Засаг даргад мэдээлж, хор уршгийг арилгах арга хэмжээ авах;

6/ хариуцсан нутаг дэвсгэртээ байгалийн баялгийг нөхөн сэргээх ажлыг зохион байгуулах.

29 дүгээр зүйл. Улсын байцаагч, байгаль хамгаалагч галт зэвсэг, бие хамгаалах тусгай хэрэгсэл хэрэглэх

1. Улсын байцаагч, байгаль хамгаалагч хээрийн нөхцөлд хууль тогтоомжийн биелэлтийг хянан шалгах үедээ галт зэвсэг, бие хамгаалах тусгай хэрэгсэл биедээ авч явах эрхтэй.

2. Улсын байцаагч, байгаль хамгаалагч хээрийн нөхцөлд хяналт, шалгалт хийх үедээ илэрсэн зөрчил, гадны халдлагыг өөр арга хэрэгслээр таслан зогсоох боломжгүй бол дараахь тохиолдолд галт зэвсэг хэрэглэж болно:

1/ байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж зөрчсөн этгээд хууль ёсны шаардлагыг нь илт, эсэргүүцэн зэвсэг хэрэглэх буюу өөр аргаар хүч хэрэглэн амь насанд нь халдсан;

2/ зэрлэг амьтан довтолж амь насанд аюул учруулахад хүрсэн.

3. Байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж зөрчсөн этгээд улсын байцаагч, байгаль хамгаалагчийн хууль ёсны шаардлагыг хүч хэрэглэн эсэргүүцвэл резинэн болон цахилгаан бороохой, нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагчаар цэнэглэсэн буу, резинэн буюу хуванцар сумтай буу зэрэг нэг бүрийн тусгай хэрэгсэл хэрэглэж болно.

4. Галт зэвсэг, тусгай хэрэгсэл хэрэглэх зааврыг төрийн захиргааны төв байгууллагын саналыг харгалзан Улсын ерөнхий прокурортой зөвшилцөн цагдаагийн төрийн захиргааны төв байгууллага батална.

29¹ дүгээр зүйл. Улсын байцаагч, байгаль хамгаалагчийн нийгмийн болон эрхээ хэрэгжүүлэх баталгаа

1. Улсын байцаагч, байгаль хамгаалагч нь нийгмийн болон эрхээ хэрэгжүүлэх дараахь баталгаагаар хангагдана:

1/ төрийн албанд 25 ба түүнээс дээш жил, түүнээс сүүлийн 10 жилийг нь байгаль хамгаалах албанд ажилласан байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч нарыг тэтгэвэрт гарахад нь 12 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тусламжийг ажиллаж байгаа байгууллагаас нь нэг удаа олгох;

2/ ажил үүргээ гүйцэтгэх зориулалтаар унаа, дүрэмт хувцас, галт зэвсэг, бие хамгаалах тусгай хэрэгсэлээр хангагдах.

2. Улсын байцаагч, байгаль хамгаалагч албан үүргээ гүйцэтгэх явцдаа бусдын нөлөөгөөр хөдөлмөрийн чадвараа түр алдсан, хөгжлийн бэрхшээлтэй болсон, амь насаа алдсан тохиолдолд түүнд болон түүний ар гэрт нь дараахь буцалтгүй тусламж, цалингийн зөрүүг олгоно:

1/ хөдөлмөрийн чадвараа түр алдсан тохиолдолд эмнэлэгийн чөлөөтэй байсан хугацааны тэтгэмж, албан тушаалын үндсэн цалингийн зөрүүг ;

2/ хөгжлийн бэрхшээлтэй болсон тохиолдолд хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэвэр, албан тушаалын үндсэн цалингийн зөрүүг;

3/ амь насаа алдсан тохиолдолд ар гэрт нь хохирогчийн 3 жилийн үндсэн цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй тусламж;

4/ энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан үндсэн цалингийн зөрүү, буцалтгүй тусламжийг төсвөөс олгож, түүнтэй тэнцэх хөрөнгийг гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлнэ.

5/ хуульд заасан бусад баталгаа.

БАЙГАЛЬ ОРЧИН, БАЙГАЛИЙН БАЯЛГИЙГ ХАМГААЛАХ
ТАЛААРХИ АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ҮҮРЭГ

30 дугаар зүйл. Мэргэжлийн байгууллага

1. Ой, амьтан, ус, ашигт малтмал зэрэг байгалийн баялаг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх асуудлыг хуулиар болон төрийн захиргааны төв байгууллагаас олгосон эрхийн дагуу эрхлэн зохицуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагыг мэргэжлийн байгууллага гэнэ.

2. Мэргэжлийн байгууллагад энэ зүйлийн 1дэх хэсэгт заасан үйл ажиллагааг эрхлэн зохицуулах эрх олгох журмыг Засгийн газар батална.

3. Мэргэжлийн байгууллага хариуцсан нутаг дэвсгэртээ дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

1/ төрийн захиргааны төв байгууллага, Засаг даргын шийдвэрийг үндэслэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай байгалийн баялгийг ашиглах гэрээ байгуулах, уг гэрээний дагуу байгалийн баялгийг ашиглах газрыг зааж өгөх;

2/ байгалийн баялгийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх төсөл, төлөвлөгөө боловсруулах, тэдгээрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, эрх олгосон тохиолдолд нөлөөллийн үнэлгээ хийх;

3/ байгалийн баялгийн нөөцийн судалгаа хийлгэх захиалга өгөх;

4/ байгалийн баялгийг өвчин, хөнөөлт мэргэч амьтан, хөнөөлт шавьж, түймэр зэрэг байгалийн гамшиг, гэнэтийн аюулаас урьдчилан сэргийлэх, хамгаалах, тэдгээртэй тэмцэх арга хэмжээг хэрэгжүүлэх;

Удаан задардаг органик бохирдуулагчийн үлдэгдэл, гарц хаягдлыг бууруулах, устгах арга хэмжээ авч, хүний эрүүл мэнд, байгаль орчныг хамгаалах олон улсын үйл ажиллагааны эхлэлийг тавихад чиглэсэн НҮБ-ын Орчны Хөтөлбөрийн Удирдах Зөвлөлийн 1997 оны 2 дугаар сарын 7-ны өдрийн 19/13 С тоот шийдвэрийг иш үндэс болгон,

Байгаль орчны талаарх олон улсын холбогдох конвенцийн заалтуудыг, тухайлбал Аюултай зарим химийн бодис, пестицидийг олон улсын хэмжээнд худалдаалахад хэрэглэх урьдчилан мэдээлж зөвшилцөх журмын тухай Роттердамын конвенц, Аюултай хог хаягдлыг хил дамжуулан тээвэрлэх, зайлуулахад хяналт тавих тухай Базелийн конвенц, түүний дотор уг конвенцийн 11 дүгээр зүйлийн заалтын хүрээнд боловсруулсан бүс нутгийн хэлэлцээрийг иш татан,

Мөн түүнчлэн Байгаль орчин, хөгжлийн асуудлаарх Риогийн тунхаглал, Хөтөлбөр-21-ийн холбогдох заалтуудыг иш татан,

Болгоомжлон сэрэмжлэх явдал нь бүх Талуудын анхааралд байгаа бөгөөд энэхүү конвенцод тусгагдсаныг хүлээн зөвшөөрч,

Энэхүү конвенц нь худалдаа, байгаль орчны чиглэлийн олон улсын бусад гэрээ, хэлэлцээрүүдэд нийцэж, тэдгээрт дэм болж байгааг тэмдэглэж,

Улс орнууд НҮБ-ын Дүрэм, олон улсын эрх зүйн зарчмуудын дагуу байгалийн нөөц баялгаа байгаль орчны болон хөгжлийн бодлогынхоо дагуу ашиглах бүрэн эрхтэй бөгөөд тэрхүү эрхээ эдлэхдээ эрх, хяналтынх нь дор явагдаж буй үйл ажиллагаа үндэсний хууль тогтоомж үйлчлэх хүрээнээс нь гадна буй газар нутаг, бусад орны байгаль орчинд хор хохирол учруулахгүй байх хариуцлага хүлээхийг ноголж,

Хөгжиж буй орнуудын, ялангуяа нэн буурай хөгжилтэй болон шилжилтийн эдийн засагтай орнуудын нөхцөл байдал, онцгой хэрэгцээ шаардлагыг, түүний дотор химийн салбарын нь удирдлага, зохицуулалтын үндэсний чадавхийг технологи дамжуулах, санхүү, техникийн туслалцаа үзүүлэх, Талуудын хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлэх зэрэг замаар бэхжүүлэхийн чухлыг анхаарч,

Хөгжиж буй арлын жижиг улсуудыг тогтвортой хөгжүүлэх үйл ажиллагааны 1994 оны 5 дугаар сарын 6-нд Барбадост баталсан

хөтөлбөрийг анхааралдаа бүрэн авч,

Хөгжингүй ба хөгжиж буй орнуудын боломж чадавх өөр өөр, хариуцлага нь нийтлэг хэдий ч Байгаль орчин ба хөгжлийн тухай Риогийн тунхаглалын 7 дугаар зарчимд заасанчлан ялгавартай болохыг тэмдэглэн,

Удаан задардаг органик бохирдуулагчийн үлдэгдэл, гарц хаягдлыг бууруулах, устгахад хувийн хэвшил, төрийн бус байгууллагууд чухал хувь нэмэр оруулж чадахыг хүлээн зөвшөөрч,

Удаан задардаг органик бохирдуулагчийг үйлдвэрлэгчид нь бүтээгдэхүүнийхээ сөрөг үр дагаврыг бууруулах, хор уршгийн нь талаар хэрэглэгчид, Засгийн Газар, олон нийтийг мэдээллээр хангах хариуцлага хүлээх нь чухал болохыг цохон тэмдэглэн,

Удаан задардаг органик бохирдуулагчийн уршиг нөлөөнөөс хамгаалах арга хэмжээг бохирдуулагчийн бүхий л шатанд авах шаардлагатайг харгалзан,

Эрх бүхий үндэсний байгууллагууд байгаль орчны холбогдолтой хохирлыг тухайн газар нутагт нь хязгаарлах, эдийн засгийн хөшүүргүүдийг хэрэглэхийг эрмэлзэх, бохирдуулагч нь бохирдуулсныхаа бүх зардлыг нийтийн ашиг сонирхол, олон улсын худалдаа, хөрөнгө оруулалтын шаардлагыг зохих ёсоор харгалзан хариуцах ёстойг заасан Байгаль орчин ба хөгжлийн тухай Риогийн Тунхаглалын 16 дугаар Зарчмыг нотолж,

Пестицид, үйлдвэрлэлийн зориулалттай химийн бодисын талаар зохицуулалтын ба үнэлгээний хөтөлбөргүй Талуудыг тийм хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэхийг нь дэмжиж,

Байгаль орчинд халгүй үйлдвэрлэл, химийн бодисыг бий болгох, хэрэглэхийн чухлыг хүлээн зөвшөөрч,

Удаан задардаг органик бохирдуулагчийн уршиг нөлөөнөөс хүний эрүүл мэнд, байгаль орчныг хамгаалахыг зорин,

Дараахийг хэлэлцэн тохиров.

Нэгдүгээр зүйл

Зорилго

Энэхүү конвенц нь хүний эрүүл мэнд, байгаль орчныг удаан задардаг органик бохирдуулагчаас хамгаалах зорилготой бөгөөд Байгаль орчин, хөгжлийн тухай Риогийн Тунхаглалын 15 дугаар Зарчимд тусгасан болгоомжлолыг харгалзаж байгаа болно.

Хоёрдугаар зүйл

Тодорхойлолт

Энэхүү конвенцийн хувьд:

(а) "Тал" гэдэг нь энэхүү конвенциор үүрэг хүлээхийг хүлээн зөвшөөрсөн, өөрийн нь хувьд энэхүү конвенц хүчин төгөлдөр үйлчилж буй улс буюу эдийн засгийн хамтын ажиллагааны бүсийн байгууллагыг хэлнэ.

(б) "Эдийн засгийн хамтын ажиллагааны бүсийн байгууллага" гэдэг нь тухайн бүс нутгийн бүрэн эрхт улс орнуудаас байгуулсан, гишүүд нь энэхүү конвенциор зохицуулагдах асуудлуудаарх эрх мэдлээ түүнд шилжүүлсэн, горимынхоо дагуу энэхүү конвенцид гарын үсэг зурах, түүнийг соёрхон батлах, хүлээн авах, батлах буюу түүнд нэгдэн орох эрх бүхий байгууллагыг хэлнэ.

(в) "Байлцан санал өгч буй Талууд" гэдэг нь байлцан дэмжиж буюу эсрэг санал өгч буй Талуудыг хэлнэ.

Гуравдугаар зүйл

Зайлшгүй үйлдвэрлэл, хэрэглээтэй холбогдсон
гарц хаягдлыг бууруулах буюу устгах арга хэмжээ

1. Оролцогч Тал бүр:

(а) дараах зүйлийг хориглоход чиглэсэн хуулийн болон захиргааны арга хэмжээ авна. Үүнд:

(i) Хавсралт А-д дурдсан химийн бодисуудыг мөн хавсралтад заасан нөхцлийн дагуу үйлдвэрлэх, хэрэглэх;

(ii) Хавсралт А-д дурдсан химийн бодисуудыг 2 дугаар заалтын дагуу импортлох, экспортлох;

(б) Хавсралт Б-д дурдсан химийн бодисуудыг мөн хавсралтад заасан нөхцлийн дагуу үйлдвэрлэх, хэрэглэхийг хязгаарлах.

2. Дараах нөхцөл, зорилтуудыг хангахын тулд оролцогч Тал бүр арга хэмжээ авна. Үүнд:

(а) Хавсралт А, Б-д дурдсан химийн бодисуудыг зөвхөн дараах зорилгоор импортлоно:

(i) 6 дугаар зүйлийн 1 (г)-д заасны дагуу байгаль орчинд халгүйгээр зайлуулах; буюу

(ii) Хавсралт А буюу Б-гийн нөхцлийн дагуу тухайн Талд зөвшөөрсөн хэрэглээ, зорилгод ашиглах;

(б) Хавсралт А-д дурдсан бөгөөд үйлдвэрлэл, хэрэглээнд нь тусгай зөвшөөрөл олгосон химийн бодисыг буюу Хавсралт Б-д дурдсан бөгөөд үйлдвэрлэл, хэрэглээнд нь тусгай зөвшөөрөл олгосон буюу зориулалтыг нь зөвшөөрсөн химийн бодисыг урьдчилан мэдээлж зөвшилцөх олон улсын журмын холбогдох бүх нөхцлийг харгалзан, зөвхөн дараах нөхцөлд экспортлох. Үүнд:

(i) 6 дугаар зүйлийн 1 (г)-д заасны дагуу байгаль орчинд халгүйгээр зайлуулах;

(ii) Хавсралт А буюу Б-д заасны дагуу тухайн химийн бодисыг ашиглах зөвшөөрөл авсан оролцогч Талд экспортлох:

(iii) Энэхүү Конвенцид оролцоогүй боловч экспортлогч Талд жил бүр баталгаа гаргаж өгсөн Талд экспортлох. Баталгаанд тухайн химийн бодисыг ямар зориулалтаар хэрэглэхийг заасан байх бөгөөд импортлогч улс нь тухайн химийн бодисын хувьд дараах үүрэг хүлээх тухай мэдэгдлийг тусгасан байна:

а. гарц хаягдлаас сэргийлэх буюу түүнийг хамгийн бага хэмжээнд нь хүртэл бууруулахад чиглэсэн шаардлагатай арга хэмжээг авч, хүний эрүүл мэнд, байгаль орчныг хамгаалах:

б. 6 дугаар зүйлийн 1 дүгээр заалтуудыг биелүүлэх;

в. холбогдох тохиолдолд хавсралт Б-гийн II хэсгийн 2 дугаар заалтуудыг биелүүлэх.

Энэхүү баталгаанд мөн эрх зүйн акт, зохицуулалтын, зохион байгуулалтын болон бодлогын шинжтэй холбогдох бусад баримт бичгийг хавсаргана. Экспортлогч Тал нь баталгааг зөвшөөрөл авснаасаа хойш 60 хоногийн дотор Нарийн бичгийн дарга нарын газарт хүргүүлнэ.

(в) Хавсралт А-д дурдсан бөгөөд үйлдвэрлэл, хэрэглээний талаарх тусгай нөхцөл нь ямар ч Талд үйлчлэхээ больсон химийн бодисыг 6 дугаар зүйлийн 1 (г)-д заасанчлан байгаль орчинд халгүйгээр зайлуулахаас бусад нөхцөлд экспортлохгүй байх:

(г) “Энэхүү Конвенцид оролцоогүй Тал” гэдэг нь тодорхой химийн бодисын хувьд энэхүү Конвенциор үүрэг хүлээгээгүй улс буюу эдийн засгийн хамтын ажиллагааны бүсийн байгууллагыг энэхүү заалтын хувьд хэлнэ.

3. Шинэ пестицид буюу үйлдвэрлэлийн шинэ химийн бодисын талаар зохицуулалтын ба үнэлгээний нэг буюу хэд хэдэн хөтөлбөр хэрэгжүүлж буй Тал Хавсралт Г-гийн 1-д заасан шалгуураар авч үзвэл удаан задардаг органик бохирдуулагчийн шинж чанартайд тооцогдох шинэ пестицид буюу үйлдвэрлэлийн шинэ химийн бодисын үйлдвэрлэл, хэрэглээг хориглох зорилгоор зохицуулалтын холбогдох арга хэмжээ

авна.

4. Пестицид, үйлдвэрлэлийн химийн бодисын талаар зохицуулалтын ба үнэлгээний нэг буюу хэд хэдэн хөтөлбөр хэрэгжүүлж буй Тал пестицид, үйлдвэрийн химийн бодисын талаар үнэлгээ хийхдээ Хавсралт Г-гийн 1-д заасан шалгууруудыг харгалзан үзнэ.

5. Энэхүү Конвенцид өөрөөр заагаагүй бол 1, 2 дугаар заалт нь лабораторийн судалгаа болон стандартын зорилгоор ашиглах химийн бодист хамаарахгүй.

6. Хавсралт А-гийн дагуу тусгай зөвшөөрөл авсан буюу Хавсралт Б-гийн дагуу тусгай зөвшөөрөл авсан буюу зориулалт нь зөвшөөрөгдсөн Тал тусгай зөвшөөрөл, зориулалтын нь дор явагдаж буй үйлдвэрлэл, хэрэглээ хүнд нөлөөлөх, байгаль орчинд хаягдал болон гарахаас сэргийлэх буюу тийм нөлөө, хаягдлыг хамгийн бага байлгахаар үйл ажиллагаагаа явуулна. Зөвшөөрөгдсөн хэрэглээ, зориулалтын нь улмаас байгаль орчинд хэвийн нөхцөлд зайлшгүй гарах гарц хаягдлыг мөрдөгдөж байгаа стандарт, зөвлөмжийн дагуу аль болох бага хэмжээнд байлгана.

Дөрөвдүгээр зүйл
Тусгай зөвшөөрлийн бүртгэл

1. Хавсралт А болон Б-д дурдсан тусгай зөвшөөрлийг авсан Талуудыг тогтоох зорилгоор энэхүү бүртгэлийг бий болгов. Үүнд Хавсралт А буюу Б-гийн бүх Талаас хэрэгжүүлж болох заалтуудыг ашигладаг Талууд хамаарахгүй.

Бүртгэлийг Нарийн бичгийн дарга нарын газраас хөтлөх ба нийтэд нээлттэй байна.

2. Бүртгэлд дараах зүйл багтана. Үүнд:

(а) Хавсралт А, Б-д заасан тусгай зөвшөөрлийн төрлийн жагсаалт;

(б) Хавсралт А, Б-д заасан тусгай зөвшөөрлийг авсан Талуудын жагсаалт; болон

(в) Бүртгэгдсэн тусгай зөвшөөрөл бүрийн хүчинтэй байх хугацааны жагсаалт.

3. Конвенцид оролцохыг хүссэн аливаа Улс Нарийн бичгийн газарт бичгээр мэдэгдэл өгч, хавсралт А, Б-д заасан тусгай зөвшөөрлийн нэг буюу хэд хэдэн төрлийг авахаар бүртгүүлнэ.

4. Хэрэв Тал нь бүртгэлдээ хугацаа заагаагүй буюу хугацааг нь 7 дугаар заалтын дагуу сунгаагүй бол тусгай бүхий зөвшөөрлийн хугацаа

энэхүү конвенц тухайн бодисын хувьд хүчин төгөлдөр болсноос хойш 5 жилийн дараа дуусна.

5. Талуудын Бага Хурал нь анхдугаар хуралдаанаараа бүртгүүлэх зүйлийг хянан хэлэлцэх журмын талаар шийдвэр гаргана.

6. Бүртгүүлсэн зүйлийг хянахаас өмнө холбогдох Тал тусгай зөвшөөрлийг бүртгүүлэх шаардлага хэвээр байгааг нотолсон илтгэлийг Нарийн бичгийн дарга нарын газарт өгнө. Нарийн бичгийн дарга нарын газар илтгэлийг бүх Талд хүргүүлнэ. Бүртгэлийг олдсон бүх мэдээлэлд үндэслэн хянана. Дүнгээр нь Талуудын Бага хурал холбогдох Талд зориулж зөвлөмж гаргаж болно.

7. Талуудын Бага хурал холбогдох Талын хүсэлтийг үндэслэн тусгай зөвшөөрлийн хугацааг 5 хүртэл жилээр сунгаж болно. Чингэхдээ хөгжиж буй болон шилжилтийн эдийн засагтай орон - Талуудын онцгой нөхцөл байдлыг зохих ёсоор харгалзан үзнэ.

8. Аливаа Тал тусгай зөвшөөрөл авахаар бүртгүүлсэн мэдэгдлээ Нарийн бичгийн дарга нарын газарт бичгээр мэдэгдэл өгөн цуцлуулж болно. Чингэхэд бүртгэл тухайн мэдэгдэлд дурдсан өдрөөс эхлэн үйлчлэхгүй.

9. Ямар ч Тал аль нэг төрлийн тусгай зөвшөөрөл авахаар бүртгүүлээгүй байгаа үед тухайн төрлийн хувьд шинэ бүртгэл хийхгүй байж болно.

Тавдугаар зүйл

Зориудын бус үйлдвэрлэлээс гарах хаягдлыг бууруулах ба устгах арга хэмжээ

Тал бүр Хавсралт В-д дурдсан химийн бодис бүрийн хүний үйл ажиллагаатай холбогдон бий болсон гарц хаягдлыг бууруулах, болбол бүрмөсөн зогсоох зорилгоор наад захын дараах арга хэмжээг авна. Үүнд:

(а) Өөрийн нь хувьд Конвенц хүчин төгөлдөр болсноос хойш 2 жилийн дотор үйл ажиллагааны төлөвлөгөөг, шаардлагатай бол бүсийн буюу дэд бүсийн хэмжээнд боловсруулж, улмаар 7 дугаар зүйлд заасан төлөвлөгөөний нэг хэсэг болгон хэрэгжүүлнэ. Чингэхдээ Хавсралт В-д дурдсан химийн гарц хаягдлыг тогтоох, тодорхойлох болон зохицуулах, (б)-гээс (д) хүртэлх дэд заалтуудыг хэрэгжүүлэхэд тус дөхөм үзүүлэхийг зорино. Үйл ажиллагааны төлөвлөгөөнд доорх зүйлийг оруулна. Үүнд:

(i) Гарч байгаа болон цаашид гарч болзошгүй гарц хаягдлын,

түүний дотор эх үүсвэрийн бүртгэлийг бий болгох, хийхэй холбогдсон үнэлгээ. Чингэхдээ Хавсралт В-д тодорхойлсон эх үүсвэрийн төрлүүдийг харгалзан үзнэ;

(ii) Тийм гарц хаягдлыг зохицуулах талаар оролцогч Талаас явуулж буй бодлого, гарсан хууль тогтоомжийн үр дүнгийн үнэлгээ;

(iii) Энэхүү заалтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн бөгөөд (i), (ii)-д дурдсан үнэлгээг харгалзсан стратеги;

(iv) Дээрх стратегитай холбогдсон бөгөөд түүнийг таниулан сурталчлахад чиглэсэн сургалт, боловсролыг дэмжих алхмууд;

(v) Эдгээр стратеги болон энэхүү заалтыг хэрэгжүүлэхэд гарсан ахиц ололтыг 5 жил тутам хянан үзэхэд гарах үр дүн; хяналтын үр дүнг 15 дугаар зүйлийн дагуу тавих илтгэлд тусгана;

(vi) Үйл ажиллагааны төлөвлөгөөг, түүний дотор түүнд тусгагдсан стратеги, арга хэмжээг хэрэгжүүлэх график;

(б) Гарц хаягдлыг түргэн бөгөөд бодитойгоор бууруулах, эх үүсвэрийг нь арилгахад хүргэхүйц хэрэгжүүлж болох зохистой практик арга хэмжээг авахад дэмжлэг үзүүлнэ;

(в) Хавсралт В-д дурдсан химийн бодис бий болох, хаягдал болон гарахаас сэргийлэх зорилгоор орлуулах буюу сайжруулсан материал, бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийн үйл явцыг бий болгох, хэрэглэхийг дэмжих буюу зохих нөхцөлд шаардана. Чингэхдээ Хавсралт В-д дурдсан гарц хаягдлыг бууруулах, хаягдлаас сэргийлэх арга хэмжээний тухай ерөнхий чиглэл болон Талуудын Бага хурлаас батлан гаргах зөвлөмжийг харгалзана;

(г) Шинэ эх үүсвэрийн хувьд тэргүүний арга техникийг хэрэглэх явдлыг Талаас тийм арга хэмжээ авах шаардлагатай гэж үзсэн эх үүсвэрийн төрлүүдийн хувьд дэмжих буюу шаардлагатай бол үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх графикийн дагуу шаардана. Чингэхдээ Хавсралт В-гийн II хэсэгт тодорхойлсон эх үүсвэрийн төрлүүдэд эхэн үед онцгой анхаарч арга хэмжээ авна. Тухайн Хавсралтын II хэсэгт заасан төрлүүд дэх шинэ эх сурвалжийн хувьд тэргүүний арга техникийг ашиглах шаардлагыг боломжийн хэрээр даруй, гэхдээ тухайн Талын хувьд конвенци хүчин төгөлдөр болсноос хойш 4 жилээс хэтрэлгүй тавина. Тодорхойлсон төрлүүдийн хувьд байгаль орчинд халгүй тэргүүний практик ашиглахыг Талууд дэмжинэ. Тэргүүний арга техникийг ашиглах, байгаль орчинд халгүй тэргүүний практик ажиллагааг хэрэгжүүлэхдээ гарц хаягдлаас сэргийлэх, хорогдуулах арга хэмжээний талаар тухайн хавсралтад тусгасан ерөнхий чиглэл болон Талуудын Бага хурлаас батлан гаргах тэргүүний арга техник, байгаль

орчны тэргүүний практикийн тухай зөвлөмжийг харгалзана;

(д) Тэргүүний арга техникийг ашиглах, байгаль орчинд халгүй тэргүүний практикийг хэрэгжүүлэх явдлыг:

(i) Байгаа эх үүсвэрүүдийн хувьд Хавсралт В-гийн II хэсэгт дурдсан эх үүсвэрийн төрлүүдийн болон мөнхүү хавсралтын III хэсэгт тусгасантай адил эх үүсвэрийн төрлүүдийн хувьд;

(ii) Шинэ сурвалжийн хувьд Хавсралт В-гийн III хэсэгт дурдсантай адил бөгөөд Талаас дэд заалт (г) 2-ын хүрээнд авч үзээгүй эх үүсвэрүүдийн хувьд тус тус үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу дэмжинэ

Талууд тэргүүний арга техникийг ашиглах, байгаль орчинд халгүй тэргүүний практик ажиллагааг хэрэгжүүлэхдээ гарц хаягдлаас сэргийлэх, бууруулах арга хэмжээний талаар Хавсралт В-д тусгасан ерөнхий чиглэл болон Талуудын Бага хурлаас батлан гаргах тэргүүний арга техник ба байгаль орчинд халгүй тэргүүний практикийн тухай зөвлөмжийг харгалзана;

(е) Энэхүү заалт болон Хавсралт В –гийн хувьд:

(i) “Тэргүүний арга техник” гэдэг нь Хавсралт В-гийн I хэсэгт дурдсан химийн бодисын гарц хаягдал, түүнээс байгаль орчинд үзүүлэх нөлөөнөөс сэргийлэх, энэ нь биелшгүй тохиолдолд бууруулахад чиглэсэн, практикийн хувьд хаягдлыг бууруулах үндсийг зарчмын хувьд олгож буй үйл ажиллагаа, түүнийг явуулах хамгийн үр ашигтай, шилдэг арга барилыг хэлнэ;

(ii) “Арга техник” гэдэг нь ашиглаж буй технологи болон түүнийг зохиох, хийж бүтээх, арчлах, ажиллуулах болон ашиглалтаас гаргах арга замыг хэлнэ;

(iii) “Байгаа” арга техник гэдэг нь гүйцэтгэгчид ашиглах боломжтой, үйлдвэрлэлийн холбогдох секторт өргөнөөр хэрэглэхээр эдийн засгийн болон техникийн нөхцөл, зардал, давуу талыг нь харгалзан боловсруулсан арга техникийг хэлнэ;

(iv) “Тэргүүний” гэдэг нь байгаль орчныг хамгаалахад хамгийн үр ашигтай байх явдлыг хэлнэ:

(v) “Байгаль орчинд халгүй тэргүүний практик ” гэдэг нь байгаль орчны хяналтын арга хэмжээ, стратегийн хамгийн зохистой хослолыг хэрэглэх явдлыг хэлнэ;

(vi) “Шинэ эх үүсвэр” гэдэг нь дор дурдсанаас наад зах нь I жилийн дараа байгуулж эхэлсэн буюу үлэмж өөрчлөлт оруулсантай холбогдон бий болсон эх үүсвэр болно:

а. Холбогдох Талын хувьд энэхүү конвенци хүчин төгөлдөр

болсон; буюу

б. Хавсралт В-д оруулсан өөрчлөлтөд дурдсан эх үүсвэр энэхүү конвенцийн нөхцөлд хамаарах болж, тухайн өөрчлөлт холбогдох Талын хувьд хүчин төгөлдөр болсон.

(ё) Тал нь энэхүү заалтын дагуу тэргүүний арга техникийг ашиглах үүднээс хаягдлыг хязгаарлах хэмжээ буюу үйл ажиллагааны стандартыг ашиглаж болно.

Зургадугаар зүйл

Нөөцөөс үүссэн гарц болон хаягдлыг бууруулах
буюу устгах арга хэмжээ

1. Хавсралт А буюу Б-д дурдсан химийн бодисоос бүрдсэн буюу тийм бодис бүхий бодисын нөөц болон Хавсралт А,Б, В-д дурдсан химийн бодисоос бүрдсэн буюу тийм бодис бүхий буюу тийм бодисоор хордсон бодис бүхий хаягдал, түүний дотор хаягдал болж буй бүтээгдэхүүн, зүйлийг хүний эрүүл мэнд, байгаль орчинд хохирол учруулахгүйгээр зохицуулахын тулд Тал тус бүр:

(а) дараахийг тодорхойлоход чиглэсэн холбогдох стратегийг боловсруулна:

(i) Хавсралт А буюу Б-д дурдсан химийн бодисоос бүрдсэн буюу тийм бодис бүхий бодисуудын нөөц;

(ii) Хавсралт А, Б, В-д дурдсан химийн бодисыг агуулсан буюу тэдгээрээр бохирдсон хаягдал, хэрэглэж буй бүтээгдэхүүн, зүйлс.

(б) Хавсралт А буюу Б-д дурдсан химийн бодисоос бүрдсэн буюу тийм бодисыг агуулсан, түүгээр бохирдсон нөөцийг дэд заалт (а)-д заасан стратегийн үндсэн дээр боломжийн хэрээр тогтооно:

(в) Нөөцийг нөхцөл байдлыг нь харгалзан аюулгүйгээр, үр ашигтайгаар, байгаль орчинд халгүйгээр зохицуулна. Хавсралт А, Б-д дурдсан химийн бодисын нөөцийг хавсралт А-д заасан тусгай зөвшөөрөл буюу Хавсралт Б-д заасан тусгай зөвшөөрөл буюу зөвшөөрөгдсөн зориулалтын дагуу ашиглах боломжгүй нөхцөлд хаягдал хэмээн үзэж, дэд заалт (г)-д заасны дагуу арга хэмжээ авна. Үүнд 3 дугаар зүйлийн 2 дугаар заалтын дагуу экспортлохыг зөвшөөрсөн нөөц хамаарахгүй.

(г) Тийм хаягдал, түүний дотор бүтээгдэхүүн, зүйлс хаягдал болоход зохих арга хэмжээг авна. Тухайлбал:

(i) Байгаль орчинд хохирол учруулахгүйгээр цуглуулж, тээвэрлэж, хадгална;

(ii) Удаан задардаг органик бохирдуулагч нь устгах буюу

бүрмөсөн хувирч, бохирдуулагчийн шинж чанараа алдаж байхаар зайлуулна. Хэрэв устгах буюу бүрмөсөн хувиргах нь байгаль орчинд халтай эсвэл удаан задардаг органик бохирдуулагчийн агууламж нь маш бага бол байгаль орчинд халгүй өөр замаар зайлуулна. Чингэхдээ олон улсын, түүний дотор 2 дугаар заалтын дагуу боловсруулан гаргах дүрэм, стандарт, зөвлөмжүүд болон аюултай хаягдлын талаарх дэлхий нийтийн болон бүс нутгийн холбогдох дэглэм, журмыг харгалзана;

(iii) Удаан задардаг органик бохирдуулагчийг сэргээх, дахин боловсруулах, хэрэглээнд оруулах, шууд буюу өөр хэлбэрээр ашиглахад хүргэхүйц зайлуулах арга ажиллагаанд зөвшөөрөл олгохгүй байна;

(iv) Олон улсын холбогдох дүрэм, стандарт, зөвлөмжийг чанд сахих үндсэн дээр олон улсын хил дамжуулан тээвэрлэнэ.

(д) Хавсралт А, Б, буюу В-д дурдсан химийн бодисоор бохирдсон газрыг тодорхойлох арга замыг бий боловсруулах талаар хүч чармайлт тавина: тийм газрыг сэргээх арга хэмжээ авч буй бол түүнийг байгаль орчинд хохирол учруулахгүйгээр явуулна:

2. Талуудын Бага хурал нь Аюултай хог хаягдлыг хил дамжуулан тээвэрлэх, зайлуулахад хяналт тавих тухай Базелийн конвенцийн холбогдох байгууллагуудтай, тухайлбал дараах зорилгоор ойр дотно хамтран ажиллана:

(а) Удаан задардаг органик бохирдуулагчийн Хавсралт Г-гийн 1 дүгээр заалтад заасан шинж чанар дахин илрэхгүйгээр устгах, бүрмөсөн хувирах түвшинг тогтоох;

(б) Дээр дурдсан байгаль орчинд халгүй зайлуулах арга гэж юу болохыг тодорхойлох;

(в) Энэ зүйлийн 1 дэх заалтын (г) (ii) –д дурдсан удаан задардаг органик бохирдуулагчийн бага агууламжийг тодорхойлох үүднээс Хавсралт А, Б, В -д дурдсан химийн бодисуудын концентрацийн түвшинг тогтоох.

Долдугаар зүйл
Хэрэгжүүлэх төлөвлөгөө

1. Тал бүр:

(а) Энэхүү конвенциор хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулж, түүнийгээ биелүүлэхийг зорино;

(б) Өөрийнх нь хувьд конвенц хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 2 жилийн дотор Талуудын Бага хуралд конвенцийг хэрэгжүүлэх төлөвлөгөөгөө хүргүүлнэ.

(в) Конвенцийг хэрэгжүүлэх төлөвлөгөөгөө үе үе болон Талуудын Бага хурлаас заасны дагуу тогтмол хянан шинэчилнэ.

2. Талууд конвенцийг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулах, биелүүлэх, шинэчлэхэд бие биедээ туслалцаа үзүүлэх үүднээс шууд буюу дэлхий нийтийн, бүсийн, дэд бүсийн байгууллагуудаар дамжуулан хамтран ажиллах ба үндэсний холбогдох этгээдүүдтэй, түүний дотор эмэгтэйчүүдийн хэсгүүд, хүүхдийн эрүүл мэндийн асуудал эрхэлсэн хэсгүүдтэй зөвлөлдөнө.

3. Талууд удаан задардаг органик бохирдуулагчийн талаарх үндэсний төлөвлөгөөгөө болбол тогтвортой хөгжлийнхөө стратегид тусгах арга замыг эрэлхийлж ажиллана.

Наймдугаар зүйл

Хавсралт А, Б, В-д оруулсан химийн бодисууд

1. Тал нь Хавсралт А, Б, буюу В-д химийн бодис нэмж оруулах саналаа Нарийн бичгийн дарга нарын газарт гаргаж болно. Саналд Хавсралт Г-д дурдсан мэдээллийг тусгасан байна. Саналыг боловсруулахдаа бусад Талын болон Нарийн бичгийн дарга нарын газрын туслалцааг авч болно.

2. Нарийн бичгийн дарга нарын газар саналд Хавсралт Г-д заасан мэдээллийг тусгасан эсэхийг нягтлан шалгана. Мэдээллийг тусгасан гэж үзвэл түүнийг Удаан задардаг органик бохирдуулагчийн асуудал хариуцсан Хороонд хүргүүлнэ.

3. Хороо нь саналыг Хавсралт Г-д заасан шалгууруудыг ашиглан уян хатан, ил тод байдлаар хянан үзнэ. Чингэхдээ байгаа бүх мэдээллийг зохих ёсоор харгалзана.

4. Хэрэв Хороо:

(а) шалгуурын нөхцлүүд хангагдсан гэж үзвэл уг санал болон Хорооны дүгнэлтийг Нарийн бичгийн дарга нарын газраар дамжуулан бүх Тал ба ажиглагчдад толилуулж, хавсралт Д-д заасан мэдээллийг гаргаж өгөхийг хүснэ:

(б) шалгуурын нөхцлүүд хангагдсангүй гэж үзвэл уг санал болон Хорооны дүгнэлтийг Нарийн бичгийн дарга нарын газраар дамжуулан бүх Тал болон ажиглагчдад толилуулж, саналыг хэлэлцэх явдлыг түдгэлзүүлнэ.

5. Аливаа Тал 4 дүгээр заалтын дагуу хэлэлцэхийг нь түдгэлзүүлсэн саналыг Хороонд дахин тавьж болно. Чингэхдээ түүнийг авч үзэх өөрийн үндэслэлүүдийг, түүнчлэн Хороо яагаад түүнийг дахин

авч үзэх шаардлагатайг заасан үндэслэлүүдийг Хороонд гаргаж болно. Хэрэв Хороо түүнийг энэхүү журмын дагуу авч үзээд хэлэлцэхийг нь дахин түдгэлзүүлбэл холбогдох Тал Хорооны шийдвэртэй заалдаж болох ба Талуудын Бага хурал асуудлыг дараагийн хуралдаанаараа авч үзнэ. Талуудын Бага хурал нь Хавсралт Г-д дурдсан шалгууруудыг үндэслэн Хорооны дүгнэлт болон Тал, ажиглагчдаас өгсөн нэмэлт мэдээллийг харгалзан саналыг хэлэлцэх шийдвэр гаргаж болно.

6. Хэрэв Хороо шалгуурын нөхцлүүд хангагдсан гэж үзсэн буюу Бага хурал саналыг хэлэлцэх нь зүйтэй гэж тогтсон тохиолдолд Хороо саналыг хянан үзнэ. Чингэхдээ хүлээн авсан нэмэлт мэдээллийг харгалзах бөгөөд Хавсралт Д-гийн дагуу эрсдлийн тодорхойлолтын төслийг бэлтгэнэ. Эрсдлийн тодорхойлолтын төслийг Нарийн бичгийн дарга нарын газраар дамжуулан бүх Тал, ажиглагчдад толилуулан саналыг нь авч, эрсдлийн тодорхойлолтыг гүйцээнэ.

7. Хороо Хавсралт Д-гийн дагуу бэлтгэсэн эрсдлийн тодорхойлолтын үндсэн дээр:

(а) тухайн химийн бодис нь байгаль орчны үйл явцад хол тархаж, хүний эрүүл мэнд, байгаль орчинд дэлхий нийтийг хамарсан арга хэмжээ авахыг шаардахуйц сөрөг нөлөө үзүүлж болзошгүй гэж үзвэл саналыг хэлэлцэнэ. Шинжлэх ухааны бүрэн мэдээлэл нотолгоо хангалттай бус байх нь саналыг хэлэлцэхэд саад болохгүй. Хороо Хавсралт Е-д дурдсан асуудлуудтай холбогдсон мэдээлэл өгөхийг Нарийн бичгийн дарга нарын газраар дамжуулан бүх Тал, ажиглагчдаас хүснэ. Мөн эрсдлийн удирдлагын үнэлгээг, түүний дотор тухайн химийн бодист тавих хяналтын арга хэмжээнд Хавсралт Е –гийн дагуу хийх үнэлгээг бэлтгэх; буюу

(б) саналыг цаашид хэлэлцэх шаардлагагүй гэж үзвэл эрсдлийн тодорхойлолтыг Нарийн бичгийн дарга нарын газраар дамжуулан бүх Тал, ажиглагчдад толилуулан саналыг хэлэлцэхийг түдгэлзүүлнэ.

8. Талнь 7(б) заалтын дагуу түдгэлзүүлсэн саналтай холбогдуулан санал тавигч болон бусад Талаас нэг жил хүртэлх хугацааны дотор нэмэлт мэдээлэл авах асуудлыг Хороонд тавих хүсэлтийг Талуудын Бага хуралд гаргаж болно. Хороо саналыг дурдсан хугацааг өнгөрсний дараа хүлээн авсан нэмэлт мэдээллийн үндсэн дээр 6 дугаар заалт болон Талуудын Бага хурлаас тогтоох дарааллын дагуу дахин хэлэлцэнэ. Хэрэв саналыг авч үзээд түүнийг хэлэлцэхийг дахин түдгэлзүүлбэл Тал Хорооны шийдвэртэй заалдаж болох ба Талуудын Бага хурал асуудлыг дараагийн хуралдаанаараа авч үзнэ. Талуудын Бага хурал нь нь Хавсралт Д-д дурдсан эрсдлийн тодорхойлолтыг үндэслэн Хорооны дүгнэлт, Тал

болон ажиглагчдаас өгсөн бусад нэмэлт мэдээллийг харгалзан саналыг хэлэлцэх шийдвэр гаргаж болно. Хэрэв Талуудын Бага хурал саналыг хэлэлцэх нь зүйтэй гэж үзвэл Хороо эрсдлийн удирдлагын үнэлгээг бэтгэнэ.

9. Хороо 6 дугаар заалтад дурдсан эрсдлийн тодорхойлолт, 7(а) буюу 8 дугаар заалтад дурдсан эрсдлийн удирдлагын үнэлгээг үндэслэн тухайн химийн бодисыг Хавсралт А, Б буюу В дэх жагсаалтад оруулах асуудлыг Талуудын Бага хурлаар хэлэлцүүлэх эсэх талаар зөвлөмж гаргана. Талуудын Бага хурал Хорооны зөвлөмжийг, түүний дотор шинжлэх ухааны баримт нотолгоо хангалттай бус байгааг харгалзан тухайн химийн бодисыг Хавсралт А, Б буюу В-д оруулах эсэх, хяналтын холбогдох арга хэмжээг тусгах эсэх талаар шийдвэр гаргана.

Есдүгээр зүйл
Мэдээлэл солилцоо

1. Тал бүр доорх чиглэлээр мэдээлэл солилцох буюу тийнхүү солилцоход тус дөхөм үзүүлнэ:

(а) удаан задардаг органик бохирдуулагчийн үйлдвэрлэл, хэрэглээ, гарц хаягдлыг бууруулах буюу зогсоох:

(б) удаан задардаг органик бохирдуулагчийг орлох зүйлс, түүний дотор тэдгээрийн улмаас учирч буй эрсдэл, эдийн засаг, нийгмийн хохирол.

2. Талууд 1 дүгээр заалтад дурдсан мэдээллийг шууд буюу Нарийн бичгийн дарга нарын газраар дамжуулан солилцоно.

3. Тал бүр тийм мэдээлэл солилцох үндэсний төвийг томилж ажиллуулна.

4. Нарийн бичгийн дарга нарын газар нь удаан задардаг органик бохирдуулагчийн талаарх мэдээллийн, түүний дотор Талууд, засгийн газар хоорондын болон төрийн бус байгууллагуудаас ирүүлсэн мэдээллийн зуучлагчийн үүрэг гүйцэтгэнэ.

5. Хүний эрүүл мэнд, аюулгүй байдал, байгаль орчны аюулгүй байдлын тухай мэдээллийг энэхүү конвенцийн зорилгын үүднээс нууцад хамааруулахгүй. Энэхүү конвенцийн дагуу өөр бусад мэдээлэл солилцож байгаа Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр нууц мэдээллийг задруулахгүй байна.

Аравдугаар зүйл

Олон нийтийн мэдээлэл, сурталчилгаа, боловсрол

Тал бүр дараах арга хэмжээг авахад бололцооныхоо хэрээр дэмжиж тусална. Үүнд:

(а) удаан задардаг органик бохирдуулагчийн талаар бодлого боловсруулагчид, шийдвэр гаргагчдад сурталчлан танилцуулах;

(б) удаан задардаг органик бохирдуулагчийн тухай байгаа бүхий л мэдээллийг олон нийтэд хүргэх. Чингэхдээ 9 дүгээр зүйлийн 5 дугаар заалтыг харгалзана.

(в) удаан задардаг органик бохирдуулагчид, тэдгээрээс хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлдэг уршиг нөлөө болон тэдгээрийг орлуулах зүйлийн талаар танилцуулсан олон нийтийн сурталчилгааны болон сургалтын хөтөлбөрийг, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд, боловсрол дутмаг хүмүүст зориулан боловсруулж хэрэгжүүлэх;

(г) удаан задардаг органик бохирдуулагчид, тэдгээрээс хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлж буй уршиг нөлөөний талаар хэлэлцэх, холбогдох арга хэмжээг боловсруулахад олон нийтийг оролцуулах, тухайлбал энэхүү конвенцийг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулах боломжийг олгох;

(д) ажилчин, эрдэм шинжилгээний ажилтан, сурган хүмүүжүүлэгчид, техникийн болон удирдах боловсон хүчин бэлтгэх;

(е) сургалт, олон нийтийн сурталчилгааны материалыг үндэсний болон олон улсын хэмжээнд боловсруулах, солилцох; болон

(ё) боловсролын ба сургалтын хөтөлбөрийг үндэсний болон олон улсын хэмжээнд боловсруулж хэрэгжүүлэх.

2. Тал бүр 1 дүгээр заалтад дурдсан мэдээлийг бололцооны хэрээр олон нийтэд нээлттэй байлгаж, шинэчилж байна.

3. Үйлдвэрлэлийн болон мэргэжлийн ашиглагчид нь 1 дүгээр заалтад дурдсан мэдээллийг үндэсний, шаардлагатай бол дэд бүсийн, бүсийн ба олон улсын түвшинд солилцох явдлыг Тал бүр бололцооны хэрээр дэмжинэ.

4. Талууд удаан задардаг органик бохирдуулагчид болон тэдгээрийг орлох зүйлийн тухай мэдээлэл солилцохдоо мэдээлэх хуудас, илтгэл, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл болон харилцаа холбооны бусад хэрэгслийг ашиглаж болох бөгөөд үндэсний болон олон улсын мэдээллийн төвүүдийг байгуулж болно.

5. Тал бүр хавсралт А, Б, буюу В-д дурдсан бөгөөд жилд гарсан буюу зайлуулсан химийн бодисын хэмжээний тухай мэдээлэл цуглуулах,

солилцох үүднээс гарсан, шилжүүлсэн бохирдуулагчийг бүртгэх хэрэгсэл, механизмыг бий болгох асуудлыг нааштайгаар авч үзнэ.

Арван нэгдүгээр зүйл
Судалгаа, боловсруулалт, ажиглалт

1. Талууд удаан задардаг органик бохирдуулагчид, тэдгээрийг орлуулах бодис, удаан задардаг органик бодис болж болзошгүй зүйлс, түүний дотор тэдгээрийн:

(а) байгаль орчинд гарах гарц хаягдал, эх сурвалж;

(б) байгаль орчин болон хүний биед орших байдал, түвшин, хандлага;

(в) байгаль орчинд шилжин тархах, хувирах явдал;

(г) хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх нөлөө;

(д) нийгэм-эдийн засаг, соёлын үр дагавар;

(е) гарц хаягдлын хорогдол, устал; болон

(ё) үүсгэгч эх сурвалжийг бүртгэх нэгдсэн арга зүй болон гарц хаягдлыг хэмжих аналитик арга техникийн талаар үндэсний ба олон улсын түвшинд зохих судалгаа, боловсруулалт, ажиглалт хийх болон хамтарч ажиллахыг болоцооны хэрээр дэмжинэ.

2. Талууд 1 дүгээр заалтыг хэрэгжүүлэхдээ:

(а) шинжилгээ судалгаа хийх, мэдээлэл цуглуулах, ажиглалт явуулах явдлыг тодорхойлох, үнэлж дүгнэх, санхүүжүүлэхэд чиглэсэн олон улсын хөтөлбөр, сүлжээ, байгууллагыг бололцооны хэрээр хөгжүүлж дэмжинэ. Чингэхдээ давхардсан ажиллагаа, хүч чармайлт аль болох бага гаргана;

(б) ялангуяа хөгжиж буй болон шилжилтийн эдийн засагтай орнуудын шинжлэх ухаан-техникийн судлагаа явуулах боломж чадавхийг бэхжүүлэх, мэдээлэл, судалгааг ашиглах, солилцох явдлыг нь хөхүүлэн дэмжихэд чиглэсэн үндэсний болон олон улсын хүчин чармайлтыг бололцоогоороо дэмжинэ;

(в) хөгжиж буй болон шилжилтийн эдийн засагтай орнуудын, ялангуяа санхүү хийгээд техникийн талаарх хэрэгцээ шаардлагыг харгалзаж, (а), (б) дэд заалтад дурдсан хүч чармайлтыг хэрэгжүүлэхэд оролцох чадавхийг нь бэхжүүлэх талаар хамтран ажиллана;

(г) удаан задардаг органик бохирдуулагчаас нөхөн үржихүйн эрүүл мэндэд үзүүлдэг нөлөөллийг бууруулах талаар судалгаа хийнэ;

(д) судлах, боловсруулах, ажиглалт хийх талаар энэхүү заалтад дурдсан үйл ажиллагааны үр дүнтэй цаг тухайд нь танилцах боломжийг

олон нийтэд байнга олгоно;

(е) шинжилж судлах, боловсруулах болон ажиглалт хийх явцад гарсан мэдээллийг хадгалах, баяжуулах талаар хамтран ажиллах буюу тийнхүү хамтран ажиллах явдлыг дэмжинэ.

Арван хоёрдугаар зүйл
Техникийн тусламж

1. Хөгжиж буй болон шилжилтийн эдийн засагтай орон – Талуудын хүсэлтээр техникийн зохих туслалцааг цаг тухайд нь олгож байх нь энэхүү конвенцийг амжилттай хэрэгжүүлэх чухал нөхцөл гэдгийг Талууд хүлээн зөвшөөрч байна.

2. Талууд хөгжиж буй болон шилжилтийн эдийн засагтай орон – Талуудад онцгой хэрэгцээ шаардлагыг нь харгалзан туслах, энэхүү конвенциор хүлээсэн үүргээ биелүүлэх чадавхийг нь хөгжүүлэн бэхжүүлэх үүднээс тэдэнд техникийн зохих туслалцааг цаг тухайд нь үзүүлэх талаар хамтран ажиллана.

3. Хөгжингүй болон бусад орон – Талаас боломж чадавхиа харгалзан үзүүлэх техникийн туслалцаанд энэхүү конвенциор хүлээсэн үүргийг биелүүлэх чадавхийг бэхжүүлэхэд чиглэсэн техникийн тусламжийг харилцан тохиролцсоноор оруулна. Энэ талаар удирдлага болгох нэмэлт чиглэлийг Талуудын бага хурал батлан гаргана.

4. Талууд хөгжиж буй болон шилжилтийн эдийн засагтай орон – Талуудад энэхүү конвенцийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан техникийн туслалцаа үзүүлэх, технологи шилжүүлэхийг дэмжих үүднээс шаардлагатай бол тохиролцоо байгуулна. Тийм тохиролцоонд энэхүү конвенциор хүлээсэн үүргээ биелүүлэхэд нь хөгжиж буй болон шилжилтийн эдийн засагтай орон – Талуудад туслах үндэсний чадавхийг бэхжүүлэх, технологи шилжүүлэх бүсийн болон салбар бүсийн төвүүд хамаарна. Энэ талаар удирдлага болгох нэмэлт чиглэлийг Талуудын бага хурал батлан гаргана.

5. Талууд техникийн туслалцааны талаар арга хэмжээ авахдаа нэн буурай хөгжилтэй болон арлын хөгжиж буй жижиг орнуудын онцлог хэрэгцээ шаардлага, онцгой байдлыг энэ зүйлийн хувьд бүрэн харгалзан үзнэ.

Арван гуравдугаар зүйл
Санхүүгийн эх сурвалж, механизм

1. Тал бүр энэхүү конвенцийн зорилгыг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг үндэсний төлөвлөгөө, тэргүүлэх зорилт, хөтөлбөрийн дагуу санхүүгийн талаар бололцооны хэрээр дэмжиж урамшуулна.

2. Энэхүү конвенциор хүлээсэн үүргээ бүрэн биелүүлэхэд гарах тохиролцсон нэмэлт бүх зардлыг нөхөх боломжийг хөгжиж буй болон шилжилтийн эдийн засагтай орон – Талуудад олгох үүднээс хөгжингүй орон – Талууд санхүүгийн шинэ нэмэлт хөрөнгийг тусламж авч буй Тал болон 6 дугаар заалтад дурдсан механизмд оролцож буй этгээдийн хооронд тохиролцсоны дагуу гаргана. Бусад тал санхүүгийн тийм хөрөнгийг өөрийн боломжийн дагуу сайн дурын үндсэн дээр олгож болно. Бусад эх сурвалжаас хандив оруулах явдлыг дэмжинэ. Эдгээр үүргийг биелүүлэхэд үзүүлэх санхүүгийн туслалцаа нь хүрэлцэхүйц, урьдчилан тооцож болохуйц, цаг үеэ олсон, хандив оруулж буй Талуудын санхүүгийн үүрэг хариуцлага нь тэнцвэртэй байхын чухлыг тус тус харгалзана.

3. Энэхүү конвенциор хүлээсэн үүргийг биелүүлэхтэй холбогдуулан хөгжингүй болон бусад орон - Талаас өөрсдийн боломж, үндэсний төлөвлөгөө, тэргүүлэх зорилт, хөтөлбөрөө харгалзан үзүүлж болох болон хөгжиж буй болон шилжилтийн эдийн засагтай орон – Талуудын авах санхүүгийг туслалцааг хоёр талын, бүсийн болон олон талын бусад сурвалж буюу сувгаар дамжуулж болно.

4. Хөгжиж буй орон – Талуудаас энэхүү конвенциор хүлээсэн үүргээ хэр зэрэг биелүүлэх нь хөгжингүй орон – Талууд санхүүгийн болон техникийн туслалцаа үзүүлэх, технологи шилжүүлэх талаар конвенциор хүлээсэн үүргээ хэр зэрэг биелүүлэхээс хамаарна. Хөгжиж буй орон – Талуудын хувьд нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах, ядуурлыг арилгах нь нэн тэргүүний бөгөөд хамгаас чухал зорилго болохыг бүрэн харгалзахын хамт хүний эрүүл мэнд, байгаль орчныг хамгаалахад зохих ёсоор анхаарна.

5. Талууд санхүүжилтийн талаар арга хэмжээ авахдаа нэн буурай хөгжилтэй болон арлын хөгжиж буй жижиг орнуудын онцлог хэрэгцээ шаардлага, онцгой байдлыг бүрэн анхаарч үзнэ.

6. Энэхүү конвенцийг хэрэгжүүлэхэд нь туслах үүднээс хөгжиж буй болон шилжилтийн эдийн засагтай орон – Талуудад санхүүгийн хүрэлцэхүйц бөгөөд тогтвортой хөрөнгийг буцалтгүйгээр буюу хөнгөлөлттэй нөхцлөөр олгох механизмыг үүгээр тогтоож

байна. Энэхүү механизм нь Талуудын бага хурлын ерөнхий удирдлага, шаардлагатай бол тодорхой чиглэлийн дор үйл ажиллагаагаа явуулах бөгөөд ажлаа Бага хуралд тайлагнана. Механизмын үйл ажиллагааг Талуудын бага хурлаас батлан гаргах шийдвэрийн үндсэн дээр нэг буюу хэд хэдэн этгээдэд, түүний дотор үйл ажиллагаагаа явуулж байгаа олон улсын байгууллагуудад хариуцуулна. Механизм нь олон талын, бүсийн болон хоёр талын шугамаар санхүүгийн болон техникийн туслалцаа үзүүлдэг бусад этгээдийг хамарч болно. Механизмд оруулах хандив нь хөгжиж буй болон шилжилтийн эдийн засагтай орон – Талуудад 2 дугаар заалтын дагуу олгож байгаа санхүүгийн бусад хөрөнгөд нэмэлт дэмжлэг болно.

7. Талуудын бага хурал энэхүү конвенцийн зорилго болон 6 дугаар заалтын дагуу уг механизмын үйл ажиллагаанд удирдлага болгох чиглэлийг анхдугаар хуралдаанаараа баталж, түүнийг хүчин төгөлдөр болгох журмын талаар санхүүгийн механизмд оролцож буй этгээд буюу этгээдүүдтэй тохирно. Чиглэл нь, тухайлбал дараах асуудлуудыг зохицуулна:

(а) бодлого, стратеги болон хөтөлбөрийн тэргүүлэх зорилтууд, түүнчлэн санхүүжилт авах, түүнийг хэрэглэх дэлгэрэнгүй бөгөөд тодорхой шалгуур, зөвлөмжийг тодорхойлох, түүний дотор хөрөнгийн ашиглалтыг тогтмол хянаж, үнэлж дүгнэх;

(б) энэхүү конвенцийг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааны санхүүжилт нь хангалттай бөгөөд тогтвортой байгаа эсэх талаар санхүүгийн механизмд оролцож буй этгээд буюу этгээдүүдээс Талуудын бага хуралд тогтмол илтгэл бэлтгэн тавих;

(в) санхүүжилтийн олон сурвалжийг олж ашиглах арга зам, механизм, тохиролцоог дэмжих;

(г) энэхүү конвенцийг хэрэгжүүлэхэд шаардлагатай бөгөөд бэлэн байгаа санхүүжилтийн хэмжээг аль болох үнэн зөвөөр тодорхойлох арга зам, хэлбэр. Чингэхдээ удаан задардаг органик бохирдуулагчийг шахан зайлуулах нь удаан хугацааны тогтвортой санхүүжилт болон түүнийг үе үе хянан үзэхийг шаардаж болзошгүйг харгалзах;

(д) Зохицуулалтад нь тус дөхөм үзүүлэх үүднээс санхүүгийн бэлэн байгаа сурвалж болон санхүүжилтийг хэрэгжүүлж буй байдлын тухай мэдээллийг санхүүгийн хэрэгцээ шаардлагын тухай мэдээний хамт сонирхсон Талуудад өгөх.

8. Талуудын бага хурал энэхүү зүйлийн дагуу байгуулж буй механизмын үр өгөөж, түүнээс хөгжиж буй болон шилжилтийн эдийн засагтай орон – Талуудын өөрчлөгдөж буй хэрэгцээ шаардлагыг хангаж

буй байдал, 7 дугаар заалтад дурдсан шалгуур, чиглэл, санхүүжилтийн түвшин, түүнчлэн санхүүгийн механизмыг ажиллуулах үүрэг хүлээсэн байгууллагуудын үйл ажиллагааны үр дүнг хоёр дахь хуралдаанаасаа хэтрэлгүй хянаж эхэлж, түүнээс хойш тогтмолжуулна.

Арван дөрөвдүгээр зүйл
Санхүүгийн түр тохиролцоо

Байгаль орчны Өөрчлөн байгуулсан дэлхий дахины Санг бий болгох тухай батламж бичгийн дагуу ажиллаж буй Байгаль орчны дэлхий дахины Сан нь энэхүү конвенц хүчин төгөлдөр болох үеэс Талуудын Бага хурлын анхны хуралдаан болох хүртэл буюу Талуудын бага хурал 13 дугаар зүйлийн дагуу зохион байгуулалтын холбогдох бүтцийг томилох хүртэл 13 дугаар зүйлд заасан санхүүжилтийн механизмын үүргийг түр гүйцэтгэнэ. Байгаль орчны дэлхий дахины Сан удаан задардаг органик бохирдуулагчийн талаар тухайлсан арга хэмжээ авах замаар энэхүү үүргээ гүйцэтгэнэ. Чингэхдээ энэ салбарт шинэ тохиролцоо шаардагдаж болзошгүйг харгалзана.

Арван тавдугаар зүйл

Илтгэл мэдээлэл

1. Тал бүр энэхүү конвенцийн заалтуудыг хэрэгжүүлэхээр авч буй арга хэмжээ болон тэдгээр арга хэмжээ нь хэр үр дүнтэй байгаа талаар Талуудын Бага хуралд тайлагнана.

2. Тал бүр Нарийн бичгийн дарга нарын газарт доорх зүйлийг хүргүүлнэ. Үүнд:

(а) Хавсралт А, Б-д дурдсан химийн бодис тус бүрийн үйлдвэрлэсэн, импортлосон, экспортлосон нийт хэмжээний тухай статистикийн тоо баримт буюу тийм мэдээллийн үнэлгээ;

(б) тийм химийн бодисыг импортоор авсан болон экспортлосон орнуудын жагсаалт.

3. Тайлангийн хугацаа, форматыг Талуудын Бага хурлын анхдугаар хуралдаанаас тогтооно.

Арван зургадугаар зүйл
Үнэлгээ

1. Талуудын Бага хурал энэхүү конвенц хүчин төгөлдөр болсноос хойш дөрөв дэх жилээс нь эхлэн, цаашдаа Бага хурлаас тогтоох хугацаанд конвенцийн үр дүнг тогтмол үнэлж байна.

2. Үнэлгээг хийхэд тус дөхөм үзүүлэх үүднээс болон Хавсралт А, Б, В-д дурдсан химийн бодис болон тэдгээрийн бүс нутаг хийгээд дэлхий дахинаа тархсан байдлын тухай хяналтын харьцуулсан мэдээлэлтэй болохын тулд Талуудын бага хурал анхны хуралдаанаараа зохих тохиролцоог санаачилна. Тохиролцоо нь:

(а) шаардлагатай бол бүсийн хэмжээнд хэрэгжихээр байх бөгөөд Талуудын техникийн болон санхүүгийн бололцоонд түшиглэсэн, хэрэгжүүлж байгаа хөтөлбөр, хяналтын механизмыг бүрэн хэмжээгээр ашиглах, холбогдох арга зам, хандлагуудыг уялдуулан зохицуулах явдлыг дэмжихэд чиглэсэн байна;

(б) шаардлагатай бол нэмэлт өөрчлөлт оруулж болохоор байна. Чингэхдээ бүс хоорондын ялгаа, тэдгээрээс хяналт хийх чадавхийг нь харгалзан үзнэ;

(в) бүсийн болон дэлхий дахины хэмжээнд Талуудын бага хурлаас тогтоох хугацаанд явуулах хяналтын дүнгийн талаар Талуудын Бага хуралд тавих илтгэлийг хамарна.

3. Энэ зүйлийн 1 дүгээр заалтад дурдсан үнэлгээг шинжлэх ухаан, байгаль орчин, техник, эдийн засгийн түүний дотор дараах мэдээллийн үндсэн дээр гаргана. Үүнд:

(а) 2 дугаар заалтын дагуу гаргах тайлан болон хяналтын бусад мэдээлэл;

(б) 15 дугаар зүйлийн дагуу өгөх үндэсний илтгэл; болон

(в) конвенц биелэгдээгүй талаар 17 дугаар зүйлээр тогтоох горимын дагуу өгөх мэдээлэл.

Арван долдугаар зүйл
Конвенц биелэгдэхгүйд

Талуудын Бага хурал энэхүү конвенцийн заалтуудыг хэрэгжүүлээгүй нөхцөл байдлыг тогтоох болон конвенцийг биелүүлээгүй Талын талаар авах арга хэмжээг тодорхойлох журам, зохион байгуулалтын механизмыг аль болох даруй боловсруулан батлана.

Арван наймдугаар зүйл
Маргааныг зохицуулах

1. Талууд энэхүү конвенцийг тайлбарлах, хэрэглэх талаар гарсан аливаа маргааныг хэлэлцээр буюу сонгосон бусад арга замаар эв зүйгээр зохицуулна.

2. Эдийн засгийн хамтын ажиллагааны бүсийн байгууллагаас өөр Тал энэхүү Конвенцийг соёрхон батлах, хүлээн авах, батлах буюу түүнд нэгдэн орох үедээ буюу түүнээс хойш конвенцийг тайлбарлах, хэрэглэх талаар гарсан аливаа маргаантай холбогдуулан дараах хоёр аргын аль нэгийг буюу хоёуланг нь шийдвэрийг нь заавал биелүүлэх үүрэг хүлээсэн аливаа Талын хувьд хүлээн авахаа Хадгалагчид бичгээр мэдэгдэж болно:

(а) Талуудын Бага хурлаас аль болох даруй хавсралтаар батлах горимын дагуу явагдах арбитраж;

(б) маргааныг Олон улсын Шүүхэд шилжүүлэх.

3. Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс нутгийн байгууллага - Тал 2(а) заалтад дурдсан горимын дагуу явагдах арбитражийн хувьд дээрх мэдэгдлийг хийж болно:

4. энэ зүйлийн 2 буюу 3 дугаар заалтын дагуу хийсэн мэдэгдэл нь нөхцлийнхөө хугацаа дуустал буюу түүнийг цуцалсан талаар Хадгалагчид бичгээр мэдэгдэл өгснөөс хойш 3 сарын хугацаа өнгөртөл хүчин төгөлдөр байна.

5. Мэдэгдлийн хугацаа дууссан, түүнийг цуцалсан буюу шинэ мэдэгдэл хийсэн зэрэг нь Талууд өөрөөр тохироогүй бол арбитраж буюу Олон улсын шүүхийн явцад нөлөөлөхгүй.

6. Хэрэв маргалдаж буй Талууд 2 дугаар заалтын дагуу буюу түүнд дурдсаны адил журмыг хүлээн аваагүй буюу хооронд нь маргаан байгаа гэдгийг нэг Тал нь нөгөө Талдаа мэдэгдсэнээс хойш 12 сарын дотор маргаанаа зохицуулж чадаагүй бол уг маргааныг аль нэг талын нь хүсэлтээр Эвлэрүүлэх комисст шилжүүлнэ. Эвлэрүүлэх комисст нь зөвлөмж бүхий илтгэл гаргана. Эвлэрүүлэх комисст холбогдох нэмэлт горимыг Талуудын Бага хурлын 2 дугаар хуралдаанаас хэтрэлгүйгээр хавсралтаар батлан гаргана.

Арван есдүгээр зүйл

Талуудын Бага хурал

1. Үүгээр Талуудын Бага хурлыг зохион байгуулав.

2. Талуудын Бага хурлын анхдугаар хуралдааныг энэхүү конвенц хүчин төгөлдөр болсноос хойш нэг жилээс хэтрэлгүйгээр НҮБ-ын Байгаль орчны Хөтөлбөрийн Гүйцэтгэх Захирал хуралдуулна.

Цаашид Талуудын Бага хурлын ээлжит хуралдааныг Бага хурлаас тогтоох хугацаанд зарлан хуралдуулна.

3. Талуудын Бага хурлын ээлжит бус хуралдааныг Бага хурлаас шаардлагатай гэж үзсэн үед буюу оролцогч Талуудын наад зах нь гуравны нэгний дэмжлэг авсан аливаа Талын бичгээр ирүүлсэн хүсэлтийн дагуу хуралдуулна.

4. Талуудын Бага хурал нь анхныхаа хуралдаанаар өөрийн болон туслах байгууллагуудынхаа горим, санхүүгийн дүрэм, мөн түүнчлэн Нарийн бичгийн дарга нарын газрын үйл ажиллагаанд удирдлага болох санхүүгийн заалтуудыг консенсусаар тохирч батална.

5. Талуудын Бага хурал нь энэхүү конвенцийн биелэлтийг байнга хянан үнэлж дүгнэнэ. Мөн конвенциор хүлээлгэсэн үүргийг биелүүлэх бөгөөд үүний тулд:

(а) энэхүү конвенцийг хэрэгжүүлэхэд шаардлагатай гэж үзсэн туслах байгууллагуудыг 6 дугаар заалтын дагуу байгуулна;

(б) эрх бүхий олон улсын байгууллагууд, засгийн газар хоорондын болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллана;

(в) 15 дугаар зүйлийн дагуу Талуудад толилуулж буй бүх мэдээлэл, түүний дотор 3 дугаар зүйлийн 2 (б) (iii) заалтын үр дүнг тогтмол хянан үзнэ;

(г) конвенцийн зорилгод хүрэхэд шаардагдах нэмэлт арга хэмжээг хэлэлцэж хэрэгжүүлнэ.

6. Энэхүү Конвенцаар хүлээлгэсэн үүргийг нь гүйцэтгүүлэхийн тулд Талуудын Бага хурал анхныхаа хуралдаанаар Удаан задардаг органик бохирдуулагчийн асуудлаарх Хороо хэмээх туслах байгууллагыг байгуулна. Үүнтэй холбогдуулан:

(а) Удаан задардаг органик бохирдуулагчийн асуудлаарх Хорооны гишүүдийг Талуудын Бага хурлаас томилно. Гишүүд нь химийн салбарт үнэлгээ буюу удирдлагын чиглэлээр мэргэжсэн, засгийн газраас томилсон мэргэжилтнүүд байна. Хорооны гишүүдийг газар зүйн тэгш хуваарилалтын үндсэн дээр томилно.

(б) Талуудын Бага хурал нь Хорооны горим, зохион байгуулалт, үйл ажиллагааны талаар шийдвэр гаргана.

(в) Хороо нь зөвлөмжөө консенсусын үндсэн дээр гаргах талаар хүч чармайлт тавина. Хэрэв консенсуст хүрэх бүх арга зам барагдаж, консенсуст хүрч чадаагүй бол зөвлөмжөө байлцан санал өгч буй гишүүдийн гуравны хоёрын саналаар батлан гаргана.

7. Талуудын Бага хурал 3 дахь хуралдаанаараа 3 дугаар зүйлийн 2 (б) заалтад дурдсан журам шаардлагатай хэвээр байгаа эсэхийг үр

дүнгийн нь хамт үнэлж дүгнэнэ.

8. НҮБ, түүний төрөлжсөн байгууллагууд, Олон улсын атомын энергийн Агентлаг, мөн түүнчлэн конвенцид оролцоогүй улс Талуудын Бага хуралд ажиглагчаар оролцож болно. Мөн конвенцид хамаарах асуудлаар үйл ажиллагаа явуулдаг бөгөөд Талуудын Бага хуралд ажиглагчаар оролцох хүсэлтээ Нарийн бичгийн дарга нарын газарт тавьсан үндэсний болон олон улсын, засгийн газар хоорондын болон төрийн бус байгууллагуудыг Талуудын гуравны нэгээс багагүй нь дэмжсэн тохиолдолд Талуудын Бага хуралд оролцуулж болно.

Хорьдугаар зүйл
Нарийн бичгийн дарга нарын газар

1. Үүгээр Нарийн бичгийн дарга нарын газрыг байгуулав.
2. Нарийн бичгийн дарга нарын газар доорх үүргийг гүйцэтгэнэ.

Үүнд:

(а) Талуудын Бага хурал, түүний туслах байгууллагуудын хуралдааны бэлтгэлийг хангах, шаардлагатай үйлчилгээ үзүүлэх;

(б) Энэхүү конвенциор хүлээсэн үүргээ биелүүлэхэд нь хөгжиж буй болон шилжилтийн эдийн засагтай орон - Талуудад хүсэлтийнх нь дагуу туслах;

(в) Олон улсын холбогдох бусад байгууллагын Нарийн бичгийн дарга нарын газартай шаардлагатай зохицуулалт хийх;

(г) 15 дугаар зүйлийн дагуу хүлээн авсан болон байгаа бусад мэдээлэл дээр үндэслэн үе үе илтгэл бэлтгэж, Талуудад хүргүүлэх;

(д) Үүргээ үр дүнтэй биелүүлэхэд нь шаардагдах аж ахуйн болон гэрээт тохиролцоог Талуудын Бага хурлын ерөнхий чиглэлийн дор байгуулах;

(е) Энэхүү конвенцид заасан нарийн бичгийн даргын газрын бусад ажил болон Талуудын Бага хурлаас тогтоож болох бусад үүргийг гүйцэтгэх.

3. Хэрэв Талуудын Бага хурал байлцан санал өгч буй гишүүдийнхээ дөрөвний гурвын саналаар нарийн бичгийн дарга нарын газрын үүргийг олон улсын өөр ямар нэг буюу хэд хэдэн байгууллагад хариуцуулахаар шийдвэрлээгүй л бол НҮБ-ын Байгаль орчны Хөтөлбөрийн Гүйцэтгэх захирал тус нарийн бичгийн дарга нарын газрын үүргийг гүйцэтгэнэ.

Хорин нэгдүгээр зүйл.

Конвенцид нэмэлт өөрчлөлт оруулах

1. Аль ч Тал энэхүү конвенцид нэмэлт өөрчлөлт оруулах санал тавьж болно.

2. Энэхүү конвенцид оруулах нэмэлт өөрчлөлтийг Талуудын Бага хурлын хуралдаанаар батална. Нэмэлт өөрчлөлтийн тухай саналыг Нарийн бичгийн дарга нарын газар уг нэмэлт өөрчлөлтийг хэлэлцэн батлах хуралдаан болохоос 6 сараас доошгүй хугацааны өмнө Талуудад тараана. Нэмэлт өөрчлөлтийн тухай саналыг Нарийн бичгийн дарга нарын газар мөн конвенцид гарын үсэг зурсан Талуудад болон конвенцийг Хадгалагчид танилцуулахаар хүргүүлнэ.

3. Талууд Конвенцид оруулах нэмэлт өөрчлөлтийн талаар консенсуст хүрэх талаар хүч чармайлт тавина. Консенсуст хүрэх бүх арга зам барагдаж, түүнд хүрч чадаагүй бол нэмэлт өөрчлөлтийг байлцан санал өгч буй Талуудын дөрөвний гурвын саналаар батлана.

4. Нэмэлт өөрчлөлтийг Хадгалагч соёрхон батлуулах, хүлээн авахуулах буюу батлуулахаар бүх Талд хүргүүлнэ.

5. Нэмэлт өөрчлөлтийг соёрхон баталсан, хүлээн авсан буюу баталсныг Хадгалагчид бичгээр мэдэгдэнэ. 3 дугаар заалтын дагуу баталсан нэмэлт өөрчлөлт нь түүнийг хүлээн авсан Талуудын дөрөвний гурваас доошгүй нь нэмэлт өөрчлөлтийг соёрхон баталсан, хүлээн авсан, баталсан тухай батламж бичгээ Хадгалагчид хадгалуулснаас хойш 90 дэх хоногоос хүчин төгөлдөр болно. Түүнээс хойш соёрхон баталсан, хүлээн авсан, баталсан Талын хувьд холбогдох батламж бичгийг Хадгалагч хүлээн авснаас хойш 90 дэх өдөр хүчин төгөлдөр болно.

Хорин хоёрдугаар зүйл

Хавсралтыг батлах, түүнд нэмэлт өөрчлөлт оруулах

1. Энэхүү конвенцийн Хавсралт нь конвенцийн салшгүй хэсэг байх бөгөөд түүнд өөрөөр заагаагүй бол конвенциос иш татах нь түүний хавсралтаас иш татсантай адил байх болно.

2. Нэмэлт Хавсралт нь горимын, шинжлэх ухаан, техникийн буюу зохион байгуулалтын асуудлуудыг хамарна.

3. Энэхүү конвенцид Хавсралт нэмэхийг санал болгох, хавсралтыг батлах, хүчин төгөлдөр болгоход дараах журмыг мөрдөнө. Үүнд:

(а) Нэмэлт хавсралтыг 21 дүгээр зүйлийн 1, 2, 3 дугаар заалтад тусгасан журмын дагуу санал болгож батлана;

(б) Нэмэлт хавсралтыг хүлээн авах боломжгүй аливаа Тал хавсралтыг баталсан тухай Хадгалагчаас мэдээлэл авснаасаа хойш 1 жилийн дотор энэ тухайгаа Хадгалагчид бичгээр мэдэгдэнэ. Хадгалагч мэдэгдлийг хүлээн авсан даруйдаа бүх Талд уламжилна. Аливаа Тал хүлээн авах боломжгүй талаар өмнө нь хийсэн мэдэгдлээ хэзээ ч цуцалж болох бөгөөд чингэхэд хавсралт тухайн Талын хувьд мэдэгдэл хийсэн үеэс эхлэн /в/ дэд заалтын дагуу хүчин төгөлдөр болно;

(в) Нэмэлт хавсралт нь түүнийг баталсан тухай Хадгалагч мэдэгдэл тарааснаас хойш нэг жилийн дараа (б) дэд заалтын дагуу мэдэгдэл хийгээгүй бүх Талын хувьд хүчин төгөлдөр болно.

4. Хавсралт А, Б буюу В-д нэмэлт өөрчлөлт оруулахыг санал болгох, нэмэлт өөрчлөлтийг батлах, хүчин төгөлдөр болгохдоо энэхүү конвенцид хавсралт нэмэхийг санал болгох, хавсралтыг батлах, хүчин төгөлдөр болгоход баримталдгийн адил журмыг мөрдөнө. Гагцхүү Хавсралт А, Б буюу В-д оруулсан нэмэлт өөрчлөлт нь тэдгээр хавсралтад оруулсан нэмэлт өөрчлөлтийн талаар 25 дугаар зүйлийн 4 дүгээр заалтын дагуу мэдэгдэл хийсэн Талын хувьд хүчин төгөлдөр болохгүй. Тийм мэдэгдэл хийсэн Талын хувьд хавсралтад оруулсан нэмэлт өөрчлөлт нь түүнийг соёрхон баталсан, хүлээн авсан, баталсан буюу түүнд нэгдэн орсон тухай батламж бичгээ Хадгалагчид хадгалуулснаас хойш 90 хоногийн дараа хүчин төгөлдөр болно.

5. Хавсралт Г, Д буюу Е-д нэмэлт өөрчлөлт оруулахыг санал болгох, нэмэлт өөрчлөлтийг батлах, хүчин төгөлдөр болгохдоо доорх журмыг баримтална:

(а) нэмэлт өөрчлөлтийг 21 дүгээр зүйлийн 1, 2 дугаар заалтад тусгасан горимын дагуу санал болгоно;

(б) Талууд хавсралт Г, Д буюу Е –д оруулах нэмэлт өөрчлөлтийн тухай шийдвэрийг консенсусаар гаргана;

(в) Хавсралт Г, Д буюу Е –д оруулах нэмэлт өөрчлөлтийн тухай шийдвэрийг Хадгалагч Талуудад хүргэнэ. Нэмэлт өөрчлөлт шийдвэрт заасан хугацаанд бүх Талын хувьд хүчин төгөлдөр болно.

6. Хэрэв нэмэлт хавсралт буюу хавсралтад оруулах нэмэлт өөрчлөлт нь энэхүү конвенцид оруулах нэмэлт өөрчлөлттэй холбоотой бол нэмэлт хавсралт буюу нэмэлт өөрчлөлт нь энэхүү конвенцид оруулсан нэмэлт өөрчлөлт хүчин төгөлдөр болох үед хүчин төгөлдөр болно.

Хорин гуравдугаар зүйл
Санал өгөх эрх

1. Энэхүү конвенцид оролцогч Тал бүр энэ зүйлийн 2 дугаар заалтад дурдсанаас бусад тохиолдолд нэг санал өгнө.

2. Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс нутгийн байгууллага нь эрх хэмжээнийхээ асуудлаар санал өгөх эрхтэй бөгөөд саналын тоо нь түүний энэхүү конвенцид оролцогч гишүүн улсууд - Талуудын тоотой тэнцүү байна. Тийм байгууллага гишүүн аль нэг улс нь санал өгөх эрхээ эдлэхэд санал өгөхгүй, байгууллага нь санал өгөх эрхээ эдэлж байхад гишүүн улсууд нь санал өгөхгүй.

Хорин дөрөвдүгээр зүйл
Гарын үсэг зурах

Энэхүү конвенц нь 2001 оны 5 дугаар сарын 23-нд Стокгольмд, 2001 оны 5 дугаар сарын 24-нөөс 2002 оны 5 дугаар сарын 22 –нд Нью-Йорк дахь НҮБ-ын Төв байранд бүх улс, эдийн засгийн хамтын ажиллагааны бүс нутгийн байгууллагууд гарын үсэг зурахад нээлттэй байна.

Хорин тавдугаар зүйл
Соёрхон батлах, хүлээн авах, батлах буюу нэгдэн орох

1. Энэхүү конвенцийг улс орнууд болон эдийн засгийн хамтын ажиллагааны бүс нутгийн байгууллагууд соёрхон баталж, хүлээн авч батална. Конвенц нь түүнд гарын үсэг зурах явдал хаагдсаны дараа өдрөөс нь эхлэн улс орнууд болон эдийн засгийн хамтын ажиллагааны бүс нутгийн байгууллагууд нэгдэн ороход нээлттэй байна. Конвенцийг соёрхон батлах, хүлээн авах, батлах буюу түүнд нэгдэн орох тухай батламж бичгүүд нь Хадгалагчид хадгалагдана.

2. Аль ч гишүүн орон нь оролцогч Тал болоогүй байхад энэхүү конвенцид оролцогч болж байгаа эдийн засгийн хамтын ажиллагааны бүс нутгийн байгууллага конвенцид заасан бүхий л үүргийг биелүүлнэ. Нэг буюу хэд хэдэн гишүүн орон нь конвенцийн тал байх тийм байгууллагын хувьд конвенциор хүлээсэн үүргээ биелүүлэх талаар хэн нь ямар хариуцлага хүлээх талаар байгууллага ба түүний гишүүн орнууд хэлэлцэн шийдвэрлэнэ. Байгууллага болон түүний гишүүн орнууд конвенцийн дагуу эдлэх эрхээ давхардан хэрэгжүүлэхгүй.

3. Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс нутгийн байгууллага нь конвенцийг соёрхон батлах, хүлээн авах, батлах буюу нэгдэн орох батламж бичигтээ конвенциор зохицуулагдах асуудлын талаар эдлэх эрх хэмжээнийхээ хүрээг заана. Байгууллага эрх хэмжээнийхээ хүрээнд гарсан холбогдох өөрчлөлтийн талаар Хадгалагчид мэдээлж, тэр нь цааш Талуудад мэдэгдэнэ.

4. Аливаа тал конвенцийг соёрхон батлах, хүлээн авах, батлах буюу нэгдэн орох батламж бичигтээ А, Б, буюу В-д оруулсан нэмэлт өөрчлөлт нь түүний хувьд холбогдох батламж бичгээ Хадгалагчид өгснөөр хүчин төгөлдөр болно гэж мэдэгдэж болно.

Хорин зургадугаар зүйл
Хүчин төгөлдөр болох

1. Энэхүү конвенц түүнийг соёрхон баталсан, хүлээн авсан, баталсан буюу нэгдэн орсон тухай 50 дахь батламж бичгийг хадгалуулахаар өгсөний дараа өдрөөс хойш 90 дэх хоногоос хүчин төгөлдөр болно.

2. Энэхүү конвенц нь түүнийг соёрхон баталсан, хүлээн авсан, баталсан буюу нэгдэн орсон тухай 50 дахь батламж бичгийг хадгалуулахаар өгснөөс хойш соёрхон баталж, хүлээн авч, баталж буюу нэгдэж байгаа улс орон, эдийн засгийн хамтын ажиллагааны бүс нутгийн байгууллагын хувьд тухайн улс, байгууллага холбогдох батламж бичгээ хадгалуулахаар өгснөөс хойш 90 дэх хоногоос хүчин төгөлдөр болно.

3. Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс нутгийн байгууллагаас хадгалуулахаар өгсөн аливаа батламж бичгийг 1, 2 дугаар заалтын зорилгын үүднээс тухайн байгууллагын гишүүн орнуудаас хадгалуулахаар өгсөн баримт бичгийн нэмэлт гэж үзэхгүй.

Хорин долдугаар зүйл
Тайлбар

Энэхүү конвенцид тайлбар хийж болохгүй.

Хорин наймдугаар зүйл
Конвенциос гарах

1. Тал нь энэхүү конвенц өөрийн нь хувьд хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 3 жил өнгөрсний дараа Хадгалагчид бичгээр мэдэгдэл өгөн

конвенциос гарч болно.

2. Хадгалагч гарах мэдэгдлийг хүлээн авснаас хойш нэг жил өнгөрсний дараа буюу гарах мэдэгдэлд заасан хугацаа өнгөрөхөд конвенц тухайн талд үйлчлэхээ болино.

Хорин есдүгээр зүйл

Хадгалагч

НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга энэхүү конвенцийн Хадгалагч байна.

Гучдугаар зүйл

Адил хүчинтэй байх бичвэрүүд

Энэхүү конвенцийн англи, араб, испани, хятад, орос, франц хэлээр үйлдэгдсэн, адил хүчинтэй эхүүд нь НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалагдана.

ДЭЭРХИЙГ НОТОЛЖ доорх нэр бүхий төлөөлөгчид бүрэн эрхийнхээ дагуу энэхүү Конвенцид гарын үсэг зурав.

Хоёр мянга нэгэн оны тавдугаар сарын хоринхоёр дахь өдөр Стокгольмд үйлдэв.

Хавсралт А

УСТГАХ

I Хэсэг

Химийн бодис	Үйл ажиллагаа	Тусгай нөхцөл
Альдрин* CAS№ 309-00-2	үйлдвэрлэл	Байхгүй
	хэрэглээ	Орон нутгийн эктопаразит Инсектицид

Хлорден* CAS № 57-74-9	үйлдвэрлэл	Бүртгэлд орсон Талуудад зөвшөөрөгдсөнөөр
	хэрэглээ	Орон нутгийн эктопаразитицид Инсектицид Термитицид Байшин барилга, гүүр далангийн термитицид Засмал замын термитицид Наамал банз, сарампайн цавууны нэмэлт
Дилдрин* CAS № 60-57-1	үйлдвэрлэл	Байхгүй
	хэрэглээ	ХАА-н үйл ажиллагаанд
Эндрин* CAS №72-20-8	үйлдвэрлэл	Байхгүй
	хэрэглээ	Байхгүй
Гептахлор* CAS № 76-44-8	үйлдвэрлэл	Байхгүй
	хэрэглээ	Термитицид Барилгын хийцийн термитицид Термитицид (хөрсний) Ой модыг арчлах Газар доорхи кабель шугамын ашиглалт
Гексахлорбензол CAS №118-74-1	үйлдвэрлэл	Бүртгэлд орсон Талуудад зөвшөөрөгдсөнөөр
	хэрэглээ	Завсрын бүтээгдэхүүн Пестицидийн уусгагч Завсрын бүтээгдэхүүнийг хязгаарласан битүү системийн хэсэг
Мирекс* CAS№2385-85-5	үйлдвэрлэл	Бүртгэлд орсон Талуудад зөвшөөрөгдсөнөөр
	хэрэглээ	Термитицид
Токсафен* CAS№ 8001-35-2	үйлдвэрлэл	Байхгүй
	хэрэглээ	Байхгүй
Полихлорт бифенил (PCB)	үйлдвэрлэл	Байхгүй
	хэрэглээ	Энэхүү хавсралтын II хэсэгт заагдсан нөхцөлд хэрэглэнэ

Тайлбар:

(i) Энэхүү конвенцид өөрөөр заагаагүй л бол бүтээгдэхүүн болон эд зүйлст зориудын бус микробохирдуулагчийн хэлбэрээр байх химийн бодис энэхүү Хавсралтад хамаарахгүй.

(ii) Энэхүү тайлбар 3 дугаар зүйлийн 2 дугаар заалтын зорилгын хувьд үйлдвэрлэл, хэрэглээний талаарх тусгай зөвшөөрөлд хамаарахгүй. Тухайн бодисын хувьд хүлээх үүрэг хүчин төгөлдөр болох үед буюу өмнө нь үйлдвэрлэсэн буюу хэрэглэгдэж байгаа бүтээгдэхүүнд байх бодисын хэмжээ нь тухайн бүтээгдэхүүн ашиглагдаж байгаа тухай холбогдох Тал Нарийн бичгийн дарга нарын газарт мэдэгдсэн тохиолдолд энэхүү Хавсралтад хамаарахгүй. Нарийн бичгийн дарга нарын газар тийм мэдээллийг нийтэд хүртээлтэй байлгана.

(iii) Энэ тайлбар нь энэхүү Хавсралтын 1 дүгээр хүснэгтийн “Химийн бодис” баганад одоор тэмдэглэсэн бодисуудад хамаарахгүй бөгөөд 3 дугаар зүйлийн 2 дугаар заалтын зорилгын хувьд үйлдвэрлэл, хэрэглээний талаарх тусгай зөвшөөрөлд тооцогдохгүй. Хаалттай тогтолцоонд, хязгаарлагдмал хүрэн дэх үйлдэрлэл, хэрэглээний явцад байгаа завсрын химийн бодис нь хүн, байгальтай их хэмжээгээр харьцаанд орохгүй гэж үзэж болох тул Орлоцогч Тал энэхүү хавсралтад заасан химийн бодисын тодорхой хэмжээний үйлдвэрлэл, хэрэглээг Хавсралт Г-гийн 1 дүгээр заалтад дурдсан шалгуураар авч үзвэл удаан задардаг органик бохирдуулагчийн шинж чанарыг гаргадаггүй бусад бодисыг үйлдвэрлэх явцад химийн урвалд орж хувирах завсрын химийн бодис мэтээр үзэж, Нарийн бичгийн дарга нарын газарт мэдэгдэн зөвшөөрч болно. Мэдэгдэл нь тухайн химийн бодисын үйлдвэрлэл, хэрэглээний нийт хэмжээний тухай мэдээллийг буюу тийм мэдээллийг үнэлж дүгнэсэн тайлбарыг болон хаалттай тогтолцоонд, хязгаарлагдмал хүрэн дэх үйл явцын шинж чанарын тухай мэдээллийг, түүний дотор эцсийн бүтээгдэхүүн дэх удаан задардаг органик бохирдуулагчийн анхдагч материалын хувираагүй болон зориудын биш микробохирдуулагчийн тоо хэмжээний тухай мэдээллийг тусгасан байна. Энэхүү Хавсралтанд өөрөөр заагаагүй бол энэхүү журмыг хэрэглэнэ. Нарийн бичгийн дарга нарын газар нь мэдэгдлийг Талуудын Бага хурал ба олон нийтэд хүртээлтэй байлгана. Тийм үйлдвэрлэл, хэрэглээг үйлдвэрлэл, хэрэглээний тусгай зөвшөөрөлд хамааруулж үзэхгүй. Холбогдох Тал Нарийн бичгийн дарга нарын газарт шинэ мэдэгдэл өгөн Талуудын Бага хурал тухайн үйлдвэрлэл, хэрэглээг хянан үзэж, өөрөөр шийдээгүйгээс хугацааг нь дахин арван жилээр сунгаагүй л бол, тийм үйлдвэрлэл, хэрэглээг арван

жилийн дараа зогсооно. Мэдэгдлийг давтан өгч болно.

(iv) Энэхүү Хавсралтын тусгай бүх зөвшөөрлийг 4 дүгээр зүйлийн дагуу бүртгүүлсэн Талууд эдэлж болно. Үүнд энэхүү Хавсралтын 2 дугаар хэсгийн заалтын дагуу бүх Тал эдэлж болох бөгөөд хэрэглээнд байгаа бүтээгдэхүүний полихлорт бифенилийг ашиглах явдал хамаарахгүй.

II Хэсэг

Полихлорт бифенил

Оролцогч Тал бүр:

(а) Полихлорт бифенилыг тоног төхөөрөмжид (трансформатор, конденсатор болон шингэн бодис агуулдаг бусад хүлээн авагчид) хэрэглэх явдлыг Талуудын Бага хурлаар хэлэлцэж, 2025 он гэхэд хориглохтой холбогдуулан дараах тэргүүлэх зорилтуудын дагуу арга хэмжээ авна. Үүнд:

(i) 5 литрээс илүү эзэлхүүнтэй, 10 хувиас илүү концентрацитай полихлорт бифенил агуулсан тоног төхөөрөмжийг илрүүлэх, шошголох, хэрэглээнээс гаргах;

(ii) 5 литрээс илүү эзэлхүүнтэй, 0.05 хувиас илүү полихлорт бифенил агуулсан тоног төхөөрөмжийг илрүүлэх, шошголох, хэрэглээнээс гаргах;

(iii) 5 литрээс илүү эзэлхүүнтэй, 0.005 хувиас илүү концентрацитай полихлорт бифенил агуулсан тоног төхөөрөмжийг илрүүлэх, хэрэглээнээс гаргах.

(б) полихлорт бифенилд өртөх, эрсдэх явдлыг бууруулах, түүний хэрэглээнд хяналт тавих зорилгоор (а) дэд заалтад тусгасан зорилтуудын дагуу дараах арга хэмжээ авахыг дэмжинэ:

(i) огт гэмтээгүй, шингэн алдахгүй битүү тоног төхөөрөмжийг зөвхөн байгаль орчинд хаягдах гарц бохирдол нь маш бага байх бөгөөд арилгаж болох газарт л ашиглах;

(ii) хүнс, тэжээл үйлдвэрлэдэг, боловсруулдаг газруудад ашиглахгүй байх;

(iii) сургууль, эмнэлэг бүхий суурин газарт ашиглах тохиолдолд гал түймэр гарахад хүргэж болзошгүй цахилгааны саатлаас сэргийлэх, хамгаалах бүхий л арга хэмжээг авах, битүү сав агууламжийг тогтмол шалгаж байх.

(в) дэд заалт (а)-д дурдсан полихлорт бифенил агуулсан тоног

төхөөрөмжийг байгаль орчинд халгүй зайлуулахаас өөр зориулалтаар экспортлох, импортлохгүй байх; чингэхдээ 3 дугаар зүйлийн 2 дугаар заалтыг харгалзахгүй байна;

(г) 0.005 хувиас дээш концентрац бүхий полихлорт бифенил агуулсан шингэнийг арчилгаа, үйлчилгээнээс өөр бусад зорилгоор ашиглуулахгүй байх;

(д) полихлорт бифенил агуулсан шингэнийг болон 0.005 хувиас дээш концентрац бүхий полихлорт бифенилээр бохирдсон тоног төхөөрөмжийг 6 дугаар зүйлийн 1 дүгээр заалтын дагуу байгаль орчинд халгүйгээр зайлуулах асуудлыг Талуудын Бага хурлаар хэлэлцүүлэн 2028 оноос өмнө аль болох даруй шийдвэрлэх;

(е) 0.005 хувиас дээш концентрац бүхий полихлорт бифенил агуулсан бусад (кабелийн бүрхүүл, хатсан жийргэвч ба будсан эдлэл гэх мэт) зүйлийг илрүүлж, 6 дугаар зүйлийн 1 дүгээр заалтын дагуу арга хэмжээ авах; /энэхүү Хавсралтын I дүгээр хэсгийн (ii) тайлбар хамаарахгүй/

(ё) полихлорт бифенилыг устгах явцын талаар 5 жил тутам илтгэл бэлтгэн 15 дугаар зүйлийн дагуу Талуудын Бага хуралд хүргүүлэх;

(ж) Талуудын Бага хурал полихлорт бифенилтэй холбогдсон асуудлуудыг хянан үзэхдээ (ё)-д заасан илтгэлийг хэлэлцэнэ; Бага хурал полихлорт бифенилийг устгах үйл явцыг 5 жил тутам буюу зохих өөр хугацаанд хянан үзнэ. Чингэхдээ дээр дурдсан илтгэлийг харгалзана.

Хавсралт Б
ХЯЗГААРЛАЛТ
I хэсэг

Химийн бодис	Үйл ажиллагаа	Зөвшөөрөгдөх зориулалт буюу тусгай заалт
--------------	---------------	--

ДДТ [1.1.1-трихлор -2.2-бис (4- хлорфенил)этан] CAS № 50-29-3	Үйлдвэрлэл	Зөвшөөрөгдөх зориулалт: Энэхүү хавсралтын II хэсэгт заасны дагуу өвчний нян тээгчийн хяналтанд ашиглах Тусгай нөхцөл: Дикофолын үйлдвэрлэлд завсрын бүтээгдэхүүн байдлаар Завсрын бүтээгдэхүүн
	Хэрэглээ	Зөвшөөрөгдөх зориулалт: Энэхүү хавсралтын II хэсэгт заасны дагуу өвчний нян тээгчийн хяналт. Тусгай нөхцөл: Дикофолын үйлдвэрлэл Завсрын бүтээгдэхүүн

Тайлбар:

(i) Энэхүү Конвенцид өөрөөр заагаагүй л бол бүтээгдэхүүн болон эд зүйлсэд зориудын биш микробохирдуулагчийн хэлбэрээр орших химийн бодисын тоо хэмжээ энэхүү хавсралтад хамаарахгүй.

(ii) Энэхүү тайлбар 3 дугаар зүйлийн 2 дугаар заалтын зорилгын хувьд үйлдвэрлэл, хэрэглээний талаарх тусгай зөвшөөрөлд хамаарахгүй. Тухайн бодисын хувьд хүлээх үүрэг хүчин төгөлдөр болох үед буюу өмнө нь үйлдвэрлэсэн буюу хэрэглэгдэж байгаа бүтээгдэхүүнд байх бодисын хэмжээ нь тухайн бүтээгдэхүүн ашиглагдаж байгаа тухай холбогдох Тал Нарийн бичгийн дарга нарын газарт мэдэгдсэн тохиолдолд энэхүү хавсралтад хамааахгүй. Нарийн бичгийн дарга нарын газар тийм мэдээллийг нийтэд хүртээлтэй байлгана.

(iii) Энэ тайлбар нь энэхүү хавсралтын 1 дүгээр хүснэгтийн “Химийн бодис” баганад одоор тэмдэглэсэн бодисуудад хамаарахгүй бөгөөд 3 дугаар зүйлийн 2 дугаар заалтын зорилгын хувьд үйлдвэрлэл, хэрэглээний талаарх тусгай зөвшөөрөлд тооцогдохгүй. Хаалттай тогтолцоонд, хязгаарлагдмал хүрэн дэх үйлдвэрлэл, хэрэглээний явцад байгаа завсрын химийн бодис нь хүн, байгальтай их хэмжээгээр харьцаанд орохгүй гэж үзэж болох тул Оролцогч Тал энэхүү хавсралтад заасан химийн бодисын тодорхой хэмжээний үйлдвэрлэл, хэрэглээг хавсралт Г-гийн 1 дүгээр заалтад дурдсан шалгуураар авч үзвэл удаан задардаг органик бохирдуулагчийн шинж чанарыг гаргадаггүй бусад бодисыг үйлдвэрлэх явцад химийн урвалд орж хувирах завсрын химийн бодис

мэтээр үзэж, Нарийн бичгийн дарга нарын газарт мэдэгдэн зөвшөөрч болно. Мэдэгдэл нь тухайн химийн бодисын үйлдвэрлэл, хэрэглээний нийт хэмжээний тухай мэдээлэл буюу тийм мэдээлийг үнэлж дүгнэсэн тайлбарыг болон хаалттай тогтолцоонд, хязгаарлагдмал хүрээнд дэх үйл явцын шинж чанарын тухай мэдээллийг, түүний дотор эцсийн бүтээгдэхүүн дэх удаан задардаг органик бохирдуулагчийн анхдагч материалын хувираагүй болон зориудын биш микробоирдуулагчийн тоо хэмжээний тухай мэдээллийг тусгасан байна. Энэ хавсралтад өөрөөр заагаагүй бол энэхүү журмыг хэрэглэнэ. Нарийн бичгийн дарга нарын газар нь тийм мэдэгдлийг Талуудын Бага хурал ба олон нийтэд хүртээлтэй байлгана. Тийм үйлдвэрлэл, хэрэглээг үйлдвэрлэл, хэрэглээний тусгай зөвшөөрөлд хамааруулж үзэхгүй. Холбогдох Тал Нарийн бичгийн дарга нарын газарт шинэ мэдэгдэл өгөн Талуудын Бага хурал тухайн үйлдвэрлэл, хэрэглээг хянан үзэж, өөрөөр шийдээгүйгээс хугацааг нь дахин арван жилээр сунгаагүй л бол, тийм үйлдвэрлэл, хэрэглээг арван жилийн дараа зогсооно. Мэдэгдлийг давтан өгч болно.

(iv) Энэхүү Хавсралтын тусгай бүх зөвшөөрлийг 4 дүгээр зүйлийн дагуу бүртгүүлсэн Талууд эдэлж болно.

II хэсэг

ДДТ (1.1.1 трихлор-2, 2-бис(4-хлорфенил) этан)

1. ДДТ-г үйлдвэрлэх ба/буюу хэрэглэх хүсэлтээ Нарийн бичгийн дарга нарын газарт мэдэгдээгүй тохиолдолд ДДТ-гийн үйлдвэрлэл ба хэрэглээг хориглоно. Үүгээр байгуулж буй ДДТ-гийн бүртгэл нь олон нийтэд ил тод байна. Нарийн бичгийн дарга нарын газар ДДТ-гийн бүртгэлийг хийнэ.

2. Аюулгүй, үр ашигтай орлуулах зүйл байхгүй үед ДДТ-г өвчний нян тээгчдэд хяналт тавих зорилгоор үйлдэрлэх ба/буюу хэрэглэж байгаа Тал тийм үйлдвэрлэл, хэрэглээг Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас боловсруулсан зөвлөмж болон ДДТ-г ашиглах чиглэлийн дагуу хязгаарлана.

3. ДДТ-гийн бүртгэлд ороогүй Тал нь өвчний нян тээгчдэд хяналт тавих зорилгоор ДДТ-г үйлдвэрлэх шаардлагатай бол ДДТ-гийн бүртгэлд бүртгүүлэх хүсэлтээ Нарийн бичгийн дарга нарын газарт аль болох даруй тавина. Чингэхдээ Дэлхийн эрүүл мэндийн байгууллагад мөн адил мэдэгдэнэ.

4. ДДТ-г ашиглаж буй Тал Нарийн бичгийн дарга нарын

газар болон Дэлхийн эрүүл мэндийн байгууллагад ашиглаж буй тоо хэмжээ, ашиглалтын нөхцөл, ДДТ нь холбогдох өвчлөлийг анагаахад хэр зэрэг хамаатай талаар Талуудын Бага хурлаас Дэлхийн эрүүл мэндийн байгууллагатай зөвлөлдөн тогтоох журмын дагуу 3 жил тутам мэдээлнэ.

5. ДДТ-гийн хэрэглээг багасгах, улмаар бүрмөсөн үгүй болгох зорилгоор Талуудын Бага хурал дараах арга хэмжээ авахыг дэмжинэ:

(а) ДДТ-г ашигладаг Тал бүр үйл ажиллагааны төлөвлөгөөг 7 дугаар зүйлд заасан хэрэгжүүлэх төлөвлөгөөний нэгэн хэсэг болгон боловсруулж хэрэгжүүлэх. Үйл ажиллагааны төлөвлөгөө нь дараах арга хэмжээг тусгана:

(i) ДДТ-гийн хэрэглээг өвчний нян тараагчдад тавих хяналтаар хязгаарлахад чиглэсэн зохицуулалтын болон бусад механизмыг боловсруулах:

(ii) Зохих альтернатив бүтээгдэхүүн, арга зам, стратегийг, түүний дотор удирдлагын холбогдох стратегийг хэрэгжүүлэх. Чингэхдээ тийм альтернатив зүйлсийг үр дүнтэй байлгахыг зорих.

(iii) Хүний эрүүл мэндийн талаар тавих анхаарал халамжийг сайжруулах, өвчлөлтийг бууруулах арга хэмжээ авах:

(б) Талууд ДДТ-г ашигладаг Талуудад зориулж, химийн болон химийн бус аюулгүй альтернатив бүтээгдэхүүн, арга барил, стратегийг өвчлөлтөөс хүмүүст болон эдийн засагт үзүүлэх дарамтыг багасгах зорилгоор судлах, боловсруулахыг нөхцөл байдлаа харгалзан бололцоогоороо дэмжинэ.

Дурьдсан альтернатив буюу тэдгээрийн зохистой хослолыг авч үзэхдээ хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд эерэг нөлөө үзүүлж буй хүчин зүйлсийг дэмжинэ. ДДТ-г орлуулах зүйлс нь хүрээлэн байгаа орчин, хүний эрүүл мэндэд бага хохирол учруулдаг, өвчлөлд хяналт тавихад Оролцогч Талуудын нөхцөл байдалд тохирсон, ажиглалт хяналтын тоо баримтаар батлагдаж байх ёстой.

6. Талуудын бага хурал анхны хуралдаанасаа эхлэн түүнээс хойш наад зах нь 3 жил тутамд өвчний нян тээгчдэд хяналт тавихад ДДТ хэрэгтэй хэвээр байгаа эсэх талаар үнэлэлт дүгнэлт гаргана. Чингэхдээ Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагатай зөвлөлдөн шинжлэх ухаан, техник, байгаль орчин, эдийн засгийн холбогдох мэдээллийг, түүний дотор дараах зүйлийг харгалзана:

(а) ДДТ-гийн хэрэглээ, үйлдвэрлэл болоон 2 дугаар заалтад тусгагдсан нөхцлүүд;

(б) ДДТ-г орлуулах зүйл нь хэр зэрэг олдцтой, хэрэглэхэд

зохимжтой, боломжтой;

(в) Тийм зүйлийг аюулгүй шилжүүлэх талаар улс орнуудад гарч буй ахиц.

7. Оролцогч Тал ДДТ-гийн бүртгэлээс Нарийн бичгийн дарга нарын газарт бичгээр мэдэгдэл өгөн гарч болно. Тухайн Талыг мэдэгдэл дурдсан хугацаанаас эхлэн Бүртгэлээс гарсанд тооцно.

Хавсралт В

ЗОРИУДЫН БУС ҮЙЛДВЭРЛЭЛ

I Хэсэг: 5 дугаар зүйлийн шаардлагад хамаарах удаан задардаг органик бохирдуулагчид

Энэхүү Хавсралтыг хүний үйл ажиллагаатай холбогдон үүссэн удаан задардаг дараах органик бохирдуулагчийн хувьд хэрэглэнэ.

Химийн бодис
Полихлоржуулсан дибензо-п-диоксинууд ба дибензофуранууд (PCDD/PCDF)
Гексахлорбензол (HCB) (CAS №:118-74-1)
Полихлорт бифенилүүд (PCB)

II Хэсэг. Эх үүсвэрийн төрөл

Полихлорт дибензо-п-диоксинууд, дибензофуранууд, гексахлорбензолууд ба полихлорт бифенилүүд зэрэг бодис нь органик нэгдэл, хлор оролцсон дулааны үйл явцад химийн урвал болон дутуу шаталтын үр дагавар болон бий болдог. Үйлдвэрлэлийн дараах эх үүсвэрийн төрлүүд нь бий болох, дээрх бодисуудыг байгаль орчинд ялгаруулан гаргахдаа харьцангуй түргэн байдаг:

(а) Хог шатаагч, түүний дотор хотын болон эмнэлгийн хаягдал, бохирын ус зэрэг хог хаягдлыг устгах төхөөрөмж;

(б) Хортой хаягдал шатаах цементийн зуух;

(в) Цайруулагчаар ашигладаг дан хлор ба дан хлор ялгаруулдаг химийн бодисыг ашиглан элдэв зуурмаг үйлдвэрлэх;

(г) Төмөрлөгийн үйлдвэрлэл дэх дараах дулааны процессууд:

(i) Зэсийн хоёрдогч үйлдвэрлэл;

(ii) Төмөр болон гангийн үйлдвэрлэлийн хайлуулах хэсэг;

(iii) Хөнгөн цагааны хоёрдогч үйлдвэрлэл;

(iv) Цайрын хоёрдогч үйлдвэрлэл.

III Хэсэг. Эх үүсвэрийн төрөл

Полихлорт дибензо-п-диоксинууд, дибензофуранууд, гексахлорбензолууд ба полихлорт бифенилүүд нь дараах эх үүсвэрийн төрлүүдээс үүсэн тархаж болно. Үүнд:

(а) Хог хаягдлыг ил задгай шатаах, газарт булсан хог хаягдлыг шатаах;

(б) II хэсэгт дурдаагүй төмөрлөгийн үйлдвэрлэлийн дулааны процесс;

(в) Ахуйн шаталтын эх үүсвэрүүд

(г) Байгалийн шатагч материалаар ажилладаг төхөөрөмж, үйлдвэрийн уурын тогоонууд;

(д) Мод болон бусад биомассыг түлшний зориулалтаар шатаах төхөөрөмж;

(е) Удаан задардаг органик бохирдуулагчид, ялангуяа хлорфенол ба хлоранилийг гаргагч химийн тусгай үйлдвэрийн процесс;

(ё) Чандарлах;

(ж) Дотоод шаталтын, ялангуяа хар тугалгатай бензин шатаадаг хөдөлгүүр хэрэгсэл;

(з) Амьтны сэг устгал;

(и) Бөс даавуу, арьс ширний хлоранил бүхий будаг болон өнгөлөгч (шүлтийн ханд) ашигладаг боловсруулалт;

(к) Хэрэглээнээс гарсан тоног төхөөрөмж, хэрэгслийг буталж жижиглэх үйлдвэр;

(л) Зэс кабелийг шатаах;

(м) Нефть боловсруулахтай холбогдон бий болсон хаягдал.

IV Хэсэг. Тодорхойлолт

1. Энэхүү Хавсралтын зорилгын хувьд:

(а) “Полихлорт бифенил” нь бифенилийн (нүүрстөрөгч-нүүрстөрөгч гэсэн дан холбоогоор холбогдсон 2 бензолын цагираг) молекулын устөрөгчийн атомууд нь 10 хүртэл тооны хлорын атомаар халагдсан ароматик нэгдэл юм.

(б) “Полихлорт дибензо-п-диоксин” ба “полихлорт дибензофуранууд” нь 3 цагирагт ароматик нэгдлүүд бөгөөд “полихлорт

дибензо-п-диоксинууд” нь 2-хүчилтөрөгчийн атомаар дамжин холбогдсон хоёр бензолын цагираг ба “полихлорт дибензофуранууд” нь нүүрстөрөгч-нүүрстөрөгч дан холбоо ба нэг хүчилтөрөгчийн атомаар дамжин холбогдсон хоёр бензолын цагираг юм. Эдгээрийн устөрөгчийн атомууд нь найм хүртэл тооны хлорын атомаар халагдсан байж болно.

2. Энэхүү Хавсралтад дурдсан полихлорт дибензо-п-диоксин болон хлорт дибензофуранын хоруу чанарыг тодорхойлохдоо эдгээр нэгдлүүд ба копланар полихлорт бифенилийн төсөөт нэгдлүүдийг 2, 3, 7, 8-тетрахлор-дибензо-п-диоксинтой харьцуулан хоруу чанарыг хэмжиж диоксинтой төсөөт хоруу чанарын эквивалент гэсэн нэр томъёогоор илэрхийлнэ. Энэ конвенцийн зорилгод хэрэглэх хоруу чанарын эквивалент хүчин зүйлийн утга нь 1998 онд Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагаас хөхтөн амьтдын хувьд гаргасан полихлорт дибензо-п-диоксин, полихлорт дибензофуран болон копланар полихлорт бифенилийн хоруу чанарын тодорхойлолтод болон олон улсын хүлээн хэмжээнд хүлээн зөвшөөрсөн бусад стандартад тохирох ёстой. Концентрац нь хоруу чанарын эквивалентаар илэрхийлэгдэнэ.

V Хэсэг. Тэргүүний арга техник, байгаль
орчинд зохистой тэргүүний практикт холбогдолтой
ерөнхий арга хэмжээ

Энэхүү хэсэг нь I хэсэгт дурдсан химийн бодисуудаас хамгаалах буюу тэдгээрийг бууруулах талаар Талуудаас баримтлах ерөнхий чиглэл болно.

A. Тэргүүний арга техник, байгаль орчинд зохистой тэргүүний практикт холбогдолтой урьдчилан сэргийлэх ерөнхий арга хэмжээ

I хэсэгт дурдсан химийн бодисууд үүсч тархахаас хамгаалах явдлыг тэргүүлэх зорилт болгоно. Ашигтай арга хэмжээнд дараахийг оруулж болно. Үүнд:

- (a) Хаягдал бага гаргадаг технологи ашиглах;
- (б) Аюул уршиг багатай бодисуудыг ашиглах;
- (в) Үйлдвэрлэлийн явцад ашигласан ба үүссэн бодис, хог хаягдлыг дахин боловсруулах болон эргүүлж ашиглах явдлыг дэмжих;
- (г) Удаан задардаг органик бохирдуулагч өөрөө тэжээл болж байх буюу эсвэл эх үүсвэрээс гарч байгаа удаан задардаг органик бохирдуулагч ба материал нь шууд холбоотой байвал

түүнийг орлуулах;

(д) Үйлдвэрлэл эрхлэлт ба урьдчилан сэргийлэх сайн хөтөлбөрүүдийг боловсруулж хэрэгжүүлэх;

(е) Хог хаягдлыг задгайгаар болон хяналтгүйгээр шатаах, газар доор булсан хогийг шатаах явдлыг зогсоох үүднээс хогийн менежментийн бодлогыг сайжруулах. Хог боловсруулах шинэ байгууламжийг байгуулах асуудлыг авч үзэхдээ хотын болон эмнэлгийн хог хаягдлыг багасгах, хогийг ялгаж дахин боловсруулж ашиглах, хог бага гаргах шинэ төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих зэрэг шийдлүүдэд ач холбогдол өгнө. Эдгээр шийдэлд хүрэхдээ хүн амын эрүүл мэндтэй холбоотой асуудлыг анхаарч үзнэ.

(ё) Эдгээр бодисыг бүтээгдэхүүн дэх бохирдуулагч хэмээн үзэж аль болох багасгах;

(ж) Цайруулагч болгон ашигладаг дан хлор болон дан хлор ялгаруулдаг химийн бодисыг ашиглахаас зайлсхийх.

Б. Тэргүүний арга техник

Тэргүүний арга техникийн талаарх концепц нь ямар нэгэн тодорхой техник, технологийг зөвлөмж болгоход бус харин холбогдох байгууламжийн техникийн үзүүлэлт, газар зүйн байршил, тухайн байгаль орчны нөхцөл байдлыг харгалзахад чиглэж байгаа болно. I хэсэгт дурдсан химийн бодисууд ялгарах явдлыг бууруулах хяналтын арга техник нь ерөнхийдөө адил болно. Тэргүүний арга техникийг тодорхойлохдоо холбогдох арга хэмжээний өртөг зардал, ашиг тус, хамгаалах болон урьдчилан сэргийлэх хэрэгцээ шаардалгыг харгалзан дараах хүчин зүйлүүдэд ерөнхийд нь болон тусгайлан тэргүүлэх ач холбогдол өгнө:

(а) Анхаарах ерөнхий зүйлс:

(i) Үүссэн бодисуудын мөн чанар, үр дагавар, тоо хэмжээ; ашиглах арга техник нь эх үүсвэрийн хэмжээнээс хамааран өөр өөр байж болно.

(ii) Шинэ, хуучин байгууламжийг ашиглалтад оруулсан хугацаа;

(ii) Тэргүүний арга техникийг нэвтрүүлэхэд шаардлагатай хугацаа;

(iv) Үйлдвэрлэлийн процесст хэрэглэгдэж байгаа түүхий эдийн шинж чанар, хэрэгцээ, эрчим хүч зарцуулалт;

(v) Үүссэн бодисуудаас орчинд үзүүлэх нөлөө, эрсдлийг аль болох бууруулах буюу түүнээс урьдчилан сэргийлэх;

(vi) Ослоос хамгаалах, тэдгээрээс орчиндоо үзүүлэх үр дагаврыг багасгах;

(vii) Ажлын байрны аюулгүй байдал болон мэргэжлийн холбогдолтой өвчлөл гаргахгүй байх явдлыг хангах;

(viii) Үйлдвэрлэлд амжилттай нь шалгагдсан үйл ажиллагааны адил төстэй процесс, байгууламж, арга барил;

(ix) Шинжлэх ухааны мэдлэг, ойлголтод гарсан технологийн дэвшил, өөрчлөлтүүд.

(б) Үүсч буй бодисуудыг бууруулах ерөнхий арга хэмжээ

Энэхүү хавсралтад дурдсан химийн бодисыг үүсгэдэг процессыг ашиглах байгууламж байгуулах буюу хуучин байгууламжийг сайжруулах саналыг авч үзэхдээ ашгийн хувьд адил боловч дурдсан бодис үүсгэдэггүй арга барил, практикт илүү ач холбогдол өгнө. Тийм байгууламжийг байгуулах буюу үлэмж өөрчлөх тохиолдолд ашиглах тэргүүний арга техникийг тодорхойлохдоо V хэсгийн А-д дурдсан урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдээс гадна гадна дараах арга хэмжээ, хандлагыг авч үзэж болно. Үүнд:

(i) Ялгарсан хийг цэвэрлэх дулааны буюу катализаторын исэлдүүлэлт, тоос буулгах, шингээх гэх мэт сайжруулсан аргыг ашиглах;

(ii) Дулаанаар үйлчлэх, идэвхгүйжүүлэх, химийн аргаар хоргүйжүүлэх зэрэг аргаар тунадас, хаягдал ус, хог хаягдал ба бохир усыг боловсруулж цэвэрлэхэд

(iii) Битүү системд шилжих зэрэг замаар гарц хаягдлыг бууруулах буюу үгүй хийхэд хүргэх өөрчлөлт хийх;

(iv) Шатаах температур, хугацаа зэрэг үзүүлэлтийг хянах замаар шаталтыг сайжруулах, энэ хавсралтад дурдсан бодисууд үүсэхээс сэргийлэх процесст дэвшил гаргах.

В. Байгаль орчинд халгүй тэргүүний практик

Талуудын Бага хурал байгаль орчинд халгүй тэргүүний практикийн талаар удирдлага болгох зөвлөмж боловсруулж болно.

Хавсралт Г
МЭДЭЭЛЭЛД ТАВИХ ШААРДЛАГА,

ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

1. Хавсралт А, Б буюу В-д химийн бодис нэмж оруулахаар санал тавьж буй Тал тухайн бодисыг дэд заалт (а)–д заасан байдлаар тодорхойлох ба түүний болон түүний хувирлын бүтээгдэхүүнүүдийн талаар дэд заалт (б)-гээс (д)-д заасан шалгуур үзүүлэлтүүдэд холбогдох мэдээллийг өгнө:

(а) Химийн чанар:

(i) Нэр, түүний дотор үйлдвэрийн болон худалдааны нэр, төстэй нэгдлийн нэр, Олон улсын кодын бүртгэлийн дугаар, Цэвэр болон хэрэглээний химийн олон улсын холбоо (IUPAC)-ноос оноосон нэр;

(ii) Бүтэц, түүний дотор изомеруудынх нь тодорхойлолт, бүтэц ба химийн анги бүлгийн нь бүтэц;

(б) Удаан задрах чанар:

(i) Тухайн бодисын усан дахь хагас задралын үе нь 2 сараас, хөрсөн дэх хагас задралын үе нь 6 сараас, чулуулаг дахь хагас задралын хугацаа нь 6 сараас тус тус илүү байгааг харуулах үзүүлэлтүүд;

(ii) Эсвэл тухайн бодис нэн удаан задардаг тул энэхүү конвенцид хамруулах шаардлагатай гэдгийг харуулах үзүүлэлтүүд;

(в) Био-хуримтлал:

(i) Тухайн бодисын усны организм, биетэд байх биоконцентрацийн хүчин зүйл буюу био-хуримтлалын чадвар нь 5000-аас их, буюу тийм баримт үгүй тохиолдолд $\log K_{ow}$ (ионы үржвэрийн логарифмын утга) нь 5-аас их байгааг харуулах үзүүлэлтүүд;

(ii) Химийн бодис бусад талаар ч асуудал, уршиг тарих шинжтэйг, тухайлбал биологийн бусад төрөл зүйлд хуримтлагдахдаа амархан, хоруу чанар ихтэй буюу эсвэл байгаль орчинд хортойг харуулах үзүүлэлтүүд;

(iii) Био-хуримтлагдах чадвар нь конвенцид хамааруулах хангалттай үндэслэл болж байгааг харуулах амьд байгаль дахь хяналтын үзүүлэлтүүд.

(г) Байгаль орчинд хол тархах чадвар:

(i) Эх үүсвэрээсээ хол, түгшмээр их тархсан байдал;

(ii) Агаар, ус болон нүүдэллэдэг организм, биетээр дамжин байгаль орчинд хол тархах чадварыг нь харуулсан хяналтын үзүүлэлтүүд;

(iii) Тухайн бодисын агаар, ус, нүүдэллэдэг организм, биетээр дамжин эх үүсвэрээсээ хол тархах чадварыг харуулах байгаль орчны шинж чанар буюу загварын үзүүлэлт. Агаараар дамжин тархдаг бодисуудын хувьд тэдгээрийн агаар дахь хагас задралын хугацаа нь 2 өдрөөс илүү байна.

(д) Сөрөг нөлөө

(i) Хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлж буй сөрөг нөлөө нь тухайн бодисыг энэхүү конвенцийн хүрээнд хамруулах үндэслэл болох үзүүлэлтүүд

(ii) Хүний эрүүл мэнд буюу байгаль орчинд хохирол учруулах боломжийг нь илтгэсэн аюултай буюу хортой чанарын нь үзүүлэлтүүд

2. Санал гаргагч Тал тухайн бодистой холбогдуулан болгоомжлох үндэслэлийг тайлбарласан мэдэгдэл хийнэ. Чингэхдээ боломжтой бол түүний байгаль орчинд тархсны нь улмаас хоруу чанарын нь тогтоогдсон болон хүрч болзошгүй түвшинтэй нь харьцуулсан үзүүлэлтүүдийг тусгах бөгөөд мөн дэлхий нийтээр хяналт тавих шаардлагатайг анхааруулсан товч мэдэгдэл хийнэ.

3. Санал гаргагч Тал 8 дугаар зүйлийн 6 дугаар заалтад дурдсан саналыг хэлэлцэхэд тус дөхөм болох нэмэлт мэдээллээр боломжийн хэрээр хангана. Саналыг боловсруулахдаа ямар ч эх үүсвэрээс мэргэжлийн туслалцаа авч болно.

Хавсралт Д

ЭРСДЛИЙН ТОДОРХОЙЛОЛТОД ХОЛБОГДОХ
МЭДЭЭЛЭЛД ТАВИХ ШААРДЛАГА

Энэхүү хяналт нь тухайн бодис нь хүний эрүүл мэнд ба/ буюу байгаль орчинд дэлхий дахиныг хамарсан арга хэмжээ авахыг шаардсан ноцтой хохирол учруулахад хүргэж болзошгүй эсэхийг үнэлэх зорилготой. Үүний тулд Хавсралт Г-д дурдсан мэдээллийг дэлгэрүүлэх, үнэлэхэд чиглэсэн бөгөөд дараах төрлийн мэдээллийг тусгасан эрсдлийн тодорхойлолтыг боловсруулна:

(а) Зохих үед дараах зүйлийг агуулсан эх үүсвэрүүд:

(i) Хэмжээ ба байршлыг тусгасан үйлдвэрлэлийн үзүүлэлтүүд;

(ii) Хэрэглээ;

(iii) Хаях, алдах, ялгарах зэрэгт үүссэн бодис, зүйлс.

(б) Олон тооны химийн бодисуудын хоруу чанарын харилцан үйлчлэлийн үнэлгээ;

(в) Тухайн бодисын физик химийн шинж чанар, задрал, тэдгээр нь тухайн бодисын байгаль орчинд тархах, нэг орчингоос нөгөө орчинд шилжих, задарч бусад химийн бодист хувирахад хэрхэн нөлөөлж байгаа зэргийг тусгасан байгаль орчны үзүүлэлтүүд. Биоконцентрац буюу био-хуримтлалын хүчин зүйлийн

хэмжигдсэн утгууд дээр тулгуурласан тодорхойлолттой хяналтын тийм үзүүлэлтүүд нь энэ шаардлагыг хангаж байгаа эсэхийг авч үзэхээс бусад тохиолдолд танилцах боломжтой байх ёстой.

(г) Хяналтын үзүүлэлтүүд:

(д) Ялангуяа байгаль орчинд тархсны улмаас хэсэгчлэн өртсөн байдал. Үүнд био-боломжийн тухай мэдээллийг тусгасан байна.

(е) Үндэсний болон олон улсын эрсдлийн үнэлгээ, тодорхойлолт, бүтээгдэхүүний шошгод тусгах мэдээлэл болон уршиг аюулын ангилал,

(ё) Тухайн бодисын олон улсын конвенц дахь статус.

Хавсралт Е

НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ХОЛБОГДОЛТОЙ МЭДЭЭЛЭЛ

Энэхүү конвенцид хамруулахаар авч үзэж буй бодисуудад хяналт тавих бүхий л хувилбарыг, түүний дотор зохицуулах, устгах асуудлыг тусгасан үнэлгээ хийнэ. Үүний тулд хяналтын арга хэмжээнд холбогдолтой нийгэм-эдийн засгийн асуудлуудын тухай мэдээллээр хангаж, Талуудын Бага хурлаас шийдвэр гаргах боломжийг олгоно. Тийм мэдээлэл нь Талуудын өөр өөр боломж чадавхи, нөхцөл байдлыг тусгах бөгөөд дараахийг авч үзсэн байна.

(а) Эрсдлийг багасгах зорилгыг хэрэгжүүлэх хяналтын арга хэмжээний үр дүн;

(i) Техникийн боломж; болон

(ii) Зардал, түүний дотор байгаль орчин, эрүүл мэндийг хамгаалахтай холбогдсон өртөг зардал

(б) Альтернатив бүтээгдэхүүн, процесс:

(i) Техникийн боломж;

(iii) Зардал, түүний дотор байгаль орчин, эрүүл мэндийг хамгаалахтай холбогдсон өртөг зардал;

(iii) Үр ашиг;

(iv) Эрсдэл;

(v) Олдоц;

(vi) Хүртээмж.

(в) Хяналтын арга хэмжээг хэрэгжүүлэхэд нийгэмд гарах эерэг ба/ буюу сөрөг нөлөө.

(i) Нийтийн эрүүл мэндийг хамгаалах, түүний дотор байгаль

орчны болон мэргэжлийн өвчлөлийг анагаах;

- (ii) Усны болон ойн аж ахуйг хамарсан хөдөө аж ахуй;
- (iii) Амьд байгаль (биологийн төрөл зүйл);
- (iv) Эдийн засгийн асуудлууд;
- (v) Тогтвортой хөгжилд хүргэх хөдөлгөөн; болон
- (vi) Нийгмийн өртөг зардал.

(г) Хог хаягдалтай холбогдсон үр дагавар (тухайлбал, пестицидийн хуучин нөөцийг устгах, бохирдсон газрыг цэвэршүүлэх)

- (i) Техникийн боломж; болон
- (ii) Өртөг зардал.

(д) Мэдээлэлтэй танилцах, олон нийтэд таниулах боломж

(е) Хянах, ажиглалт явуулах чадавхи;

(ё) Үндэсний буюу бүс нутгийн хэмжээнд авсан арга хэмжээ, түүний дотор орлуулах зүйлийн болон эрсдлийн менежментийн холбогдолтой бусад мэдээлэл.

Тайлбар: 2009 онд Женев хотноо хуралдсан талуудын бага хурлаар 9 төрлийн шинэ удаан задардаг органик бохирдуулагчдыг тус конвенцийн хавсралтад нэмэлтээр оруулсан. Эдгээр 9 УЗОБ-чдын талаархи мэдээллийг www.mne.mn/chemical цахим хуудаснаас монгол хэлээр авна уу.

ЗАРИМ АЮУЛТАЙ ХИМИЙН БОДИС БОЛОН
ПЕСТИЦИДИЙГ ОЛОН УЛСЫН ХЭМЖЭЭНД
ХУДАЛДААЛАХАД ХЭРЭГЛЭХ УРЬДЧИЛАН МЭДЭЭЛЖ
ЗӨВШИЛЦӨХ ЖУРМЫН ТУХАЙ РОТТЕРДАМЫН
КОНВЕНЦИ

Удиртгал

Энэхүү Конвенцид оролцогч Талууд.

Олон улсын хэмжээнд худалдаалж байгаа зарим аюултай химийн бодис болон пестицид нь хүний эрүүл мэнд болон байгаль орчинд хортой нөлөөтэйг харгалзан.

Байгаль орчин, хөгжлийн асуудлаархи Рио-гийн тунхаглалын зохих заалтууд болон “Хортой болоод аюултай бүтээгдэхүүнийг хууль бусаар хил дамжуулан зөөвөрлөхөөс урьдчилан сэргийлэх асуудлыг хамруулан химийн хорт бодисыг байгаль орчинд халгүйгээр ашиглах” тухай XXI зууны мөрийн хөтөлбөрийн 19 дүгээр бүлгийг үндэслэн.

Химийн бодисын олон улсын худалдаанд мэдээлэл солилцох тухай нэмэлт өөрчлөлт

оруулсан Лондонгийн зарчим (цаашид “Нэмэлт өөрчлөлт оруулсан Лондонгийн зарчим” гэнэ) болон Пестицидийг хуваарилах болон ашиглах талаархи Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын хэрэглэний олон улсын код (цаашид Хэрэглээний олон улсын код гэнэ)-од тусгагдсан сайн дурын үндсэн дээр урьдчилан мэдээлж зөвшилцөх журмыг хэрэгжүүлэх талаар НҮБ-ын Орчны Хөтөлбөр болон НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагаас гүйцэтгэсэн ажлыг анхааралдаа авч.

Хөгжиж буй болон шилжилтийн эдийн засагтай орнуудын хувьд Талуудын хоорондын хамтын ажиллагаа хөгжүүлэх, техникийн тусламж авах, ялангуяа химийн бодисыг зохистой ашиглах үндэсний чадавхийг бэхжүүлэх зэрэг нөхцөл байдал, шаардлага байгааг анхааран үзэж.

Зарим орнуудад химийн бодисыг хил дамжуулан худалдаалах талаар мэдээлэл авах тодорхой шаардлага байгааг тэмдэглэж.

Пестицидийг хуваарилах болон ашиглах талаархи Хэрэглэний олон улсын код болон НҮБ-ын Орчны Хөтөлбөрийн Химийн бодисын олон улсын худалдаа хийх дүрмийн кодоод тусгагдсан сайн дурын стандартуудыг анхааралдаа авч бүх улс оронд химийн бодисыг зүй зохистой ашиглах арга туршлагыг нэвтрүүлэх нь зүйтэйг хүлээн зөвшөөрч.

Экспортлогч Талын нутаг дэвсгэрээс гарч байгаа аюултай химийн бодисыг Нэмэлт өөрчлөлт оруулсан Лондонгийн зарчим болон Хэрэглээний олон улсын кодоод тусгагдсан шаардлагын дагуу хүний эрүүл мэнд болон байгаль орчныг найдвартай хамгаалахаар савлаж, зохих ёсоор шошгожуулсан байх нөхцлийг хангахыг хүсч,

Тогтвортой хөгжилд хүрэхэд худалдааны болон байгаль орчны бодлогууд нэг нь нөгөөгөө харилцан дэмжиж байх ёстойг хүлээн зөвшөөрч,

Энэ Конвенцийн заалтуудыг ямар ч тохиолдолд түүний Талуудаас химийн бодисын олон улсын худалдаа болон байгаль орчныг хамгаалах асуудлаар олон улсын гэрээ хэлэлцээрээр хүлээсэн эрх, үүргийг нь өөрчлөх байдлаар тайлбарлахгүйг онцлон тэмдэглэж,

Ийнхүү дурьдсан нь энэ Конвенц болон олон улсын бусад гэрээ хэлэлцээрүүдэд дэс дугаар тогтоох зорилго агуулаагүй хэмээн ойлгож,

Хүний эрүүл мэнд түүний дотор хэрэглэгчид, ажилчид болон байгаль орчныг олон улсын хэмжээнд худалдаалж байгаа зарим аюултай химийн бодис болон пестицидээс үзүүлж болох хортой нөлөөллөөс хамгаалах шийдвэр төгс байгаагаа илэрхийлж, ДАРААХ ЗҮЙЛИЙГ ХЭЛЭЛЦЭН ТОХИРОВ:

1 дүгээр зүйл

Зорилго

Энэ Конвенцийн зорилго нь хүний эрүүл мэнд болон байгаль орчныг зарим аюултай химийн бодисын хор хөнөөлөөс хамгаалах, тэдгээрийг зохистой ашиглахад хувь нэмэр оруулахын тулд уг бодисуудын тодорхойлолтын талаар харилцан мэдээлэл солилцох, импортлох болон экспортлох асуудлыг үндэсний түвшинд шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлж гарсан шийдвэрийг Талуудад хүргэх замаар зарим аюултай химийн бодисыг олон улсын хэмжээнд худалдаалахад Талуудын хүлээх хамтын хариуцлага болон хамтран ажиллах хүчин чармайлтыг дээшлүүлэхэд оршино.

2 дугаар зүйл

Тодорхойлолт

Энэ Конвенцийн зорилгод:

(а) “Химийн бодис” гэж өөрийн үндсэн эсвэл хольц болон бэлтгэц байдлаар байгаа үйлдвэрлэлийн аргаар эсвэл байгалиас гаргаж авсан химийн бодисыг хэлэх бөгөөд түүнд ямар нэг амьд биет үл

хамаарна. Энэхүү химийн бодис нь пестицидийн (онцгой аюултай пестицидийн бүрэлдэхүүнийг оруулан) болон үйлдвэрлэлийн гэсэн зориулалтын ангилалтай байна.

(б) “Хориглосон химийн бодис” гэж хүний эрүүл мэнд эсвэл байгаль орчныг хамгаалахын тулд эцэслэн журамласан тогтоолоор нэг буюу хэд хэдэн зориулалтын ангилалын хүрээнд бүх төрлийн ашиглалтыг нь хязгаарласан химийн бодисыг хэлнэ. Түүнд хүний эрүүл мэнд эсвэл байгаль орчныг хамгаалахын бодит шаардлагын үүднээс анх удаагийн хэрэглээг нь зөвшөөрөөгүй түүнчлэн үйлдвэрлэлийн улмаас дотоодын зах зээлээс хасагдсан эсвэл дотоодод хэрэглэх асуудлыг цаашид авч хэлэлцэхгүй болсон химийн бодисууд хамаарна.

(в) “Онцгой хязгаарласан химийн бодис” гэж хүний эрүүл мэнд эсвэл байгаль орчныг хамгаалахын тулд эцэслэн журамласан тогтоолоор нэг буюу хэд хэдэн зориулалтын ангилалын хүрээнд бүх төрлийн ашиглалтыг нь хязгаарласан боловч зарим онцгой тохиолдолд ашиглахыг зөвшөөрсөн химийн бодисыг хэлнэ. Түүнд хүний эрүүл мэнд эсвэл байгаль орчныг хамгаалахын бодит шаардлагын үүднээс бараг бүх төрлийн хэрэглээг нь зөвшөөрөөгүй түүнчлэн үйлдвэрлэлийн улмаас дотоодын зах зээлээс хасагдсан эсвэл дотоодод хэрэглэх асуудлыг цаашид авч хэлэлцэхгүй болсон химийн бодисууд хамаарна

(г) “Онцгой аюултай пестицидийн бүрэлдэхүүн” гэж хөдөө аж ахуйн хортон шавьж устгах зориулалтаар үйлдвэрлэсэн бөгөөд ашиглалтын нөхцлийн дагуу ганц эсвэл хэд хэдэн удаа хэрэглэсний дараа богино хугацааны дотор хүний эрүүл мэнд эсвэл байгаль орчинд онцгой аюул учруулах химийн бодисыг хэлнэ.

(д) “Эцэслэн журамласан тогтоол” гэж ямар нэг химийн бодисыг хориглох эсвэл онцгой хязгаарлахын тулд тухайн Талаас цаашид дахин журамлах шаардлагагүйгээр гаргасан тогтоолыг хэлнэ.

(е) “Экспорт” болон “Импорт” гэж тэдгээрийн тус тусын утгаар нэг Талаас нөгөө Талд химийн бодис шилжүүлэхийг хэлэх бөгөөд харин цэвэр шилжүүлэхтэй холбогдсон үйлдлүүд түүнд үл хамаарна.

(ё) “Тал” гэж энэ Конвенцоор хүлээсэн үүргээр хоорондоо холбоотой бөгөөд тэдний хувьд уг Конвенц хүчин төгөлдөр болсон улс эсвэл бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагыг хэлнэ.

(ж) “Бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага” гэж аль нэг бүс нутгийн бие даасан улсууд хамтран байгуулсан, энэ Конвенцоор зохицуудагдах асуудлуудыг хариуцахыг гишүүн улсуудаас нь даалгасан, дотоод журмынхаа дагуу энэ Конвенцид

гарын үсэг зурах, соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, сайшаан дэмших эсвэл нэгдэн орох эрх олгогдсон байгууллагыг хэлнэ.

(з) “Химийн бодисын магадлах хороо” гэж 19 дүгээр зүйлийн 6 дугаар заалтын (б)-д тусгагдсан туслах байгууллагыг хэлнэ.

3 дугаар зүйл

Конвенцийн үйлчлэх хүрээ

1. Энэ Конвенцид дараах бодисууд хамаарна. Үүнд:

(а) Хориглосон болон онцгой хязгаарласан химийн бодис;

(б) Онцгой аюултай пестицидийн бүрэлдэхүүн.

2. Энэ Конвенцид дараах бодисууд үл хамаарна. Үүнд:

(а) Мансууруулах эмийн зүйлс болон сэтгэгцэд нөлөөлөх бодисууд;

(б) Радио идэвхит материал;

(в) Хог хаягдал;

(г) Химийн зэвсэг;

(д) Хүн болон малын эмийн зүйлсийг оруулсан эмийн бодисууд;

(е) Хоол хүнсэнд нэмж хэрэглэдэг химийн бодисууд;

(ё) Хоол хүнс;

(ж) Хүний эрүүл мэнд эсвэл байгаль орчинд нөлөөлөхөөргүй тоо хэмжээгээр дараах зорилгоор импортлож буй химийн бодисууд. Үүнд:

(I) Судалгаа шинжилгээний зориулалтаар; эсвэл

(II) Хувь хүн өөрийн ахуйн хэрэгцээнд шаардагдах тоо хэмжээгээр импортлох.

4 дүгээр зүйл

Үндэсний томилогдсон байгууллагууд

1. Тал тус бүр түүний нэрийн өмнөөс энэ Конвенцийн хүрээнд удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх эрх олгогдсон үндэсний нэг эсвэл хэд хэдэн байгууллагыг томилно.

2. Тал тус бүр өөрийн томилсон үндэсний байгууллагыг зорилгоо хэрэгжүүлэхэд хүрэлцээтэй нөөц боломжоор хангахыг эрмэлзэнэ.

3. Тал тус бүр энэ Конвенц түүний хувьд хүчин төгөлдөр болох өдрөөс хэтрүүлэлгүйгээр өөрийн томилсон үндэсний байгууллага буюу байгууллагуудын нэр болон хаягийг Нарийн бичгийн дарга нарын газарт мэдэгдэнэ. Тал тус бүр ийм байгууллага буюу байгууллагуудынхаа нэр

болон хаягийг өөрчлөгдөхөд нэн даруй Нарийн бичгийн дарга нарын газарт мэдэгдэнэ.

4. Нарийн бичгийн дарга нарын газар 3 дугаар заалтын дагуу авсан мэдээллийг нэн даруй Талуудад тараана.

5 дугаар зүйл

Хориглосон болон онцгой хязгаарласан химийн бодисын талаархи журам

1. Эцэслэн журамласан тогтоол гаргасан Тал тус бүр энэ тухайгаа Нарийн бичгийн дарга нарын газарт бичгээр мэдэгдэнэ. Ийм мэдэгдлийг аль болохоор хурдан гэхдээ эцэслэн шийдвэрлэсэн тогтоол гаргасан өдрөөс хойш 90 хоногийн дотор өгөх бөгөөд түүнд I хавсралтын дагуу шаардагдах мэдээллийг оруулна.

2. Тал тус бүр түүний хувьд энэ Конвенц хүчин төгөлдөр болсон өдөр Нэмэлт өөрчлөлт оруулсан Лондонгийн зарчим болон Хэрэглээний олон улсын кодын хүрээнд урьд өмнө гаргасан бөгөөд дахин мэдэгдэх шаардлагагүй эцэслэн журамласан тогтоолуудаа оролцуулахгүйгээр энэ өдрийг хүртэл гаргасан ийм тогтоолуудынхаа тухай Нарийн бичгийн дарга нарын газарт бичгээр мэдэгдэнэ.

3. Нарийн бичгийн дарга нарын газар 1 болон 2 дугаар заалтын дагуу тухайн мэдэгдлийг хүлээн авсны дараа аль болох хурдан гэхдээ ямар ч тохиолдолд 6 сараас хэтрүүлэлгүйгээр уг мэдэгдэлд I хавсралтын дагуу шаардагдах мэдээлэл орсон эсэхийг шалгана. Хэрэв мэдэгдэлд шаардлагатай мэдээлэл орсон бол Нарийн бичгийн дарга нарын газар авсан мэдээллийнхээ тоймыг бүх Талуудад нэн даруй илгээнэ. Хэрэв мэдэгдэлд шаардлагатай мэдээлэл ороогүй бол уг мэдэгдлийг ирүүлсэн Талд энэ тухай мэдээлнэ.

4. Нарийн бичгийн дарга нарын газар 6 сар тутам 1 болон 2 дугаар заалтын дагуу авсан мэдээллийн товч тоймд I хавсралтын дагуу шаардагдах бүх мэдээллийг агуулаагүй мэдэгдлүүдийн талаархи мэдээллийг тусган Талуудад явуулж байна.

5. Нарийн бичгийн дарга нарын газар тодорхой нэг химийн бодисын талаар өөрийн шалгаж тогтоосны дагуу I хавсралтын шаардлагыг хангасан мэдэгдэл Урьдчилан мэдээлж зөвшилцөх журмыг хэрэглэх зорилгоор хуваасан хоёр бүс тус бүрээс дор хаяж нэг нэгийг авсан бол эдгээр мэдэгдлийг Химийн бодисын магадлах хороонд илгээнэ. Урьдчилан мэдээлж, зөвшөөрөл авах журмыг хэрэглэх зорилгоор хуваах бүсүүдийг бүрэлдэхүүнийг Талуудын анхдугаар бага хурлаас

хавсралтаар тодорхойлж шийдвэрлэнэ.

6. Химийн бодисын шүүмжийн хороо эдгээр мэдэгдэлд орсон мэдээллийг хянаж II хавсралтад өгөгдсөн шалгуурын дагуу тухайн химийн бодисыг Урьдчилан мэдээлж, зөвшилцөх журамд хамааруулан III хавсралтад оруулах эсэх талаар Талуудын бага хуралд зөвлөмж өгнө.

6 дугаар зүйл

Онцгой аюултай пестицидийн бүрэлдэхүүний талаархи журам

1. Өөрийн нутаг дэвсгэр дээр ашиглалтын нөхцлийн дагуу хэрэглэсэн онцгой аюултай пестицидийн бүрэлдэхүүнээс үүдсэн асуудалтай тулгарсан бөгөөд энэ Конвенцид нэгдсэн хөгжиж буй болон шилжилтийн эдийн засагтай аль нэг орон уг онцгой аюултай пестицидийн бүрэлдэхүүнийг III хавсралтад оруулах саналыг Нарийн бичгийн дарга нарын газарт тавьж болно. Тал нь саналаа бэлтгэхдээ зохих эх үүсвэрээс авсан техникийн тодорхойлолт болон мэдээнд үндэслэж болно. Саналд IV хавсралтын 1 дүгээр хэсэгт шаардагдах мэдээллийг тусгана.

2. Нарийн бичгийн дарга нарын газар 1 дүгээр заалтын дагуу санал хүлээн авсны дараа аль болох хурдан гэхдээ ямар ч тохиолдолд 6 сараас хэтрүүлэлгүйгээр уг саналд IV хавсралтын 1 дүгээр хэсэгт шаардагдах мэдээлэл орсон эсэхийг шалгана. Хэрэв саналд шаардлагатай мэдээлэл орсон бол Нарийн бичгийн дарга нарын газар авсан мэдээллийнхээ тоймыг бүх Талуудад нэн даруй илгээнэ. Хэрэв саналд шаардлагатай мэдээлэл ороогүй бол уг саналыг гаргасан талд энэ тухай мэдээлнэ.

3. Нарийн бичгийн дарга нарын газар 2 дугаар заалтын дагуу ирүүлсэн саналтай холбогдуулан IV хавсралтын 2 дугаар хэсэгт тусгагдсан нэмэлт мэдээлэл цуглуулна.

4. Тухайн онцгой аюултай пестицидийн хувьд 2 болон 3 дугаар заалтын шаардлагууд биелэгдвэл Нарийн бичгийн дарга нарын газар уг санал болон холбогдох мэдээллийг Химийн бодисын магадлах хороонд илгээнэ.

5. Химийн бодисын магадлах хороо саналд тусгагдсан мэдээлэл болон цуглуулсан нэмэлт мэдээллийг хянаж IV хавсралтын 3 дугаар хэсэгт өгөгдсөн шалгуурын дагуу тухайн химийн бодисыг Урьдчилан мэдээлж зөвшилцөх журамд хамааруулан III хавсралтад оруулах эсэх

талаар Талуудын бага хуралд зөвлөмж өгнө.

7 дугаар зүйл

Химийн бодисыг III хавсралтад оруулах

1. Химийн бодисын шүүмжийн хороо III хавсралтад оруулахаар өөрийн зөвлөмж болгосон химийн бодис тус бүрийн талаар шийдвэр гаргуулах баримт бичгийн төсөл бэлтгэнэ. Шийдвэр гаргуулах энэхүү баримт бичиг нь дор хаяж I хавсралтад агуулагдах мэдээлэлд үндэслэсэн байх бөгөөд, эцэслэн журамласан тогтоолд хамаарах зориулалтын ангилалаас өөр ангилалын химийн бодисын ашиглалтын талаархи мэдээллийг мөн агуулсан байх ёстой.

2. 1 дүгээр заалтад өгөгдсөн зөвлөмжийг шийдвэр гаргуулах баримт бичгийн хамт Талуудын бага хуралд оруулна. Талуудын бага хурал тухайн химийн бодисыг Урьдчилан мэдээлж зөвшилцөх журамд хамааруулах, III хавсралтад оруулах болон шийдвэр гаргуулах баримт бичгийн төслийг батлах эсэх зэргийг шийдвэрлэнэ.

3. Талуудын бага хурлаас химийн бодисыг III хавсралтад оруулахаар шийдвэрлэж, уг шийдвэрийг гаргуулах баримт бичгийг баталсны дараа Нарийн бичгийн дарга нарын газар энэ тухай нэн даруй бүх Талуудад мэдээлнэ.

8 дугаар зүйл

Урьдчилан мэдээлж зөвшилцөх сайн дурын журамд орсон химийн бодисууд

1. III хавсралтад орсноос өөр бөгөөд Талуудын бага хурлын анхдугаар хуралдаан болох өдрөөс өмнө Урьдчилан мэдээлж зөвшилцөх сайн дурын журамд орсон химийн бодисыг III хавсралтад оруулах шийдвэрийг уг хавсралтад оруулахад тавигдах бүх шийдвэрийг хангасан гэж үзсэн нөхцөлд Талуудын бага хурал анхныхаа хуралдаанаар шийдвэрлэнэ.

9 дүгээр зүйл

Химийн бодисыг III хавсралтаас хасах

1. Хэрэв аль нэг Тал тухайн химийн бодисыг III хавсралтад оруулах

шийдвэр гарах үед байгаагүй мэдээллийг Нарийн бичгийн дарга нарын газарт өгч тэр мэдээллийн улмаас уг химийн бодис II болон IV хавсралтад өгөгдсөн зохих шалгуурыг цаашид хангаж чадахгүй болвол Нарийн бичгийн дарга нарын газар тэрхүү мэдээллийг Химийн бодисын магадлах хороонд явуулна.

2. Химийн бодисын шүүмжийн хороо 1 дүгээр заалтын дагуу хүлээн авсан мэдээлэлд шүүмж хийнэ. Химийн бодисын шүүмжийн хороо III хавсралтаас гаргуулахаар өөрийн зөвлөмж болгосон химийн бодис тус бүрийн хувьд II эсвэл IV хавсралтын зохих шалгуурт үндэслэн шинээр шийдвэр гаргуулах баримт бичиг бэлтгэнэ.

3. 2 дугаар заалтад тусгагдсан зөвлөмжийг шинээр шийдвэр гаргуулах баримт бичгийн хамт Талуудын бага хуралд оруулна. Талуудын бага хурал тухайн химийн бодисыг III хавсралтаас хасах, шинээр шийдвэр гаргуулах баримт бичгийг батлах эсэх зэргийг шийдвэрлэнэ.

4. Талуудын бага хурлаас химийн бодисыг III хавсралтаас хасахаар шийдвэрлэж, уг шийдвэрийг гаргуулах баримт бичгийг баталсны дараа Нарийн бичгийн дарга нарын газар энэ тухай нэн даруй бүх Талуудад мэдээлнэ.

10 дугаар зүйл

III хавсралтад орсон химийн бодисыг импортлохтой холбогдсон үүргүүд

1. Тал тус бүр III хавсралтад орсон химийн бодисыг импортлох талаар цаг тухайд нь шийдвэр гаргахтай холбогдсон зохих хууль эрхийн болон удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

2. Тал тус бүр 7 дугаар зүйлийн 3 дугаар заалтад тусгагдсан шийдвэр гаргуулах баримт бичгийг явуулсан өдрөөс хойш аль болох түргэн хугацаанд гэхдээ 9 сараас хэтрүүлэлгүйгээр тухайн химийн бодисын цаашдын импортын талаар Нарийн бичгийн дарга нарын газарт хариулт өгнө. Хэрэв Тал нь энэ хариундаа ямар нэгэн өөрчлөлт хийвэл тэр тухайгаа Нарийн бичгийн дарга нарын газарт яаралтай мэдэгдэнэ.

3. 2 дугаар заалтад өгөгдсөн хугацаа хэтэрсэн тохиолдолд Нарийн бичгийн дарга нарын газраас тухайн Талд хариугаа яаралтай өгөхийг бичгээр мэдэгдэнэ. Хэрэв уг Тал хариу өгч чадахгүй бол Нарийн бичгийн дарга нарын газар боломжтой нөхцөлд хариу өгөхөд нь түүнд тусална.

2 дугаар заалтын дагуух хариуг дараах хэлбэрүүдийн аль нэгээр өгнө. Үүнд:

(а) Хууль эрхийн болон удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээнүүдэд нийцсэн эцсийн шийдвэр:

(I) импортыг зөвшөөрөх;

(II) импортыг үл зөвшөөрөх;

(III) импортыг тусгай нөхцөлтэйгээр зөвшөөрөх; эсвэл

(б) Дараах зүйлийг тусгасан түр хариу:

(I) тусгай нөхцөлтэйгээр болон нөхцөлгүйгээр импортыг зөвшөөрсөн түр хариу, эсвэл түр хугацаанд импортыг үл зөвшөөрөх түр хариу;

(II) эцсийн шийдвэр гаргах асуудлыг идэвхитэй авч хэлэлцэж байгаа тухай мэдэгдэл;

(III) Нарийн бичгийн дарга нарын газар эсвэл тухайн Талд хандаж эцэслэн шийдвэрлэсэн тогтоолын талаар нэмэлт мэдээлэл авах талаар гаргасан хүсэлт;

(IV) Химийн бодист үнэлгээ өгөхөд тусламж авах талаар Нарийн бичгийн дарга нарын газарт гаргасан хүсэлт.

5. 4 дүгээр заалтын (а) эсвэл (б)-гийн дагуу өгөгдөх хариу нь III хавсралтад орсон тухайн химийн бодисын зэрэглэл эсвэл зэрэглэлүүдэд хамаарна.

6. Эцсийн шийдвэрт түүнийг гаргахад үндэслэсэн хууль эрхийн болон удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээнүүдийн талаархи бичиглэлийг хавсаргана.

7. Тал тус бүр түүний хувьд энэ Конвенц хүчин төгөлдөр болох өдрөөс хэтрүүлэлгүйгээр III хавсралтад орсон химийн бодис бүрээр Нарийн бичгийн дарга нарын газарт хариу өгнө. Нэмэлт өөрчлөлт оруулсан Лондонгийн зарчим болон Хэрэглээний олон улсын кодын дагуу ийм хариу өгсөн Тал дахин өгөх шаардлагагүй.

8. Тал тус бүр өөрийн авч хэрэгжүүлсэн хууль эрхийн болон удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээтэй уялдуулан хууль эрхийнхээ хүрээнд сонирхогч этгээдүүдэд хариуны талаар энэ зүйлийн дагуу мэдээлнэ.

9. Хэрэв дээрхи 2 болон 4 дүгээр заалт, мөн 11 дүгээр зүйлийн 2 дугаар заалтын дагуу химийн бодисыг импортлохыг үл зөвшөөрөх, эсвэл зөвхөн тусгай нөхцлийн дагуу импортлохыг зөвшөөрөх шийдвэр гаргасан Тал уг үйлдлээ гүйцэтгээгүй байгаа бол нэгэн зэрэг хориглох эсвэл дараах хоёр тохиолдлын хувьд адил төстэй нөхцөл байдал тогтооно. Үүнд:

(а) дурын эх үүсвэрээс химийн бодис импортлох;

(б) дотооддоо ашиглахаар химийн бодисыг дотооддоо үйлдвэрлэх.

10. Нарийн бичгийн дарга нарын газар өөрийн хүлээн авч буй хариуны талаар бүх Талуулад зургаан сар тутам мэдээлж байна. Энэ мэдээлэлд шийдвэр гаргахад үндэслэсэн хууль эрхийн болон удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээний талаар байгаа мэдээг оруулна. Нарийн бичгийн дарга нарын газар хариуг дамжуулж чадаагүй тохиолдолуудын талаар Талуудад мэдээлнэ.

11 дүгээр зүйл

III хавсралтад орсон химийн бодисыг экспортлохтой холбогдсон үүргүүд

1. Экспортлогч Тал тус бүр:

(а) 10 дугаар зүйлийн 10 дугаар заалтын дагуу Нарийн бичгийн дарга нарын газраас ирүүлсэн хариунуудыг хууль эрхийн хүрээнд зохих Талуудад мэдэгдэх хууль эрхийн болон удирдлага, зохион байгуулалтын шаардлагатай арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

(б) 10 дугаар зүйлийн 10 дугаар заалтын дагуу Нарийн бичгийн дарга нарын газраас Талуудад ийм хариунуудын талаар мэдээлсэн өдрөөс хойш зургаан сараас хэтрүүлэлгүйгээр хариу бүрт тусгагдсан шийдвэрийн биелэлтийг хууль эрхийн хүрээнд Экспортлогч Талуудаар хангуулах эрх зүйн болон удирдлага зохион байгуулалтын зохих арга хэмжээ авна.

(в) Импортлогч Талуудад тэдний хүсэлтээр доорх тохиолдолд зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх Үүнд:

(1) 10 дугаар зүйлийн 4 дүгээр заалт болон энэ зүйлийн 2 (в) заалтын дагуу шийдвэр гаргахад шаардагдах нэмэлт мэдээлэл авах;

(2) Химийн бодисыг хүчинтэй хугацааных нь туршид аюулгүй ашиглах боломж, чадавхийг бэхжүүлэх.

2. Хэрэв аль нэг импортлогч Тал нь хариу ирүүлээгүй эсвэл ямар нэгэн түр шийдвэр агуулаагүй завсрын хариу ирүүлсэн онцгой тохиолдолд Тал тус бүр III хавсралтад орсон химийн бодисыг доорхиос бусад тохиолдолд түүнд экспортлохгүй. Үүнд:

(а) Тухайн химийн бодисыг импортлож байх үед түүнийг импортлогч Тал химийн бодис хэмээн бүртгэж авах;

(б) Тухайн химийн бодисыг импортлогч Тал урьд нь ашиглаж байсан болон импортлож байсан тухай баталгаа байгаа болон түүний ашиглалтыг хориглох шийдвэр гаргаагүй байх;

(в) Экспортлогч нь импортлогч Талын үндэсний томилогдсон

байгууллагад тухайн химийн бодисыг түүнд экспортлох хүсэлт тавьж импортын тодорхой зөвшөөрөл гаргуулж авна. Импортлогч Тал ийм хүсэлтийг 60 хоногийн дотор барагдуулж Нарийн бичгийн дарга нарын газарт өөрийн шийдвэрийн тухай яаралтай мэдэгдэнэ.

Нарийн бичгийн дарга нарын газар 10 дугаар зүйлийн 10 дугаар заалтын дагуу аль нэг Тал хариугаа ирүүлээгүй болон ямар нэгэн түр шийдвэр агуулаагүй завсрын хариу ирүүлсэн тухай Талуудад мэдэгдсэнээс хойш 6 сарын хугацаа өнгөрсний дараа Экспортлогч Тал энэ заалтын дагуу үүргээ 1 жилийн хугацаагаар хэрэгжүүлж эхлэнэ.

12 дугаар зүйл

Экспортын мэдэгдэл

1. Өөрийн нутаг дэвсгэр дээр ашиглахыг хориглосон болон онцгой хязгаарласан химийн бодисыг экспортолж байгаа Тал импортлогч Талд экспортын мэдэгдэл өгнө. Экспортын мэдэгдэлд V хавсралтад орсон мэдээллийг тусгана.

2. Тухайн бодисын хувьд эцэслэн шийдвэрлэсэн тогтоол гарсны дараа анхны экспорт хийхийн өмнө экспортын мэдэгдэл өгнө. Түүнээс хойш экспортын мэдэгдлийг аль нэг хуанлийн жилд анхны экспорт хийхийн өмнө өгнө. Экспорт хийхээс өмнө мэдэгдэл өгөх шаардлагаас импортлогч Талын үндэсний томилогдсон байгууллага татгалзаж болно.

3. Экспортлогч Тал аль нэг химийн бодисын хориглолт, онцгой хязгаарлалтыг өөрчилсөн эцэслэн шийдвэрлэх тогтоол гаргавал импортлогч Талдаа экспортын шинэчилсэн мэдэгдэл өгнө.

4. Импортлогч Тал нь эцэслэн шийдвэрлэх тогтоол гарсны дараа хүлээн авсан анхны экспортын мэдэгдлийг авсан тухайгаа хариу мэдээнэ. Хэрэв экспортлогч Тал экспортын мэдэгдлээ явуулснаас хойш гучин өдрийн дотор хариу авахгүй бол хоёр дахь мэдэгдлээ явуулна. Экспортлогч Тал нь өөрийн өгсөн хоёр дахь мэдэгдлээ импортлогч Талд хүргэх талаар хүчин чармайлт гаргана.

5. I дүгээр заалтад тусгагдсан Талын хүлээх үүрэг дараах тохиолдолд хүчингүй болно. Үүнд:

(а) Тухайн химийн бодис III хавсралтад орох;

(б) Импортлогч Тал тухайн химийн бодис талаар 10 дугаар зүйлийн 2 дугаар заалтын дагуу Нарийн бичгийн дарга нарын газарт хариу ирүүлэх;

(в) Нарийн бичгийн дарга нарын газар 10 дугаар зүйлийн 10 дугаар заалтын дагуу уг хариуны тухай Талуудад мэдээлэх.

13 дугаар зүйл

Экспортлогдож буй химийн бодисыг дагалдах мэдээлэл

1. Талуудын бага хурал III хавсралтад орсон бие даасан бодисууд болон нэг хэсэг химийн бодисын хувьд гаалийн тодорхой зөвшөөрөгдсөн кодын систем гаргаж мөрдүүлэхийг санал болгоно. Кодын систем мөрдөгдөж эхлэхэд экспортлогдож байгаа химийн бодис бүрийг дагалдах бичиг баримтад зохих кодыг тавьсан байхыг Тал бүр шаардана.

2. Талууд импортлогч Талын аль нэг шаардлагыг хөндөхгүйгээр III хавсралтад орсон химийн бодисууд болон экспортлогч Талын нутаг дэвсгэрт ашиглахыг хориглосон эсвэл онцгой хязгаарласан химийн бодисуудыг экспортлоход олон улсын стандартын дагуу хүний эрүүл мэнд эсвэл байгаль орчинд эрсдэл, хорт нөлөө үзүүлэхгүй байлгахын тулд хангалттай мэдээлэл агуулсан шошго хийх шаардлагыг тавина.

3. Талууд импортлогч Талын аль нэг шаардлагыг хөндөхгүйгээр өөрсдийн нутаг дэвсгэрт байгаль орчин эсвэл хүний эрүүл мэндийг хамгаалах үүднээс шошгожуулах шаардлага тавигдсан химийн бодисыг экспортлоход олон улсын стандартын дагуу хүний эрүүл мэнд эсвэл байгаль орчинд эрсдэл, хорт нөлөө үзүүлэхгүй байлгахын тулд хангалттай мэдээлэл агуулсан шошго хийх шаардлага тавьж болно.

4. 2 дугаар заалтад дурьдагдсан, мэргэжлийн зорилгоор ашиглах химийн бодисуудын хувьд экспортлогч Тал бүр олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрсөн загвар бүхий хамгийн сүүлийн үеийн аюулгүйн мэдээ агуулсан хуудсыг импортлогч Талуудад явуулахыг шаардана.

5. Шошгон дээрхи болон аюулгүйн мэдээ агуулсан хуудсан дахь мэдээлэлийг боломжийн хэрээр импортлогч Талын нэг эсвэл хэд хэдэн албан ёсны хэл дээр өгнө.

14 дүгээр зүйл

Мэдээлэл солилцох

1. Талууд энэ Конвенцийн зорилгод нийцүүлэн дараах зүйлүүдээр зохих дэмжлэг үзүүлнэ. Үүнд:

(а) Энэ Конвенцийн хүрээнд химийн бодисуудын талаартэдгээрийн хор аюул, экологийн хор аюул болон аюулгүйн мэдээллийг оруулсан судалгаа шинжилгээний, техникийн, эдийн засгийн болон хууль эрхийн мэдээлэл солилцох;

(б) Энэ Конвенцийн зорилгод нийцэх дотооддоо гаргасан

зохицуулалтын арга хэмжээний талаархи өргөн мэдээллийг өгөх;

(в) Химийн бодисын нэг буюу хэд хэдэн төрлийн ашиглалтыг ихээхэн хязгаарласан үйл ажиллагааныхаа тухай мэдээллийг бусад Талууддаа шууд эсвэл Нарийн бичгийн дарга нарын газраар дамжуулан өгөх.

2. Энэ Конвенцийн дагуу мэдээлэл солилцож байгаа Талууд харилцан тохирсон ёсоор мэдээллийн нууцыг хадгална.

3. Энэ Конвенцийн зорилгод дараах мэдээллийг нууц бус мэдээлэл гэж үзнэ. Үүнд:

(а) 5 болон 6 дугаар зүйлийг хэрэгжүүлэхээр I болон IV хавсралтад өгөгдсөн мэдээлэл;

(б) 13 дугаар зүйлийн 4 дүгээр заалтад өгөгдсөн аюулгүйн мэдээллийн хуудсанд орсон мэдээлэл;

(в) Химийн бодисын хугацаа дуусах он сар өдөр;

(г) Хор хөнөөлийн ангилал, эрсдлийн шинж төрх болон аюулгүй ажиллагааны зөвлөмж зэргийг хамарсан урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаархи мэдээлэл;

(д) Хор аюул болон экологийн хор аюулын туршилт шинжилгээний нэгдсэн дүн.

5. Өөрийн нутаг дэвсгэр дээгүүр III хавсралтад орсон химийн бодисыг өнгөрүүлж байгаатай холбогдуулан мэдээлэл шаардах Тал өөрийн хэрэгцээний талаар Нарийн бичгийн дарга нарын газарт мэдээлж болох бөгөөд тэр нь бүх Талуудад энэ тухай мэдэгдэнэ.

15 дугаар зүйл

Конвенцийг хэрэгжүүлэх

1. Тал тус бүр энэ Конвенцийг үр ашигтай хэрэгжүүлэхэд шаардагдаж болох дэд бүтэц болон үндэсний байгууллагуудыг бий болгох арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Энэ арга хэмжээнд зохих шаардлагын үүднээс үндэсний түвшинд хууль тогтоомж гаргах, өөрчлөх болон удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авах зэрэг ажлууд орохын зэрэгцээ дараах үйл ажиллгааг хамруулж болно. Үүнд:

(а) Химийн бодисыг аюулгүй ашиглах мэдээлэл зэргийг агуулсан үндэсний бүртгэлийн болон мэдээллийн сан байгуулах;

(б) Химийн аюулгүй байдлын талаар санаачлага гарган ажиллаж буй үйлдвэрийг урамшуулах;

(в) 16 дугаар зүйлийн заалтуудын дагуу сайн дурын үндсэн дээр гэрээ хэлэлцээр байгуулахад дэмжлэг үзүүлэх.

2. Тал тус бүр химийн бодистой харьцах, аюул ослын үеийн арга

ажиллагаа, дүрэм заавар болон III хавсралтад орсон химийн бодисуудтай харьцуулахад хүний эрүүл мэнд эсвэл байгаль орчинд хор нөлөө багатай адил төстэй химийн бодисуудын талаархи мэдээллийг олон нийтэд зохих ёсоор хүргэх ажлыг баталгаажуулна.

3. Талууд энэ Конвенцийг дэд бүсийн, бүсийн болон дэлхийн дахины түвшинд хэрэгжүүлэхэд шууд эсвэл эрх бүхий олон улсын байгууллагаар дамжуулан хамтран ажиллана.

4. Энэ Конвенцийн ямар ч заалт хүний эрүүл мэнд болон байгаль орчныг хамгаалахын тулд Талуудын зүгээс Конвенцид тусгагдсанаас илүү хатуу арга хэмжээ авах эрхийг хязгаарлахгүй бөгөөд ийм арга хэмжээ нь энэ Конвенц болон олон улсын хуулийн заалтуудтай уялдаж байх нөхцөлтэй.

16 дугаар заалт
Техникийн тусламж

Талууд хөгжиж буй болон шилжилтийн эдийн засагтай орнуудын хэрэгцээ шаардлагыг харгалзан энэ Конвенцийг хэрэгжүүлэхээр химийн бодисыг ашиглалтыг удирдан зохицуулах дэд бүтэц болон чадавхийг хөгжүүлэхэд техникийн тусламж үзүүлэхэд хамтран ажиллана. Химийн бодисыг журамлах талаар илүү дэвшилтэт хөтөлбөртэй Талууд химийн бодисын ашиглалтыг түүний хэрэглээний хугацааных нь туршид удирдан зохицуулах дэд бүтэц болон чадавхи бий болгон хөгжүүлэх сургалтыг оролцуулсан техникийн тусламжийг үзүүлэх ёстой.

17 дугаар зүйл
Дагаж мөрдөх

Талуудын бага хурал энэ Конвенцийг Талууд дагаж мөрдөж байгаа эсэхийг тодорхойлох болон дагаж мөрдөөгүй нь тогтоогдвол хэрхэн хандах талаар баримтлах журам болон зохион байгуулалтын механизм бий болгож батална.

18 дугаар зүйл
Талуудын бага хурал

1. Үүгээр Талуудын бага хурлыг зохион байгуулна.
2. Талуудын бага хурлын анхдугаар чуулганыг энэхүү Конвенц хүчин төгөлдөр болсноос хойш нэг жилийн дотор НҮБ-ын Орчны

Хөтөлбөрийн Гүйцэтгэх захирал болон НҮБ-ын Хүнс хөдөө аж ахуйн байгууллагын Ерөнхий захирал нар хамтран хуралдуулна. Цаашид Талуудын бага хурлын ээлжит чуулганыг бага хурлын анхны чуулганаар тогтоосон хугацаанд тогтмол зарлан хуралдуулна.

3. Талуудын бага хурлын ээлжит бус чуулганыг бага хурлаас шаардлагатай гэж үзсэн эсвэл аль нэг Талын бичгээр өгсөн хүсэлтийн дагуу Талуудын дор хаяж гуравны нэг нь дэмжсэн тохиолдолд хуралдуулна.

4. Талуудын бага хурал нь өөрийн болон туслах байгууллагуудынхаа үйл ажиллагааны болон санхүүгийн дүрэм, журам, тэрчлэн Нарийн бичгийн дарга нарын газрын үйл ажиллагаанд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийн талаар анхныхаа чуулганаар зөвшилд хүрч шийдвэр гаргана.

5. Талуудын бага хурал нь Конвенцийн хэрэгжилтийг байнга хэлэлцэж үнэлэлт өгнө. Тэрээр Конвенцоор хүлээлгэсэн үүргүүдийг хэрэгжүүлэх бөгөөд үүний тулд дараах үйл ажиллагааг явуулна. Үүнд:

(а) Конвенцийг хэрэгжүүлэхэд шаардлагатай гэж үзсэн туслах байгууллагуудыг байгуулах;

(б) Олон улсын эрх бүхий байгууллагууд, засгийн газар хоорондын болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах;

(в) Конвенцийн зорилгод хүрэхэд шаардагдах нэмэлт арга хэмжээг хэлэлцэж хэрэгжүүлэх.

6. Талуудын бага хурал анхныхаа чуулганаар энэхүү Конвенцийн хүрээнд зарим үүргүүдийг хүлээж ажиллах Химийн бодисын магадлах хороо гэж нэрлэгдэх туслах байгууллагыг байгуулна. Үүнтэй холбогдуулан:

(а) Химийн бодисын магадлах хорооны гишүүдийг Талуудын бага хурлаас томилно. Хорооны гишүүнчлэлд химийн бодисын ашиглалтын асуудал хариуцдаг мэргэжилтнүүдээ томилсон цөөн тооны Засгийн газрууд хамаарагдана.

Хорооны гишүүдийг газар зүйн байршлын тэнцүү хуваарилалтыг үндэс болгон, хөгжингүй болон хөгжиж буй Талуудын адил тэгш оролцоог ханган томилно;

(б) Талуудын бага хурал нь Хорооны гүйцэтгэх ажил, зохион байгуулалт болон үйл ажиллагааны талаар шийдвэр гаргана;

(в) Хороо нь өөрийн гаргасан зөвлөмжийг зөвшилцөх журмаар шийдвэрлүүлэхэд бүх хүчин чармайлт гаргана. Хэрэв бүх хүчин чармайлт үр дүнгүй болж зөвшилд хүрэхгүй бол санал асуулгад оролцож байгаа гишүүдийн гуравны хоёрын саналаар шийдвэрлэнэ.

7. НҮБ, түүний төрөлжсөн байгууллагууд болон Олон улсын

атомын эрчим хүчний агентлаг, тэрчлэн энэхүү Конвенцийн Тал бус аль нэг улс Талуудын бага хуралд ажиглагчаар оролцож болно. Энэхүү Конвенцийн хамрах асуудлаар мэргэшсэн үндэсний эсвэл олон улсын, засгийн газрын эсвэл төрийн бус ямар ч байгууллага Талуудын бага хуралд ажиглагчаар оролцох хүсэлтээ Нарийн бичгийн дарга нарын газарт илэрхийлсэн бол хуралд оролцогч Талуудын гуравны нэгээс илүү нь татгалзаагүй тохиолдолд хуралд оролцуулж болно. Ажиглагчдыг хуралд оролцуулах асуудлыг Талуудын бага хурлаар батлах журмаар зохицуулна.

19 дүгээр зүйл

Нарийн бичгийн дарга нарын газар

1. Үүгээр Нарийн бичгийн дарга нарын газар байгуулагдана.

2. Нарийн бичгийн дарга нарын газар нь дараах ажил үүргийг эрхлэн гүйцэтгэнэ. Үүнд:

(а) Талуудын бага хурал болон түүний туслах байгууллагууды хуралдааныг зохион байгуулах, шаадлагатай үйлчилгээ үзүүлэх;

(б) Талууд түүний дотор хөгжиж байгаа болон шилжилтийн эдийн засагтай орнуудад хүсэлтийн дагуу Конвенцийг хэрэгжүүлэхэд дэмжлэг тусламж үзүүлэх;

(в) Олон улсын холбогдох байгууллагуудтай Нарийн бичгийн дарга нарын газрын үйл ажиллагааг зохицуулах;

(г) Талуудын бага хурлын ерөнхий удирдамж зааврын дагуу өөрийн үйл ажиллагааг үр дүнтэй явуулахад шаардагдаж болох захиргааны болон гэрээ хэлцэл хийх ажилд оролцох;

(д) Энэхүү Конвенцийн хүрээнд Нарийн бичгийн дарга нарын газартай холбогдсон болон Талуудын бага хурлаас хүлээлгэж болох бусад ажил үүргүүдийг хэрэгжүүлэх.

3. Энэхүү Конвенцийн хүрээнд Нарийн бичгийн дарга нарын газрын ажил үүргийг НҮБ-ын Орчны Хөтөлбөрийн Гүйцэтгэх захирал, НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын Ерөнхий захирал нар хамтран гүйцэтгэх бөгөөд шаардлагатай асуудлуудыг харилцан тохиролцож Талуудын бага хурлаар батлуулан ажиллана.

4. Хэрэв Нарийн бичгийн дарга нарын газар ажил үүргээ зохих ёсоор гүйцэтгэж чадахгүй бол Талуулын бага хурлаас санал асуулгад оролцож буй Талуудын дөрөвний нэгээс дийлэнхийн саналаар түүний ажил үүргийг нэр хүнд бүхий олон улсын нэг эсвэл хэд хэдэн байгууллагад

шилжүүлэх шийдвэр гаргаж болно.

20 дугаар зүйл
Маргааныг зохицуулах

1. Талууд нь тэдний хооронд Конвенцийг хэрэглэх болон тайлбарлахтай холбогдон гарсан ямар ч маргааныг хэлцэл хийх буюу өөрсдийн сонгон авсан эвийн бусад аргаар зохицуулна.

2. Конвенцийг соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, сайшаан дэмжих үед буюу түүнд нэгдэн орох, мөн түүний дараа бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагын гишүүн бус аливаа Тал Конвенцийг хэрэглэх болон тайлбарлахтай холбогдсон ямар ч маргааны тухай эх бичиг хадгалагчид дурын үед бичгээр ирүүлж болох бөгөөд мөн тийм үүрэг өөртөө хүлээсэн бусад Талын маргааныг зохицуулахад дор дурдсан арга замын аль нэгийг буюу хоёуланг хүлээн зөвшөөрнө. Үүнд:

(а) Талуудын бага хурлаас шийдвэрлэн хавсралтаар гаргасан дүрэм журмын дагуу аль болох богино хугацаанд арбитраар хянан хэлэлцүүлэх;

(б) Маргааныг олон улсын шүүхэд шилжүүлэх.

3. Конвенцийн Тал болох бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага 2 дугаар заалтын (а)-д дурдсан журмын дагуу арбитраын шүүн шийдвэрлэсэнтэй төстэй мэдэгдэл гаргаж болно.

4. 2 дугаар заалтын дагуу хийсэн мэдэгдэл нь түүний нөхцөл болзлын дагуу хүчинтэй байх хугацаа дуусах хүртэл, эсвэл түүнийг буцаан татах тухай сануулгыг Эх бичиг хадгалагчид бичгээр өгснөөс хойш гурван сарын турш хүчин төгөлдөр байна.

5. Хэрэв маргалдагч Талууд өөрөөр тохироогүй бол мэдэгдлийн хүчинтэй байх хугацаа дуусах, түүнийг буцаан татах болон шинээр мэдэгдэл хийх зэрэг нь арбитраын шүүх болон Олон улсын шүүхээр хянагдаж буй асуудлыг ямар нэг байдлаар үл хөндөнө.

6. Хэрэв Талууд маргаандаа 2 дугаар заалтын дагуу түүнтэй адил эсвэл өөр ямар ч журам хэрэглээгүй бөгөөд тэдний хооронд маргаан байгааг нэг Тал нь нөгөөдөө мэдэгдсэнээс хойш арван хоёр сарын дотор маргааныг зохицуулж чадаагүй бол маргагч Талуудын аль нэгний хүсэлтээр түүнийг Эвийн комисст шилжүүлнэ. Эвийн комисстой холбогдсон нэмэлт журмыг Талуудын бага хурал хоёрдугаар чуулганаасаа хэтрүүлэлгүйгээр хавсралтаар баталж гаргана.

21 дүгээр зүйл

Конвенцид нэмэлт өөрчлөлт оруулах

1. Аль ч Тал энэ Конвенцид нэмэлт өөрчлөлт оруулах санал гаргаж болно.

2. Энэ Конвенцид оруулах нэмэлт өөрчлөлтийг Талуудын бага хурлаар батална. Нарийн бичгийн дарга нарын газар ямар нэг нэмэлт өөрчлөлт оруулах тухай саналыг хэлэлцүүлэх хурал эхлэхээс дор хаяж зургаан сарын өмнө Талуудад хүргүүлнэ. Нарийн бичгийн дарга нарын газар санал болгож буй нэмэлт өөрчлөлтийн тухай энэ Конвенцид гарын үсэг зурсан Талуудад мэдэгдэх бөгөөд Эх бичиг хадгалагчид мөн мэдээлэл өгнө.

3. Талууд энэ Конвенцид оруулах ямар нэг нэмэлт өөрчлөлтийг зөвшилцөх журмаар шийдвэрлүүлэхэд бүх хүчин чармайлт тавина. Хэрэв бүх хүчин чармайлт үр дүнгүй болж зөвшилд хүрэхгүй бол хуралдааны санал асуулгад оролцож байгаа гишүүдийн дөрөвний гурвын саналаар шийдвэрлэнэ.

4. Эх бичиг хадгалагч нь нэмэлт өөрчлөлтийг батламжлуулах, хүлээн зөвшөөрүүлэх эсвэл сайшаан дэмжүүлэхээр бүх Талуудад явуулна.

5. Батламжилсан, хүлээн зөвшөөрсөн эсвэл сайшаан дэмжсэн тухайгаа Эх бичиг хадгалагчид бичгээр мэдэгдэнэ. 3 дугаар заалтын дагуу оруулсан нэмэлт өөрчлөлт нь Талуудын дор хаяж дөрөвний гурваас дийлэнхийн саналаар батламжилсан, хүлээн зөвшөөрсөн эсвэл сайшаан дэмжсэн тухай баримт бичгийг Эх бичиг хадгалагч хүлээн авсан өдрөөс хойш ер дэх хоног дээр хүчин төгөлдөр болно. Түүнээс хойш ямар нэг Тал уг нэмэлт өөрчлөлтийг батламжлсан, хүлээн зөвшөөрсөн эсвэл сайшаан дэмжсэн тухай баримт бичгээ Эх бичиг хадгалагчид өгсөн өдрөөс хойш ер дэх хоног дээр тэрхүү нэмэлт өөрчлөлт уг Талын хувьд хүчин төгөлдөр болно.

22 дугаар зүйл

Хавсралтуудыг батлах, нэмэлт өөрчлөлт оруулах

1. Энэ Конвенцийн хавсралтууд нь түүний салшгүй хэсэг болох бөгөөд хэрэв өөрөөр заагаагүй бол Конвенцоос иш татах нь түүний хавсралтуудаас иш татсантай адил байх болно.

2. Хавсралтад зөвхөн шинжлэх ухаан-техник, удирдлага зохион байгуулалтын болон журмын чанартай асуудлыг оруулна.

3. Энэ Конвенцид шинээр хавсралт нэмж оруулах санал гаргах, батлах, хүчин төгөлдөр болгоход дараах журмыг баримтлана. Үүнд:

(а) Нэмэлт хавсралтыг 21 дүгээр зүйлийн 1, 2 болон 3 дугаар заалтуудад тусгагдсан журмын дагуу санал болгох буюу батална;

(б) Нэмэлт хавсралтыг хүлээн зөвшөөрөх боломжгүй аль нэг Тал энэ тухайгаа уг хавсралтыг шинээр нэмж оруулсан тухай Эх бичиг хадгалагчаас мэдээлэл авсан өдрөөс хойш нэг жилийн дотор түүнд бичгээр мэдэгдэнэ. Эх бичиг хадгалагч ийм мэдэгдэл бүрийг тухай бүр нь бүх Талуудад мэдээлнэ. Тал нь аль нэг нэмэлт хавсралтыг хүлээн зөвшөөрөх боломжгүй тухай өмнө өгсөн мэдэгдлээ дурын үед буцаан авч болох бөгөөд энэ тохиолдолд уг хавсралт тэрхүү Талын хувьд доорхи (в) заалтын дагуу хүчин төгөлдөр болно;

(в) Нэмэлт хавсралт шинээр нэмж оруулсан тухай Эх бичиг хадгалагчаас мэдээлэл тарааснаас хойш нэг жилийн хугацаа өнгөрсний дараа уг хавсралт (б) заалтын дагуу мэдэгдэл өгөөгүй бүх Талуудын хувьд хүчин төгөлдөр болно.

4. III хавсралтаас бусад тохиолдолд энэ Конвенцийн хавсралтуудад нэмэлт өөрчлөлт оруулах санал гаргах, батлах болон хүчин төгөлдөр болгох үйл ажиллагаа нь түүнд нэмэлт хавсралт оруулах санал гаргах, батлах болон хүчин төгөлдөр болгохтой адил журмын дагуу хийгдэнэ.

5: III хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах санал гаргах, батлах болон хүчин төгөлдөр болгох үйл ажиллагааг дараах журмаар явуулна. Үүнд:

(а) III хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах санал гаргах, батлах, хүчин төгөлдөр болгох үйл ажиллагааг 5 - 9 дүгээр зүйлүүд болон 21 дүгээр зүйлийн 2 дугаар заалтад тусгагдсан журмын дагуу явуулна;

(б) Талуудын бага хурал батлах шийдвэрээ зөвшилцөх журмаар гаргана;

(в) III хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулахаар гаргасан шийдвэрийг Эх бичиг хадгалагч Талуудад нэн даруй мэдээлнэ. Нэмэлт өөрчлөлт нь шийдвэрт заасан өдөр бүх Талуудын хувьд хүчин төгөлдөр болно.

6. Хэрэв шинээр оруулсан нэмэлт хавсралт эсвэл аль нэг хавсралтад оруулсан нэмэлт өөрчлөлт энэ Конвенцид о р у л а х нэмэлт өөрчлөлттэй холбоотой бол тэрхүү нэмэлт хавсралт эсвэл аль нэг хавсралтад оруулсан нэмэлт өөрчлөлт нь Конвенцид оруулсан нэмэлт өөрчлөлтийг хүчинтэй болтол хүчин төгөлдөр болохгүй.

Санал өгөх эрх

1. Доорхи 2 дугаар заалтад авч үзсэнээс бусад тохиолдолд энэ Конвенцийн Тал тус бүр нэг санал өгнө.
2. Бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагууд нь өөрийн эрхийн хүрээнд хамаарах асуудлаар энэ Конвенцийн Талууд болох гишүүн улсуудынхаа тоотой тэнцүү тооны саналтайгаар санал хураалтад оролцох эрх эдэлнэ. Хэрэв гишүүн улсуудын аль нэг нь санал өгөх эрхээ эдэлж байгаа тохиолдолд тэдгээр байгууллагууд санал өгөх эрх эдлэхгүй буюу дээрхийн эсрэг байна.

3. Энэ Конвенцийн зорилгод “оролцон санал өгөгч Талууд” гэдэг нь санал хураалтад оролцон баталгаажуулах эсвэл эсрэг санал өгөгч Талуудыг хэлнэ.

24 дүгээр зүйл

Гарын үсэг зурах

1. Энэ Конвенц бүх улс орнууд болон бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагууд гарын үсэг зурахад зориулж 1998 оны нээс нд д, мөн Нью Йорк хотноо НҮБ-ын Төв байранд 1998 оны нээс ... нд нээлттэй байна.

25 дугаар зүйл

Соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, сайшаан дэмжих ба нэгдэн орох

1. Энэ Конвенцийг улс орнууд болон бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагууд соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх буюу сайшаан дэмжинэ. Конвенцид гарын үсэг зурах хугацаа дууссан өдрөөс эхлэн түүнд улс орнууд болон бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагууд нэгдэн орох явдал нээлттэй болно. Батламжилсан, хүлээн зөвшөөрсөн, сайшаан дэмжсэн эсвэл нэгдэн орсон тухай баримт бичгийг Эх бичиг хадгалагчид хадгалуулахаар өгнө.
2. Нэг ч гишүүн улс нь Конвенцийн Тал болоогүй бол түүний Тал болсон бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны аль нэг байгууллага Конвенцийн бүх үүргийг өөртөө хүлээнэ. Мөн ийм байгууллагын хувьд түүний нэг эсвэл хэд хэдэн гишүүн улс энэ Конвенцийн Тал болсон тохиолдолд уг байгууллага болон тэдгээр гишүүд Конвенциор хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхэд тус тусын хүлээх хариуцлагын талаар шийдвэр гаргана. Ийм тохиолдолд уг байгууллага болон тэдгээр гишүүн орнууд

Конвенцийн хүрээнд нэгэн зэрэг эдлэх эрхээр хангагдахгүй.

3. Бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагууд нь батламжилсан, хүлээн зөвшөөрсөн, сайшаан дэмжсэн эсвэл нэгдэн орсон тухай баримт бичигтээ Конвенциор зохицуулагдах асуудлуудаар өөрийн эдлэх эрхийн хэр хэмжээг мэдэгдэнэ. Мөн эдгээр байгууллагууд нь өөрийн эдлэх эрхийн хэр хэмжээг өөрчилсөн бол энэ тухай Эх бичиг хадгалагчид мэдээлэх бөгөөд тэр нь бусад Талуудад мэдээлнэ.

26 дугаар зүйл

Хүчин төгөлдөр болох

1. Энэ Конвенц нь түүнийг батламжилсан, хүлээн зөвшөөрсөн, сайшаан дэмжсэн эсвэл нэгдэн орсон тухай тавь дахь баримт бичгийг Эх бичиг хадгалагчид өгснөөс хойш ер дэх хоног дээр хүчин төгөлдөр болно.

2. Батламжилсан, хүлээн зөвшөөрсөн, сайшаан дэмжсэн эсвэл нэгдэн орсон тухай тавь дахь баримт бичгийг хадгалуулснаас хойш уг Конвенцийг батламжилсан, хүлээн зөвшөөрсөн, сайшаан дэмжсэн эсвэл нэгдэн орсон улс эсвэл бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагын хувьд батламжилсан, хүлээн зөвшөөрсөн, сайшаан дэмжсэн эсвэл нэгдэн орсон тухай баримт бичгээ хадгалуулахаар өгсөн өдрөөс хойш ер хоногийн дараа уг Конвенц хүчин төгөлдөр болно.

3. 1 ба 2 дугаар заалтуудын хувьд бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагаас Эх бичиг хадгалагчид өгсөн ямар нэг баримт бичгийг түүний гишүүн орнуудаас өгсөн нэмэлт баримт бичиг гэж үзэхгүй.

27 дугаар зүйл

Хүлээн зөвшөөрөхгүй байх зарчим

Энэ Конвенцийг хэсэгчлэн хүлээн зөвшөөрөхгүй.

28 дугаар зүйл

Конвенциос гарах

1. Аль нэг Тал түүний хувьд энэ Конвенци хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш гурван жил өнгөрсний дараа дуртай үедээ Эх бичиг

хадгалагчид бичгээр мэдэгдэл өгч Конвенциос гарч болно.

2. Уг мэдэгдлийг Эх бичиг хадгалагч хүлээн авсан өдрөөс хойш нэг жилийн дараа эсвэл мэдэгдэлд заасан хугацаагаар тухай Талыг Конвенциос гарсан гэж үзнэ.

29 дүгээр зүйл

Эх бичиг хадгалагч

Нэгдсэн үндэстний байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга энэ Конвенцийн Эх бичиг хадгалагч байна.

30 дугаар зүйл

Ижил эх бичвэр

Энэ Конвенцийн жинхэнэ эх бичвэр нь англи, арав, испани, орос, хятад, франц хэл дээр цөм адил хүчинтэй үйлдэгдсэн бөгөөд Нэгдсэн үндэстний байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалагдана.

Үүнийг нотолж зохих бүрэн эрх бүхий дор нэр дурдсан төлөөлөгчид энэ Конвенцид гарын үсэг зурав.

Нэг мянга есөн зуун ерэн найман оны ... сарын ны өдөрд үйлдэв.

I хавсралт

5 ДУГААР ЗҮЙЛИЙН ДАГУУ ХИЙХ МЭДЭГДЭЛД
ШААРДАГДАХ МЭДЭЭЛЭЛ

Мэдэгдэлд дараах зүйлс орно. Үүнд:

1. Химийн шинж чанар түүний илрэлт болон хэрэглээний төрлүүд

- (а) Ерөнхий нэр;
- (б) Олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн номенклатур (жишээлбэл Онолын болон хавсрага химийн олон улсын холбоо) байгаа нөхцөлд түүнд орсон химийн нэр;
- (в) Худалдааны нэр болон бэлдэцийн нэр;
- (г) Кодын дугаар: Химийн шинжилгээний тойм бэлтгэх албаны дугаар, Гаалийн кодын нэгдсэн системийн болон бусад дугаарууд;
- (д) Ангилалд хамааруулах шаардлагатай химийн бодисуудыг аюулын зэргээр ангилсан мэдээлэл;
- (е) Химийн бодисын ашиглалтын төрлүүд;
- (ё) Физик-хими, хор аюул, экологийн хор аюулын шинж чанар.

2. Эцэслэн шийдвэрлэсэн тогтоол

- (а) Эцэслэн шийдвэрлэсэн тогтоолтой холбогдсон мэдээлэл. Үүнд:
- (I) Эцэслэн шийдвэрлэсэн тогтоолын товч тойм;
 - (II) Ашигласан дүрэм журмын баримт бичгүүд;
 - (III) Эцэслэн шийдвэрлэсэн тогтоол хүчин төгөлдөр болох он сар өдөр;
 - (IV) Эцэслэн шийдвэрлэсэн тогтоолыг эрсдлийн аль эсвэл хор өнөөлийн үнэлгээний үндсэн дээр гаргасан эсэхийг бичих, хэрэв ийм бол үнэлгээний талаархи мэдээллийг ашигласан дүрэм журмын хамт мэдээлэх;
- (V) Эцэслэн шийдвэрлэсэн тогтоолыг хүний эрүүл мэнд түүний дотор хэрэглэгчид болон ажиллагсдын эрүүл мэндийг эсвэл байгаль орчныг хамгаалах үүднээс гаргасан шалтгаан;
- (VI) Хүний эрүүл мэнд түүний дотор хэрэглэгчид болон ажиллагсдын эрүүл мэнд эсвэл байгаль орчинд учруулах хор хөнөөл болон эрсдэлийн товч тойм, эцэслэн шийдвэрлэсэн тогтоолоос үүдэх үр дагавар.
- (б) Эцэслэн шийдвэрлэсэн тогтоол гаргасан зэрэглэлүүд:
- (I) Эцэслэн шийдвэрлэсэн тогтоолоор хориглосон ашиглалтын төрлүүд;
 - (II) Ашиглалтын зөвшөөрөгдсөн төрлүүд;
 - (IV) Үйлдвэрлэсэн, импортлосон, экспортлосон болон ашигласан химийн бодисын тоо хэмжээний үнэлгээ.
- (в) Эцэслэн шийдвэрлэсэн тогтоол нь бусад улс болон бүс нутгийн хувьд хэр хамаатай болохыг заах:
- (г) Дараах асуудлуудыг хамарсан бусад мэдээлэл. Үүнд:
- (I) Эцэслэн шийдвэрлэсэн тогтоолын нийгэм-эдийн засгийн үр дагаварын үнэлгээ;
 - (II) Ижил төстэй химийн бодисууд, тэдгээртэй холбогдон гарах эрсдэл болон доорхи зүйлийг хамарсан мэдээлэл:
 - Хөдөө аж ахуйн хортон шавьжтай тэмцэх нэгдсэн стратеги;
 - Цэвэр технологийг оролцуулсан үйлдвэрлэлийн арга болон үйл ажиллагаа;

II хавсралт

ХОРИГЛОСОН БОЛОН ОНЦГОЙ ХЯЗГААРЛАСАН ХИМИЙН
БОДИСЫГ III ХАВСРАЛТАД ОРУУЛАХ ШАЛГУУР

Химийн бодисын шүүмжийн хороо нь 5 дугаар зүйлийн 5 дугаар заалтын дагуу Нарийн бичгийн дарга нарын газарт ирүүлсэн мэдэгдлүүдэд шүүмж хийхэд дараах үйлдлүүдийг гүйцэтгэнэ. Үүнд:

(а) Эцэслэн шийдвэрлэсэн тогтоолыг хүний эрүүл мэнд эсвэл байгаль орчныг хамгаалахын тулд гаргасныг батлах;

(б) Эцэслэн шийдвэрлэсэн тогтоолыг эрсдлийн үнэлгээний үр дүнд гаргасан болохыг тогтоох. Энэ үнэлгээ нь тухайн Талын голлох нөхцлүүдийг хамарсан шинжлэх ухааны мэдээ матариалд хийсэн шүүмжид тулгуурласан байна. Энэ зорилгоор баримт бичиг үйлдэхэд дараах шаардлагыг хангана:

(I) Мэдээ материалыг шинжлэх ухааны үндэслэлтэй аргаар гаргаж авсан байх;

(II) Мэдээ материалыг тоймлож, баримт бичигт оруулахдаа шинжлэх ухааны нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим болон дүрэм журамд үндэслэх;

(III) Эцэслэн шийдвэрлэсэн тогтоолыг гаргахдаа эдгээр арга хэмжээг авч байгаа Талын голлох нөхцлүүдийг эрсдлийн үнэлгээнд тулгуурлах.

(в) Эцэслэн шийдвэрлэсэн тогтоол нь химийн бодисыг III хавсралтад оруулах хангалттай үндэслэл болох эсэхийг дараах байдлыг харгалзан тодорхойлох Үүнд:

(I) Эцэслэн шийдвэрлэсэн тогтоол нь химийн бодисын ашиглалтын хэмжээ болон төрлийг эрс багасгасан болон багасгах эсэх;

(II) Эцэслэн шийдвэрлэсэн тогтоол нь мэдэгдэл өгсөн Талын хүний эрүүл мэнд эсвэл байгаль орчинд тохиолдох эрсдэлийг бодитойгоор багасгасан эсвэл ихээхэн хэмжээгээр багасгах эсэх;

(III) Эцэслэн шийдвэрлэсэн тогтоол гаргах үндэслэл нь зөвхөн газар зүйн хязгаарлагдмал орчин эсвэл хязгаарлагдмал нөхцөл байдалд хүчинтэй эсэх;

(IV) Тухайн химийн бодисыг олон улсын хэмжээнд худалдаалж буй баталгаа байгаа эсэх;

(г) Химийн бодисыг санаатайгаар буруу ашиглаж байгаа нь түүнийг III хавсралтад оруулах хангалттай шалтгаан болохгүй гэдгийг анхааралдаа авах.

III хавсралт

УРЬДЧИЛАН МЭДЭЭЛЖ ЗӨВШИЛЦӨХ ЖУРАМД ХАМААРАХ ХИМИЙН БОДИСУУД

Химийн бодисууд	Олон улсын код	Зориулалтын ангилал
2,4,5-Т	93-76-5	Пестицид
Алдрин	309-00-2	Пестицид
Каптафол	2425-06-1	Пестицид
Хлордан	57-74-9	Пестицид
Хлордимерформ	6164-98-3	Пестицид
Хлоробензилат	510-15-6	Пестицид
ДДТ	50-29-3	Пестицид
Делдрин	60-57-1	Пестицид
Диносив болон түүний давсууд	88-85-7	Пестицид
1, 2-дибромэтан, ЭДВ	106-93-4	Пестицид
Флуорацитамид	640-19-7	Пестицид
НСН изомерийн холимогууд	608-73-1	Пестицид
Гептахлор	76-44-8	Пестицид
Гексахлорбензин	118-74-1	Пестицид
Линдан	58-89-9	Пестицид
Мөнгөн усны нэгдлүүд, мөнгөн усны органик бус нэгдлүүд, алкил мөнгөн усны нэгдлүүд, алкилоксиалкил буюу мөнгөн усны арил нэгдлүүд		Пестицид
5 хлор фенол	87-86-5	Пестицид
Нэгкродифос (600 гр/литр идэвхт бодис бүхий шингэн хэлбэрт уусмал)	6923-22-4	Онцгой аюултай пестицидийн бүрэлдэхүүн
Метамидфос (600 гр/литр идэвхт бодис бүхий шингэн хэлбэрт уусмал)	10265-92-6	Онцгой аюултай пестицидийн бүрэлдэхүүн
Фосфоамидон (1000 гр/литр идэвхт бодис бүхий шингэн хэлбэрт уусмал)	13171-21-6 (E) & (Z) изомерийн холимог 23783-98-4 (Z)-изомерт 297-99-4 (γ)-изомерт	Онцгой аюултай пестицидийн бүрэлдэхүүн
Метил-паратрион (эмульсийн концентрац нь 19.5 %, 40%, 50% –ийн хэлбэрийн, 60% –ийн идэвхт бодис бүхий 1.5 %–ийн тоосонцор агуулсан, 2% ба 3% –ийн идэвхт бодис бүхий)	298-00-0	Онцгой аюултай пестицидийн бүрэлдэхүүн
Паратрион (суспензээс бусад аэрозоль, тоосонцор, эмульс, буурцагт хэлбэртэй)	56-38-2	Онцгой аюултай пестицидийн бүрэлдэхүүн

Кросидолит	12001-28-4	Үйлдвэрлэлийн
Олон хлорт бифенилүүд (РВВ)	59080-40-9 ажирЭ 27858-07-7 мисЭ 13654-09-6 бвиЭ	Үйлдвэрлэлийн
Олон хлорт бифенилүүд (РСВ)	1336-36-3	Үйлдвэрлэлийн
Олон хлорт терфенилүүд (РСТ)	61788-33-3	Үйлдвэрлэлийн
Трис (2,3 дибромпропил фосфатууд)	126-72-7	Үйлдвэрлэлийн

IV хавсралт
ОНЦГОЙ АЮУЛТАЙ ПЕСТИЦИДИЙН БҮРЭЛДЭХҮҮНИЙГ
III ХАВСРАЛТАД ОРУУЛАХАД ШААРДАГДАХ МЭДЭЭЛЭЛ
БОЛОН ШАЛГУУР

1 дүгээр хэсэг. Санал гаргагч Талаас шаардагдах баримт бичгүүд
6 дугаар зүйлийн 1 дүгээр заалтын дагуу гаргасан саналд дараах мэдээллийг агуулсан баримт бичгийг хавсаргана. Үүнд:

- (а) Аюултай пестицидийн бүрэлдэхүүний нэр;
- (б) Бүрэлдэхүүнд агуулагдах идэхитэй болон бусад бодисын нэр;
- (в) Бүрэлдэхүүнд агуулагдах идэвхитэй болон бусад бодисын харьцангуй хэмжээ;
- (г) Бүрэлдэхүүний төрөл;
- (д) Хэрэв байгаа бол үйлдвэрлэгчийн нэр болон худалдааны нэр;
- (е) Санал гаргагч Талд уг бүрэлдэхүүнийг өргөн хэрэглэж буй хэлбэрүүд;
- (ё) Бүрэлдэхүүнийг яаж ашигласан болон ямар хор уршиг илэрсэн зэргийг оруулан аюултай тохиолдол бүрийн тухай хийсэн нарийвчилсан бичлэг;
- (з) Санал гаргагч Талаас энэхүү аюултай тохиолдлын хариуд авсан болон авахаар төлөвлөж буй зохицуулалт, удирдлага зохион байгуулалтын болон бусад арга хэмжээ.

2 дугаар хэсэг. Нарийн бичгийн дарга нарын газраас цуглуулах мэдээлэл

6 дугаар зүйлийн 3 дугаар заалтын дагуу Нарийн бичгийн дарга нарын газраас аюултай пестицидийн бүрэлдэхүүнтэй холбогдсон зохих мэдээллийг цуглуулах бөгөөд дараах мэдээллийг хамруулна. Үүнд:

- (а) Физик-хими шинж чанар, хор аюул болон экологийн хор аюул;
- (б) Бусад орнуудад боловсруулах, хэрэглэхтэй холбогдуулан гаргасан хязгаарлалтын талаархи мэдээлэл;

- (в) Бусад орнуудад пестицидийн бүрэлдэхүүнтэй холбогдон гарсан аюултай тохиолдлын тухай мэдээлэл;
- (г) Бусад Талууд, олон улсын байгууллагууд болон төрийн бус байгууллагууд, түүнчлэн үндэсний болон олон улсын бусад эх үүсвэрүүдээс өгсөн мэдээлэл;
- (д) Эрсдэл болон аюулын үнэлгээ;
- (е) Пестицидийн бүрэлдэхүүний хэрэглээний цар хүрээг илтгэсэн мэдээлэл, жишээ нь бүртгэлийн тоо, үйлдвэрлэл, худалдааны хэмжээг зэргийг байгаа боломжоор нь мэдээлэх;
- (ё) Пестицидийн бусад бүрэлдэхүүнүүд, тэдгээртэй холбогдсон аюултай тохиолдлууд;
- (з) Хөдөө аж ахуйн хортон шавьжтай тэмцэх ижил төстэй аргууд;
- (ж) Химийн бодисын шүүмжийн хорооноос энэ асуудалтай холбоотой гэж үзсэн бусад мэдээлэл.

3 дугаар хэсэг. Онцгой аюултай пестицидийн бүрэлдэхүүнийг
III хавсралтад оруулах шалгуур

Химийн бодисын шүүмжийн хороо нь 6 дугаар зүйлийн 5 дугаар заалтын дагуу Нарийн бичгийн дарга нарын газраас ирүүлсэн саналыг авч хэлэлцэхдээ дараах зүйлийг харгалзан үзнэ. Үүнд:

- (а) Пестицидийн бүрэлдэхүүнийг санал гаргагч Талын хүрээнд нийтээр хүлээн зөвшөөрсөн аргаар ашигласан нь аюултай тохиолдолд хүргэснийг илтгэсэн мэдээний найдвартай байдал;
- (б) Ийм аюултай тохиолдол нь уур амьсгал, нөхцөл байдал болон пестицидийн бүрэлдэхүүний ашиглалтын төрлөөр ойролцоо бусад улс орнуудад гарсан байдал;
- (в) Шаардлагатай дэд бүтэцгүй улс орнуудад зохих ёсоор өргөн хэрэглэгдэж чадахгүй байж болох техник, технологитой холбогдуулан боловсруулах болон ашиглах талаар хийсэн хязгаарлалт;
- (г) Бүртгэгдсэн сөрөг үр дагаврыг ашигласан пестицидийн бүрэлдэхүүнний хэмжээтэй харьцуулсан байдал;
- (д) Пестицидийн бүрэлдэхүүнийг санаатайгаар буруу ашиглаж байгаа нь түүнийг III хавсралтад оруулах хангалттай шалтгаан болохгүй.

V хавсралт

ЭКСПОРТЫН МЭДЭГДЭЛД ШААРДАГДАХ МЭДЭЭЛЭЛ

1. Экспортын мэдэгдэл дараах мэдээллийг агуулна. Үүнд:

- (а) Экспортлогч болон импортлогч Талуудын үндэсний томилогдсон байгууллагуудын нэр хаяг;
 - (б) Импортлогч Тал руу экспорт хийх урьдчилсан он сар өдөр;
 - (в) Хориглосон болон онцгой хязгаарласан химийн бодисын нэр, 5 дугаар зүйлийн дагуу Нарийн бичгийн дарга нарын газарт өгөхөөр I хавсралтад заасан мэдээллийн товч тойм. Хэрэв хольц болон бэлдэцэд нэгээс илүү химийн бодис орсон бол бодис тус бүрээр мэдээлэл өгнө;
 - (г) Химийн бодисыг импортлогч Талын ямар зэрэглэлд оруулах, уг зэрэглэлийн хүрээнд хэрхэн ашиглах талаар хийсэн мэдэгдэл;
 - (д) Химийн бодисын хортой нөлөөллийг багасгах талаар авах урьдчилан сэргийлэх арга хэмжээний тухай мэдээлэл;
 - (е) Хольц эсвэл бэлдэц байх тохиолдолд хориглосон болон онцгой хязгаарласан химийн бодисын найрлага;
 - (ё) Импортлогчийн нэр, хаяг;
 - (з) Импортлогч Талын үндэсний томилогдсон байгууллагад хэрэг болохоор Экспортлогч Талын үндэсний томилогдсон байгууллагад бэлэн байгаа дурын нэмэлт мэдээлэл.
2. Экспортлогч Тал энэхүү 1 дүгээр заалтад өгөгдсөн мэдээлэлд нэмэлт болгон I хавсралтад заасан иймэрхүү мэдээллийг импортлогч Талаас хүсэлт болгож болгосноор гаргаж өгнө.

ТЭЭВЭРЛЭХ, ЗАЙЛУУЛАХАД ХЯНАЛТ ТАВИХ ТУХАЙ БАЗЕЛИЙН КОНВЕНЦ

УДИРТГАЛ

Энэхүү Конвенцид оролцогч Талууд:

Аюултай болон бусад хог хаягдал, тэдгээрийг хил дамжуулан тээвэрлэх нь хүний эрүүл мэнд, байгаль орчинд хохирол учруулж болзошгүйг харгалзан,

-үйлдвэрлэлийн өсөлттэй уялдан гарах аюултай болон бусад хог хаягдлын төвөгтэй шинж байдал, тэдгээрийг хил дамжуулан тээвэрлэх явцад хүний эрүүл мэнд, байгаль орчинд учрах аюул улам нэмэгдэж байгааг ухамсарлан,

-аюултай хог хаягдлын хор хөнөөлөөс хүний эрүүл мэнд, байгаль орчныг хамгаалах хамгийн үр дүнтэй арга бол үйлдвэрлэлээс гарах хаягдлын хэмжээ, түүний аюулын чадавхийг бууруулах явдал гэдгийг мөн ухамсарлаж,

-аюултай болон бусад хог хаягдлыг зохицуулах түүний дотор хил дамжуулан тээвэрлэх, зайлуулах ажлыг хүний эрүүл мэнд, байгаль орчныг хамгаалах асуудалтай нийцүүлэх арга хэмжээг улс орнууд авч хэрэгжүүлэх үүрэгтэй гэдэгт итгэж,

-аюултай болон бусад хог хаягдлыг хаягдал гаргагч нь байгаль орчныг хамгаалахад зохицсон аргаар тээвэрлэн зайлуулах арга хэмжээг улс орнууд авч байх ёстойг тэмдэглэж,

-аюултай болон бусад хаягдлыг өөрийн нутаг дэвсгэрт оруулах, хаяхыг хориглох биеэ даасан эрхтэй гэдгийг улс орнууд бүрэн хүлээн зөвшөөрч,

-аюултай болон бусад хог хаягдлыг өөр улсад, ялангуяа хөгжиж буй орнуудад тээвэрлэх, зайлуулахыг таслах зогсоох эрмэлзлэл улам бүр өсөж байгааг мөн хүлээн зөвшөөрч,

-аюултай болон бусад хог хаягдлыг анх гаргасан тухайн улсад нь байгаль орчинд аюулгүй байдлаар зайлуулах ёстой гэдэгт итгэж,

-хаягдлыг анх гаргагч улсаас өөр аль ч улсад хил дамжуулан тээвэрлэх асуудал нь энэхүү Конвенцийн нөхцөлийг хангасан, хүний эрүүл мэнд, байгаль орчинд аюул учруулахгүй нөхцөлд л шийдвэрлэгдэх ёстой гэдгийг ухамсарлаж,

-аюултай болон бусад хог хаягдлыг хил дамжуулан тээвэрлэхэд тавих хяналтыг хүчтэй болгосноор тэдгээрийг тээвэрлэх хэмжээг нь багасгаж, байгаль орчинд халгүйгээр ашиглах боломжтой болно гэдэгт

итгэж,

Аюултай болон бусад хог хаягдлыг улс орондоо оруулах буюу гаргах, түүнд хяналт тавих талаар мэдээлэл солилцох арга хэмжээг улс бүр авбал зохино гэж үзэж,

Олон улсын болон бүс нутгийн хэлэлцээрүүдэд аюултай ачаа тээвэрлэхтэй холбогдуулан байгаль орчныг хамгаалах асуудал тусгагдсаныг тэмдэглэж,

Байгаль орчны асуудлаархи НҮБ-ын бага хурлын Тунхаглал Стокольм НҮБ-ын Хүрээлэн буй орчны хөтөлбөрийн Удирдах зөвлөлөөс 1987 оны 6 дугаар сарын 17-нд гаргасан аюултай хог хаягдлыг экологийн хувьд зүй зохистой ашиглах тухай 14/30 тоот шийдвэр дэх Каирын баримтлах чиглэл, зарчим, аюултай ачааг тээвэрлэх асуудлаар 1957 онд анх гаргасан /2 жил тутамд шинэчлэгдэж байдаг/ НҮБ-ын шинжээчя нарын хорооны зөвлөмж, НҮБ-ын системийн хүрээнд гаргасан холбогдох зөвлөмж, уриалга, баримт бичиг, дүрэм журам мөн түүнчлэн олон улсын болоод бүс нутгийн бусад байгууллагын судалгаа дүгнэлтийг анхааралдаа авч,

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 37 дугаар чуулган /1982/-аас гаргасан Дэлхий нийтийн байгаль орчны Харти-д заасан хүрээлэн буй орчныг хамгаалах, байгалийн нөөцийг зүй зохистой ашиглах дүрмийн зорилго, зарчим, үзэл санааг анхааран үзэж,

Улс орнууд хүний эрүүл мэндийг хамгаалах, байгаль орчны тэнцвэртэй байдлыг хадгалах талаар олон улсын өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх ёстой бөгөөд олон улсын эрх зүйн дагуу хариуцлага хүлээнэ гэдгийг баталж,

Энэхүү Конвенц болон түүнд хамаарах аливаа Протоколын заалтыг ноцтой зөрчсөн тохиолдолд олон улсын гэрээ хэлэлцээрийн холбогдох заалтыг хэрэглэнэ гэдгийг хүлээн зөвшөөрч,

Үйлдвэрлэлээс гарах аюултай болон бусад хог хаягдлын хэмжээг багасгах зорилгоор экологийн хувьд зохистой хаягдал багатай технологи дахин боловсруулах арга зам, бүтэц, аж ахуйн үр ашигтай систем боловсруулж нэвтрүүлэх шаардлагатай байгааг ухамсарлан,

Олон улсын харилцаанд түгшүүр төрүүлж буй аюултай болон бусад хог хаягдлыг хил дамжуулан тээвэрлэхэд тавих хяналтыг хүчтэй болгох, тээвэрлэлтийн хэмжээг аль болохоор багасгах шаардлагатайг тэмдэглэж,

Аюултай болон бусад хог хаягдлыг хууль бусаар хил дамжуулан тээвэрлэх асуудалд сэтгэл зовнин,

Аюултай болон бусад хог хаягдлыг зүй зохистой ашиглах боломж

хөгжиж буй орнуудын хувьд хязгаарлагдмал байгааг анхааралдаа авч,

Байгаль хамгаалах технологийг нэвтрүүлэх ажлыг өргөжүүлэх тухай НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн удирдах зөвлөлийн 14/16 тоот шийдвэр, Каирын баримтлах чиглэлийн үзэл санааны дагуу улс орнуудад гарч байгаа аюултай болон бусад хог хаягдлыг зүй зохистой ашиглах, ялангуяа хөгжиж буй орнуудад технологи нэвтрүүлэх ажлыг өргөжүүлэх шаардлагатай байгааг хүлээн зөвшөөрч,

Аюултай болон бусад хог хаягдлыг олон улсын Конвенц, зөвлөмжийн дагуу тээвэрлэх ёстойг мөн хүлээн зөвшөөрч,

Аюултай болон бусад хог хаягдлыг хил дамжуулан тээвэрлэх, зайлуулах үйл ажиллагаа нь зөвхөн байгаль орчинд халгүй аргаар явуулах нөхцөлд л хэрэгжих ёстойг эрхэмлэн үзэж,

Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас үүсэх аюултай болон бусад хог хаягдал, түүнийг ашиглах явцад гарч болох хортой нөлөөллөөс хүн амын эрүүл мэнд, хүрээлэн буй орчныг хатуу хяналтын дотор хамгаалах шийдвэр төгс байгаагаа илэрхийлж,

ДАРААХЬ ЗҮЙЛИЙГ ХЭЛЭЛЦЭН ТОХИРОВ: НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ

Конвенцийн үйлчлэх хүрээ

Энэхүү Конвенцид хил дамжуулан тээвэрлэх объект болох дор дурдсан хог хаягдлыг “Аюултай хог хаягдал” гэж үзнэ:

а/Хог хаягдал нь нэгдүгээр хавсралтын аль нэг ангилалд орсон боловч . . . дугаар хавсралтад заасан аливаа шинж чанарыг агуулаагүй бол;

б/Хог хаягдал нь /а/ хэсэгт хамаарахгүй боловч экспортлогч, импортлогч болон дамжуулан өнгөрүүлэгч Талуудын үндэсний хууль тогтоомжийн дагуу аюултай тогтоогдсон буюу аюултайд тооцогддог бол.

Хил дамжуулан тээвэрлэж байгаа хаягдал нь энэхүү Конвенцийн 2 дугаар хавсралт дахь аль нэг ангилалд хамаарагдаж байгаа бол түүнийг “бусад хог хаягдал” гэж үзнэ.

Цацраг идэвхит чанартайн улмаас олон улсын хяналтын бусад систем, түүний дотор цацраг идэвхит материалд тусгайлан хэрэглэгддэг олон улсын гэрээ хэлэлцээрт хамаарагдах хог хаягдлууд энэхүү Конвенцид үл хамаарна.

Далайн тээврийн хэрэгслийн хэвийн үйл ажиллагааны явцад

гардаг болон олон улсын эрх зүйн бусад баримт бичигт тусгагдсан хог хаягдлууд энэхүү Конвенцид мөн үл хамаарна.

ХОЁРДУГААР ЗҮЙЛ

Тодорхойлолт

Энэхүү Конвенцид:

1. "хог хаягдал"-үндэсний хууль тогтоомжийн заалтын дагуу зайлуульж байгаа болон зайлуулах юмс;

2. "ашиглах"-аюултай болон бусад хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, зайлуулах, хяналт тавих бүх үйл ажиллагаа;

3. "хил дамжуулан тээвэрлэх"-аюултай болон бусад хог хаягдлыг нэг улсын үндэсний хууль тогтоомжийн үйлчлэх нутгаас өөр нэг улсын үндэсний хууль тогтоомжийн үйлчлэх нутагт, эсвэл нутаг орноор нь дамжуулан тээвэрлэх, эсвэл аль нэг улсын үндэсний хууль тогтоомжид үл хамаарах нутагт болон тухайн нутгаар дамжуулан тээвэрлэх, наад зах нь хоёр улсыг хамрах үйл ажиллагаа;

4. "зайлуулах"-энэхүү Конвенцийн 4 дүгээр хавсралтад тодорхойлсон аливаа үйл ажиллагаа;

5. "зөвшөөрөгдсөн газар буюу объект"-аюултай болон бусад хог хаягдлыг зайлуулахад тухайн улсын зохих байгууллагаас зөвшөөрөл олгосон газар буюу объект;

6. "эрх бүхий байгууллага"-аюултай болон бусад хог хаягдлыг хил дамжуулан тээвэрлэх тухай мэдэгдэл, түүнтэй холбоотой бүхий л мэдээлэл болон 6 дугаар зүйлийн дагуу мэдэгдэлд хариу өгөх ажиллагааг газар зүйн нутгийн хүрээнд хариуцуулахаар тухайн Талаас томилсон төрийн байгууллага;

7. "товлосон төв"-13, 15 дугаар зүйлийн дагуу мэдээлэл хүлээн авах, дамжуулах асуудлыг хариуцсан, 5 дугаар зүйлд дурдсан Талын хуулийн этгээд;

8. "аюултай болон бусад хог хаягдлыг байгаль орчинд халгүйгээр зүй зохистой ашиглах"-аюултай болон бусад хог хаягдлыг ашиглах үед тэдгээрийн хортой нөлөөллөөс хүний эрүүл мэнд, байгаль орчныг хамгаалахын тулд авах боломжтой бүх арга хэмжээ;

9. "Үндэсний хууль тогтоомжийн үйлчлэх хүрээнд оршин нутаг"-тухайн улсын олон улсын эрх зүйн дагуу хүний эрүүл мэнд, байгаль орчны төлөв байдлыг хамгаалах талаар захиргааны болон эрх зүйн хэм хэмжээний хариуцлага хүлээх үүрэгтэй хуурай газар, ус, агаарын орон зай;

10. "экспортлогч улс"-аюултай болон бусад хог хаягдлыг хил

дамжуулан тээвэрлэж эхэлсэн буюу тээвэрлэхээр төлөвлөж буй Тал;

11. "импортлогч улс"-аюултай болон бусад хог хаягдлыг өөрийн нутаг эсвэл өөр улсын хууль тогтоомжид үл хамрах газар нутагт зайлуулах зорилгоор хүлээн авч байгаа буюу хүлээн авахаар төлөвлөж буй Тал;

12. "дамжуулан өнгөрүүлэгч улс"-аюултай болон бусад хаягдлыг экспортлох буюу импортлох бус, өөрийн нутгаар тээвэрлэн өнгөрүүлж байгаа, эсвэл өнгөрүүлэхээр төлөвлөж буй улс;

13. "сонирхогч улсууд"-Тал мөн бишээс үл хамаарах экспортлогч, импортлогч, дамжуулан өнгөрүүлэгч улсууд;

14. "этгээд"-хуулийн этгээд буюу бие хүн;

15. "экспортлогч"-аюултай болон бусад хог хаягдлыг экспортлох ажлыг зохион байгуулж байгаа Талын этгээд;

16. "импортлогч"-аюултай болон бусад хог хаягдлыг импортлох ажлыг зохион байгуулж байгаа Талын этгээд;

17. "тээвэрлэгч"-аюултай болон бусад хог хаягдлыг тээвэрлэх ажлыг гүйцэтгэгч этгээд;

18. "хаягдал гаргагч"-аюултай болон бусад хаягдлыг бий болгох үйл ажиллагаа явуулдаг этгээд, энэхүү этгээд нь тодорхойгүй бол уг хаягдлыг эзэмшиж байгаа буюу түүнд хяналт тавигч этгээд;

19. "зайлуулагч этгээд"-аюултай болон бусад хог хаягдлыг хүлээн авч зайлуулдаг этгээд;

20. "улс төр буюу эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага"-тухайн бүс нутгийн бүрэн эрхт улс орнуудын байгуулсан энэхүү Конвенцоор зохицуулагдах асуудлыг шийдвэрлэх эрх бүхий, дотоод журмын дагуу холбогдох баримт бичигт гарын үсэг зурах, батламжлах, хүлээн зөвшөөрөх, сайшаах, эсвэл түүнд нэгдэн орох зохих эрхээр хангагдсан байгууллага;

21. "хууль бус тээвэрлэлт"-энэхүү Конвенцийн 9 дүгээр зүйлд тодорхойлсон аюултай болон бусад хог хаягдлыг хил дамжуулан тээвэрлэх аливаа үйл ажиллагаа.

ГУРАВДУГААР ЗҮЙЛ

Аюултай хаягдлын үндэсний тодорхойлолт

1.Талууд энэхүү Конвенцид нэгдэн орсноос хойш 6 сарын хугацаанд өөрийн улсын хууль тогтоомжоор мөн тэдгээрийг хил дамжуулан тээвэрлэхтэй холбогдсон ямар нэгэн шаардлагуудын дагуу аюултай гэж үзсэн 1, 2 дугаар хавсралтуудад дурдсанаас бусад хог

хаягдлын талаар Конвенцийн Нарийн бичгийн дарга нарын газарт мэдээлнэ.

2.Талууд нэгдүгээр заалтын дагуу өгсөн мэдээлэлдээ гарсан аливаа өөрчлөлтийг тухай бүр нь Нарийн бичгийн дарга нарын газарт мэдэгдэж байна.

3.Нарийн бичгийн дарга нарын газар энэ зүйлийн 1, 2 дугаар заалтын дагуу хүлээн авсан мэдээллийг бүх Талуудад даруй хүргүүлж байна.

4.Талууд, 3 дугаар заалтын дагуу Нарийн бичгийн дарга нарын газраас ирүүлсэн мэдээллийг өөрсдийн экспортлогч нартаа хүргэх үүргийг хүлээнэ.

ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ

Ерөнхий үүрэг

1.а/ Талууд аюултай болон бусад хог хаягдлыг зайлуулах зорилгоор импортлохыг өөрийн эрх хэмжээний хүрээнд хориглосон тухай шийдвэрийг 13 дугаар зүйлд заасны дагуу бусад Талуудад мэдэгдэнэ.

б/ энэ зүйлийн 1-ийн “а”-д дурдсаны дагуу мэдэгдэл хүлээн авсан Талууд аюултай болон бусад хог хаягдлыг импортлохыг хориглосон Талуудад түүнийг экспортлохыг үл зөвшөөрч, хориг тавина;

с/ аюултай болон бусад хог хаягдлыг импортлоход хориг тавиагүй улстай харьцахдаа хэрэв импортлогч улс нь тодорхой ачаанд бичгээр албан ёсны зөвшөөрөл өгөөгүй бол Талуудад хог хаягдал тээвэрлэхийг үл зөвшөөрөх буюу хориглоно.

2. Талууд дараахь арга хэмжээг авна. Үүнд:

а/нийгэм, эдийн засаг, техникийн боломжийг харгалзан аюултай болон бусад хог хаягдлыг аль болохоор багасгах;

б/аюултай болон бусад хог хаягдлыг зайлуулах газраас үл хамааран байгаль орчинд халгүйгээр ашиглах объектуудыг боломжийнхоо хэрээр өөрийн нутагт байлгах;

с/аюултай болон бусад хог хаягдлыг ашиглахад оролцож буй хүмүүсийг уг хаягдлаас үүсэх хортой нөлөөллөөс хамгаалах бүхий л арга хэмжээ авах ба хэрэв ямар нэг хэмжээгээр сөрөг нөлөө үзүүлэх тохиолдолд хүний эрүүл мэнд, байгаль орчинд учруулах хор уршгийг багасгах арга хэмжээ авах;

д/аюултай болон бусад хог хаягдлыг хил дамжуулан тээвэрлэх үйл ажиллагааг байгаль орчинд халгүйгээр ашиглах шаардлагын дагуу

хязгаарлах тээвэрлэлтээс учирч болох сөрөг үр дагавраас хүний эрүүл мэнд, байгаль орчныг хамгаалсан нөхцөлд тээвэрлэх үйл ажиллагааг явуулж байх;

е/конвенцид Тал болж нэгдэн орсон улс төр болон эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагад хамаарах улс буюу хэсэг бүлэг улсуудад, ялангуяа хөгжиж буй улсуудад хэрэв тэд өөрсдийн хуулийн хүрээнд импортлохыг хориглосон буюу Талуудын анхны хуралдаанаар тодорхойлсон шалгуураар хог хаягдлыг байгаль орчинд халгүйгээр ашиглах боломжгүй гэж үзсэн тохиолдолд аюултай болон бусад хог хаягдлыг тэдгээрт экспортлохыг хориглох;

f/аюултай болон бусад хог хаягдлыг тээвэрлэснээс хүний эрүүл мэнд, байгаль орчинд учирч болох хортой нөлөөллийн талаар тодорхой мэдээллийг хавсралт, YA-д заасны дагуу сонирхогч улсуудад хүргэхийг шаардах;

g/аюултай болон бусад хог хаягдлыг байгаль орчинд халгүйгээр ашиглах боломжгүй бол түүнийг импортлохыг хориглох;

h/аюултай болон бусад хог хаягдлыг байгаль орчинд халгүйгээр ашиглах аргыг боловсронгуй болгох, хууль бусаар тээвэрлэхээс сэргийлэх зорилгоор тийм хаягдлыг дамжуулан тээвэрлэхтэй холбогдсон мэдээлэл солилцох асуудлаар сонирхогч байгууллагууд болон бусад Талуудтай шууд буюу Нарийн бичгийн дарга нарын газраар дамжуулан хамтран ажиллах.

Талууд аюултай болон бусад хог хаягдлыг хууль бусаар тээвэрлэхийг гэмт хэрэг гэж үзнэ.

Энэхүү Конвенцийн заалтыг биелүүлэх, мөрдөхийн тулд түүнийг зөрчих аюулаас сэргийлэх, зөрчсөн тохиолдолд шийтгэл ногдуулах талаар Талууд эрх зүй, захиргааны болон холбогдох бусад арга хэмжээ авна.

Талууд аюултай болон бусад хог хаягдлыг Конвенцид нэгдэн ороогүй улсаас импортлох, экспортлохыг хориглоно.

Талууд аюултай болон бусад хог хаягдлыг хил дамжуулан тээвэрлэх хаягдал мөн бишээс үл хамааран өмнөд өргөргийн 600 урагш орших газар нутагт экспортлохгүй байхаар тохиролцов.

Үүнээс гадна Талууд:

a/аюултай болон бусад хог хаягдлыг тээвэрлэх, зайлуулах зөвшөөрлийг үндэсний хууль тогтоомжийн дагуу аваагүй этгээдийг ийм үйл ажиллагаа явуулахыг хориглоно;

b/аюултай болон бусад хог хаягдлыг хил дамжуулан тээвэрлэхэд түүнийг савлах,

тэмдэг тавих, тээвэрлэх үйл ажиллагааг олон улсын бүх нийтээр хүлээн зөвшөөрсөн олон улсын дүрэм, норм, туршлагын дагуу явуулахыг шаардана;

с/аюултай болон бусад хог хаягдлыг гаргаж байгаа газраас нь зайлуулах газар хүртэл тээвэрлэх талаар дагалт баримт бичгийг шаардана.

Талууд аюултай болон бусад хог хаягдлыг экспортлохдоо байгаль орчинд халгүйгээр ашиглах шаардлагыг импортлогч болон бусад улсуудад тавина. Энэхүү Конвенцид хамаарах хог хаягдлыг байгаль орчинд халгүйгээр ашиглах арга зүйн зарчмуудыг Талууд анхны хуралдаанаар тодорхойлно.

9.Талууд аюултай болон бусад хог хаягдлыг зөвхөн дор дурдсан нөхцөлд хил дамжуулан тээвэрлэж байх талаар холбогдох арга хэмжээг авна. Үүнд:

а/экспортлогч улс нь байгаль орчинд халгүйгээр зайлуулах техникийн хүчин чадал, боломж, тусгай тоног төхөөрөмж байхгүй буюу зайлуулах газар тохиромжгүй байх, эсвэл,

б/тийм хаягдал нь импортлогч улсын үйлдвэрт түүхий эд болгон дахин ашиглах буюу сэргээн ашиглах боломж байх, эсвэл,

с/хил дамжуулан тээвэрлэх ажиллагаа нь энэхүү Конвенцийн зорилгод нийцсэн бөгөөд Талуудын тодорхойлсон бусад шалгуурт тохирсон байх.

10.Аюултай болон бусад хог хаягдал гаргадаг улс нь түүнийг байгаль орчинд халгүйгээр ашиглахыг энэ Конвенцийн хүрээнд шаардах үүрэгтэй бөгөөд харин ямар ч тохиолдолд импортлогч буюу дамжуулан өнгөрүүлэгч улсад шилжүүлж болохгүй.

11.Хүний эрүүл мэнд, байгаль орчныг хамгаалах арга хэмжээг сайжруулах зорилгоор Талууд энэхүү Конвенцийн заалт болон олон улсын эрх зүйн хэм хэмжээнд нийцсэн нэмэлт шаардлага тавихад энэхүү Конвенц ямар нэг саад болохгүй.

12.Энэхүү Конвенц нь олон улсын эрх зүйн дагуу тогтоосон далайн болон эдийн засгийн бүс нутгийн халдашгүй дархан байдалд нөлөөлөхгүй бөгөөд олон улсын эрх зүйн хэм хэмжээ, баримт бичгийн дагуу усан болон агаарын тээвэр хийхэд саад болохгүй.

13.Талууд бусад улсуудад ялангуяа хөгжиж буй орнуудад экспортолж байгаа аюултай болон бусад хог хаягдлын хэмжээ, бохирдлын хортой нөлөөллийг багасгах боломжийг байнга судалж байх үүрэгтэй.

ТАВДУГААР ЗҮЙЛ

Эрх бүхий байгууллага буюу Товлосон төвийг томилох

Талууд энэхүү Конвенцийн хэрэгжилтийг дэмжих зорилгоор:

1.Нэг буюу хэд хэдэн эрх бүхий байгууллага ба нэг товлосон төвийг томилох буюу байгуулна. Дамжуулан өнгөрүүлэх улсын хувьд мэдээлэл хүлээн авч байх зорилгоор нэг эрх бүхий байгууллагыг томилно.

2.Энэхүү Конвенцийг хүчин төгөлдөр болсноос хойш 3 сарын дотор өөрийн эрх бүхий байгууллага болон товлосон төвийг байгуулсан тухай Нарийн бичгийн дарга нарын газарт мэдэгдэнэ.

3.Энэ зүйлийн 2 дугаар заалтад хамаарах ямар нэг өөрчлөлт хийсэн тухай шийдвэрийг нэг сарын дотор Нарийн бичгийн дарга нарын газарт мэдээлнэ.

ЗУРГАДУГААР ЗҮЙЛ

Талууд хоорондоо хил дамжуулан тээвэрлэх

1.Экспортлогч улс аюултай болон бусад хог хаягдлыг хил дамжуулан тээвэрлэхээр төлөвлөж буй экспортлогч болон хаягдал гаргагчаас экспортлогч улсын эрх бүхий байгууллагаар дамжуулан сонирхогч улсын эрх бүхий байгууллагад бичгээр мэдээлэхийг шаардна. Ийм мэдэгдэлд ҮА дугаар хавсралтын дагуу өргөдөл ба мэдээллийг импортлогч улсын эх хэлээр бичнэ. Сонирхогч улс бүрт уг мэдэгдлийг хүргүүлнэ.

2.Импортлогч улс мэдэгдэл хүлээн авсан тухай бичгээр хариу өгөх ба түүндээ зөвшөөрсөн эсэх, тодорхой нөхцөлд зөвшөөрсөн буюу нэмэлт мэдээлэл шаардсан тухайгаа дурдсан байна. Импортлогч улсад өгөх эцсийн хариуны хуулбарыг сонирхогч Талуудын эрх бүхий байгууллагад явуулна.

3.Экспортлогч улс дараахь баталгааг албан ёсоор бичгээр авсан тохиолдолд хаягдлыг хил дамжуулан тээвэрлэх ажлыг эхлэх зөвшөөрөл олгоно. Үүнд:

а/импортлогч улсаас бичгээр зөвшөөрөл авсан байх;

б/хаягдлыг экспортлогч болон түүнийг зайлуулахаар хүлээн авагч хоёр этгээдийн хооронд байгаль орчинд халгүй байдлаар ашиглах тухай гэрээ байгуулсныг импортлогч улс нотолсон байх.

4.Дамжуулан өнгөрүүлэгч Талууд нь мэдэгдэл хүлээн авсан тухайгаа нотолж даруй эргэж мэдэгдэнэ. Дараа нь зөвшөөрөл олгох

эсэх, тодорхой нөхцөлд зөвшөөрсөн, нэмэлт мэдээлэл шаардлагатай зэргийг 60 хоногийн дотор бичгээр мэдэгдэнэ. Экспортлогч улс нь дамжуулан өнгөрүүлэгч улсаас зөвшөөрлийн бичиг аваагүй нөхцөлд хил дамжуулан тээвэрлэх үйл ажиллагааг эрхлэх зөвшөөрөл олгохгүй. Гэхдээ тухайн Тал аюултай болон бусад хог хаягдлыг хил дамжуулан тээвэрлэх талаар урьдчилсан зөвшөөрлийг бичгээр огт шаардахгүй буюу тодорхой нөхцөлд шаардахгүй байх шийдвэр гаргасан буюу эсвэл энэ талаар шаардлагаа өөрчилсөн бол 13 дугаар зүйлийн дагуу бусад Талуудад даруй мэдэгдэнэ. Энэ тохиолдолд дамжуулан өнгөрүүлэгч улс мэдэгдэл хүлээн авснаас хойш 60 хоногийн дотор экспортлогч улсад хариу өгөөгүй бол экспортлогч улс нь хил дамжуулан тээвэрлэх ажлыг эхэлж болно.

5.Хаягдлыг хил дамжуулан тээвэрлэхэд түүнийг хуулийн үндсэн дээр аюултай хаягдал гэж тодорхойлохдоо зөвхөн:

а/экспортлогч улс тодорхойлсон бол импортлогч, зайлуулагч этгээд болон экспортлогч улсад тавьдаг энэ зүйлийн 9 дүгээр заалтын шаардлагууд *mutatis mutandis* /зохих өөрчлөлттэйгээр/ экспортлогч этгээд болон экспортлогч улсад мөн адил тавигдана.

б/конвенцид Тал болж орсон импортлогч улс буюу импортлогч болон дамжуулан өнгөрүүлэгч орнууд тодорхойлсон бол экспортлогч этгээд болон экспортлогч улсад тавьдаг энэ зүйлийн 1,3,4,6 дугаар заалтын шаардлагууд *mutatis mutandis* /зохих өөрчлөлттэйгээр/ импортлогч буюу зайлуулах үүрэгтэй этгээд болон импортлогч улсад мөн адил тавигдана.

с/конвенцид Тал болж нэгдэн орсон дамжуулан өнгөрүүлэгч аливаа улс оронд зөвхөн 4 дүгээр заалтыг хэрэглэнэ.

6.Экспортлогч улс сонирхогч орнуудтай бичгээр тохиролцсон нөхцөлд нэгэн төрлийн физик, химийн шинж чанар бүхий хаягдлыг зайлуулах үүрэг бүхий нэгэн этгээдэд экспортлогч, импортлогч болон дамжуулан өнгөрүүлэгч улсын гаалийн хилийн боомтоор оруулж гаргах буюу дамжуулан өнгөрүүлж байнга тээвэрлэх тохиолдолд хаягдал гаргагч болон экспортлогчид ерөнхий мэдэгдэл ашиглахыг зөвшөөрч болно.

7.Тээвэрлэх гэж байгаа аюултай болон хог хаягдлын жагсаалт, нарийн тоо хэмжээ зэрэг тодорхой мэдээллийг авсан тохиолдолд сонирхогч улсууд 6 дугаар заалтад дурдсан ерөнхий мэдэгдлийг ашиглах зөвшөөрлөө бичгээр илэрхийлж болно.

8. 6, 7 дугаар хэсэгт заасан ерөнхий мэдэгдэл, бичгээр өгсөн зөвшөөрлийг аюултай болон бусад хог хаягдлыг 12 сарын турш олон

дахин тээвэрлэх үйл ажиллагаанд хэрэглэж болно.

9.Талууд аюултай болон бусад хог хаягдлыг хил дамжуулан тээвэрлэгч этгээдийн ачааг хүргэж өгсөн буюу хүлээн авсан тухай баримт бичигт гарын үсэг зурахыг шаардана. Мөн Талууд тухайн хаягдлыг хүлээн авсан, мэдэгдэлд заасны дагуу түүнийг зайлуулсан тухайгаа экспортлогч этгээд болон экспортлогч улсын эрх бүхий байгууллагад мэдэгдэхийг хаягдал зайлуулах үүрэг бүхий этгээдээс шаардана. Экспортлогч улс ийм мэдээлэл аваагүй бол экспортлогч этгээд эсвэл экспортлогч улсын эрх бүхий байгууллага энэ тухай импортлогч улсад мэдэгдэнэ.

10.Энэ зүйлийн дагуу шаардсан мэдэгдэл ба түүнд өгсөн хариуг сонирхогч талуудын эрх бүхий байгууллага болон Тал болж нэгдээгүй улсын Төрийн холбогдох байгууллагад илгээнэ.

11.Аюултай болон бусад хог хаягдлыг хил дамжуулан тээвэрлэх аливаа үйл ажиллагаа нь импортлогч болон дамжуулан өнгөрүүлэгч Талуудын хүсэлтээр даатгагдаж баталгаажсан байна.

ДОЛООДУГААР ЗҮЙЛ

Конвенцид Тал болж нэгдэн орсон улсаас нэгдэн
ороогүй улсын хилээр дамжуулан тээвэрлэх тухай

Конвенцид Тал болж нэгдэн орсон улсаас аюултай болон бусад хог хаягдлыг тал бус улсын хилээр дамжуулан тээвэрлэхэд энэхүү Конвенцийн 6 дугаар зүйлийн 2 дугаар заалтыг *mutatis mutandis* /зохих өөрчлөлттэйгээр/ хэрэглэнэ.

НАЙМДУГААР ЗҮЙЛ

Дахин импортлох үүрэг

Энэхүү Конвенцийн заалтын дагуу сонирхогч улсууд зөвшөөрөл олгосон аюултай болон бусад хог хаягдлыг хил дамжуулан тээвэрлэх үйл ажиллагаа гэрээний нөхцөлийн дагуу хэрэгжих боломжгүй тохиолдолд импортлогч улс экспортлогч орон болон Нарийн бичгийн дарга нарын газарт мэдэгдсэнээс хойш 90 хоногийн дотор буюу мөн сонирхогч улсуудтай тохиролцсон хугацаанд уул хаягдлыг байгаль орчинд халгүйгээр зайлуулах өөр боломж буйг олж чадаагүй бол экспортлогч улс уг хаягдлыг экспортлогчид буцаах боломжийг бүрдүүлнэ. Үүнийг үндэслэн экспортлогч улс болон дамжуулан өнгөрүүлэгч аль ч Тал уг

хаягдлыг экспортлогч улсад буцаахад ямар нэгэн саад болох ёсгүй.

ЕСДҮГЭЭР ЗҮЙЛ
Хууль бусаар тээвэрлэх

1. Аюултай болон бусад хог хаягдлыг хил дамжуулан тээвэрлэх аливаа үйл ажиллагааг дараахь байдлаар гүйцэтгэсэн бол энэхүү Конвенцийн дагуу хууль бус тээвэрлэлт гэж үзнэ. Үүнд:

а/сонирхогч бүх улсуудад энэхүү Конвенцийн заалтын дагуу мэдэгдэл өгөөгүй; эсвэл,

б/сонирхогч бүх улсуудаас энэхүү Конвенцийн дагуу зөвшөөрөл аваагүй; эсвэл,

с/хуурах, залилан мэхлэх замаар сонирхогч улсуудаас зөвшөөрөл авсан; эсхүл,

д/баримт бичгийн шаардлагад нийцээгүй; эсвэл,

е/аюултай болон бусад хог хаягдлыг тээвэрлэх ажиллагаа нь энэхүү Конвенц болон олон улсын эрх зүйн ерөнхий зарчмыг зөрчсөн, санаатай үйлдэл болох.

2. Аюултай болон бусад хог хаягдлыг хил дамжуулан тээвэрлэх үйл ажиллагааг экспортлогч буюу хаягдал гаргагчаас шалтгаалан хууль бус тээвэрлэлт гэж үзсэн тохиолдолд экспортлогч улс дараахь арга хэмжээ авна. Үүнд:

а/шаардлагатай бол экспортлогч улс нь экспортлогч болон хаягдал ялгагчаар өөрийн нутаг дэвсгэрт буцааж авчруулах;

б/хууль бус тээвэрлэлт гэж үзсэн тухай экспортлогч улсад мэдээлснээс хойш 30 хоногийн дотор эсвэл сонирхогч улсуудтай тохиролцсон хугацаанд энэхүү Конвенцийн заалтын дагуу өөр аргаар зайлуулна. Энэ зорилгоор уг хаягдлыг экспортлогч улсад нь буцаахад сонирхогч Талууд ямар нэгэн саад эсэргүүцэл үзүүлэхгүй.

3. Аюултай болон бусад хог хаягдлын тээвэрлэлтийг импортлогч болон зайлуулагч этгээдээс шалтгаалан хууль бус гэж үзвэл импортлогч улс, импортлогч болон зайлуулах үүрэг бүхий этгээдээр уг хаягдлыг байгаль орчинд халгүйгээр зайлуулах ба шаардлагатай үед импортлогч улс өөрөө хууль бус тээвэрлэлтийн тухай мэдээлэл авснаас хойш 30 хоногийн дотор буюу эсвэл сонирхогч улсуудтай тохиролцож болох хугацааны дотор байгаль орчинд халгүйгээр зайлуулах арга хэмжээ авна. Сонирхогч Талууд хог хаягдлыг байгаль орчинд халгүйгээр зайлуулах шаардлагатай арга хэмжээг хамтран авна.

4. Экспортлогч, хаягдал гаргагч этгээд эсвэл импортлогч болон

зайлуулах үүрэг бүхий этгээдэд хууль бус тээвэрлэлтийн хариуцлага хүлээлгэх боломжгүй байх тохиолдолд сонирхогч Талууд болон Талууд хамтран экспортлогч, импортлогч улсуудад буюу өөр газарт уг хаягдлыг байгаль орчинд халгүйгээр зайлуулах арга хэмжээг яаралтай авна.

5.Талууд энэ зүйлийн заалтыг хэрэгжүүлэхийн төлөө хамтран ажиллах ба хууль бус тээвэрлэлтийг хориглох, түүнд шийтгэл ногдуулах талаар үндэснийнхээ хууль тогтоомжид тусгасан байна.

АРАВДУГААР ЗҮЙЛ

Олон улсын хамтын ажиллагаа

1.Аюултай болон бусад хог хаягдлыг байгаль орчинд халгүйгээр ашиглах ажлыг сайжруулах зорилгоор Талууд хамтран ажиллана.

2.Энэ зорилгоор Талууд:

а/хоёр болон олон талын хүсэлтийн үндсэн дээр аюултай болон бусад хог хаягдлыг байгаль орчинд халгүйгээр ашиглаж байгаа талаар мэдээллүүдийг танилцуулж, аюултай болон бусад хог хаягдлыг ашиглаж байгаа практик ажиллагаанд техникийн нормуудыг нийцүүлнэ.

б/аюултай болон бусад хог хаягдлыг ашигласнаас хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд үзүүлэх хортой нөлөөлөлд хамтран хяналт тавина;

с/аюултай болон бусад хог хаягдлыг гаргадаг үйлдвэрийг аль болохоор устгах зорилгоор одоогийн технологийг экологт сөрөг нөлөөлөлгүй, хаягдал бага гаргадаг болгон шинэчлэн сайжруулах, хаягдлыг байгаль орчинд халгүйгээр ашиглах талаар илүү үр дүнтэй арга зүйг шинээр боловсруулан хэрэглэх, эдгээр шинэ болон шинэчилсэн техник, технологи нэвтрүүлснээс эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр дагаврыг судлах талаар тус орнууд өөрсдийн үндэснийхээ хууль дүрэм, бодлогын хүрээнд хамтран ажиллана.

д/аюултай болон бусад хог хаягдлыг байгаль орчинд халгүйгээр ашиглах технологи дамжуулах, ялангуяа энэ талаар туслалцаа шаардлагатай Талуудын техникийн чадавхийг нэмэгдүүлэх талаар өөрсдийн хууль, дүрэм, бодлогын хүрээнд идэвхтэй хамтран ажиллана;

е/техникийн удирдлагын зарчим, холбогдох хууль, дүрэм боловсруулах асуудлаар хамтран ажиллана.

3.4 дүгээр зүйлийн 2 дугаар заалтын а, б, с хэсгүүдийг ялангуяа хөгжиж буй улсуудад хэрэгжүүлэхэд туслах талаар Талууд хамтарч шаардлагатай арга хэмжээ авна.

4.Хөгжиж буй орнуудын шаардлага хэрэгцээг харгалзан

үзсэний үндсэн дээр Талууд хоорондын болон олон улсын эрх бүхий байгууллагуудын хамтын ажиллагаа, ялангуяа /inter alia/ энэ асуудлаарх олон нийтийн ойлголтыг идэвхжүүлэх, аюултай болон бусад хог хаягдлыг байгаль орчинд халгүйгээр ашиглах үйл ажиллагааг өргөжүүлэх, хаягдал бага гаргадаг шинэ технологи нэвтрүүлэхэд нөлөөлөх зорилгоор хөхүүлэн дэмжинэ.

АРВАН НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ

Хоёр болон олон тал, бүс нутгийн хэлэлцээр

Талууд хоорондоо болон Тал болж нэгдэн ороогүй улс орнуудтай аюултай болон бусад хог хаягдлыг хил дамжуулан тээвэрлэх, байгаль орчинд халгүйгээр ашиглах талаар 5 дугаар зүйлийн 4 дүгээр заалтыг үл харгалзан энэхүү Конвенцийн шаардлагыг хангасан хоёр болон олон тал, бүс нутгийн гэрээ хэлэлцээр байгуулж болно. Эдгээр гэрээ хэлэлцээрүүд нь ялангуяа хөгжиж буй орнуудын сонирхлыг харгалзан, аюултай болон бусад хог хаягдлыг байгаль орчинд халгүйгээр зохицуулах замаар энэхүү Конвенцийн заалтыг хангасан байх ёстой.

Хэлэлцэн тохирогч Талуудын хооронд, энэхүү Конвенцийн дагуу аюултай болон бусад хог хаягдлыг хил дамжуулан тээвэрлэх үйл ажиллагаанд хяналт тавих зорилгоор Талууд нэгдүгээр заалтад заасан хоёр болон олон тал, бүс нутгийн энэхүү Конвенцид нэгдэн орохоос өмнө байгуулсан аливаа хэлэлцээрийн талаар Нарийн бичгийн дарга нарын газарт мэдэгдэнэ. Гагцхүү эдгээр гэрээ хэлэлцээрүүд аюултай болон бусад хог хаягдлыг байгаль орчинд халгүйгээр ашиглах талаар энэхүү Конвенцийн шаардлагаг хангасан байх шаардлагатай.

АРВАН ХОЁРДУГААР ЗҮЙЛ

Хариуцлагын талаар

Талууд аюултай болон бусад хог хаягдлыг хил дамжуулан тээвэрлэснээс гарах үр дагавар, хохирлыг арилгах, хүлээх хариуцлагын талаар зохих дүрэм, журмыг тусгасан протоколыг аль болох богино хугацаанд байгуулах зорилгоор хамтран ажиллана.

АРВАН ГУРАВДУГААР ЗҮЙЛ

Мэдээлэл дамжуулах

1.Талууд, аюултай болон бусад хог хаягдлыг тээвэрлэх,

зайлуулах үед осол болон хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд аюул учруулах нөхцөл бий болсон тухай мэдээ авсан даруй холбогдох бусад улсуудад яаралтай мэдэгдэх ёстой.

2.Талууд Нарийн бичгийн дарга нарын газраар дамжуулж дараахь мэдээллийг дамжуулна. Үүнд:

а/5 дугаар зүйлийн дагуу холбогдох эрх бүхий байгууллага, товлосон төвийн талаар гарсан өөрчлөлт;

б/3 дугаар зүйлийн дагуу аюултай хог хаягдлын шинж байдлын үндэсний тодорхойлолтод гарсан өөрчлөлт

Яаралтай мэдээлэх зүйл:

с/аюултай болон бусад хог хаягдлыг үндэсний хууль тогтоомжийн үйлчлэх газар нутагт импортлохыг бүр мөсөн буюу хэсэгчилсэн байдлаар хориглосон тухай шийдвэр;

д/аюултай болон бусад хог хаягдлыг экспортлохыг хориглосон буюу хязгаарлах тухай шийдвэр;

е/энэ зүйлийн 4 дүгээр заалтад шаардлагатай холбогдох бусад мэдээлэл.

3.Талууд үндэсний хууль, дүрмийн дагуу жил бүрийн эцэст Нарийн бичгийн дарга нарын газраар дамжуулан 15 дугаар зүйлийг үндэслэн байгуулсан Талуудын бага хуралд тайлангаа тавина. Тайланд дараахь зүйлийг оруулна. Үүнд:

а/5 дугаар зүйлийн дагуу томилогдсон эрх бүхий байгууллагууд болон товлосон төвийн тухай мэдээлэл;

б/аюултай болон бусад хаягдлыг хил дамжуулан тээвэрлэх аливаа үйл ажиллагаанд оролцсон тухай мэдээлэл; Үүнд:

-мэдэгдлийн хариунд заасан аюултай болон бусад хог хаягдлыг экспортлох хэмжээ, ангилал, шинж чанар, зайлуулах газар, дамжуулсан улс ба зайлуулсан арга,

-аюултай болон бусад хог хаягдлыг импортлох хэмжээ, түүний ангилал, шинж чанар, гарал үүсэл, зайлуулсан арга,

-хил дамжуулан тээвэрлэх аюултай болон бусад хог хаягдлын хэмжээг багасгах зорилгоор хийсэн ажил,

с/энэхүү Конвенцийг биелүүлэх талаар авсан арга хэмжээний тухай мэдээлэл;

д/аюултай болон бусад хог хаягдлыг гаргах, тээвэрлэх, зайлуулах явцад хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлж байгаа нөлөөллийн талаар цуглуулсан статистикийн найдвартай тоо баримт, мэдээлэл;

е/энэхүү Конвенцийн 12 дугаар зүйлийн дагуу байгуулсан хоёр болон олон тал, бүсийн гэрээ, хэлэлцээрүүдэд хамаарах мэдээлэл;

f/аюултай болон бусад хог хаягдлыг хил дамжуулан тээвэрлэх, зайлуулах үед гарсан аюул осол, түүний хор уршгийг арилгах талаар авсан арга хэмжээний тухай мэдээлэл;

g/үндэсний хууль тогтоомжийн үйлчлэх газар нутагт хаягдал зайлуулах боломжтой арга замын талаар мэдээлэл;

h/аюултай болон бусад хог хаягдал гаргахыг багасгах, улмаар зогсооход чиглэсэн технологи боловсруулах талаар авсан арга хэмжээний тухай мэдээлэл;

i/Талуудын Бага хурлын шаардсан бусад мэдээлэл.

4.Аль нэг Тал өөрийн байгаль орчны асуудалтай холбогдуулан хүсэлт гаргавал Талууд үндэснийхээ хууль, дүрмийн дагуу аюултай болон бусад хог хаягдлыг хил дамжуулан тээвэрлэхтэй холбогдсон мэдэгдлүүд, тэдгээрт өгсөн хариуны хуулбарыг Нарийн бичгийн дарга нарын газарт өгнө.

АРВАН ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ

Санхүүгийн асуудал

Бүсийн болон дэд бүс нутгийн тодорхой шаардлагыг харгалзан аюултай хог хаягдлыг багасгах, түүнийг оновчтой ашиглах технологийг нэвтрүүлэх, боловсон хүчин бэлтгэх бүсийн болон дэд бүсийн төвүүдийг байгуулахаар талууд тохиролцоно. Талууд энэ арга хэмжээг сайн дурын үндсэн дээр санхүүжүүлэх механизм буй болгох талаар шийдвэр гаргана.

Талууд аюултай болон бусад хог хаягдлыг хил дамжуулан тээвэрлэх, зайлуулах үеийн гэнэтийн аюул ослоос гарах хохирлыг багасгах зорилгоор онцгой тохиолдолд тусламж үзүүлэх эргэлтийн сан байгуулах асуудлыг шийдвэрлэнэ.

АРВАН ТАВДУГААР ЗҮЙЛ

Талуудын бага хурал

Талуудын бага хурлыг байгуулах:

Талуудын бага хурлын зохион байгуулна. Талуудын бага хурлын анхдугаар чуулганыг энэхүү Конвенц хүчин төгөлдөр болсноос хойш нэг жилийн дотор НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөрийн гүйцэтгэх захирал хуралдуулна. Цаашид Талуудын бага хурлын ээлжит чуулганыг бага хурлын анхны чуулганаар тогтоосон хугацаанд тогтмол зарлан хуралдуулж байна.

Талуудын бага хурлын ээлжит бус чуулганыг хуралдуулах чухал

шаардлагатай гэж үзсэн Тал энэ тухай хүсэлтийг Нарийн бичгийн дарга нарын газарт бичгээр гаргана. Нарийн бичгийн дарга нарын газраас энэ хүсэлтийг Талуудад уламжилснаас хойш 6 сарын дотор Талуудын гуравны нэгээс доошгүй нь дэмжсэн тохиолдолд зарлан хуралдуулна.

Талуудын бага хурал нь өөрийн болон туслах байгууллагуудынхаа үйл ажиллагааны дэг журам, Конвенцийн хүрээнд талуудын санхүүгийн оролцооны дүрмийн талаар нэгдсэн зөвшилд хүрэх шийдвэр гаргана.

Энэ Конвенцийн хүрээнд далайн орчныг хамгаалахтай холбогдсон өөрийн хүлээсэн үүргийг биелүүлэх талаар ямар нэгэн нэмэлт арга хэмжээ авах асуудлыг Талууд анхны хуралдаанаараа авч хэлэлцэнэ.

Талууд бага хурал нь Конвенцийг бүрэн биелүүлэхэд тогтмол хяналт тавихын зэрэгцээ дараахь арга хэмжээг авна. Үүнд:

а/аюултай болон бусад хог хаягдлаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд учруулах хохирлыг багасгахад чиглэсэн бодлого, стратеги, арга хэмжээг уялдуулан зохицуулах;

б/Шаардлагатай гэж үзвэл энэхүү Конвенц болон түүний хавсралтуудад, ялангуяа /inter alia/ шинжлэх ухаан, техник, эдийн засгийн болон байгаль орчны талаарх мэдээллийг харгалзан үзсэн нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг авч хэлэлцэх, батлах,

с/Конвенцийг хэрэгжүүлэх, 11 дүгээр зүйлд заасан гэрээ, хэлэлцээрийг биелүүлэх явцад хуримтлуулсан туршлагад үндэслэн Конвенцийн зорилтыг хангахад шаардлагатай нэмэлт арга хэмжээг авах,

д/шаардлагатай гэж үзвэл Протокол гаргах;

е/энэ Конвенцийг хэрэгжүүлэхэд шаардлагатай туслах байгууллагуудыг байгуулна.

6. Нэгдсэн үндэстний байгууллага, түүний төрөлжсөн байгууллагууд, аливаа улс орон, мөн энэ Конвенцид нэгдэн ороогүй аливаа улс орон, Талуудын бага хуралд ажиглагчаар оролцож болно. Аюултай болон бусад хог хаягдлын асуудлаар эрх мэдэл бүхий олон улсын болон үндэстний, Засгийн газрын болон төрийн бус ямар ч байгууллага хуралд оролцох хүсэлтээ Нарийн бичгийн дарга нарын газарт илэрхийлж, хэрэв оролцогч Талуудын гуравны нэгээс доошгүй хэсэг нь зөвшөөрвөл энэ хуралд ажиглагчаар оролцож болно. Ажиглагчаар оролцох үйл ажиллагааг Талуудын бага хурлын дүрэм журмаар зохицуулна.

7. Талуудын бага хурал энэхүү Конвенц хүчин төгөлдөр болсноос хойш эхний 3 жилд, дараа нь 6 жилд нэгээс доошгүй удаа түүний үр дүнг үнэлэх ба хэрэв шаардлагатай гэж үзвэл сүүлийн үеийн шинжлэх ухаан,

эколог, техник эдийн засгийн мэдээллийг үндэслэн аюултай болон бусад хог хаягдлыг хил дамжуулан тээвэрлэх үйл ажиллагааг бүр мөсөн буюу хэсэгчлэн хориглох боломжийг авч хэлэлцэнэ.

АРВАН ЗУРГАДУГААР ЗҮЙЛ
Нарийн бичгийн дарга нарын газар

Нарийн бичгийн дарга нарын газар нь дараахь ажлыг эрхлэн гүйцэтгэнэ. Үүнд:

а/15 болон 17 дугаар зүйлд заасны дагуу хурлыг зохион байгуулах;

б/3,4,6,11,13 дугаар зүйлийн дагуу авсан мэдээлэл, 15 дугаар зүйлд заасан туслах байгууллагуудын хурлын мэдээлэл, мөн түүнчлэн Засгийн газар хоорондын буюу Төрийн бус байгууллагаас өгсөн мэдээллийг үндэслэн илтгэл бэлтгэж дамжуулах;

с/энэ Конвенцоор хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байгаа талаар илтгэл бэлтгэж Талуудын бага хуралд танилцуулах;

д/үүргээ амжилттай гүйцэтгэхэд олон улсын холбогдох бусад байгууллагуудтай үйл ажиллагаагаа уялдуулан зохицуулах, захиргааны болон бусад гэрээ хэлэлцээрийг байгуулах;

е/энэхүү Конвенцийн 5 дугаар зүйлийн дагуу Талуудын байгуулсан эрх бүхий байгууллагууд, товлосон төвүүдтэй холбоо тогтоож ажиллах;

ф/аюултай болон бусад хог хаягдлыг зайлуулж болох Талуудын баталсан газар, объектын талаар мэдээлэл бэлтгэж, Талуудад тараах;

г/дараахь мэдээллийг авч тэдэнд мэдээлж байх. Үүнд:

-техникийн тусламж боловсон хүчин бэлтгэх, нөөц боломж;

-шинжлэх ухаан техникийн мэдлэг, туршлага;

-зөвлөх, шинжээчдийн боломж;

-нөөц боломж зэрэг болно.

Оролцогч Талуудын хүсэлтээр дараахь чиглэлээр туслалцаа үзүүлнэ. Үүнд:

-энэ Конвенцийн хүрээнд мэдээлэх систем хэрэглэх;

-аюултай болон бусад хог хаягдлыг байгаль орчинд халгүйгээр ашиглах;

-аюултай болон бусад хог хаягдалтай холбогдох байгаль орчинд халгүй технологи болон хаягдал багатай буюу хаягдалгүй технологи нэвтрүүлэх;

-хаягдлыг зайлуулах боломж болон газрын үнэлгээ;

- аюултай болон бусад хог хаягдлын хяналт;
- онцгой тохиолдолд авах арга хэмжээ.

h/оролцогч Талуудын хүсэлтээр аюултай болон бусад хаягдлыг хил дамжуулан тээвэрлэх талаар мэдээллийг хянаж үзэх, мэдээллийн дагуу зайлуулах боломжтой эсэх, хаягдлыг экологийн халгүйгээр ашиглаж болох эсэх, зайлуулах газар нь экологийн хувьд тохирч байгаа эсэхийг хянахад тусалж чадах техникийн боломж бүхий зөвлөх болон зөвлөгөө өгөх фирмүүдийн тухай мэдээллээр хангана. Эдгээр асуудлыг Нарийн бичгийн дарга нарын газрын зардал хөрөнгөөр хэрэгжүүлэхгүй;

i/Нарийн бичгийн дарга нарын газар Талуудын хүсэлтээр хууль бус тээвэрлэлтийг илрүүлэхэд нь тэдэнд туслах ба хууль бус тээвэрлэлттэй холбогдсон аливаа мэдээллийг хүлээн авсан даруй сонирхогч Талуудад тараах;

j/Талууд онцгой нөхцөл байдалтай болсон улс оронд шинжээч тоног төхөөрөмж явуулж яаралтай тусламж үзүүлэх талаар олон улсын эрх бүхий байгууллагуудтай хамтран ажиллах;

k/Талуудын бага хурлаар тодорхойлсон энэхүү Конвенцтой холбоотой бусад ажил үүргийг гүйцэтгэнэ.

НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөрийн байгууллага 15 дугаар зүйлд заасан Талуудын бага хурлын анхдугаар чуулганыг дуустал Нарийн бичгийн дарга нарын ажлыг түр гүйцэтгэнэ.

Талуудын бага хурлын анхдугаар чуулганаар энэ Конвенцийн дагуу Нарийн бичгийн дарга нарын газрын үүргийг гүйцэтгэхэд бэлэн байгаагаар илэрхийлсэн Засгийн газар хоорондын эрх бүхий байгууллагуудаас Нарийн бичгийн дарга нарын газрыг зохион байгуулна. Мөн Талууд анхдугаар чуулганаараа Нарийн бичгийн дарга нарын газрын үүргийг нэгдүгээр заалтад дурдсаны дагуу түр гүйцэтгэсэн ажлын явцыг дүгнэж, энэ үүргийг гүйцэтгэхэд шаардлагатай механизмын талаар шийдвэр гаргана.

АРВАН ДОЛДУГААР БҮЛЭГ Конвенцид нэмэлт өөрчлөлт оруулах

1.Энэхүү Конвенц болон аливаа протоколд нэгдэн орсон Талууд тэдгээрт нэмэлт, өөрчлөлт хийх саналаа тавьж болно. Санал болгож буй нэмэлт, өөрчлөлтөд ялангуяа /inter alia/ шинжлэх ухаан, техникийн шаардлагыг харгалзан үзэх ёстой.

2.Энэ Конвенцид оруулах нэмэлт, өөрчлөлтийг оролцогч

Талуудын бага хурлын чуулганаар, аль нэг Протоколд оруулах нэмэлт, өөрчлөлтийг тухайн Протоколд оролцогч Талуудын зөвлөлгөөнөөр тус тус хэлэлцэж батална. Нарийн бичгийн дарга нарын газар энэ Конвенц ба аль нэг Протоколд оруулах нэмэлт, өөрчлөлтийн эх бичвэрийг хэрвээ тухайн Протоколд өөрөөр заагаагүй бол уг нэмэлт, өөрчлөлтийг хэлэлцэх зөвлөлгөөн болохоос 6 сараас доошгүй хугацааны өмнө Талуудад мэдэгдэх бөгөөд энэ санал болгосон нэмэлт өөрчлөлтийн эхийг Конвенцид гарын үсэг зурсан улсуудад тараана.

3.Оролцогч Талууд энэ Конвенцид оруулах нэмэлт, өөрчлөлтийн тухай саналыг нэгдсэн тохиролцоонд хүрч батлахын төлөө бүхий л хүчин чармайлт тавина. Тохиролцоонд хүрч чадахгүй бол эцсийн арга хэмжээ болгож нэмэлт, өөрчлөлтийг санал хураалтаар шийдвэрлэх бөгөөд санал хураахад зөвлөлгөөнд байлцсан болон санал хураалтад оролцсон Талуудын дөрөвний гурвын саналаар засварыг баталж эх бичвэр Хадгалагчаар дамжуулан батламжлах, сайшаах, албан ёсоор батлуулахаар оролцогч бүх Талуудад хүргүүлнэ.

4.Энэ зүйлийн 3 дугаар заалтын зарчмыг зөвлөлгөөнд байлцсан, санал хураалтад оролцсон Талуудын гуравны хоёроос доошгүйн саналаар баталдаг зарим протоколоос бусад аливаа Протоколд нэмэлт, өөрчлөлт оруулахад мөрдөнө.

5.Нэмэлт, өөрчлөлтийг батламжилсан, хүлээн зөвшөөрсөн, сайшаан дэмжсэн, албан ёсоор баталсан баримт бичгийг эх бичвэр Хадгалагчид өгч хадгалуулна. Энэ зүйлийн 3, 4 дүгээр заалтын дагуу оруулах нэмэлт, өөрчлөлт нь түүнийг зөвшөөрсөн Талуудын дөрөвний гурваас доошгүй нь эсвэл тухайн Протоколд өөрөөр заагаагүй бол Протоколын нэмэлт, өөрчлөлтийг баталсан Талуудын гуравны хоёроос доошгүй нь батламжилсан, хүлээн зөвшөөрсөн, сайшаан дэмжсэн, албан ёсоор баталсан тухай баримт бичгийг эх бичвэр Хадгалагчид хүлээн авснаас хойш 90 дэх хоногоос тэдгээр Талуудын хувьд тус тус хүчин төгөлдөр болно. Бусад Талуудын хувьд нэмэлт, өөрчлөлтийг батламжилсан, хүлээн зөвшөөрсөн, сайшаан дэмжсэн албан ёсоор баталсан тухай мэдэгдлээ өгснөөс хойш 90 дэх хоногоос уг нэмэлт өөрчлөлт хүчин төгөлдөр болно.

6.Энэ зүйлийн дотор байгаа “байлцсан, санал хураалтад оролцсон Талууд” гэдгийг санал хураалтад оролцож “татгалзсан”, “зөвшөөрсөн” санал өгсөн Талууд гэж ойлгоно.

АРВАН НАЙМДУГААР БҮЛЭГ

Хавсралтыг батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах

1.Энэхүү Конвенц болон аливаа протоколын хавсралт нь энэ Конвенц болон тухайн Протоколын салшгүй хэсэг байх бөгөөд хэрэв өөрөөр заагаагүй бол Конвенц болон Протоколоос иш татах нь тэдгээрийн хавсралтаас иш татсантай ижил байх болно. Хавсралтад зөвхөн шинжлэх ухаан-техникийн болон удирдлага, зохион байгуулалтын асуудлыг оруулна.

2.Хэрэв ямар нэгэн Протоколд түүнд оруулах хавсралтын талаар өөрөөр заагаагүй бол энэхүү Конвенц болон Протоколын хавсралтыг санал болгох, батлах, хүчин төгөлдөр болгоход дараах журмыг мөрдөнө:

а/энэхүү Конвенц болон Протоколын хавсралтыг 17 дугаар зүйлийн 2,3,4 дүгээр заалт дахь журмын дагуу хүлээн авах;

б/ энэхүү Конвенц болон холбогдох аливаа Протоколд оруулах нэмэлт хавсралтыг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзэж байгаа аливаа Тал тэдгээрийг баталсан тухай эх бичвэр Хадгалагчаас мэдээлснээс хойш 6 сарын дотор эх бичвэр Хадгалагчид энэ тухайгаа бичгээр мэдэгдэнэ. Эх бичвэр Хадгалагч нь мэдэгдэл хүлээн авсан тухайгаа бүх Талуудад нэн даруй мэдээнэ. Аливаа Тал хүссэн цагтаа өмнө илгээсэн татгалзсан мэдэгдлээ өөрчилж хүлээн авсан тухай мэдэгдэл өгч болох бөгөөд энэ үеэс эхлэн тухайн Талын хувьд хавсралт хүчин төгөлдөр болно.

с/эх бичвэр Хадгалагчаас мэдэгдэл тарааснаас хойш 6 сар болоод энэхүү Конвенц болон аливаа Протоколд хамаарах хавсралтуудад дурдсан /б/-д заасны дагуу мэдэгдлээ ирүүлээгүй бүх Талуудын хувьд хүчин төгөлдөр болно.

3.Энэхүү Конвенц болон аливаа Протоколын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах талаар санал дэвшүүлэх, батлах, хүчин төгөлдөр болох журам нь Конвенц болон аль нэг Протоколд нэмэлт хавсралт оруулах журамтай нэгэн адилаар зохицуулагдана. Хавсралт ба нэмэлт өөрчлөлтүүдэд, ялангуяа /inter alia/ шинжлэх ухаан-техникийн ойлголтыг харгалзан үзсэн байх шаардлагатай.

4.Хэрэв нэмэлт хавсралт, түүнд оруулах нэмэлт, өөрчлөлт нь энэ Конвенц болон аливаа Протоколд нэмэлт, өөрчлөлт оруулсантай холбоотой бол тэдгээр нь Конвенц болон Протоколд оруулсан нэмэлт, өөрчлөлт хүчин төгөлдөр болсны дараа хүчин төгөлдөр болно.

АРВАН ЕСДҮГЭЭР ЗҮЙЛ
Шалгалт

Оролцогч аливаа Тал нөгөө Талыг энэхүү Конвенцоор хүлээсэн үүргээ зөрчсөн эсвэл зөрчиж байна гэж үзэх үндэслэлтэй бол энэ тухайгаа Нарийн бичгийн дарга нарын газарт мэдэгдэнэ. Энэ тохиолдолд тухайн зөрчил гаргаж байгаа Талдаа шууд буюу Нарийн бичгийн дарга нарын газраар дамжуулан яаралтай мэдэгдэнэ. Нарийн бичгийн дарга нарын газар нь Талуудад зайлшгүй шаардлагатай мэдээллийг танилцуулна.

ХОРЬДУГААР ЗҮЙЛ
Маргааныг зохицуулах

1.Энэхүү Конвенц болон түүний Протоколыг мөрдөж хэрэгжүүлэх үед Талуудын хооронд маргаан, санал зөрөлдөөн гарвал түүнийг хэлэлцээний замаар буюу өөрсдөө сонгож авсан бусад ямар нэгэн эвийн аргаар зохицуулахыг эрмэлзэнэ.

2.Талууд дээр дурдсан аргаар маргааныг зохицуулж чадаагүй тохиолдолд харилцан тохиролцсоны үндсэн дээр маргааныг олон улсын шүүх эсвэл хөндлөнгөөс маргаан таслах тухай 6 дугаар хавсралтад дурдсаны дагуу арбитраг шилжүүлнэ. Маргааныг олон улсын шүүх эсвэл арбитраг шилжүүлэх талаар Талууд нэгдүгээр заалтад заасны дагуу хэлэлцээний замаар зохицуулах замыг тохиролцож чадаагүй тохиолдолд үргэлжлүүлэн хайх үүргээс чөлөөлөгдөхгүй.

3.Энэхүү Конвенцийг батламжлах, хүлээн зөвшөөрөх, сайшаан дэмжих, соёрхон батлах, түүнд нэгдэн орох үед болон энэ бүхний дараахь ямар ч үед аливаа улс болон улс төр, эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагаас Талууд дараахь арга замаар шийдвэрлэх үүрэгтэйг ipso facto /байгаа байдлаар нь/ хүлээн зөвшөөрч байгаагаа мэдэгдэж болно. Үүнд:

а/маргааныг олон улсын шүүхэд өгөх; эсвэл,

б/6 дугаар хавсралтад заасан журмын дагуу маргааныг арбитраг өгнө. Ийм өргөдлийг Нарийн бичгийн дарга нарын газарт бичгээр өгөх ба тэрээр Талуудад мэдэгдэнэ.

ХОРИН НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ
Гарын үсэг зурах

Энэхүү Конвенц нь Намиби Улсыг төлөөлж НҮБ-ын Намибийн

Зөвлөл, улс төр, эдийн засгийн хамт ажиллагааны байгууллагууд болон бусад улсууд гарын үсэг зурахад зориулж Базельд 1989 оны 3 дугаар сарын 22-нд, дараа нь Швейцарийн Берн дахь Холбооны департаментын гадаад хэргийн хэлтэст 1989 оны 3 дугаар сарын 23-наас 7 дугаар сарын 30-ны хооронд, Нью-Йорк дахь НҮБ-ын Төв байгууллагуудад 1989 оны 7 дугаар сарын 1-нээс 1990 оны 3 дугаар сарын 23-ны хооронд тус тус гарын үсэг зурахад нээлттэй байна.

ХОРИН ХОЁРДУГААР ЗҮЙЛ

Соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, албан ёсоор нотлох буюу сайшаан дэмжих

1. Энэхүү Конвенцийг Намиби Улсыг төлөөлж НҮБ-ын Намибийн Зөвлөл болон бусад улс орнууд соёрхон баталж, хүлээн зөвшөөрч, сайшаан дэмжих бөгөөд улс төр, эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагууд албан ёсоор нотолж сайшаан дэмжинэ. Батламжилсан, хүлээн зөвшөөрсөн, албан ёсоор нотолсон буюу сайшаан дэмжсэн тухай баримт бичгээ эх бичвэр Хадгалагчид хадгалуулахаар өгнө.

2. Энэ зүйлийн нэгдүгээр заалтад заасан энэ Конвенцид Тал болж нэгдэн орсон хамтын ажиллагааны байгууллага нь түүний гишүүн улсуудаас Тал болж нэгдэн ороогүй тохиолдолд Конвенцоос урган гарах бүхий л үүргийг хүлээнэ. Хэрэв тухайн байгууллагад нэг эсвэл хэд хэдэн гишүүн улсууд Конвенцид Тал болж орсон тохиолдолд уг байгууллага ч, түүний гишүүн улсууд ч хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх талаар шийдвэр гаргана. Энэ тохиолдолд тухайн байгууллага, түүний гишүүн улсууд энэ Конвенцийн дагуу давхар эрх эдлэхгүй.

3. Энэ зүйлийн нэгдүгээр заалтад дурдсан байгууллагууд өөрийн соёрхон баталсан, сайшаан дэмжсэн тухай баримт бичигтээ Конвенцоор зохицуулагдах асуудлын талаар өөрийн эрх хэмжээний хүрээг зааж өгөх ба цаашид эрх хэмжээнийхээ хүрээнд гарсан өөрчлөлтийг эх бичвэр Хадгалагчид тухай бүр нь мэдээлж байна.

ХОРИН ГУРАВДУГААР ЗҮЙЛ

Нэгдэн орох

1. Намиби улсыг төлөөлж НҮБ-ын Намибийн Зөвлөл, бусад улс орнууд болон улс төр, эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагуудын хувьд Конвенцид гарын үсэг зурах хугацаа дуусгавар болсны дараа өдрөөс нэгдэн орох явдал чөлөөтэй байх бөгөөд нэгдэн

орсон тухай баримт бичгээ эх бичвэр Хадгалагчид өгнө.

2.Энэ зүйлийн 1 дүгээр заалтад дурдсан байгууллагууд нэгдэн орсон тухай баримт бичигтээ Конвенцоор зохицуулагдах асуудлуудын талаар өөрийн эрх хэмжээний хүрээг зааж өгөх ба цаашид энэ талаар гарсан өөрчлөлтийг тухай бүр нь эх бичвэр Хадгалагчид мэдээлж байна.

3.22 дугаар зүйлийн 2 дугаар заалт энэхүү Конвенцид нэгдэн орсон улс төр, эдийн засгийн хамтын ажиллагааны бүс нутгийн байгууллагуудад нэгэн адил хамаарна.

ХОРИН ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ

Санал өгөх эрх

1.Энэ зүйлийн 2 дугаар заалтад дурдсанаас бусад тохиолдолд Конвенцийн аль ч Тал нэг санал өгнө.

2.Улс төр, эдийн засгийн хамтын ажиллагааны бүс нутгийн байгууллагууд 22 дугаар зүйлийн 3 дугаар заалт, 23 дугаар зүйлийн 2 дугаар заалтын дагуу өөрийн эрх хэмжээний хүрээний асуудлаар санал өгөх эрхтэй байна. Саналын тоо нь Конвенц эсвэл Протоколд оролцогч Талууд болох гишүүн улсуудын тоотой тэнцүү байна. Харин гишүүн улсууд санал өгч байхад байгууллага нь санал өгөх эрхээ эдлэхгүй, эсвэл байгууллага нь санал өгөх эрхээ эдэлж байхад гишүүн улсууд нь бие даан санал өгөх эрхгүй.

ХОРИН ТАВДУГААР ЗҮЙЛ

Хүчин төгөлдөр болох

1.Энэхүү Конвенц нь түүнийг батламжилсан, хүлээн зөвшөөрсөн, сайшаан дэмжсэн буюу нэгдэн орсон тухай 20 дахь баримт бичиг хадгалуулахаар өгсөн өдрөөс хойш ер дэх хоногоос эхлэн хүчин төгөлдөр болно.

2.Батламжилсан, хүлээн зөвшөөрсөн, сайшаан дэмжсэн буюу нэгдэн орсон тухай 20 дахь баримт бичгийг хадгалуулахаар өгснөөс хойш батламжлах, хүлээн зөвшөөрөх, сайшаан дэмжих буюу нэгдэн орж байгаа улс орон, хамтын ажиллагааны бүс нутгийн байгууллагын хувьд тэд өөрийн батламжилсан, хүлээн зөвшөөрсөн, сайшаан дэмжсэн буюу нэгдэн орсон тухай баримт бичгээ хадгалуулахаар өгснөөс хойш 90 дэх хоногоос эхэлж энэхүү Конвенц хүчин төгөлдөр болно.

3.Энэ зүйлийн 1, 2 дугаар заалтын хувьд эдийн засгийн хамтын

ажиллагааны бүс нутгийн байгууллагаас хадгалуулахаар өгсөн аливаа баримт бичгийг уг байгууллагын гишүүн орнуудын хадгалуулахаар өгсөн баримт бичгийн нэмэлт гэж үзэхгүй.

ХОРИН ЗУРГАДУГААР ЗҮЙЛ

Нэмэлт тайлбар ба мэдэгдэл

1. Энэ конвенцид ямар нэг нэмэлт тайлбар хийхийг зөвшөөрөхгүй.

2. Энэ зүйлийн нэгдүгээр заалт нь аль ч улс орон эсвэл улс төр, эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагуудын энэхүү Конвенцид гарын үсэг зурах, батламжлах, сайшаан дэмжих, хүлээн зөвшөөрөх буюу нэгдэн орохд мөн түүнчлэн өөрийн хууль дүрмийг Конвенцийн заалттай уялдуулах зорилгоор ямар нэг томъёолол ба нэрээр тунхаг бичиг, мэдэгдэл гаргахад саад болохгүй. Гэндээ энэ тунхаг бичиг мэдэгдэл нь тус улс энэхүү Конвенцийг хэрэглэхэд түүний заалтуудад хууль зүйн өөрчлөлт оруулахааргүй байх шаардлагатай.

ХОРИН ДОЛДУГААР ЗҮЙЛ

Конвенцоос гарах

1. Тухайн Талын хувьд энэхүү Конвенц хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 3 жил өнгөрсний дараа хүссэн цагтаа эх бичвэр Хадгалагчид бичгээр мэдэгдээд Конвенцоос гарч болно.

2. Эх бичвэр Хадгалагч мэдэгдэл хүлээн авснаас хойш нэг жил өнгөрсний дараа буюу гарах тухай өгсөн мэдэгдэлд заасан хугацаа өнгөрмөгц гарах явдал хүчин төгөлдөр болно.

ХОРИН НАЙМДУГААР ЗҮЙЛ

Эх бичвэр Хадгалагч

НҮБ-ын Ерөнхий Нарийн Бичгийн Дарга энэхүү Конвенц болон түүнд хавсаргасан аливаа Протоколын эх бичвэр Хадгалагчийн үүрэг гүйцэтгэнэ.

ХОРИН ЕСДҮГЭЭР ЗҮЙЛ

Эх бичвэрүүд адил хүчинтэй байх

Энэхүү Конвенцийн Араб, Хятад, Англи, Франц, Орос, Испани

хэл дээрх эх бичвэрүүд нь адил хүчинтэй байна.

ДЭЭР ДУРДСАНЫГ НОТОЛЖ доорхи нэр бүхий төлөөлөгчид бүрэн эрхийнхээ дагуу энэхүү КОНВЕНЦИД гарын үсэг зурав.

1 дүгээр хавсралт
ХОГ ХАЯГДЛЫН АНГИЛАЛ
ХОГ ХАЯГДЛУУД:

Ү1. Клиник, поликлиник болон бусад нэгдсэн эмнэлгээс өвчтөнг эмчлэх, сувилах явцад гарах хаягдал

Ү2.Эмийн бүтээгдэхүүнийг дахин боловсруулах болон үйлдвэрлэснээс гарах хаягдал

Ү3.Хэрэгцээгүй болсон эм бэлдмэл болон эмийн бүтээгдэхүүн

Ү4.Биологийн болон ургамлын гаралтай бэлдмэл үйлдвэрлэх, хэрэглэснээс гарах хаягдал

Ү5.Модны үйлдвэрт хэрэглэх химийн бодисыг үйлдвэрлэх, болон түүний хэрэглээнээс гарах хаягдал

Ү6.Органик уусгагчийг хэрэглэдэг болон гарган авдаг үйлдвэрийн хаягдал

Ү7.Цианид агуулсан материалыг цэвэрлэх болон дулааны боловсруулалтаас гарах хаягдал

Ү8.Хэрэгцээгүй болсон буюу хэрэглэхэд тохиромжгүй эрдэс тос.

Ү9.Тос-ус, нүүрс-устөрөгч-усны хольц болон эмульс байдалтай хаягдал.

Ү10.Полихлорбифенил, полихлортерфенил, полибромбифенил болон тэдгээрийн хольцыг агуулсан хэрэгцээгүй болсон бодис, бүтээгдэхүүн

Ү11. Нэрэх, цэвэрлэх болон бусад пиролизын боловсруулалтын явцад үүсэх хэрэгцээгүй болсон давирхайлаг хаягдал

Ү12. Будаг, лак, маажин, пигмент, бэх хэрэглэдэг болон тэдгээрийг гарган авдаг үйлдвэрийн хаягдал

Ү13.Нийлэг давирхай, каучук, уяруулагч, цавуу, холбогч бодис зэргийг хэрэглэдэг болон тэдгээрийг гарган авдаг үйлдвэрийн хаягдал.

Ү14. Эрдэм шинжилгээ, сургалтын явцад буй болсон, шинж чанар нь судлагдаагүй, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд хэрхэн нөлөөлөх нь тогтоогдоогүй, хэрэгцээгүй болсон химийн бодис.

- Y15. Бусад хууль тогтоомжоор зохицуулагдахгүй тэсрэх аюул бүхий бодисын хаягдал
- Y16. Фотоматериал боловсруулах зориулалттай фотохимийн бодис, материалыг хэрэглэдэг болон тэдгээрийг гарган авдаг үйлдвэрийн хаягдал
- Y17. Металл болон плагмасс боловсруулалтаас гарсан хаягдал.
- Y18. Үйлдвэрийн хаягдлыг зайлуулснаас гарах үлдэгдэл.
- Y19. Металлын карбонил нэгдлүүд
- Y20. Бериллий, түүний нэгдлүүд.
- Y21. 6 валенттай хромын нэгрдлүүд
- Y22. Зэсийн нэгдлүүд
- Y23. Цайрын нэгдлүүд
- Y24. Хүнцэл, түүний нэгдлүүд
- Y25. Селен, түүний нэгдлүүд
- Y26. Кадмий, түүний нэгдлүүд
- Y27. Сурьма, түүний нэгдлүүд
- Y28. Теллур, түүний нэгдлүүд
- Y29. Мөнгөн ус, түүний нэгдлүүд
- Y30. Таллий, түүний нэгдлүүд
- Y31. Хар тугалга, түүний нэгдлүүд
- Y32. Фторт кальциас бусад фторын органик бус нэгдлүүд
- Y33. Органик бус цианидууд
- Y34. Шингэн буюу хатуу хүчлүүд
- Y35. Шүлтийн нэгдлүүд ба хатуу сууриуд
- Y36. Асбест /нунтаг, ширхэглэг/
- Y37. Фосфорын органик нэгдлүүд
- Y38. Органик цианидууд
- Y39. Фенол, фенолын нэгдлүүд, хлорфенолууд
- Y40. Эфирүүд
- Y41. Галогенжуулсэн органик уусгагчууд
- Y42. Галогенжуулснаас бусад органик уусгагчууд
- Y43. Дибензфураны төрлийн бүх материал
- Y44. Полихлордобензопидиоксины төрлийн бүх материал
- Y45. Энэ хавсралтад заасан бодисуудаас /Y39, Y41, Y42, Y43, Y44/ бусад органик галогент нэгдлүүд.

- Y46. Орон сууцнаас гарах хаягдал
Y47. Ахуйн хог хаягдлыг шатааснаас гарах үлдэгдэл

3 дугаар хавсралт
АЮУЛТАЙ БОДИСУУДЫН ЖАГСААЛТ

НҮБ-ын ангилал	Код	Шинж чанар
1	H1	Тэсрэх бодис Тэсрэх бодис буюу хаягдал. Температур, даралт, хурдны нөлөөгөөр химийн урвалд орж өөрөө тэсэрч орчны юмсыг гэмтээдэг хатуу, шингэн байдалтай бодис буюу хаягдлууд
3	H3	Галын аюултай шингэнүүд. “Галын аюултай” гэдэг нь “хялбар шатамхай” гэсэнтэй ижил утгатай. Галын аюултай шингэн гэдэг нь уусмал буюу суспензид / будаг, лак г.м/ аюултай шинж чанар бүхий хатуу бодисыг агуулсан, задгай саванд 60.5-аас дээш хэмд, битүү саванд 65.6-аас дээш хэмд галын аюултай уур ялгаруулдаг, аюултай шинж чанараар нь ангилсан бодис буюу хаягдлаас бусад шингэн болон шингэний хольцууд.
4.1	H4.1	Галд аюултай хатуу бодисууд Тэсрэх бодисын ангилалд хамаарагдахгүй, тээвэрлэх үед үрэлтээс гал авалцаж хялбархан асдаг хатуу бодис буюу хатуу хаягдлууд.
4.2.	H4.2	Өөрөө шатдаг бодис буюу хаягдлууд Ердийн нөхцөлд тээвэрлэхэд өөрөө халдаг буюу агаартай шүргэлцэхэд халж өөрөө шатдаг бодис буюу хаягдлууд
4.3	H4.3	Устай харилцан үйлчилж галын аюултай хий ялгаруулдаг бодис буюу хаягдлууд Устай харилцан үйлчлэхэд өөрөө шатамхай болон хялбар шатамхай хийг аюул учруулах хэмжээгээр

5.1	H5.1	ялгаруулдаг бодис буюу хаягдлууд Исэлдүүлэгч бодисууд Өөрөө заавал шатдаг бус, харин хүчилтөрөгчийг ялгаруулж бусад материалын шаталтыг тэтгэдэг бодисууд.
5.2.	H5.2	Органик хэт ислүүд Хоёр валенттай бүлэг /-O-O-/-ийг агуулсан дулаанд тэсвэргүй буюу дулаан ялгаруулах урвалд орж өөрөө түргэн задардаг шим бодисууд.
6.1.	H6.1	Хортой бодисууд. Амьсгалын зам, хоол боловсруулах эрхтэн, арьсаар дамжин хүний организмд орвол үхэлд хүргэх буюу хүчтэй хордуулдаг бодис буюу хаягдлууд
6.2.	H6.2	Халдвартай бодисууд. Амьд бичил биет буюу тэдгээрийн хорыг агуулсан хүн, амьтанд өвчин үүсгэдэг бодис буюу хаягдлууд
8	H8.	Идэмхий бодисууд Химийн үйлчлэл шууд харилцан явагдсанаас болж амьд эд эсэд хүчтэй гэмтэл үүсгэдэг, гоожих болон асгарч алдагдахад бусад ачаа, тээврийн хэрэгслийг гэмтээдэг бодис буюу хаягдлууд
9	H.10	Агаар, устай харилцан үйлчилснээс хортой хий ялгаруулдаг бодисууд Агаар, устай харилцан үйлчилснээс аюул учруулах хэмжээний хортой хий ялгаруулдаг бодис буюу хаягдлууд
9	H11.	Хортой бодисууд /архаг өвчин үүсгэх/ Амьсгалын зам, хоол боловсруулах эрхтэн, арьс салстаар дамжин хүний организмд ороход архаг өвчин үүсгэж улмаар хорт хавдар үүсгэх бодис буюу хаягдлууд

9	H12	Экологт хортой бодисууд Хүрээлэн буй орчинд байх тохиолдолд хоромхон уур биодэвх үүсгэж аюул учруулдаг буюу био- системд хортой нөлөөлөл үзүүлдэг бодис буюу хаягдлууд
9	H13	Зайлуулсны дараа ямар нэг байдлаар /ж: шүлтлэг болох г.м/ дээрх шинж чанарыг агуулсан бусад материалыг үүсгэдэг бодисууд.

ШАЛГУУР

Зарим төрлийн хаягдлын аюулын тодорхойлолт нь бүрэн гүйцэд баримтжаагүй, аюулын хэмжээг нь тооцоолон үнэлэх арга зүй одоогоор байхгүй байна. Эдгээр бодисоос хүний эрүүл мэнд, байгаль орчинд учруулж болзошгүй аюулыг судлах арга зүйг боловсруулах шаардлагатай байна. Стандарт шалгуурын аргуудыг цэвэр бодис, материалд зориулан боловсруулсан байдаг. Олонхи гишүүн орнуудад нэгдүгээр хавсралтад заасан хаягдлуудын шинж чанарыг тодорхойлоход хэрэглэх үндэсний шалгуурын арга зүйг боловсруулсан байна.

4 дүгээр хавсралт

ЗАЙЛУУЛАХ АЖИЛЛАГАА

Боловсруулах, дахин сэргээх, эргүүлж ашиглах буюу шууд дахин хэрэглэж болохгүй хаягдлыг зайлуулах арга

А хэсэгт хаягдал зайлуулах практикт тохиолдож буй бүх төрлийн үйл ажиллагаа орно.

D1 Газарт булшлах буюу газар дээр асгах /хогийн цэгт асгах г.м./

D2 Хөрсийг боловсруулах /хөрсөн дахь шингэн буюу лаг зэрэг хаягдлыг биохимийн аргаар задлах г.м./

D3 Газрын гүнд хаях /өрөмдлөгийн цооног, байгалийн тогтоц бүхий гүн хонгил, нүхэнд г. м./

D4 Ил задгай усанд хаях /шингэн ба лаг шаварлаг хаягдлыг цөөрөм, тунгаах усан сан г.м./

D5 Тусгай тоногдсон хогийн цэгт хаях /хүрээлэн буй орчноос нь болон өөр хооронд нь тусгайлах, хамгаалалт хашилт хийх,

бүтээх г.м/

D6 Тэнгис, далайгаас бусад усан санд хаях.

D7 Тэнгис, далайд хаях, далайн ёроолд булшлах.

D8 Энэ хавсралтын бусад хэсэгт дурдаагүй, биологийн

боловсруулалт хийсэн эцсийн нэгдэл буюу хольцыг А хэсэгт дурдсан аль нэг аргаар зайлуулах

D9 Энэ хавсралтын бусад хэсэгт дурдаагүй, физик-химийн

боловсруулалт хийсэн эцсийн нэгдэл буюу хольцыг А хэсэгт дурдсан аль нэг аргаар зайлуулах /ууршуулах, хатаах, шатаах, саармагжуулах,

тунадасжуулах г.м/

D10 Хуурай газарт шатаах

D11 Тэнгист шатаах

D12 Булшлах /чингэлгийг уурхай булшлах г.м/

D13 А хэсэгт дурдсан аливаа ажиллагааг эхлэхийн өмнө нэг

төрлийн буюу нэг төрлийн бус хольцыг гарган авах.

D14 А хэсэгт дурдсан ажиллагааг эхлэхийн өмнө дахин

боох буюу савлах

D15 А хэсэгт дурдсан ажиллагааг хүлээж хадгалах.

Боловсруулах, дахин сэргээх, эргүүлэн буюу дахин ашиглах зэргийг сонгон хэрэглэх ажиллагаа

В хэсэгт аюултай хог хаягдал буюу аюултай гэж үзэж хууль эрхийн хүрээнд тодорхойлогдсон материалуудтай харьцах бүх төрлийн ажиллагаа хамрагдах бөгөөд А хэсэгт дурдсан үйл ажиллагааны эсрэг тохиолдолд хэрэглэнэ.

R1 Түлшний хэлбэрээр /шууд шатахаас бусад/ буюу эрчим хүчийг гарган авах бусад хэлбэрээр ашиглах

R2 Дахин сэргээх /уусгагчуудыг ангижруулах/

R3 Эргүүлэн ашиглах /уусгагч байдлаар ашиглагдахгүй органик бодисуудыг боловсруулан ашиглах/

R4 Эргүүлэн ашиглах /металлууд болон тэдгээрийн нэгдлүүдийг боловсруулан ашиглах

R5 Эргүүлэн ашиглах /бусад органик бус материалуудыг ашиглах/

R6 Хүчил, шүлтийг ангижруулах

R7 Бохирдлыг арилгахад хэрэглэдэг бодисуудыг давтан ашиглах

R8 Катализаторуудыг давтан ашиглах

- R9 Нефтийн бүтээгдэхүүнийг дахин нэрэх, урьд ашиглагдсан нефтийн бүтээгдэхүүнийг өөр байдлаар дахин ашиглах
- R10 Газар тариаланд аятай нөлөөлөх буюу экологийн нөхцөл байдлыг сайжруулах үүднээс хөрсийг боловсруулах
- R11 R1-R10-д заасан аль ч ажиллагаанаас гарсан хаягдлыг ашиглах
- R12 R1- R11-д заасан ажиллагаагаар зайлуулах хаягдлуудыг солилцох.
- R13 В хэсэгт заасан ажиллагаагаар зайлуулах материалыг хуримтлуулах.

5А дугаар хавсралт
МЭДЭГДЭЛД ДУРДСАН БАЙХ ЁСТОЙ ЗҮЙЛҮҮД

1. Хаягдлыг экспортлох шалтгаан
2. Хаягдал экспортлогч 1/
3. Хаягдал гаргагч /гаргагчид/ 1/
4. Хаягдал зайлуулах ажлыг хариуцагч тэгээд 1/
5. Хаягдал тээвэрлэгч, түүний салбарууд, хэрэв энэ нь тодорхой бол 1/
6. Хаягдал экспортлох улс Эрх бүхий Засаг захиргаа 2/
7. Дамжуулан өнгөрүүлэх улс Эрх бүхий Засаг захиргаа 2/
8. Хаягдал импортлох улс Эрх бүхий Засаг захиргаа 2/
9. Ерөнхий буюу нэг удаагийн мэдэгдэл
10. Хаягдлыг экспортлохоор төлөвлөж буй замын маршрут орох гарах хилийн албад, хэзээ тээвэрлэх болон түүний үргэлжлэх хугацаа 3/
11. Төлөвлөж буй тээврийн хэлбэр /автомашинаар, төмөр замаар, агаар болон дотоодын усан тээврээр г.м/
12. Даатгалд хамаарах мэдээлэл 4/
13. Хаягдлын тодорхойлолт үүний дотор Y дугаар буюу НҮБ-ын дугаар, тэдгээрийн бүтэц 5/ ба аюул ослын үед авах арга хэмжээ болон тусгайлан анхаарвал зохих зүйлийн талаар мэдээлэл
14. Савлах хэлбэр /жиш: овоолох, торхонд хийх, шингэн тээвэрлэх тээврийн хэрэгсэлд г.м/
15. Хэмжээ жингээр, эзэлхүүнээр 6/

16. Хаягдал гарах үеийн үйл явц 7/
17. Конвенцийн 1 болон 2 дугаар хавсралтуудад дурдсан хаягдлыг аюултай байдлын ангилал, аюултай шинж чанар, Н дугаар НҮБ-ын ангилал
18. 3 дугаар хавсралтын дагуу зайлуулах арга
19. Энэ мэдээлэл үнэн болох тухай хаягдал гаргагч буюу экспортлогчийн мэдэгдэл
20. Хаягдлыг байгаль орчинд халгүйгээр импортлогч орны норм, дүрмийн дагуу зайлуулах талаар экспортлогч болон хаягдал гаргагчдад өгөх мэдээлэл
21. Экспортлогч болон хаягдал зайлуулах ажиллагааг хариуцагч этгээдийн хооронд байгуулсан гэрээний тухай мэдээлэл

ТАЙЛБАР

1. Байгууллага болон харилцах хүний бүрэн нэр, хаяг, телефон, телекс, телефаксын дугаар
2. Бүтэн нэр, хаяг, телефон, телекс, телефаксын дугаар
3. Хэд хэдэн нийлүүлэгчийг хамруулан ерөнхий мэдэгдэл авсан тохиолдолд болон эсвэл санал болгож буй нийлүүлэгч бүрийн төлөвлөж байгаа хугацааны тухай, хэрэв энэ нь тодорхой бус бол нийлүүлж болох үе шатны тухай мэдээлэл
4. Хаягдал зайлуулах ажиллагааг хариуцагч этгээдийн баталгаа, холбогдох даатгалын мэдэлэлтэй танилцана.
5. Хор зүйн болон бусад аюултай хэлбэрээрээ онц аюултай бодис агуулсан буюу шинж чанар бүхий хаягдлыг зайлуулах үйл ажиллагааны аргыг анхааран үзнэ.
6. Нийлүүлэгч тус бүрийн хэмжээг дүгнэсэн тухай ерөнхий хэмжээний дүгнэлт буюу хэд хэдэн нийлүүлэгчийн мэдээллийн тухай мэдэгдэл шаардана.
7. Хаягдал зайлуулахаар төлөвлөж буй үйл ажиллагааны тодорхойлолт болон болзошгүй аюулын үнэлгээ

5В дугаар хавсралт
ТЭЭВЭРЛЭХ ТУХАЙ БИЧИГ БАРИМТАД
БАЙВАЛ ЗОХИХ МЭДЭЭЛЭЛ

1. Хаягдал экспортлогч 1/
2. Хаягдал гаргагч болон түүний байрлаж буй газар
3. Хаягдлыг хариуцагч этгээд, зайлуулах гэж буй газрын байршил 1/
4. Хаягдал тээвэрлэгчид 1/ буюу байгууллага
5. Хаягдлын талаар ерөнхий буюу нэг удаагийн мэдэгдэл
6. Хаягдлыг хил дамжуулан тээвэрлэж эхэлсэн хугацаа, түүнийг хариуцагч этгээдийн гарын үсэг зурсан хугацаа
7. Тээвэрлэлтийн хэлбэрүүд /машинаар, гал тэргээр, орон нутгийн усан замаар, далайгаар, агаараар/ экспортлогч, дамжуулан өнгөрүүлэгч болон импортлогч улс мөн тэдгээрт орох болон тэдгээрээс гарах хилийн цэгүүд зэрэгт тодорхой байна.
8. Хаягдлын ерөнхий бүртгэл /физик шинж чанар, НҮБ-аас гаргасан ачааны нэршил, ангилал, дугаар, Y болон H код хэлбэрийн хаягдал зэргийг тодорхой бичих/
9. Аюул, ослын зэрэг зарим онцгойлон анхаарал шаардагдах үед авах арга хэмжээний тухай мэдээлэл
10. Савлалтын хэлбэр, ачааны тоо
11. Ачааны хэмжээ, эзэлхүүн
12. Хаягдал гаргагч ба экспортлогчийн холбогдох үйл ажиллагааны тухай мэдэгдэл
13. Талуудад байгаа бүх сонирхогч улсууд, эрх бүхий байгууллагуудын зүгээс татгалзах зүйлгүйг харуулсан хаягдал гаргагч, экспортлогчийн мэдэгдэл
14. Хаягдлыг зайлуулахаар төлөвлөсөн хугацаа, аргын талаар товлосон байгууллагаас хариуцагч, гэрчийн этгээд.

ТАЙЛБАР

Тээвэрлэлтийн бичиг баримтад шаардлагатай мэдээллийг тээвэрлэх дүрэм, журмын тухай мэдээлэлтэй нэгтгэнэ. Нэгтгэх боломжгүй бол уг мэдээллийг тээвэрлэх дүрэм, журмын талаар мэдээлэлтэй давхардуулалгүйгээр тодотгол хийж байх хэрэгтэй. Тээвэрлэлтийн бичиг баримтад хэн мэдээлэл өгсөн, баримтуудыг бөглөсөн тухай зааж өгөх ёстой.

1/Ослын үед хандах байгууллага хүний бүрэн нэр /овог/, хаяг, утас, телекс, факсын дугаар;

6 дугаар хавсралт
АРБИТР
1 дүгээр зүйл

Хэрэв хэлэлцэн тохирогч энэхүү Конвенцийн 20 дугаар зүйлд дурдсанаас өөрөөр хэлэлцэн тохиролцоогүй бол арбитрын хянан хэлэлцэх журмыг дараахь 10 хэсэгт зааснаар шийднэ.

2 дугаар зүйл

Конвенцийг хэрэгжүүлэх явцад гарсан маргааныг уг Конвенцийн 20 дугаар зүйлийн 2, 3 дугаар заалтын дагуу арбитраг хянан хэлэлцүүлэхээр шилжүүлж байгаагаа нэхэмжлэгч Тал Нарийн бичгийн дарга нарын газарт мэдэгдэнэ. Мэдэгдэлдээ уг Конвенцийн аль зүйлтэй холбогдсон зарга үүссэн тухайгаа тодруулан бичнэ. Нарийн бичгийн дарга нарын газар хүлээн авсан мэдээллийг Конвенцид оролцогч бүх Талуудад илгээнэ.

3 дугаар зүйл

Арбитрын шүүх нь гурван гишүүнээс бүрдэнэ. Маргалдагч талууд тус бүр нэг арбитр томилох ба эдгээр хоёр арбитр нь харилцан тохиролцож гурав дахь арбитр буюу шүүхийн даргыг томилно. Гуравдахь арбитр нь маргалдагч Талуудын иргэн биш, энэ хоёр Талын аль нэгэнд байнга оршин суудаггүй буюу алба хашдаггүй, энэ хэрэгт ямар нэгэн байдлаар холбогдолгүй байна.

4 дүгээр зүйл

Хоёр дахь Арбитрыг томилсноос хойш хоёр сарын дотор арбитрын даргыг томилоогүй бол аль нэг Талын хүсэлтээр НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга дараагийн хоёр сарын дотор түүнийг томилно.

Хэрэв маргалдагч Талуудын аль нэг нь хүсэлтийг хүлээж авснаас хойш 2 сарын дотор арбитраг томилоогүй бол нөгөө тал нь энэ тухай НҮБ-ын Ерөнхий Нарийн Бичгийн Даргад мэдэгдэж, 2 сарын дотор арбитрын шүүхийн даргыг томилуулах эрхтэй. Арбитрын шүүхийн дарга нь сонгогдсоныхоо дараа арбитраг томилоогүй талд 2 сарын дотор арбитраг томилуулах хүсэлт тавина. Энэ 2 сарын дараа

НҮБ-ын Ерөнхий Нарийн Бичгийн Дарга Арбитрын шүүхийн даргын хүсэлтээр арбитрыг томилно.

5 дугаар зүйл

Арбитрын шүүх нь олон улсын эрх зүй болон энэхүү Конвенцийн заалтуудын дагуу шийдвэрээ гаргана.

Энэхүү хавсралтын дагуу байгуулсан Арбитрын шүүх нь өөрийн үйл ажиллагаандаа дагаж мөрдөх журам боловсруулж гаргана.

6 дугаар зүйл

1. Арбитрын шүүхийн дагаж мөрдөх журам болон хэлэлцэж буй хэргийн асуудлаар гаргасан шийдвэрийг гишүүдийн олонхийн саналаар батална.

2. Шүүх хэрэг шийдвэрлэхэд холбогдох бүхий л арга хэмжээ авна. Мөн аль нэг талаас тавьсан хүсэлтийн дагуу шаардагдах хамгаалалтын арга хэмжээг түр авахыг зөвлөнө.

3. Маргалдагч Талууд хянан хэлэлцэхэд шаардагдах бүхий л нөхцөлөөр хангаж, идэвхтэй ажиллагаа явуулахад дэмжлэг үзүүлнэ.

4. Маргалдагч Талуудын аль нэг нь шүүхэд ирээгүй буюу оролцоогүй байх нь хэргийг хянан шийдвэрлэхэд саад болохгүй.

7 дугаар зүйл

Шүүх нь маргаантай шууд холбоотой сөрөг нэхэмжлэлийг хүлээн авч түүний талаар шийдвэр гаргаж болно.

8 дугаар зүйл

Хэрэв хэргийн тодорхой нөхцөл байдлаас үүдэн гагцхүү арбитрын шүүх өөрөөр шийдээгүй бол шүүхийн зардал, шүүхийн гишүүдийн ажлын хөлсийг маргалдагч Талуудаас тэнцүү гаргуулна. Шүүх өөрийн бүх зардлыг бүртгэж эцсийн тайланг Талуудад танилцуулна.

9 дүгээр зүйл

Маргаантай асуудлаар гаргасан шийдвэр нь маргалдагч Талуудын аль нэгний эрхийн шинжтэй сонирхолд харшилж байвал

хохирогч гэж үзэж байгаа тал шүүхийн зөвшөөрлөөр шүүх хурал дээр үг хэлэх эрхтэй.

10 дугаар зүйл

1.Хэрэв шийдвэр гаргах хугацааг 5 сараас дээшгүй хугацаагаар дахин сунгах шаардлагагүй гэж үзэж байгаа бол шүүх байгуулагдсан өдрөөсөө хойш 5 сарын дотор шийдвэрээ гаргана.

2.Арбитрын шүүхийн шийдвэрт учир шалтгааны тайлбарыг хавсаргана. Маргалдагч талуудын хувьд шүүхийн шийдвэр нь эцсийн бөгөөд заавал биелүүлэх үүрэг болно.

3.Шүүхийн эцсийн шийдвэрийг тайлбарлах, түүнийг биелүүлэхтэй холбогдсон Талуудын дунд гарч болох аливаа маргааныг шийдвэр гаргасан арбитрын шүүхэд хэлэлцүүлэхээр аль нэг Тал шилжүүлж болно. Хэрэв анхны арбитрын шүүхтэй холбоо барих боломжгүй бол түүнтэй ижил зорилготой байгуулагдсан аливаа шүүхэд хандаж болно.

ОЗОНЫ ҮЕ ДАВХАРГЫГ ЗАДАЛДАГ БОДИСЫН ТУХАЙ МОНРЕАЛЫН ПРОТОКОЛ

УДИРТГАЛ

Энэхүү Протоколын Талууд, Озоны үе давхаргыг хамгаалах Венийн Конвенцийн Талууд болохын хувьд, Озоны үе давхаргыг өөрчилж байгаа буюу өөрчлөх боломж бүхий хүний үйл ажиллагааны улмаас буй болсон буюу буй болж болзошгүй сөрөг үр дагавраас хүний эрүүл мэнд, байгаль орчныг хамгаалах талаар Конвенцийн дагуу холбогдох арга хэмжээ авах өөрийн үүргийг санан, озоныг задалдаг зарим бодисын дэлхий дахины хэмжээний ялгаралт нь озоны үе давхаргыг эрс хомсдуулах буюу өөрчилж энэ нь хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг үр дагавар учруулж болохыг ухамсарлан, эдгээр бодисын ялгаралт уур амьсгалд нөлөөлөх чадавхитай гэдгийг санан, озоны үе давхаргыг нимгэрэхээс хамгаалах зорилгоор авч байгаа арга хэмжээ нь техникийн болоод эдийн засгийн бодрол бүхий шинжлэх ухааны мэдлэг дээр үндэслэх ёстой гэдгийг ухамсарлан, техникийн болон эдийн засгийн шинжтэй бодрол түүний дотор хөгжиж байгаа орнуудын хөгжилтэй холбогдох хэрэгцээг тооцсон шинжлэх ухааны мэдлэг дээр түшиглэн озоныг задалдаг бодисуудын дэлхий дахины хэмжээний ялгаралтыг бүрэн хэмжээгээр зохицуулж, энэ үндсэн дээрээ тэдгээрийн ялгаралтыг бүрэн зогсооход чиглэсэн урьдчилсан арга хэмжээ авах замаар озоны үе давхаргыг хамгаалах шийдвэр төгс байгаагаа илэрхийлэн, энэ бодисуудын хувьд хөгжиж байгаа орнуудын хэрэгцээг хангах онцгой байдал түүний дотор озоны задрал, тийм задралын сөрөг үр дагаврын талаар шинжлэх ухааны хувьд тогтоосон асуудлыг дэлхийн хэмжээнд шийдвэрлэхэд мэдэгдэхүйц ахиц өөрчлөлт гаргаж чадахуйц тийм хөрөнгө хүчний хэмжээг урьдчилан тооцсон санхүүгийн нэмэлт нөөц олгох, зохих технологи нэвтрүүлэх нь зайлшгүйг хүлээн зөвшөөрч, зарим төрлийн хлорфторг нүүрстөрөгчийн ялгаралтыг зохицуулах урьдчилсан арга хэмжээг улс орнуудын хэмжээнд болон бүс нутгийн хүрээнд авсан юм уу авч хэрэгжүүлж байгааг тооцон, озоны үе давхаргыг задалдаг бодисын ялгаралтыг зохицуулах, бууруулахтай холбогдсон судалгаа явуулах, орлуулах технологи боловсруулах, дамжуулах (шинжлэх ухаан техникийн судалгаа явуулах, боловсруулах) зэргээр олон улсын ялангуяа хөгжиж байгаа орнуудын хэрэгцээ шаардлагыг анхаарсан хамтын ажиллагааг явуулахад дэмжлэг үзүүлэх нь чухлыг тооцон, ДАРААХ

ЗҮЙЛЭЭР ХЭЛЭЛЦЭН ТОХИРОЛЦОВ:

1 дүгээр зүйл. ТОДОРХОЙЛОЛТ

Энэхүү Протоколын зорилгоор:

1. «Конвенц» гэж 1985 оны 3 дугаар сарын 22-нд баталсан озоны үе давхаргыг хамгаалах тухай Венийн Конвенцийг хэлнэ.

2. «Талууд» гэж бичлэг дотор өөрөөр заагаагүй бол энэхүү Протоколын Талуудыг ойлгов.

3. «Нарийн бичгийн дарга нарын газар» гэж Конвенцийн нарийн бичгийн дарга нарын газрыг хэлэв.

«Зохицуулагдах бодис» гэж энэ Протоколын хавсралт А буюу хавсралт В-д (хавсралт В, хавсралт С буюу хавсралт Ё) заасан аль нэг бодис дангаар юмуу хольц хэлбэрээр байхыг хэлнэ. Энэ ойлголтонд холбогдох хавсралтанд заасан бодисуудаас бусад ийм бодисын изомерууд хамаарах бөгөөд [гэхдээ] дурдсан бодисыг тээвэрлэх юм уу хадгалахад ашиглаж байгаа чингэлгээс өөр хэлбэрт байгаа бэлэн бүтээгдэхүүний бүрэлдэхүүн хэсэг болж байгаа [тийм] ямар нэг зохицуулагдах бодис юмуу түүний хольц энд хамаарахгүй.

5. «Үйлдвэрлэл» гэж үйлдвэрлэсэн зохицуулагдах бодисын хэмжээнээс Талуудын зохих ёсоор баталсан тухайн үед хэрэглэж байгаа технологиор устгаж байгаа бодисын болоод химийн өөр бодис үйлдвэрлэхэд зөвхөн түүхий эд болгон хэрэглэж байгаа бодисыг хассан нийт хэмжээг ойлгоно. Үйлдвэрлэлийн эргэлтэнд орж байгаа юм уу дахин ашиглагдаж байгаа бодисыг «үйлдвэрлэл»-ийн хэмжээнд оруулж тооцохгүй.

6. «Хэрэглээ» гэж зохицуулагдах бодисын үйлдвэрлэл ба импортын нийлбэрээс экспортыг хассаныг хэлнэ.

7. «Үйлдвэрлэл, импорт, экспорт хэрэглээний тооцооны түвшин» гэж 3 дугаар зүйлээр тодорхойлогдох түвшинг хэлнэ.

8. «Үйлдвэрлэлийн оновчтой зохисжуулалт» гэж эдийн засгийн үр ашгийг хангах юм уу үйлдвэрийг хааснаас болж гарах эрэлт хэрэгцээг нөхөх зорилгоор нэг талаас нөгөө талдаа үйлдвэрлэлийн тооцооны түвшнийг бүхлээр нь юм уу хэсэгчлэн шилжүүлэхийг ойлгоно.

2 дугаар зүйл. ЗОХИЦУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ

1. (1990 онд Лондон хотноо болсон Талуудын 2 дугаар зөвлөлгөөнөөр хийсэн засварын дагуу 2А дугаар зүйлд байгаа)
2. 2В дугаар зүйлээр сольсон.
- 3 ба 4. 2А дугаар зүйлээр сольсон.

[5. Хавсралт А-ын нэгдүгээр бүлгийн зохицуулагдах бодисын үйлдвэрлэлийн тооцооны түвшин нь 1986 оны байдлаар жилд 25 мянган тонноос бага байгаа аль ч Тал энэ зүйлийн 1,3,4 дэх заалтын хязгаараас давж байгаа үйлдвэрлэлийг оновчтой сайжруулах зорилгоор аль нэг Талд дамжуулах юм уу аль нэг Талаас авч болох ба гэхдээ нөгөө Талын хувьд үйлдвэрлэлийн тооцооны нийт нийлбэр түвшин нь энэ зүйлээр тогтоосон үйлдвэрлэлийн хязгаарлалтын хүрээнд байх ёстой. Тийм үйлдвэрлэлийг дамжуулах ямар ч үйл ажиллагааг нарийн бичгийн дарга нарын газарт тийнхүү дамжуулах хугацаанаас хожимдуулалгүй мэдэгдэнэ.]

5. Аль ч Тал зохицуулалтын нэг болон хэд хэдэн үеийн дотор нөгөө аль нэг Талдаа 2А-2Е дүгээр зүйлд {мөн 2Н дугаар зүйл} заасан үйлдвэрлэлийн тооцооны түвшний өөрт оногдох хувийн аль нэг хэсгийг дамжуулж болох боловч нөгөө Талынх нь хувьд зохицуулагдах аль ч бүлэг бодисын үйлдвэрлэлийн ерөнхий нийлбэр тооцооны түвшин нь тухайн бүлэг бодисын хувьд энэ зүйлүүдээр тогтоосон үйлдвэрлэлийг нь хязгаарлах хязгаараас давж болохгүй. Энэ үйл явцад оролцож байгаа Тал бүр тэрхүү дамжуулалтынхаа тухай түүний нөхцөл, дамжуулах үйл ажиллагаа явагдах хугацааны тухай нарийн бичгийн дарга нарын газарт мэдэгдэнэ.

5-бис. 5 дугаар зүйлийн 1 дэх заалтын хүрээнд хамрагдахгүй аль ч Тал зохицуулалтын аль нэг юмуу хэд хэдэн үед 2F зүйлд заасан хэрэглээний тооцооны түвшний оногдох аль нэг хэсгийг нөгөө аль ч Талд дамжуулж болох ба гэхдээ хэрэглээний тооцооны түвшний өөрийн хэсгийн аль нэг хэсгийг дамжуулж байгаа Талын хувьд хавсралт А-ын 1 бүлгийн зохицуулагдах бодисын хэрэглээний тооцооны түвшин нь 1989 оны байдлаар нэг хүн амд 0.25 кг-аас даваагүй, энэ Талын хувьд хэрэглээний тооцооны түвшний нийт нийлбэр нь 2F дүгээр зүйлээр тогтоосон хязгаарлалтын заагаас давахгүй байвал зохино. Тухайн харгалзах Тал бүр нарийн бичгийн дарга нарын газарт тэрхүү дамжуулалтын нөхцөл, үргэлжлэх хугацааны тухай мэдэгдэнэ.

6. 5 дугаар зүйлийн хүрээнд хамрагдахгүй, хавсралт А юмуу

хавсралт В-ээр зохицуулагдах бодисын үйлдвэрлэлийн хүчин чадлыг 1987 оны 9 дүгээр сарын 16-наас өмнө контрактаар буй болгохоор үүрэг авсан, эсвэл барилгын ажил нь явагдаж байгаа болоод үндэсний хууль тогтоомжоор 1987 оны 1 дүгээр сарын 1 хүртэл урьдчилан тогтоосон арга хэмжээ байвал тэр шинээр буй болгож буй хүчин чадал нь 1990 оны 12 дугаар сарын 31-ний өмнө ашиглалтанд орох бөгөөд тэр шинэ хүчин чадлыг оролцуулаад энэ Талын зохицуулагдах бодисын жилийн хэрэглээний өсөлт нэг хүнд 0.5 кг-аас хэтрэхээргүй нөхцөлд 1986 оныхоо үйлдвэрлэлийн тооцооны түвшинг тодорхойлох зорилгоор 1986 оныхоо үйлдвэрлэлийн суурь түвшин дээр нэмж болно.

7. Энэ зүйлийн 5 дахь заалтын дагуу үйлдвэрлэлийн ямар нэг дамжуулалт хийсэн тухай болон 6 дахь заалтын Дагуу үйлдвэрлэлийн ямар нэг өсөлт гарвал энэ тухай дамжуулалт хийх хугацаанаас хожимдуулалгүй Нарийн бичгийн дарга нарын газарт мэдэгдэнэ.

8. а. Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс нутгийн байгууллагын гишүүн- улс болох аль ч Тал Конвенцийн 1 дүгээр зүйлийн 6 дугаар заалтанд өгсөн тодорхойлолтын дагуу энэ зүйл болоод 2А-2Е дүгээр зүйлийн {2А-2Н дугаар зүйл} хүрээнд хэрэглээнийхээ хувьд өөрсдийн үүргийг хамтаараа биелүүлэх талаар тогтож болох бөгөөд тэгэхдээ хэрэглээний тооцооны ерөнхий нийлбэр түвшин нь энэ зүйл болоод 2А-2Е дүгээр {2А-2Н дугаар зүйл} зүйлээр тогтоосон түвшнээс давж болохгүй.

в. хэрэглээг бууруулах тухайд хийсэн хэлэлцээрийн хугацаа дуусахаас өмнө энэ хэлэлцээрийн Талууд Нарийн бичгийн дарга нарын газарт уг хэлэлцээрийн нөхцлийн тухай мэдээлнэ.

с. эдийн засгийн бүс нутгийн хамтын ажиллагааны байгууллагын бүх гишүүн-улсууд хийгээд бүс нутгийн байгууллага өөрөө Протоколын Тал болж байгаа тохиолдолд тэр хэлэлцээрийн биелэлтийг хэрхэн хангах тухайгаа Нарийн бичгийн дарга нарын газарт мэдэгдсэний дараа сая уг хэлэлцээр хүчин төгөлдөр болно.

9. а. 6 дугаар зүйлийн дагуу хийж байгаа үнэлгээний дагуу Талууд:

i. Хавсралт А ба / буюу хавсралт В {хавсралт В, хавсралт С ба буюу Е}-д заасан озоныг задлах чадварын тооцооны коэффициентийн засварыг хийх, хэрэв тэгвэл ямрыг нь нарийвчлах ба

ii. зохицуулагдах бодисын үйлдвэрлэл, хэрэглээг бууруулах [1986 оны түвшинтэй харьцуулбал) цаашид засвар хийх эсэх, хэрэв хийвэл ямар хэмжээ хүрээнд ямар хугацаанд хийх талаар шийдвэр гаргаж болно.

в. Талууд тийм засварынхаа тухай саналаа Талуудын Зөвлөлгөөн эхлэхээс наад зах нь 6 сараас доошгүй хугацааны өмнө Нарийн бичгийн дарга нарын газарт мэдэгдэж уг Зөвлөлгөөнд тавьж батлуулна.

с. Талууд тийм шийдвэр гаргахын тулд бүхий л хүчин чармайлт тавьж нэгдсэн саналд хүрэхийг эрмэлзэнэ. Хэрэв нэгдсэн саналд хүрэх бүхий л хүчин чармайлт нэгдсэн зөвшилд хүргэхгүй бол эцсийн эцэст 5 дугаар зүйлийн 1 дэх заалтанд хамрагдах, санал хураалтанд оролцогч болон байлцагч Талуудын ихэнх ба энэ заалтанд эс хамрагдах авч санал хураалтанд оролцогч, байлцагч Талуудын ихэнхийг төлөөлөх [зохицуулагдах бодисын нийт хэрэглээний тавиас доошгүй хувийг эзлэх Талууд] санал хураалтанд оролцогч хийгээд байлцагч Талуудын гуравны хоёрын саналаар шийдвэр гаргаж болно.

d. бүх Талуудын хувьд дагаж мөрдөх шийдвэрийг эх бичвэр Хадгаламжлагчаас Талуудад нэн даруй мэдээлнэ. Хэрэв тухайн шийдвэрт өөрөөр заагаагүй бол тэр нь эх бичвэр Хадгаламжлагчаас мэдээлэл тараасан өдрөөс хойш 6 сарын хугацаа өнгөрмөгц хүчин төгөлдөр болно.

10. (a) Энэхүү Протоколын 6 дугаар зүйл, Конвенцийн 9 дүгээр зүйлд өгүүлсэн дэгийн дагуу хийж буй үнэлгээнийхээ үндсэн дээр Талууд дараах шийдвэр гаргаж болно.

i. Энэхүү Протоколын аль нэг хавсралтанд оруулах юмуу түүнээс хасах ямар нэг бодис; ба

ii. тухайн бодисын хувьд хэрэглэх зохицуулах арга хэмжээний механизм, хэмжээ, хүрээ, хийгээд хугацааны тухай зэрэг болно.

(в) тухайн ямар нэг шийдвэр нь санал хураалтанд оролцогч болон байлцагч Талуудын гуравны хоёрын олонхийн саналаар хүчин төгөлдөр болно.]

11. Энэ зүйл болон 2А-2Е дүгээр зүйл {2А-2Н дугаар зүйл} -д заасныг харгалзахгүйгээр Талууд энэ зүйл хийгээд 2А-2Е дүгээр (2А-2Н дүгээр зүйл) зүйлд дурдсан шаардлагатай харьцуулбал илүү хатуу шийдвэртэй арга хэмжээ авч болно.

ЗАСВАРЫН ОРШИЛ

Озоны үе давхаргыг задалдаг бодисын тухай Монреалын Протоколын Талуудын Хоёрдугаар зөвлөлгөөнөөр Протоколын 6 дугаар зүйлийг хэрэгжүүлэхээр хийгдсэн үнэлгээний үндсэн дээр Протоколын хавсралт А-д орсон зохицуулагдах бодисын үйлдвэрлэл, хэрэглээг хорогдуулах явдлыг дараах байдлаар ойлгож байхаар тогтоов.

а. 2 дугаар зүйлийн «энэхүү зүйлд» гэсэн болон Протоколын нийт бичлэгт «2 дугаар зүйлд» гэж ишлэл хийснийг 2, 2А ба 2В дүгээр зүйлүүдээс ишлэл татсан гэж;

в. Протоколын бүх бичлэгт «2 дугаар зүйлийн 1-4 дэх заалт»-аас гэж ишлэл татсаныг 2А ба 2В дүгээр зүйлээс иш татсантай адилаар үзэх; ба

с. 2 дугаар зүйлийн 5 дахь заалтанд «1,3 ба 4 дүгээр заалт»-аас гэж ишлэл хийснийг 2А дугаар зүйлээс ишлэл хийсэн гэж тус тус үзэх болно.

2А дугаар зүйл. ХФН

1. Энэхүү Протоколын хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 7 дахь сар өнгөрөөд эхний өдөр нь эхлэх 12 сарын дотор, мөн дараа дараагийн 12 сарын хэмжээний үе бүрт Тал тус бүр хавсралт А-ын 1 дүгээр бүлгийн зохицуулагдах бодисын хэрэглээний тооцооны түвшингээ 1986 оны хэрэглээний тооцооны түвшингээс хэтрүүлэхгүй байна. Энэ байгаа нэг буюу хэд хэдэн төрлийн бодис үйлдвэрлэдэг Талууд дээрх үе бүрийн сүүлч гэхэд эдгээр бодисын үйлдвэрлэлийн тооцооны түвшинг 1986 оны үйлдвэрлэлийн тооцооны түвшингээс давахгүй байх явдлыг хангах бөгөөд энэ түвшин өслөө өслөө гэхэд энэ нь 1986 оны түвшингээс 10 хувиас илүүгээр хэтрэхгүй байна. Гэхдээ ийм өсөлтийг 5 дугаар зүйлийн хүрээнд хамрагдах Талууд дотоодын үндсэн хэрэгцээг хангах хийгээд Талуудын хооронд аж-үйлдвэрлэлийн хуваарьт зохисжуулалт хийх зорилгын үүднээс зөвшөөрнө.

2. Тал тус бүр хавсралт А-ын 1 дүгээр бүлэгт орж байгаа зохицуулагдах бодисын хэрэглээний болоод үйлдвэрлэлийн тооцооны түвшинг 1991 оны 7 дугаар сарын 1-нээс 1992 оны 12 дугаар сарын 31-ний хоорондох 12 сарын хэмжээний үед эдгээр бодисын 1986 оны хэрэглээ, үйлдвэрлэлийн тооцооны түвшингээс 150 хувиас давахгүй байх явдлыг хангана. 1993 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн дараа дараагийн 12 сарын үе бүрт зохицуулагдах бодисын зохицуулалтыг он бүрийн 1 дүгээр сарын 1-нээс 12 дугаар сарын 31-нд тогтоож байна.

3. Тал тус бүр хавсралт А-ын 1 дүгээр бүлэгт орсон зохицуулагдах бодисын жил бүрийн хэрэглээний тооцооны түвшинг 1994 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн 12 сарын хэмжээний үед хийгээд дараа дараагийн 12 сарын үе тус бүрт 1986 оны хэрэглээний тооцооны түвшингээс 25 хувиас хэтрүүлэхгүй байх явдлыг хангана.

Энд заасан нэг буюу хэд хэдэн төрлийн бодис үйлдвэрлэдэг Тал бүр дээр дурдсан үеүдэд эдгээр бодисын жил бүрийн үйлдвэрлэлийн түвшин нь 1986 оны үйлдвэрлэлийн тооцооны түвшингээс 25 хувиас илүүгээр хэтрүүлэхгүй байна. Гэхдээ 5 дугаар зүйлийн 1 дэх заалтанд хамрагдах, Талуудын хувьд дотоодынхоо үндсэн хэрэгцээгээ хангах үндсэн дээр үйлдвэрлэл нь энэ хязгаараас давж болох авч энэ нь 1986 оны үйлдвэрлэлийн тооцооны түвшингээс 10 хувиас илүүгээр хэтэрч болохгүй.

4. Тал тус бүр хавсралт А-ын 1 дүгээр бүлэгт орсон зохицуулагдах бодисын хэрэглээний тооцооны түвшинг 1996 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн 12 сарын хэмжээний үед хийгээд, дараа дараагийн 12 сарын хэмжээний үеүдэд тэг түвшнээс давуулахгүй. Энэ заасан нэг буюу хэд хэдэн бодис үйлдвэрлэдэг тал тус бүр дээр дурдсан үеүдэд жил бүрийн үйлдвэрлэлийн тооцооны түвшинг тэг түвшнээс давуулахгүй. Гэхдээ 5 дугаар зүйлийн 1 дэх заалтанд хамрагдах Талууд дотоод үндсэн хэрэгцээгээ хангах үүднээс тэдгээрийн үйлдвэрлэлийн тооцооны түвшинг хэтрүүлж болох авч энэ нь 1986 оны үйлдвэрлэлийн тооцооны түвшнээс 15 хувиас илүү хэтрэхгүй байна. Талууд урьдчилан үндсэн гэж хэлэлцэн тохирсон хэрэглэх хэлбэрийг нь хангахад зайлшгүй шаардагдах үйлдвэрлэл хэрэглээний түвшинг нь зөвшөөрөх талаар Талуудын шийдвэр гарснаас бусад тохиолдолд энэ заалтыг мөрдөнө.

2В дүгээр зүйл. ГАЛОНУУД

1. Тал тус бүр хавсралт А-ын 2 дугаар бүлэгт орсон зохицуулагдах бодисын хэрэглээний тооцооны жил бүрийн түвшинг 1992 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн 12 сарын хоорондох үе болоод дараа дараагийн 12 сарын хэмжээний үеүдэд 1986 оны хэрэглээний тооцооны түвшингээс хэтрүүлэхгүй. Энд заасан нэг буюу хэд хэдэн бодис үйлдвэрлэдэг Тал тус бүр дээр дурдсан үеүдэд жил бүрийн үйлдвэрлэлийн тооцооны түвшинг 1986 оны үйлдвэрлэлийн тооцооны түвшнээс хэтрүүлэхгүй.

Гэхдээ 5 дугаар зүйлийн 1 дэх заалтанд хамрагдах Талууд дотоод үндсэн хэрэгцээгээ хангах зорилгоор үйлдвэрлэлийн тооцооны түвшингээ дээрх хязгаараас давуулж болох авч энэ нь 1986 оны үйлдвэрлэлийн тооцооны түвшнээс 10 хувиас илүүгээр хэтэрч болохгүй.

2. Тал тус бүр хавсралт А-ын 2 дугаар бүлэгт орсон

зохицуулагдах бодисын хэрэглээний тооцооны түвшинг 1994 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн 12 сарын нэгэн үе хийгээд дараа дараагийн 12 сарын хэмжээний үеүдэд тэг түвшнээс хэтрүүлэхгүй. Энд заасан нэг юмуу хэд хэдэн бодис үйлдвэрлэдэг Тал тус бүр дээрх үеүдэд эдгээр бодисын үйлдвэрлэлийн тооцооны түвшинг тэг түвшнээс хэтрүүлэхгүй. Гэхдээ 5 дугаар зүйлийн 1 дэх заалтанд хамрагдах Талууд дотоод үндсэн хэрэгцээгээ хангах зорилгоор үйлдвэрлэлийн тооцоо түвшингээ энэ заагаас давуулж болох ч 15 хувиас хэтрүүлэхгүй байна. Талууд урьдчилан үндсэн гэж хэлэлцэн тохирсон хэрэглэх хэлбэрийг нь хангахад зайлшгүй шаардагдах үйлдвэрлэл, хэрэглээний түвшинг нь зөвшөөрөх, талаар Талуудын, шийдвэр гарснаас бусад тохиолдолд энэ заалтыг мөрдөнө.

2С дүгээр зүйл. БҮРЭН ГАЛОГЕНЖҮҮЛСЭН БУСАД ХФН

1. Талтус бүр 1993 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн 12 сарын турш дахь үед хавсралт В-ийн 1 дүгээр бүлэгт орсон зохицуулах бодисын жил тутмын хэрэглээний тооцооны түвшинг 1986 оны хэрэглээний тооцооны түвшний 80 хувиас хэтрэхгүй байх явдлыг хангана. Энд орсон нэг буюу хэд хэдэн бодис үйлдвэрлэдэг Тал тус бүр дээр заасан хугацаанд эдгээр бодисын үйлдвэрлэлийн жил тутмын тооцооны түвшинг 1989 оны тэдгээрийн үйлдвэрлэлийн тооцооны түвшний 80 хувиас хэтрүүлэхгүй байна. Гэхдээ 5 дугаар зүйлийн 1 дэх заалтанд хамрагдах Талууд дотоод үндсэн хэрэгцээгээ хангах зорилгоор энэ хязгаараас үйлдвэрлэлийн тооцооны түвшингээ хэтрүүлж болох авч тэр нь 1989 оны үйлдвэрлэлийн тооцооны түвшнээс 10 хувиас илүүгээр хэтэрч болохгүй.

2. Тал тус бүр 1994 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн 12 сарын турш дахь нэг үе болоод дараа дараачийн 12 сарын хэмжээний үе тус бүрт хавсралт В-ын 1 дүгээр бүлэгт орсон зохицуулагдах бодисын хэрэглээний жил бүрийн тооцооны түвшинг тэдгээрийн 1989 оны хэрэглээний тооцооны түвшнээс 25 хувиас давуулахгүй явдлыг хангана. Энд заасан нэг юмуу хэд хэдэн бодисыг үйлдвэрлэдэг Тал тус бүр дээрх үеүдэд тэдгээрийн үйлдвэрлэлийн жил тутмын тооцооны түвшинг нь 1986 оны үйлдвэрлэлийн мөн бодисын тооцооны түвшнээс 25 хувиас давуулахгүй. Гэхдээ 5 дугаар зүйлийн 1 дэх заалтанд хамрагдах Талууд дотоод үндсэн хэрэгцээгээ хангах зорилгоор эдгээрийн үйлдвэрлэлийн тооцооны түвшний хязгаарыг хэтрүүлж болох авч тэр нь уг бодисын 1989 оны үйлдвэрлэлийн тооцооны түвшнээс

10 хувиас илүү гарч болохгүй.

3. Тал тус бүр 1996 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн 12 сарын нэг үе хийгээд дараа дараачийн 12 сарын хэмжээний үеүдэд хавсралт В-ын 1 дүгээр бүлэгт орсон зохицуулагдах бодисын хэрэглээний тооцооны түвшинг тэг түвшнээс хэтрүүлэхгүй байх явдлыг хангана. Энд орсон нэг буюу хэд хэдэн бодисыг үйлдвэрлэдэг Тал тус бүр дээрх үеүдэд тэдгээрийн үйлдвэрлэлийн тооцооны түвшинг тэг түвшнээс хэтрүүлэхгүй. Гэхдээ 5 дугаар зүйлийн 1 дэх заалтанд хамрагдах Талууд дотоод үндсэн хэрэгцээгээ хангах зорилгоор тэдгээрийн үйлдвэрлэлийн тооцооны түвшинг хэтрүүлж болох авч энэ нь 1989 оны үйлдвэрлэлийн тооцооны түвшнээс 15-аас илүү хувиар давахгүй. Талууд урьдчилан үндсэн гэж хэлэлцэн тохирсон хэрэглэх хэлбэрийг нь хангахад зайлшгүй шаардагдах үйлдвэрлэл, хэрэглээний түвшинг нь зөвшөөрөх талаар Талуудын шийдвэр гарснаас бусад тохиолдолд энэ заалтыг мөрдөнө.

2D дүгээр зүйл. ДӨРВӨН ХЛОРТ МЕТАН

1. Тал тус бүр хавсралт В-ын 2 дугаар бүлэгт орсон зохицуулагдах бодисын хэрэглээний жил тутмын тооцооны түвшинг 1995 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн 12 сарын үеийн дотор тэдгээрийн 1989 оны хэрэглээний тооцооны түвшнээс 15 хувиас хэтрүүлэхгүй байх явдлыг хангана. Энэ бодисыг үйлдвэрлэдэг Тал тус бүр мөн дээрх үед эдгээрийн жил тутмын үйлдвэрлэлийн тооцооны түвшинг эдгээрийн 1989 оны хэрэглээний тооцооны түвшнээс 15 хувиас хэтрүүлэхгүй. Гэхдээ 5 дугаар зүйлийн 1 дэх заалтанд хамрагдах Талууд дотоод үндсэн хэрэгцээгээ хангах зорилгоор үйлдвэрлэлийн тооцооны түвшингээ хэтрүүлж болох авч энэ нь эдгээрийн 1989 оны үйлдвэрлэлийн тооцооны түвшнээс 10 хувиас илүүгээр хэтэрч болохгүй.

2. Тал тус бүр 1996 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлээд 12 сарын турш дахь нэг үе болоод дараа дараачийн 12 сарын хэмжээтэй үеүдэд хавсралт В-ын 2 дугаар бүлэгт орсон зохицуулагдах бодисын хэрэглээний тооцооны түвшинг тэг түвшнээс хэтрүүлэхгүй байх явдлыг хангана. Эл бодисыг үйлдвэрлэдэг Тал бүр дээрх үе бүрт уг бодисын үйлдвэрлэлийн тооцооны түвшинг тэг түвшнээс хэтрүүлэхгүй. Гэхдээ 5 дугаар зүйлийн 1 дэх заалтанд хамрагдах Талууд дотоод үндсэн хэрэгцээгээ хангах зорилгоор түүний үйлдвэрлэлийн тооцооны түвшинг энэ хязгаараас хэтрүүлж болох ч гэсэн түүний 1989 оны

үйлдвэрлэлийн тооцооны түвшнээс 15 хувиас илүүгээр хэтрүүлэхгүй. Талууд урьдчилан үндсэн гэж хэлэлцэн тохирсон хэрэглэх хэлбэрийг нь хангахад зайлшгүй шаардагдах үйлдвэрлэл, хэрэглээний түвшинг нь зөвшөөрөх талаар Талуудын шийдвэр гарснаас бусад тохиолдолд энэ заалтыг мөрдөнө.

2Е дүгээр зүйл. ГУРВАН ХЛОРТ ЭТАН
(МЕТИЛХЛЮРОФОРМ)

1. Тал тус бүр 1993 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн 12 дугаар сарын дотор хавсралт В-ын 3 дугаар бүлэгт орсон зохицуулагдах бодисын жил тутмын хэрэглээний тооцооны түвшинг 1989 оны хэрэглээний тооцооны түвшнээс давуулахгүй байх явдлыг хангана. Энэ бодисыг үйлдвэрлэдэг Тал бүр мөн дээрх хугацаанд жил тутмын үйлдвэрлэлийн тооцооны түвшингээ 1989 оны үйлдвэрлэлийн тооцооны түвшнээс хэтрүүлэхгүй байна. Гэхдээ 5 дугаар зүйлийн 1 дэх заалтанд хамрагдах Талууд дотоод үндсэн хэрэгцээгээ хангах зорилгоор эл бодисын үйлдвэрлэлийн тооцооны түвшинг хэтрүүлж болох боловч энэ нь 1989 оны үйлдвэрлэлийн тооцооны түвшнээс 10 хувиас илүү давж болохгүй.

2. Тал тус бүр 1994 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлээд 12 сарын хэмжээний үед болоод дараа дараачийн 12 сарын хэмжээний үеүдэд хавсралт В-ын 3 дугаар бүлэгт орсон зохицуулагдах бодисын хэрэглээний жил тутмын тооцооны түвшинг 1989 оны хэрэглээний тооцооны түвшнээс 50 хувиас илүүгээр хэтрүүлэхгүй байх явдлыг хангана. Энэ бодисыг үйлдвэрлэдэг Тал тус бүр дээрх үеүдэд жил бүрийн үйлдвэрлэлийн тооцооны түвшингээ 1989 оны хэрэглээний тооцооны түвшнээс 50 хувиас илүү хэтрүүлэхгүй. Гэхдээ 5 дугаар зүйлийн 1 дэх заалтанд хамрагдах Талууд дотоод үндсэн хэрэгцээгээ хангах үүднээс түүний үйлдвэрлэлийн тооцооны түвшингээ энэ хязгаараас хэтрүүлж болох авч энэ нь 1989 оны үйлдвэрлэлийн тооцооны түвшнээс 10 хувиас илүүгээр хэтэрч болохгүй.

3. Тал тус бүр 1996 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн 12 сарын хэмжээний үед хийгээд дараа дараачийн 12 сарын хэмжээний үеүдэд хавсралт В-ын 3 дугаар бүлэгт орсон зохицуулагдах бодисын хэрэглээний тооцооны түвшинг тэг түвшнээс хэтрүүлэхгүй байх явдлыг хангана. Энэ бодисыг үйлдвэрлэдэг Тал тус бүр мөн дээрх үеүдэд түүний үйлдвэрлэлийн тооцооны түвшинг тэг түвшнээс

хэтрүүлэхгүй. Гэхдээ 5 дугаар зүйлийн 1 дэх заалтанд хамрагдах Талууд дотоод үндсэн хэрэгцээгээ хангах зорилгоор тэр заагийг хэтрүүлж болох авч тэр нь 1989 оны үйлдвэрлэлийн тооцооны түвшнээс 15 хувиас илүүгээр давах ёсгүй. Талууд урьдчилан үндсэн гэж тохирсон хэрэглэх хэлбэрийг нь хангахад зайлшгүй шаардагдах үйлдвэрлэл, хэрэглээний түвшинг нь зөвшөөрөх талаар Талуудын шийдвэр гаргаснаас бусад тохиолдолд энэ заалтыг мөрдөнө.

2F дүгээр зүйл. ГИДРОХЛОРФТОРТ НҮҮРСТӨРӨГЧҮҮД

1. Тал тус бүр 1996 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлээд 12 сарын хэмжээний үед хийгээд дараа дараачийн 12 сарын хэмжээний үеүдэд хавсралт С-ын 1 дүгээр бүлэгт орсон зохицуулагдах бодисын жил бүрийн тооцооны түвшинг дараах нийлбэр үзүүлэлтээс давахгүй байлгана.

а) Хавсралт А-ын 1 дүгээр бүлэгт орсон зохицуулагдах бодисын хэрэглээний түвшнээс 3.1 (гурван бүхэл аравны нэгэн хувиас) ба;

б) Хавсралт С-ын 1 дүгээр бүлэгт орсон зохицуулагдах бодисын 1989 оны хэрэглээний тооцооны түвшин эдгээр болно.

2. Тал тус бүр 2004 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн 12 сарын хэмжээний үед хийгээд дараа дараачийн 12 сарын хэмжээний үеүдэд хавсралт С-ын 1 дүгээр бүлэгт орсон зохицуулагдах бодисын хэрэглээний жил бүрийн тооцооны түвшинг энэ зүйлийн 1 дэх заалтанд заасан нийлбэр үзүүлэлтээс давуулахгүй байх явдлыг хангана.

3. Тал тус бүр 2010 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн 12 сарын хэмжээний үед хийгээд дараа дараачийн 12 сарын хэмжээний үеүдэд хавсралт С-ын 1 дүгээр бүлэгт орсон зохицуулагдах бодисын жил бүрийн хэрэглээний тооцооны түвшинг энэ зүйлийн 1 дэх заалтанд заасан нийлбэр үзүүлэлтээс 35 хувиас илүүгээр хэтрэхгүй байх явдлыг хангана.

4. Тал тус бүр 2015 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн 12 сарын хэмжээний үед хийгээд дараа дараачийн 12 сарын хэмжээний үеүдэд хавсралт С-ын 1 дүгээр бүлэгт орсон зохицуулагдах бодисын жил тутмын хэрэглээний тооцооны түвшинг энэ зүйлийн 1 дэх заалтанд өгүүлсэн нийлбэр үзүүлэлтээс 10 хувиас хэтрүүлэхгүй байх явдлыг хангана.

5. Тал тус бүр 2020 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн 12 сарын турш дахь нэг үе хийгээд дараа дараачийн 12 сарын хэмжээний

үеүдэд хавсралт С-ын 1 дүгээр бүлэгт огсон зохицуулагдах бодисын жил тутмын хэрэглээний тооцооны түвшинг энэ зүйлийн 1 дэх заалтанд өгүүлсэн нийлбэр үзүүлэлтээс 0.5 хувиас дээш гаргахгүй байх явдлыг хангана.

6. Тал тус бүр 2030 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн 12 сарын хэмжээний нэг үе хийгээд дараа дараачийн 12 сарын хэмжээний үеүдэд хавсралт С-ын 1-д орсон зохицуулагдах бодисын жил тутмын хэрэглээний тооцооны түвшнийг тэг түвшнээс давуулахгүй.

7. Тал тус бүр 1996 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн:

а. хавсралт С-ын 1 дэх бүлэгт орсон зохицуулагдах бодисын ашиглалт нь экологийн хувьд илүү зохистой орлуулах бодис болоод технологи хараахан олдоогүй тийм хэрэглээний хэлбэрээр хязгаарлагдах;

в. хүний эрүүл мэнд, амь насыг хамгаалахад зайлшгүй зарим ховор тохиолдлоос бусад үед хавсралт А,В,С-д орсон зохицуулагдах бодисоор одоо үед хэрэгцээгээ хангадаг салбараас гадуур хавсралт С-ын 1 дэх бүлэгт орсон зохицуулагдах бодисын хэрэглээг зогсоох; ба

с. озоны үе давхарга задрах явдлыг хамгийн бага болгохын тулд ба байгаль орчин, эдийн засгийн аюулгүй байдлын үүднээс хавсралт С-ын 1 дэх бүлэгт орсон зохицуулагдах бодисын сонголт хийх явдлыг хангахыг хичээнэ.

2G дүгээр зүйл. ГИДРОБРОМФТОРТ НҮҮРСТӨРӨГЧ

Тал тус бүр 1996 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн 12 сарын хэмжээний нэг үе хийгээд дараа дараачийн 12 сарын үеүдэд хавсралт С-ын 2 дугаар бүлэгт орсон зохицуулагдах бодисын хэрэглээний тооцооны түвшинг тэг түвшнээс давуулахгүй байх явдлыг хангана. Энэ бодисыг үйлдвэрлэдэг Тал тус бүр мөн дээрх үеүдэд эдгээрийн үйлдвэрлэлийн тооцооны түвшинг тэг түвшнээс хэтрүүлэхгүй. Талууд урьдчилан үндсэн гэж тохирсон хэрэглэх хэлбэрийг нь хангахад зайлшгүй шаардагдах үйлдвэрлэл, хэрэглээний түвшинг нь зөвшөөрөх талаар Талуудын шийдвэр гаргаснаас бусад тохиолдолд энэ заалтыг мөрдөнө.

2Н дугээр зүйл. БРОМТ МЕТИЛ

Тал тус бүр 1995 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн 12 сарын хэмжээний үед хийгээд дараа дараачийн 12 сарын хэмжээтэй

үеүдэд хавсралт Е-д заасан зохицуулагдах бодисын хэрэглээний тооцооны түвшинг 1991 оны хэрэглээний жилийн тооцооны түвшнээс хэтрүүлэхгүй байх явдлыг хангана. Энэ бодисыг үйлдвэрлэдэг Тал тус бүр мөн дээрх үеүдэд энэ бодисын үйлдвэрлэлийн тооцооны түвшинг 1991 оны үйлдвэрлэлийн жилийн тооцооны түвшнээс хэтрүүлэхгүй. Гэхдээ 5 дугаар зүйлийн 1 дэх заалтанд хамрагдах Талууд дотоод үндсэн хэрэгцээгээ хангах зорилгоор түүний үйлдвэрлэлийн тооцооны түвшинг хэтрүүлж болох авч энэ нь 1991 оны үйлдвэрлэлийн тооцооны түвшнээс 10 хувиас илүүгээр давж болохгүй. Энэ зүйлийн дагуух үйлдвэрлэл, хэрэглээний тооцооны түвшинд Талууд хорио цээрийн зориулалтаар болон тээвэрлэлт хийхийн өмнө бүтээгдэхүүн боловсруулах зорилгоор ашиглаж байгаа бодисуудын тоо хэмжээ хамрагдахгүй.

3 дугаар зүйл. ЗОХИЦУУЛАГДАХ ТҮВШНИЙ ТООЦОО

Тал тус бүр 2, 2А-2Е (2А-2Н) ба 5 дугаар зүйлүүдийг хэрэгжүүлэхийн тулд хавсралт А буюу хавсралт В (хавсралт А, хавсралт Ё болон хавсралт Е)-д байгаа бүлэг бодис бүрээр өөрийн тооцооны түвшин тодорхойлно.

а. Үйлдлийг:

i. Зохицуулагдах бодис бүрийн өөрийн жилийн үйлдвэрлэлийн хэмжээг хавсралт А буюу хавсралт В {хавсралт В, хавсралт G буюу хавсралт E}-д өгсөн озоныг задлах чадварын үзүүлэлтээр үржүүлнэ;

ii. Гаргаж авсан үзүүлэлтийг бүлэг бүрээр нь нийлбэрчлэх маягаар хийнэ.

в. өмнөх а/ хэсэгт тодорхойлсон *mutatis mutandis* дэгийг хэрэглээд харгалзах импорт, экспортыг тодорхойлох; ба

с. зохицуулагдах бодисын хэрэглээг өөрийн үйлдвэрлэл, импортын тооцооны түвшинг нийлбэрчлээд түүнээсээ а/ ба в/ хэсэгт өгсөн өөрийн экспортын тооцооны түвшинг хасаж болно. Гэхдээ 1993 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн экспортчлогч Талын хэрэглээний түвшинг гаргахдаа энэ Протоколын Тал болоогүй оронд экспортолсон зохицуулагдах бодисыг хасахгүй.

4 дүгээр зүйл. ТАЛ БУС УЛС ОРНУУДАЙ ХИЙХ ХУДАЛДААГ ЗОХИЦУУЛАХ НЬ

[1. Энэхүү Протокол хүчин төгөлдөр болсноос эхлэн нэгэн

жилийн турш Тал тус бүр энэхүү Протоколын Тал болж ороогүй аль ч улсаас зохицуулагдах бодис импортлохыг хориглоно.

2. 1993 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн 5 дугаар зүйлийн 1 дэх заалтанд хамрагдах аль нэг Тал энэхүү Протоколын Тал болоогүй ямар ч улсад ямар нэгэн зохицуулагдах бодис экспортолж болохгүй.

3. Конвенцийн 10 дугаар зүйлд урьдчилан заасны дагуу энэхүү Протокол хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 3 жилийн турш Талууд нь зохицуулагдах бодис агуулсан бүтээгдэхүүний нэрийн жагсаалтыг хавсралт хэлбэрээр бэлтгэнэ. Хавсралт хүчин төгөлдөр болсноос хойш нэгэн жилийн турш зохих дэгийн дагуу хавсралтыг эс зөвшөөрөх тухайгаа илэрхийлээгүй Талууд энэхүү Протоколын Тал болоогүй аль ч улсаас дээрх бүтээгдэхүүнийг импортлохыг хориглоно.]

[4. Талууд энэхүү Протокол хүчин төгөлдөр болсноос хойш 5 жилийн турш зохицуулагдах бодисыг ашиглан үйлдвэрлэдэг, гэхдээ тэдгээрийг агуулдаггүй бүтээгдэхүүнийг энэхүү Протоколын Тал болоогүй улс орнуудаас импортлохыг хориглох юм уу хязгаарлах практик боломжийг тодорхойлно. Талууд хэрэв үүнийг боломжтой гэж үзвэл Конвенцийн 10 дугаар зүйлд заасан дэгийн дагуу тийм бүтээгдэхүүний нэрийн жагсаалтыг бэлтгэнэ. Түүний эсрэг байгаагаа илэрхийлээгүй Талууд хавсралт хүчин төгөлдөр болсноос хойш нэг жилийн турш зохих дэгийн дагуу энэхүү Протоколын Тал болоогүй аль ч улсаас тийм бүтээгдэхүүн импортлохыг хориглох юмуу хязгаар тавина.

5. Тал бус бүр энэхүү Протоколын Тал болоогүй аль ч улсад зохицуулагдах бодис үйлдвэрлэх, ашиглах технологийн экспортыг урамшуулахгүй.]

1. Тал тус бүр 1990 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн хавсралт А-д үзүүлсэн зохицуулагдах бодисыг энэхүү Протоколын Тал болоогүй аль ч улсаас импортлохыг хориглоно.

1-бис. Тал тус бүр энэхүү Протоколын хүчин төгөлдөр болсноос хойш нэг жилийн турш хавсралт Е-д үзүүлсэн зохицуулагдах бодисыг энэхүү Протоколын Тал болоогүй аль ч улсаас импортлохыг хориглоно.

1-тер. Тал тус бүр энэ заалт хүчин төгөлдөр болсноос хойш нэгэн жилийн турш хавсралт С-ын 2 дугаар бүлэгт орсон зохицуулагдах бодисын энэхүү Протоколын Тал болоогүй аль ч улсаас импортлохыг хориглоно.

2. Тал тус бүр 1993 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн хавсралт А-д үзүүлсэн бүх зохицуулагдах бодисыг энэхүү Протоколын Тал болоогүй аль ч улсад экспортлохыг хориглоно.

2-бис. Тал тус бүр энэхүү заалт хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш нэг жил өнгөрөөд хавсралт В-д дурдсан бүх зохицуулагдах бодисыг энэхүү Протоколын Тал болоогүй аль ч улсад экспортлохыг хориглоно.

2-тер. Тал тус бүр энэ заалт хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш нэг жил өнгөрөөд хавсралт С-ын 2 дугаар бүлэгт орсон бүх зохицуулагдах бодисыг энэхүү Протоколын Тал болоогүй аль ч улсад экспортлохыг хориглоно.

3. Талууд 1992 оны 1 дүгээр сарын 1-н гэхэд Конвенцийн 10 дугаар зүйлд урьдчилан заасан дэгт нийцүүлэн хавсралт А-д үзүүлсэн зохицуулагдах бодисуудыг агуулж байгаа бүтээгдэхүүний нэрсийн жагсаалтыг хавсралт хэлбэрээр бэлтгэнэ. Энэ хавсралтын эсрэг байгаагаа илэрхийлээгүй Талууд энэ хавсралт хүчин төгөлдөр болсноос хойш нэгэн жилийн дотор зохих дэгт заасны дагуу ийм бүтээгдэхүүнийг энэхүү Протоколын Тал болоогүй аль ч улс орноос импортлохыг хориглоно.

3-бис. Энэ зүйл хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн 3 жилийн дотор Конвенцийн 10 дугаар зүйлд урьдчилан заасан дэгийн дагуу Талууд хавсралт В-д орсон зохицуулагдах бодисыг агуулж байгаа бүтээгдэхүүний нэрсийн жагсаалтыг хавсралт байдлаар зохионо. Энэ хавсралтын эсрэг байгаагаа илэрхийлээгүй Талууд хавсралт хүчин төгөлдөр болсон үеэс хойш нэгэн жилийн дотор дэгт заасны дагуу эдгээр бодисыг энэхүү Протоколын Тал болоогүй аль ч улсаас импортлохыг хориглоно.

3-тер. Энэ зүйл хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн 3 жилийн турш Конвенцийн 10 дугаар зүйлээр тогтоосон дэгийн дагуу Талууд хавсралт С-ын 2 дугаар бүлэгт орсон зохицуулагдах бодисыг агуулж байгаа бүтээгдэхүүний жагсаалтыг хавсралт хэлбэрээр зохионо. Энэ хавсралтын эсрэг байгаагаа зохих дэгийн дагуу илэрхийлээгүй Талууд хавсралт хүчин төгөлдөр болсон үеэс эхлэн нэгэн жилийн турш энэхүү Протоколын Тал болоогүй аль ч улсаас тийм бүтээгдэхүүн импортлохыг хориглоно.

4. Талууд 1994 оны 1 дүгээр сарын 1-н гэхэд хавсралт А-д үзүүлсэн зохицуулагдах бодис ашиглан үйлдвэрлэдэг тэгэхдээ тэдгээрийн агуулаагүй бүтээгдэхүүнийг энэхүү Протоколын Тал болоогүй улс орнуудаас импортлохыг хориглох юмуу хязгаарлах практик боломжийг

тодорхойлно. Хэрэв үүнийг боломжтой гэж үзвэл Талууд Конвенцийн 10 дугаар зүйлд урьдчилан заасан дэгийн тийм бүтээгдэхүүний нэрсийн жагсаалтыг хавсралт хэлбэрээр бэлтгэнэ. Энэ хавсралтын эсрэг байгаага илэрхийлээгүй Талууд хавсралт хүчин төгөлдөр болсноос хойш нэгэн жилийн дотор энэхүү Протоколын Тал болоогүй аль ч улсаас тийм бүтээгдэхүүн импортлохыг дурдсан дэгийн дагуу хориглоно.

4-бис. Талууд энэ зүйл хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн 5 жилийн дотор хавсралт В-д үзүүлсэн зохицуулагдах бодис ашиглан үйлдвэрлэсэн, гэхдээ тэдгээрийг агуулаагүй бүтээгдэхүүнийг энэхүү Протоколын Тал болоогүй аль ч улс орноос импортлохыг хориглох юмуу хязгаарлах практик боломжийг тодорхойлно. Талууд хэрэв үүнийг боломжтой гэж үзвэл Конвенцийн 10 дугаар зүйлд урьдчилан заасан дэгийн дагуу тийм бүтээгдэхүүний нэрсийн жагсаалтыг хавсралт хэлбэрээр бэлтгэнэ. Энэ хавсралтын эсрэг байгаага илэрхийлээгүй Талууд хавсралт хүчин төгөлдөр болсноос хойш нэг жилийн дотор энэхүү Протоколын Тал болоогүй аль ч улсаас ийм бүтээгдэхүүн импортлохыг дурдсан дэгийн дагуу хориглоно.

4-тер. Энэ заалт хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн 5 жилийн турш хавсралт С-ын 2 дугаар бүлэгт орсон зохицуулагдах бодисыг ашиглаж үйлдвэрлэсэн, гэхдээ тэдгээрийг агуулаагүй бүтээгдэхүүнийг импортлохыг хориглох юмуу хязгаарлах боломжийг тодорхойлж, хэрэв энэ нь боломжтой гэж үзвэл Конвенцийн 10 дугаар зүйлд заасан дэгийн дагуу тийм бодисын нэрсийн жагсаалтыг хавсралт хэлбэрээр боловсруулна. Энэ хавсралтыг зөвшөөрөхгүй байгаага илэрхийлээгүй Талууд энэ хавсралт хүчин төгөлдөр болсноос хойш нэгэн жилийн турш энэхүү Протоколын Тал болоогүй аль ч улс орноос тийм бүтээгдэхүүн импортлохыг хориглоно.

5. Тал тус бүр {хавсралт А, В ба хавсралт С-ын 2 дугаар бүлэгт орсон} зохицуулагдах бодисыг үйлдвэрлэх, ашиглах технологийг энэхүү Протоколын Тал болоогүй аль ч улс орон экспортлох явдлыг аль болох урамшуулахгүй байх үүрэгтэй.

6. Тал тус бүр энэхүү Протоколын Тал болоогүй аль ч улс орнуудад зохицуулагдах бодисыг {хавсралт А, В ба хавсралт С-ын 2 дугаар бүлэгт орсон} үйлдвэрлэхэд нь дэмжлэг үзүүлэхүйц экспортын бүтээгдэхүүн, тоног төхөөрөмж, тоноглол, технологид зориулан шинэ тэтгэмж, тусламж, зээллэг даатгалын хөтөлбөр, баталгаа олгохоос түдгэлзэнэ.

7. Энэ зүйлийн 5 ба 6 дугаар зүйл нь зохицуулагдах бодисын {хавсралт А, В ба хавсралт С-ын 2 дугаар бүлэгт орсон} ялгаралтыг

багасгахад дэмжлэг болох юмуу орлуулах бодис эрж хайх явдлыг түргэтгэхэд чиглэсэн зохицуулагдах бодисыг аюулгүй хадгалах, хаягдал ашиглах, дахин эргэлтэнд оруулах, устгах зориулалттай бүтээгдэхүүн, тоног төхөөрөмж, тоноглол хийгээд технологийн хувьд хамаарахгүй.

8. Хэрэв Талуудын Зөвлөлгөөнөөс эдгээр улс орнууд 2 дугаар зүйл 2А-2Е дүгээр зүйлүүд {2G дүгээр зүйл} болоод энэхүү зүйлийг бүрэн биелүүлж байгаа улсууд мөн гэж тодорхойлсон, мөн тэдгээр нь 7 дугаар зүйлээр тогтоосон мэдээллээ гаргаж өгч байвал энэ зүйлийг 1.1-бис, 3.3-бис [ба] 4.4-бис заалтанд дурдсан импорт, 2 болон 2-бис заалтанд дурдсан экспорт {энэ зүйлийн 1-4-тер заалтанд авч үзсэн экспорт}-ыг энэхүү Протоколын Тал болоогүй орноос оруулах юмуу тийм оронд гаргах тухайд энэ зүйлд заасныг харгалзахгүйгээр зөвшөөрч болно.

9. Энэ зүйлд байгаа »энэхүү Протоколын Тал болоогүй улс орнууд» гэдэгт тухайн ямар нэгэн зохицуулагдах бодисын хувьд зохицуулах арга хэмжээтэй санал нэгдээгүй улс орон юмуу эдийн засгийн хамтын ажиллагааны бүс нутгийн байгууллагыг ойлгоно.

10. 1996 оны 1 дүгээр сарын 1-н гэхэд Талууд энэ Протоколын Тал болоогүй улс орнуудтай хавсралт С-ын 1 дүгээр бүлэг, хавсралт Е-д орсон зохицуулагдах бодисын хувьд худалдааны салбарт энэ зүйлээр урьдчилан тогтоосон арга хэмжээг хэрхэх тухай энэхүү Протоколд засвар оруулах эсэх асуудлыг авч үзнэ.

5 дугаар зүйл. ХӨГЖИЖ БАЙГАА ОРНУУДЫН ОНЦГОЙ БАЙР СУУРЬ

1. Өөрийн хувьд Протокол хүчин төгөлдөр болж байгаа өдөр буюу түүнээс хойш 1990 онд 1 сарын 1 хүртэл [Протокол хүчин төгөлдөр болсноос хойш 10 жилийн турш] хавсралт А-д заасан зохицуулагдах бодисын хэрэглээний жил бүрийн тооцооны түвшин нь нэг хүн амд 0.3 кг-аас бага байгаа хөгжиж байгаа орны аль ч Тал өөрийн дотоод үндсэн хэрэгцээгээ хангах зорилгоор 2А-2Е зүйлд урьдчилан заасан [2 дугаар зүйлийн 1-4 дэх заалтанд байгаа хугацаанаас хойш 10 жил] зохицуулах арга хэмжээнүүдийг 10 жилээр хойшлуулах эрх эдэлнэ. [Гэхдээ энэ Талынхан нэг хүн амд оногдох хэрэглээний жил тутмын тооцооны түвшинг 0.3кг-аас давуулах ёсгүй. Ийм аль ч Тал нь өөрийн зохицуулах арга хэмжээг дагаж мөрдөхөөр доор үзүүлсэн сууриасаа хамаарч нэг бол 1995 оноос 1997 он дуустал үе дэх хэрэглээний жилийн дундаж тооцооны түвшнээ, нэг бол хүн амд 0.3 кг хэмжээний

хэрэглээний тооцооны түвшин оногдох гэсний аль нэгийг ашиглах эрхтэй.]

1990 оны VI сарын 29-нд Лондон хотноо болсон Талуудын II зөвлөлгөөнөөр энэ заалтанд хамрагдах Талуудад тараасан засвар, залруулганд оруулсан ямар ч нэмэлт засвар энэ зүйлийн 8 дахь заалтанд дурдсан ёсоор тойм авах ажиллагаа явуулсны дараа эдгээр тоймын үндсэн дээр дүгнэлт гарсан хойно мөрдөгдөнө.

1-Бис. 2 дугаар зүйлийн 9 дэх заалтанд дурдсан дэгийн үндсэн дээр Талууд 1996 оны 1 сарын 1 гэхэд 6 дугаар зүйлийн дагуу явуулсан тойм болоод бусад холбогдох мэдээллийн дагуу энэ зүйлийн 8 дахь заалтанд нийцүүлэн дараах шийдвэр гаргана.

а. 2F дүгээр зүйлийн 1-6 дахь заалтанд холбогдуулан хавсралт С-ын 1 бүлэгт орсон зохицуулагдах бодисын хэрэглээний хувьд ямар суурь оныг авах, эхлэлийн түвшин ямар байх, эдгээр бодисын хэрэглээний хяналтын график, зогсоох хугацааны тухайд энэ зүйлийн 1 дэх заалтанд хамрагдах Талуудын хувьд тогтоох;

в. 2G дүгээр зүйлтэй холбогдуулан хавсралт С-ын II бүлэгт орсон зохицуулагдах бодисын үйлдвэрлэл, хэрэглээг хэзээ зогсоохыг энэ зүйлийн 1 дэх заалтанд хамрагдах Талуудын хувьд тогтоох;

с. 2H дугаар зүйлтэй холбогдуулан хавсралт Е-д орсон зохицуулагдах бодисын хувьд ямар суурь он авах, эхлэлийн түвшин ямар байх, үйлдвэрлэл, хэрэглээний хяналтын графикийн асуудлаар энэ зүйлийн 1 дэх зүйлд хамрагдах Талуудын хувьд тогтоох зэрэг болно.

[2. Хөгжиж байгаа орны Талуудад экологийн хувьд аюулгүй химийн орлуулах бодис, технологи олж авах, тэдэнд тийм орлуулах бодис, технологи ашиглахад аль болох түргэн шилжихэд нь тусламж дэмжлэг үзүүлэх үүргийг Талууд хүлээнэ]

3. Хөгжиж байгаа орнуудын Талуудад орлуулах технологи, орлуулах бүтээгдэхүүн ашиглуулах зорилгоор Талууд хоёр буюу олон талын сувгаар тэдэнд тэтгэмж, тусламж, зээллэг олгох, зориулсан даатгалын баталгаа, хөтөлбөр гаргах талаар үүрэг хүлээнэ.]

2. Гэхдээ энэ зүйлийн 1 дэх заалтанд хамрагдах аль ч Тал хавсралт А-д заасан зохицуулагдах бодисын жил бүрийн хэрэглээний тооцооны түвшинг нэг хүн амд 0.3 кг-аас, хавсралт В-д заасан зохицуулагдах бодисын жил бүрийн тооцооны түвшинг нэг хүн амд 0.2 кг-аас тус тус хэтрүүлэхгүй.

3. 2А-2Е зүйлийн дагуух зохицуулах арга хэмжээг хэрэглэж байгаа тохиолдолд энэ зүйлийн 1 дэх заалтанд хамрагдах аль ч Тал:

а. Хавсралт А-д заасан зохицуулагдах бодисын хувьд 1995 оноос эхлэн 1997 он дуусталх үед өөрийн хэрэглээний жилийн дундаж тооцооны түвшинг тогтоох, нэг хүнд оногдох хэрэглээний тооцооны түвшний хэмжээ 0.3 кг-аас бага байлгах хоёрын аль нь бага байна гэдгээс хамаарч түүний зохицуулах арга хэмжээний мөрдөх критерийг тодорхойлох үндсийг сонгон авч болох;

в. Хавсралт В-д заасан зохицуулагдах бодисын хувьд 1998 оноос эхлэн 2000 он дуусталх үед өөрийн хэрэглээний жилийн дундаж тооцооны түвшинг тогтоох юмуу нэг хүнд оногдох хэрэглээний тооцооны түвшинг 0.2 кг-аас бага байлгах хоёрын аль нь бага байна гэдгээс хамаарч түүний зохицуулах арга хэмжээний мөрдөх критерийг тодорхойлох үндсийг сонгон авч болох эрх эдэлнэ.

4. Энэ зүйлийн 1 дэх заалтанд хамрагдах Тал 2А-2Е [2А-2Н дүгээр зүйлүүд] дүгээр зүйлүүдэд урьдчилан заасан зохицуулах арга хэмжээнүүд түүний хувьд хүчин төгөлдөр болохоос өмнө аль ч үед зохицуулагдах бодисын хангалттай тоо хэмжээг гаргаж чадахгүй нь гэдэг нь тодорвол энэ тухайгаа Нарийн бичгийн дарга нарын газарт мэдээлнэ. Ийм мэдээллийн хувийг Нарийн бичгийн дарга нарын газар тодорхой арга хэмжээний шийдвэр гаргуулахаар дараагийн Зөвлөлөгөөнд оруулахын тулд Талуудад яаралтай тараана.

5. 2А-2Е дүгээр зүйл, 2F-2Н дүгээр зүйлээр зохицуулах ямар нэг арга хэмжээ авах тухай энэ зүйлийн 1-бис. Заалтын дагуу шийдвэр гаргах тухай урьдчилан заасан зохицуулах арга хэмжээг мөрдөхөд энэ зүйлийн 1 дэх заалт хамрагдах Талуудыг хүлээсэн үүргээ биелүүлэх чадварыг нь хангах, мөн энэ Талын үүргээ хэрэгжүүлэх явдал бол 10А дугаар зүйлд заасанчлан технологи дамжуулах, 10 дугаар зүйлд заасанчлан санхүүгийн хамтын ажиллагааны үр ашигтай хэрэгжилтээс хамаарна.

6. Энэ зүйлийн 1 дэх заалтанд хамрагдах ямар нэг Тал аль ч үед Нарийн бичгийн дарга нарын газарт боломжтой бүх практик алхам хийсэн авч 10 ба 10А дугаар зүйлийг бүрэн биелүүлээгүй шалтгаанаар 2А- 2Е дүгээр зүйлд томъёолсон зохицуулах арга хэмжээгээр авсан үүргийн аль нэгийг юмуу бүгдийг нь эсвэл энэ зүйлийн 1-бис. заалтын дагуу авах ёстой арга хэмжээгээр хэрэгжих 2F-2Н дүгээр зүйлд томъёолсон аль нэг юмуу бүх үүргээ гүйцэтгэж чадахгүй байгаа тухай бичгээр мэдээлж болно. Нарийн бичгийн дарга нарын газраас энэ мэдээг энэ зүйлийн 5 дахь заалтыг тооцон дараагийн зөвлөлөгөөн дээр асуудал болгож авч үзэж шаардагдах шийдвэр гаргуулахын тулд Талуудад яаралтай илгээнэ.

7. Дээрх мэдээг авсан, өмнөх 6 дахь заалтын дагуу шаардагдах арга хэмжээний тухай шийдвэр гаргах ёстой Талуудын зөвлөлгөөк хуралдах хүртэлх үе хийгээд түүний дараах аль ч үед Талуудын зөвлөлгөөний шийдвэрээр 8 дугаар зүйлд томъёолсон даган мөрдөөгүйтэй холбогдон гарах дэгийг мэдээ өгсөн Талд хэрэглэхгүй.

8. Талуудын зөвлөлгөөнөөс 1995 онорс оройтолгүйгээр энэ зүйлийн 1 дэх заалтанд хамрагдах Талуудын байдлын тухай тойм хийж тэндээ энэ Талуудын хувьд хэрэглэх, зохицуулах арга хэмжээний графикайн хувьд шаардлагатай гэж үзсэн ямар нэг өөрчлөлт, санхүүгийн хамтын ажиллагаа, технологи дамжуулах хамтын ажиллагааг үр ашигтай хэрэгжүүлэх асуудлыг тусгана.

9. Энэ зүйлийн 4, 6 ба 7 дахь заалтуудад өгүүлсэн Талуудын шийдвэрийг 10 дугаар зүйлийн хүрээнд гаргах дэгийг баримтлан гаргана.

6 дугаар зүйл. ЗОХИЦУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ҮНЭЛГЭЭ БА ТОЙМ

1990 оноос эхлэн цаашид 4 жил тутам нэгээс доошгүй удаа Талууд шинжлэх ухаан, экологийн болоод техник, эдийн засгийн хуримталсан мэдээллийн үндсэн дээр 2 дугаар зүйл, 2А-2Е дүгээр зүйлүүдэд тогтоосон зохицуулах арга хэмжээ, мөн тэрчлэн хавсралт С-ын 1 бүлэгт байгаа {2А-2Н дүгээр зүйл} шилжих бодисын үйлдвэрлэл, импорт, экспортын байдалд үнэлгээ өгч байна. Тухайн үнэлгээ хийхээс нэг жилээс доошгүй хугацааны өмнө Талууд дээр заасан салбаруудаар нарийн мэргэшсэн шинжээчдийн бүлэг зохион байгуулж, бүлэг бүрийн бүрэлдэхүүн, авч үзэх асуудлыг тодорхойлж өгнө. Өөрийн бүлгийг зохион байгуулснаас хойш нэгэн жилийн дотор Нарийн бичгийн дарга нарын газраар дамжуулан бүлгүүд өөрийн дүгнэлтийг Талуудад хүргүүлнэ.

7 дугаар зүйл. ӨГӨГДӨЛ ТАНИЛЦУУЛАХ НЬ

1. Тал болон орсноос хойш 3 сарын дотор Тал тус бүр Хавсралт А-д орсон зохицуулагдах бодис бүрээр үйлдвэрлэл, экспорт, импортын тухай өөрийн статистик өгөгдөл юмуу хэрэв тийм бодит өгөгдөл байхгүй бол тэр тухайд аль болох найдвартай тоймчилсон

өгөгдлөө Нарийн бичгийн дарга нарын газарт гаргаж өгнө.

[2. Тал тус бүр Нарийн бичгийн дарга нарын газарт өөрийн жил тутмын үйлдвэрлэл {Талуудаар зохих ёсоор батлагдсан технологийг хэрэглэн жил бүр устгаж байгаа бодисын тоо хэмжээний тухай өгөгдлийг тусгайлан заагаад} болоод өөрийн Тал болж орсон жилийн хийгээд үүнээс хойшхи жил тутамд энэ Протоколын Тал болсон болоогүй аль ч улс оронтой хийсэн тухайн бодисын импорт, экспортын тухай статистик өгөгдлөө уг өгөгдөл хамаарах он дууссанаас хойш 9 сарын дотор гаргаж өгнө.]

2. Тал тус бүр хавсралт В-д орсон зохицуулагдах бодис тус бүр мөн тэрчлэн хавсралт С-ын 1 дүгээр бүлэгт байгаа шилжих бодисын 1989 оны өөрийн үйлдвэрлэл, импорт, экспортын тухай статистик өгөгдөл, хэрэв бодит өгөгдөл байхгүй бол тэдгээрийн тухай аль болох найдвартай тоймчилсон өгөгдлөө хавсралт В-д орсон бодисод хамаарах Протоколын томъёоллууд тухайн Талын хувьд хүчин төгөлдөр болсноос хойш 3 сарын дотор багтаан Нарийн бичгийн дарга нарын газарт танилцуулна.

3. Тал тус бүр Нарийн бичгийн дарга нарын газарт өөрийн жил тутмын үйлдвэрлэлийн тухай (1 дүгээр зүйлийн 5 дахь заалтанд тодорхойлсноор) статистик өгөгдөл болон тусад нь:

- анхлан хэрэглэх түүхий эд болон ашиглаж байгаа бодисын тоо хэмжээний тухайд;

- Талуудын баталсан технологийг хэрэглэн, устгаж буй бодисын тоо хэмжээний тухай;

- Тал болоогүй улс орон хийгээд байгууллагатай тухайн Талын хийсэн импорт, экспортын тухай;

Хавсралт С-ын 1 дүгээр бүлэгт орсон шилжих бодис ба хавсралт А, В-д тоочсон зохицуулагдах бодис бүрээр өгөгдөл гаргаж тухайн Талын хувьд хавсралт В-д орсон заалт хүчин төгөлдөр болсон оныг хамруулан дараа дараачийн жил бүр гаргана. Эл өгөгдлийг тухайн өгөгдөл хамаарах он дууссанаас хойш 9 сарын дотор багтаан илгээж байна.

2. Тал тус бүр Нарийн бичгийн дарга нарын газарт:

- хавсралт В ба С-ын 1989 оны

- хавсралт Е -ийн 1991 оны

зохицуулагдах бодис бүрээр өөрийн үйлдвэрлэл, импорт, экспортын тухай статистик өгөгдөл буюу хэрэв тийм бодит өгөгдөл байхгүй бол аль болох найдвартай тоймчилсон өгөгдлийг гаргаж хавсралт В,С,Е-д орсон харгалзах бодисын тухай Протоколын томъёолол тухайн

Талын хувьд хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш гурван сарын дотор гаргаж өгнө.

3. Тал тус бүр Нарийн бичгийн дарга нарын газарт хавсралт А,В,С ба Е-д заасан зохицуулагдах бодис бүрээр өөрийн жил тутмын үйлдвэрлэлийн (1 дүгээр зүйлийн 5 дахь заалтанд тодорхойлсноор) тухай статистик өгөгдөл болоод бодис тус бүрээр:

- анхлан түүхий эд хэлбэрэр ашиглаж байгаа бодисын тоо хэмжээний тухай

- Талуудын баталсан технологийг ашиглан устгаж байгаа бодисын тоо хэмжээний тухай ба

- Тал болоогүй улс орон болон байгууллагатай тухайн Талын хийж байгаа импорт, экспортын тухай мэдээг хавсралт А,В,С ба Е-д байгаа бодисуудын тухай Протоколын томъёолол тухайн Талын хувьд хүчин төгөлдөр болсон жилийг оролцуулаад дараа дараачийн жил тутам гаргаж байна. Эл өгөгдлийг тухайн өгөгдөл хамрах он дууссанаас хойш 9 сарын дотор явуулж байна.

3-бис. Тал тус бүр хавсралт А-ын 2 дугаар бүлэг, хавсралт С-ын 1 дүгээр бүлэгт орсон, дахин эргэлтэнд орсон зохицуулагдах бодис бүрээр өөрийн жил тутмын импорт, экспортын тухай статистик өгөгдлийг Нарийн бичгийн дарга нарын газарт өгч байна.

4. 2 дугаар зүйлийн 8 а/ заалтанд хамрагдах Талын хувьд энэ зүйлийн 1, 2 ба 3 дахь заалтанд өгүүлсэн {1,2,3, 3- бис заалтуудын} импорт, экспортынхоо тухай статистик өгөгдөл гаргах шаардлагын тухайд зөвхөн эдийн засгийн хамтын ажиллагааны бүс нутгийн байгууллагаас өөр хоорондоо болоод энэ байгууллагын гишүүн бус улс оронтой хийсэн импорт, экспортын тухай өгөгдлөө гаргана.

8 дугаар зүйл. ДАГАН МӨРДӨХГҮЙ БАЙХ НЬ

Талуудын ээлжит анхдугаар зөвлөлгөөнөөрөө энэхүү Протоколын томъёоллыг даган мөрдөхгүй байгаа баримт нотолгоог тодорхойлох болоод Протоколыг даган мөрдөөгүй Талтай холбогдох зохион байгуулалтын механизм, дэг журмыг хэлэлцэн батална.

9 дүгээр зүйл. СУДАЛГАА БОЛОВСРУУЛАЛТ, ОЛОН НИЙТИЙН МЭДЭЭЛЭЛ БА МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОО

1. Талууд өөр өөрийн үндэсний хууль тогтоомж, дурэм, практикт нийцүүлэн дараах шинжилгэ судалгаа, боловсруулалт,

мэдээлэл солилцоог хөгжүүлэх зорилгоор өөр хоорондоо шууд юмуу олон улсын эрх бүхий байгууллагаар дамжуулан ялангуяа хөгжиж байгаа улс орны шаардлага хэрэгцээг тооцон дараах чиглэлээр хамтран ажиллана. Үүнд:

а. зохицуулагдах бодисыг аюулгүй хадгалах, дахин боловсруулах, үйлдвэрлэлийн эргэлтэнд оруулах, устгах явдлыг сайжруулах илүү төгс сайн технологи болон бусад аргаар тэдгээрийн ялгаралтыг бууруулах талаар;

в. зохицуулагдах бодис тэдгээрийг агуулсан бүтээгдэхүүнийг орлуулах боломжтой бодис, тэдгээрийн үндсэн дээр үйлдвэрлэдэг бүтээгдэхүүний талаар; ба

с. зохицуулалтын холбогдох стратегийг хэрэглэхтэй холбогдон гарах зардал, үр ашгийн талаар эдгээр болно

2. Талууд бие даагаад юмуу хамтаараа эсвэл олон улсын эрх бүхий байгууллагаар дамжуулан озоны үе давхаргыг задалдаг зохицуулагдах бодис, энд ороогүй бусад бодисын ялгаралтаас болж гарах экологийн үр дагаврын талаар олон нийтийг гүнзгий ойлголттой болгох явдлыг хангахад хамтран ажиллана.

3. Тал тус бүр энэхүү Протокол хүчин төгөлдөр болсноос хойш 2 жилийн дотор, цаашид мөн 2 жил тутамд энэ зүйлийн дагуу өөрийн авч явуулж байгаа арга хэмжээний тухай товч тайлангаа Нарийн бичгийн дарга нарын газарт танилцуулж байна.

10 дугаар зүйл. ТЕХНИКИЙН ТУСЛАМЖ

1. Талууд хөгжиж байгаа улс орнуудын хэрэгцээг онцгойлон тооцож, Конвенцийн 4 дүгээр зүйлийн томъёололд нийцүүлэн энэхүү Протоколд оролцох явдлыг хөнгөвчлөх, түүнийг хэрэгжүүлэхэд чиглэсэн техникийн туслалцааг өргөжүүлэх чиглэлээр хамтран ажиллана.

2. Аль ч Тал түүний дотор энэ Протоколд гарын үсэг зурсан Тал түүнийг хэрэгжүүлэх юмуу түүнд оролцох явдлаа хангах зорилгоор техникийн тусламж авах тухай хүсэлтээ Нарийн бичгийн дарга нарын газарт илгээж байна.

3. Талууд өөрийн анхдугаар зөвлөлгөөнөөр 9 дүгээр зүйл болоод энэ зүйлийн 1, 2 дугаар заалтанд тодорхойлсон үүргээ биелүүлэх арга зам түүний дотор ажлын төлөвлөгөө бэлтгэхтэй холбогдуулан хэлэлцээр хийж эхэлнэ. Тэр ажлын төлөвлөгөөнд хөгжиж байгаа орнуудын хэрэгцээ шаардлага, нөхцөл байдлыг онцгойлон анхаарах ёстой. Мөн

ажлын төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнд Протоколын Тал болоогуй улс орон, эдийн засгийн хамтын ажиллагааны бүс нутгийн байгууллагын оролцоог хөхүүлэн дэмжихээр бодно.

10 дугаар зүйл. САНХҮҮГИЙН МЕХАНИЗМ

1. Монреалын Протоколын Талууд 2А-2Е дүгээр зүйлд заасан зохицуулах арга хэмжээг тэднээр мөрдүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх Протоколын 5 дугаар зүйлийн 1-бис заалтын дагуу шийдвэр гаргахтай уялдан 2F-2Н дугаар зүйлийн дагуу зохицуулах аливаа арга хэмжээ авч явуулахад нь энэ Протоколын 5 дугаар зүйлийн 1 дэх заалтанд хамрагдах Талуудад технологи дамжуулах явдлыг оролцуулаад санхүүгийн болон техникийн хамтын ажиллагааг хангах механизмыг зохион байгуулна. Энэ заалтын хүрээнд хамрагдах талуудад зориулагдсан санхүүгийн бусад эх үүсвэрт нэмэн ноогдуулж байгаа татварын механизм нь Протоколд заасан зохицуулах арга хэмжээний хэрэгжилтийг хангахад эдгээр Талуудын харилцан зохицсон бүх нэмэлт зардлыг нөхнө. Нэмэлт зардлын үлгэрчилсэн жагсаалтын Талуудын зөвлөлгөөнөөр тодорхойлно.

2. 4 дэх заалтын дагуу буй болгосон механизмуудад олон талын фонд орно. Түүнчлэн энэ нь олон талын, бүс нутгийн болоод хоёр талын хамтын ажиллагааны бусад хэлбэрийг хамарч болно.

3. Олон талын фонд:

а. хусэлтийн үндсэн дээр зохих тэтгэмж буюу хөнгөлөлт үзүүлэх, Талуудын тогтоосон критерийн дагуу зохицуулсан нэмэлт зардлыг нөхнө;

в. дараах зорилгоор зуучлах механизмын ажлыг санхүүжүүлнэ:

i) 5 дугаар зүйлийн 1 дэх заалтанд хамрагдах орнуудад тэдгээр орны хэмжээнд судалгаа хийх ажиллагаа явуулах хэрэгцээ шаардлагыг тогтоох, бусад техникийн хамтын ажиллагаа явуулахад нь тусламж үзүүлэх;

ii) энэ илрүүлж олсон шаардлага хэрэгцээг хангах зорилгоор техникийн хамтын ажиллагаа явуулахад дэмжлэг үзүүлэх;

iii) хөгжиж байгаа орны Талуудад 9 дүгээр зүйлд зааснаар мэдээлэл, бусад холбогдох материал тараах, семинар, сургалт явуулах, тэрчлэн бусад арга хэмжээ авч явуулах зэргээр тусламж үзүүлэх;

iv) хөгжиж байгаа орны Талуудад бусад олон талын, бүс нутгийн, хоёр талын хамтын ажиллагааг явуулахад нь дэмжлэг

үзүүлэх хяналт тавих зэрэг болно.

с. олон талын фондыг үйлчлэх Нарийн бичгийн дарга нарын газрын зардал ба бусад холбогдох нэмэлт зардлуудыг санхүүжүүлэх

4. Олон талын фонд нь түүний бодлогын үндсэн чиглэлийг тодорхойлж өгдөг Талуудын шууд удирдлага дор ажиллана.

5. Талууд тодорхой шуурхай бодлого хийгээд, олон талын фондын өмнө тавигдсан зорилтыг хэрэгжүүлэхэд нөөц хэрэгсэл гаргах явдлыг оролцуулаад удирдлагын ба удирдан зохицуулах арга хэмжээний зарчмыг боловсруулах, хэрэгжүүлэх үүрэг бүхий Гүйцэтгэх хороог зохион байгуулна. Гүйцэтгэх хороо нь Талуудын харилцан зохицсон үйл ажиллагааны хүрээнд өөрийн үүрэг зорилтыг биелүүлэхдээ Олон улсын хөгжил шинэчлэлийн банк (Дэлхийн банк), НҮБ-ын байгаль орчны хөтөлбөр, НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр болон холбогдох бусад байгууллагатай тэдний үйл ажиллагааны хүрээнд нийцүүлж хамтран ажиллана. Гүйцэтгэх хорооны гишүүдийг 5 дугаар зүйлийн 1 дэх заалтанд хамрагдах эсэх бүх Талын зохих тэнцвэр хангасан тооны төлөөлөгчдөөс сонгож, Талуудаар батлуулна.

6. Олон талын фонд нь 5 дугаар зүйлийн 1 дэх заалтанд үл хамрагдах Талуудын НҮБ-д өгдөг татварын хуваарийн үндсэн дээр хөрвөх валютаар, тодорхой нөхцөлд зохих үйлдчилгээ ба/ буюу үндэсний валютаар өгсөн татвараар санхүүжинэ. Бусад Талуудаас өгөх татварыг урамшуулна. Хоёр талын онцгой тохиолдолд Талуудын шийдвэрийн үндсэн дээр зохицуулсан бүс нутгийн хамтын ажиллагааны хүрээнд Талуудаар тодорхойлогдсон дурын критерийн дагуу тодорхой хэмжээний хувийг Олон талын фондын татвар гэж тооцож болох бөгөөд энэ үед тийм хамтын ажиллагаа нь доор хаяж :

а. энэ Протоколыг дагаж мөрдөхтэй нягт уялдсан байх; в. нэмэлт нөөц орох явдлыг хангах; ба

с. зохицуулсан нэмэлт зардлыг нөхөх нөхцлийг хангаж байх ёстой.

7. Олон талын фондын санхүүгийн үе бүрдэх хөтөлбөрийн төсвийг Талууд багалж байх ба мөн Тал тус бүрийн татварын хэмжээг хувиар тогтооно.

8. Олон талын фондын хүрээний хөрөнгө хүчийг Талтай нь зохицон гаргах ба тэтгэмжийн шинжтэй байна.

9. Энэ зүйлтэй холбогдох Талуудын шийдвэрийг аль болох нэгдсэн саналд хүрэх зарчмаар гаргана. Хэрэв бүхий л хүчин

чармайлт тавьсан авч нийтлэг зөвшилд хүрч чадаагүй бол 5 дугаар зүйлийн 1 дэх заалтанд хамрагдах Талуудын дийлэнхийг төлөөлж санал хураалтанд оролцсон, байлцсан Талууд болоод энэ заалтанд үл хамаарагдах Талуудын дийлэнхийг төлөөлж санал хураалтанд оролцсон, байлцсан Талуудын гуравны хоёрын олонхийн саналаар шийдвэр гаргана.

10. Энэхүү зүйлээр тодорхойлогдож байгаа санхүүгийн механизм нь экологийн бусад асуудлыг шийдвэрлэх зорилгоор боловсруулсан аль нэг гэрээ хэлэлцээрүүдийг хохироохгүй,

10А дугаар зүйл. ТЕХНОЛОГИ ДАМЖУУЛАЛТ

Тал тус бур санхүүгийн механизмаар дэмжигдэж байгаа хөтөлбөрүүдтэй зохицсон бүх боломжтой арга хэмжээ авах ба энэ нь:

а. тухайн үед бэлэн байгаа экологийн хувьд аюулгүй оруулах бодис, түүнтэй холбогдох аль сайн технологийг 5 дугаар зүйлийн 1 дэх заалтанд хамрагдах Талуудад яаралтай дамжуулах; ба

в. а) хэсэгт тэмдэглэсэн технологи дамжуулалтыг шударга, хамгийн таатай нөхцлөөр хэрэгжүүлэх явдлыг хангахад чиглэнэ.

11 дүгээр зүйл. ТАЛУУДЫН ЗӨВЛӨЛГӨӨН

1. Талуудын байнгын тодорхой хугацаанд зөвлөлгөөн зохион байгуулна. Энэхүү Протокол хүчин төгөлдөр болсноос хойш нэг жилээс илүүгүй хугацаанд багтаан Талуудын анхдугаар зөвлөлгөөнийг Нарийн бичгийн дарга нарын газраас зарлан хуралдуулах ба хэрэв Конвенцийн Талуудын зөвлөлгөөнийг энэ үед хийхээр тогтоосон бол хамтруулан хуралдуулна.

2. Хэрэв Талууд өөр шийдвэр гаргаагүй бол Талуудын дараагийн ээлжит зөвлөлгөөнийг Конвенцийн Талуудын зөвлөлгөөнтэй хамтруулан хийнэ. Талуудын ээлжит бус зөвлөлгөөнийг Талуудын зөвлөлгөөний шийдвэрээр тогтоосон аль ч үед хийж болох ба эсвэл ямар нэг Талаас бичгээр хүсэлт гаргаад тэр хүсэлтийг нь Нарийн бичгийн дарга нарын газраас Талуудын илгээсэн өдрөөс хойш 6 сарын дотор Талуудын гуравны нэгээс илүү нь дэмжсэн бол зарлан хуралдуулж болно.

3. Талуудын андугаар зөвлөлгөөн

4. өөрийн зөвлөлгөөний дэгийн дурмийг санал нэгдмэл байх зарчмаар батлах;

в. 13 дугаар зүйлийн хоёр дахь заалтанд өгүүлсэн санхүүгийн

дүрмийг санал нэгдмэл байх зарчмаар батлах;

с. 6 дугаар зүйлийн дагуу бүлэг зохион байгуулж эрхлэх ажлын хүрээг нь тогтоож өгөх;

d. 8 дугаар зүйлд өгүүлсэн дэг, зохион байгуулалтын механизмыг хэлэлцэн батлах;

e. 10* дугаар зүйлийн 3 дахь заалтын дагуу ажлын төлөвлөгөө бэлтгэж эхлэх зэрэг болно;

4. Талуудын зөвлөлгөөн дараах үүрэгтэй:

a. энэхүү Протоколын биелэлтийн тойм;

в. 2 дугаар зүйлийн 9 дэх заалтанд өгүүлснээр ямар нэг засвар буюу хорогдуулах арга хэмжээ авах шийдвэр гаргах ;

с. хавсралтанд орсон бодисуудын тоог өргөтгөх юмуу хорогдуулах, нэмэлт оруулах, түүнчлэн 2 дугаар зүйлийн 10 дахь заалтын дагуу зохицуулах арга хэмжээнд холбогдох шийдвэр гаргах;

d. 7 дугаар зүйл ба 9 дүгээр зүйлийн 3 дахь заалтанд холбогдуулан шаардагдвал удирдлагын баримт бичиг юмуу мэдээлэл өгөх дэгийг батлах;

e. 10 дугаар зүйлийн 2 дахь заалтын дагуу оруулж ирж байгаа техникийн туслалцаатай холбогдох хүсэлтийг хэлэлцэх;

f. 12 дугаар зүйлийн с/ хэсэгт нийцүүлэн Нарийн бичгийн дарга нарын газраас бэлтгэсэн илтгэлийг хэлэлцэх;

g. [2 дугаар зүйлд зааснаар]* шилжих бодисын томъёолол ба зохицуулах арга хэмжээг 6 дугаар зүйлийн дагуу авч хэлэлцэх;

h. энэхүү Протоколд буюу одоо байгаа хавсралт, шинээр нэмэх гэж байгаа хавсралтанд засвар оруулах тухай саналыг тогтсон журмаар хэлэлцэн батлах;

e. энэхүү Протоколыг хэрэгжүүлэхтэй холбогдсон төсвийг хэлэлцэх батлах; ба

j. энэхүү Протоколоор тавьсан зорилтонд хүрэхэд шаардагдаж болох ямар нэг нэмэлт арга хэмжээг хэлэлцэн батлах;

5. Нэгдсэн Үндэсний Байгууллага, түүний төрөлжсөн байгууллагууд, олон улсын атомын эрчим хүчний агентлаг түүнчлэн энэ Протоколын Тал болоогүй аль нэг улс Талуудын зөвлөлгөөнд ажиглагчаар орж болно. Озонь: үе давхаргыг хамгаалахтай холбогдсон салбарт зохих хамааралтай үндэсний болон олон улсын, Засгийн газрын болон Засгийн газрын бус ямар ч байгууллага Талуудын зөвлөлгөөнд ажиглагчаар оролцох өөрийн хүсэлтээ Нарийн бичгийн дарга нарын газарт мэдэгдсэн, тэр саналыг нь зөвлөлгөөнд оролцогч Талуудын гуравны

хоёроос илүү нь зөвшөөрсөн бол зөвлөлгөөнд ажиглагчаар оролцуулж болно. Ажиглагчийг оролцуулах, байлгах тухай асуудлыг Талуудын баталсан дэгийн дүрмээр шийдвэрлэнэ.

12 дугаар зүйл. НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
НАРЫН ГАЗАР

Нарийн бичгийн дарга нарын газар нь энэхүү Протоколд нийцүүлэн:

- a. 11 дүгээр зүйлийн дагуу Талуудын зөвлөлгөөнийг зохион байгуулж, үйлчлэх;
- в. 7 дугаар зүйлийн дагуу ирүүлсэн өгөгдлүүдийг Талуудын хүсэлтээр хүлээн авах, тараах;
- с. 7 ба 9 дүгээр зүйлийн дагуу авсан мэдээлэл дээрээ түшиглэн байнгын илтгэл бэлтгэж Талуудад илгээх;
- d. 10 дугаар зүйлийн дагуу авсан техникийн туслалцааны тухай ямар нэг хүсэлтийг, мөн тийм хүсэлтийг танилцуулахад нь дэмжлэг үзүүлэх зорилгоор Талуудад мэдээлж авах;
- f. c/ ба d/ хэсэгт өгүүлсэн мэдээлэл ба хүсэлтийг Тал болоогүй улс орон, байгууллагын ажиллагчид зохих ёсоор илгээх;
- г. Талуудаас түүнд үүрэг болгон өгч болох Протоколын зорилтонд нийцсэн аливаа бусад үүргийг биелүүлэх;

13 дугаар зүйл. САНХҮҮГИЙН БАЙДАЛ

1. Энэхүү Протоколыг хэрэгжүүлэхэд шаардагдах түүний дотор Нарийн бичгийн дарга нарын газрын энэхүү Протоколтой холбогдсон үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгө зөвхөн Талуудын татвараас бүрдэнэ.

2. Талууд өөрийн анхдугаар зөвлөлгөөнөөр энэхүү Протоколыг хэрэгжүүлэх санхүүгийн дүрмийг санал нэгдмэл байх зарчмаар батална.

14 дүгээр зүйл. ЭНЭХҮҮ ПРОТОКОЛ БА
КОНВЕНЦИЙН ХОЛБОО

Энэхүү Протоколд өөрөөр томъёолоогүй бол Протоколд хамаарах Конвенцийн томъёоллыг энэхүү Протоколд хэрэглэнэ.

15 дугаар зүйл. ГАРЫН ҮСЭГ ЗУРАХ НЬ

Энэхүү Протоколд улс орнууд хийгээд эдийн засгийн хамтын

ажиллагааны бүс нутгийн байгууллагууд 1987 оны IX сарын 16-нд Монреал хотноо, 1987 оны IX сарын 17-ноос 1988 оны 1 сарын 16-ныг дуустал Оттава хотноо, 1998 оны 1 сарын 17-ноос 1988 оны IX сарын 15-ныг дуустал Нью-Йорк хотноо Нэгдсэн Үндэстний Байгууллагын төв байранд гарын үсэг зурахад нээлттэй.

16 дугаар зүйл. ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ НЬ

1. Энэхүү Протоколд нь зохицуулагдах бодисын 1986 оны дэлхийн дахины тоймчилсон хэрэглээний гуравны хоёроос багагүй хэсэг нь оногддог улс орнууд хийгээд эдийн засгийн хамтын ажиллагааны бүс нутгийн байгууллагууд өөрийн батламжилсан, хүлээн зөвшөөрсөн, сайшаан дэмжсэн, нэгдэн орсон тухай 11-ээс цөөнгүй баримт бичгээ хадгалуулахаар өгсөн болон Конвенцийн 17 дугаар зүйлийн 1 дэх заалтын томъёолол биелсэн зэрэг нөхцөлд 1989 оны 1 сарын 1-нээс хүчин төгөлдөр болно. Хэрэв энэ хугацаанд заасан нөхцөл биелээгүй бол эдгээр нөхцөл биелснээс хойш 90 дэх хоногоос эхлэн энэ Протокол хүчин төгөлдөр болно.

2. 1 дэх заалтанд эдийн засгийн хамтын ажиллагааны бүс нутгийн ямар нэг байгууллагаас хадгалалтанд өгсөн аль нэг баримт бичиг нь энэ байгууллагын гишүүн-улсаас хадгалалтанд өгсөн баримт бичгийн гадна нэмэлт гэж тооцогдохгүй.

3. Энэ Протокол хүчин төгөлдөр болсноос хойш ямар нэг улсад хийгээд эдийн засгийн хамтын ажиллагааны бүс нутгийн байгууллагаас өөрийн батламжилсан, хүлээн зөвшөөрсөн, сайшаан дэмжсэн буюу нэгдэн орсон тухай баримт бичгээ хадгалуулахаар өгсөн өдрөөс хойш ер дэх хоног дээрээ тэрээр энэхүү Протоколын Тал болно.

17 Дугаар зүйл. ПРОТОКОЛ ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛСНООС ХОЙШ ТҮҮНД НЭГДЭН ОРСОН ТАЛУУД

5 дугаар зүйлийн томъёоллын дагуу аль ч улс орон эсвэл эдийн засгийн хамтын ажиллагааны бүс нутгийн байгууллага энэхүү Протокол хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш энэхүү Протоколын Тал болсож бол Протокол хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн Талууд болсон улс орнууд хийгээд эдийн засгийн хамтын ажиллагааны бүс нутгийн байгууллагын

хувьд энэ өдрөөс эхлэн үйлчилж эхлэх ёстой. 2 дугаар зүйл, мөн тэрчлэн 2А-2Е дүгээр зүйлс {2А-2Н дүгээр зүйл} 4 дүгээр зүйлээс урган гарах бүхий л үүргийг нэн даруй мөрдөж эхлэнэ.

18 дугаар зүйл. НЭМЭЛТ ТАЙЛБАР ХИЙЖ БОЛОХ ЭСЭХ
НЬ

Энэхүү Протокол ямар нэг нэмэлт тайлбар тавихыг зөвшөөрөхгүй.

19 дүгээр зүйл. ГАРАХ НЬ

Гарч болох тухай Конвенцийн 19 дүгээр зүйлийн томъёоллыг энэ Протоколыг хэрэгжүүлэх үүднээс 5 дугаар зүйлийн 1 дэх заалтанд зааснаас бусад Талуудад хэрэглэнэ. Дурдсан ямар нэг Тал 2 дугаар зүйлийн 1-4 дэх заалтаар авсан үүргүүдийг хүлээн зөвшөөрснөөсөө хойш 4 жил өнгөрсний дараа аль ч үед эх бичвэр Хадгаламжлагчид бичгээр мэдэгдээд энэхүү Протоколоос гарч болно, Гарах явдал эх бичвэр Хадгаламжлагч гарах тухай мэдэгдлийг нь хүлээн авсан өдрөөс хойш нэг жил өнгөрөөд юм уу гарах тухайгаа заасан дараагийн аль нэг хугацаанд хүчин төгөлдөр болно.

19 дүгээр зүйл. ГАРАХ НЬ

Ямар нэг Тал 2А дугаар зүйлийн 1 дэх заалтын үүргүүдийг хүлээн зөвшөөрснөөсөө хойш 4 жил өнгөрсний дараа аль ч үед эх бичвэр Хадгаламжлагчид бичгээр мэдэгдээд энэхүү Протоколоос гарч болно. Гарах явдал нь гарах тухай мэдэгдлийн нь эх бичвэр Хадгаламжлагч хүлээн авснаас хойш нэг жил өнгөрсний дараа юмуу гарах тухайгаа заасан дараагийн аль нэг хугацаанд хүчин төгөлдөр болно.

20 дугаар зүйл. АДИЛ ХҮЧИНТЭЙ ЭХ БИЧВЭРҮҮД

Энэхүү Протоколын англи, араб, испани, хятад, орос, франц хэл дээрх эх бичвэрүүд адил хүчинтэй бөгөөд Нэгдсэн Үндэстний Байгууллагын ерөнхий нарийн бичгийн даргад хадгалуулахаар өгнө.

ДЭЭРХ ДУРДСАНЫГ НОТОЛЖ ЗОХИХ БҮРЭН ЭРХ

БҮХИЙ ТӨЛӨӨЛӨГЧИД ЭНЭХҮҮ ПРОТОКОЛД ДОР ГАРЫН ҮСЭГ ЗУРАВ.

Хавсралт А Хяналтанд байх бодис

Групп	Бодис	Озон задлах чадвар
Групп I		
$CFCl_3$	CFC-11	1.0
CF_2Cl_2	CFC-12	1.0
$C_2F_3Cl_3$	CFC-113	0.8
$C_2F_4Cl_2$	CFC-114	1.0
C_2F_5Cl	CFC-115	0.6
Групп II		
CF_2BrCl	(halon-1211)	3.0
CF_3Br	(halon-1301)	10.0
$C_2F_4Br_2$	(halon-2402)	6.0

*Озоныг задлах чадварын эл утгууд өнөөгийн шинжлэх ухааны мэдээлэлд үндэслэсэн бөгөөд цаашид байнгын тойм, хяналтаар нарийвчлагдах болно.

Хавсралт В Хяналтанд байх бодис

Групп	Бодис	Озон задлах чадвар
Групп I		
CF_3Cl	CFC-13	1.0
C_2FCl_3	CFC-111	1.0
$C_2F_2Cl_4$	CFC-112	1.0
C_3FCl_7	CFC-211	1.0
$C_3F_2Cl_6$	CFC-212	1.0
$C_3F_3Cl_5$	CFC-213	1.0
$C_3F_4Cl_4$	CFC-214	1.0
$C_3F_5Cl_3$	CFC-215	1.0
$C_3F_6Cl_2$	CFC-216	1.0
C_3F_7Cl	CFC-217	1.0
Групп II		
CCl_4	Дөрвөн хлорт метан	1.1
Групп III		
$C_2H_3Cl_3$	Гурван хлорт этан (метил хлороцорм)	0.1

- Энэ томъёо 1,1, 2- гурван хлорт этанд хамаарахгүй.

Хавсралт С Зохицуулагдах бодис

Бүлэг	Бодис	Изомерийн тоо	Озоныг задлах чадвар
I БҮЛЭГ			
CHFCl_2	(ГХФН-21) **	1	0.4
CHF_2Cl_2	(ГХФН-22) **	1	0.055
CH_2FCI	(ГХФН-31)	1	0.02
C_2HFCl_4	(ГХФН-121)	2	0.01-0.04
$\text{C}_2\text{HF}_2\text{Cl}_3$	(ГХФН-122)	3	0.02-0.08
$\text{C}_2\text{HF}_3\text{Cl}_2$	(ГХФН-123)	3	0.02-0.06
CHCl_2CF_3	(ГХФН-123) **	-	0.02
$\text{C}_2\text{HF}_4\text{Cl}$	(ГХФН-124)	2	0.02-0.04
CHFClCF_3	(ГХФН-124) **	-	0.022
$\text{C}_2\text{H}_2\text{FCI}_3$	(ГХФН-131)	3	0.007-0.05
$\text{C}_2\text{H}_2\text{F}_2\text{Cl}_2$	(ГХФН-132)	4	0.008-0.05
$\text{C}_2\text{H}_2\text{F}_3\text{Cl}$	(ГХФН-133)	3	0.02-0.06
$\text{C}_2\text{H}_3\text{FCI}_2$	(ГХФН-141)	3	0.005-0.07
CH_3CFCl_2	(ГХФН-141B) **		0.11
$\text{C}_2\text{H}_3\text{F}_2\text{Cl}$	(ГХФН-142)	3	0.008-0.07
$\text{CH}_3\text{CF}_2\text{Cl}$	(ГХФН-142B)	-	0.065
$\text{C}_2\text{H}_4\text{FCI}$	(ГХФН-151)	2	0.003-0.005
C_4HFCl_6	(ГХФН-221)	5	0.015-0.07
$\text{C}_4\text{HF}_2\text{Cl}_5$	(ГХФН-222)	9	0.01-0.09
$\text{C}_4\text{HF}_3\text{Cl}_4$	(ГХФН-223)	12	0.01-0.08
$\text{C}_4\text{HF}_4\text{Cl}_3$	(ГХФН-224)	12	0.01-0.09
$\text{C}_4\text{HF}_5\text{Cl}_2$	(ГХФН-225)	9	0.02-0.07
$\text{CF}_3\text{CF}_2\text{CHCl}_2$	(ГХФН-225ca)**	-	0.025
$\text{CF}_2\text{ClCF}_2\text{CHClCF}$ (ГХФН-225cc1)**	0.33		
$\text{C}_4\text{HF}_6\text{Cl}$	(ГХФН-226)	5	0.02-0.10
$\text{C}_4\text{H}_2\text{FCI}_5$	(ГХФН-231)	9	0.05-0.09
$\text{C}_4\text{H}_2\text{F}_2\text{Cl}_4$	(ГХФН-232)	16	0.008-0.10
$\text{C}_4\text{H}_2\text{F}_3\text{Cl}_3$	(ГХФН-233)	18	0.007-0.23
$\text{C}_4\text{H}_2\text{F}_4\text{Cl}_2$	(ГХФН-234)	16	0.01-0.28
$\text{C}_4\text{H}_2\text{F}_5\text{Cl}$	(ГХФН-235)	9	0.03-0.52
$\text{C}_4\text{H}_3\text{FCI}_4$	(ГХФН-241)	12	0.004-0.09
$\text{C}_4\text{H}_3\text{F}_2\text{Cl}_3$	(ГХФН-242)	18	0.005-0.13
$\text{C}_4\text{H}_3\text{F}_3\text{Cl}_2$	(ГХФН-243)	18	0.007-0.12
$\text{C}_4\text{H}_3\text{F}_4\text{Cl}$	(ГХФН-244)	12	0.009-0.14
$\text{C}_4\text{H}_4\text{FCI}_3$	(ГХФН-251)	12	0.001-0.01

$C_3H_4F_2Cl_2$	(ГХФН-252)	16	0.005-0.04
$C_3H_4F_3Cl$	(ГХФН-253)	12	0.003-0.03
$C_3H_5F_2Cl$	(ГХФН-261)	9	0.002-0.02
$C_3H_5F_2Cl$	(ГХФН-262)	9	0.002-0.02
C_3H_6Cl	(ГХФН-271)	5	0.001-0.03
II БҮЛЭГ			
$CHFBr_2$		1	1.00
CHF_2Br	(ГХФН-22M1)	1	0.74
CH_2FBr		1	0.73
C_2HFBr_4		2	0.3-0.8
$C_2HF_2Br_3$		3	0.5-1.8
$C_2HF_3Br_2$		3	0.4-1.6
C_2HF_4Br		2	0.7-1.2
$C_2H_2FBr_3$		3	0.1-1.1
$C_2H_2F_2Br_2$		4	0.2-1.5
$C_2H_2F_3Br$		3	0.7-1.6
$C_2H_3FBr_2$		3	0.1-1.7
$C_2H_3F_2Br$		3	0.2-1.1
C_2H_4FBr		2	0.07-0.1
C_3HFBr_6		5	0.3-1.5
$C_3HF_2Br_5$		9	0.2-1.9
$C_3HF_3Br_4$		12	0.3-1.8
$C_3HF_4Br_3$		12	0.5-2.2
C_3HF_6Br		9	0.9-2.0
$C_3HF_6Br_2$		5	0.7-3.3
$C_3H_2FBr_5$		9	0.1-1.9
$C_3H_2F_2Br_4$		16	0.2-2.1
$C_3H_2F_3Br_3$		18	0.2-5.6
$C_3H_2F_4Br_2$		16	0.3-7.5
$C_3H_2F_5Br$		8	0.9-1.4
$C_3H_3FBr_4$		12	0.08-1.3
$C_3H_3F_2Br_3$		18	0.1-3.1
$C_3H_3F_3Br_2$		18	0.1-2.5
$C_3H_3F_4Br$		12	0.3-4.4
$C_3H_4FBr_3$		12	0.03-0.3
$C_3H_4F_2Br_2$		16	0.1-1.0
$C_3H_4F_3Br$		12	0.07-0.8
$C_3H_5FBr_2$		9	0.04-0.4
$C_3H_5F_2Br$		9	0.07-0.8
C_3H_6FBr		5	0.02-0.7

* Протоколыг хэрэгжүүлэх үүднээс үзүүлэлтийн цараатай үед энэ царааны хамгийн их үзүүлэлтийг оруулав. Хүснэгтэнд нэг үзүүлэлт тавьсан нь лабораторийн хэмжилтийн үндсэн дээр тооцоогоор гарсан ОЗЧ юм. Харин үзүүлэлтийн царааг үнэлгээний үндсэн дээр их хэлбэлзэлтэй байж болохыг илэрхийлэв. Үзүүлэлтийн цараа нь изомерийн бүлэгт хамаарна. Энэ үед хамгийн өндөр үзүүлэлт нь ОЗЧ хамгийн их изомерийн ОЗЧ-ын тооцооны утга, хамгийн бага нь ОЗЧ хамгийн бага изомерийн тооцооны үзүүлэлт юм.

**Энэ Протоколд ОЗЧ-ын үзүүлэлтээр хамгийн өрсөлдөх чадвартай бодисыг авав.

Хавсралт D*

ХАВСРАЛТАНД ЗААСАН ЗОХИЦУУЛАГДАХ БОДИС АГУУЛЖ

БУЙ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ НЭРСИЙН ЖАГСААЛТ

(4 дүгээр зүйлийн 3 дахь зүйлийн дагуу бэлтгэв)

Бүтээгдэхүүн	ГААЛИЙН КОДЫН ТОМЬЁОГ
1. Ачааны болон хөнгөн тэрэгний агааржуулагч (автомашин дээр тавьсан эсэхээс хамаарахгүй)	
2. Ахуйн болоод худалдааны хөргөгч төхөөрөмж ба агааржуулагч (дулааны шахуурга*** Жишээ нь: хөргөгч хөлдөөх шүүгээ усан хөргөлтийн төхөөрөмж мөс үүсгүүр агааржуулагч, дулаан шахуурга)	
3. Эмнэлгийн тоосруулагчаас бусад тоосруулагч бүтээгдэхүүн	
4. Зөөврийн гал унтраагуур	
5. Тусгаарлах самбар, хавтанцар, хоолойн тусгаарлагч	

6. Форполимерүүд

*Энэхүү хавсралтыг Протоколын 4 дүгээр зүйлийн 3 дахь заалтын дагуу 1991 оны VI сарын 21-нд Найроби хотноо Талуудын III зөвлөлгөөнөөр зөвшөөрөв.

** Хувийн хогшил, гэр ахуйн эд зүйлтэй чингэлэг брлон бусад төсөөтэй худалдааны бус нөхцөлд гаалийн албанд өртөгдөхгүй тохиолдлыг оруулахгүй.

*** Хөргүүр ба/буюу бүтээгдэхүүний тусгаарлах материалд ордог,

хавсралт А-д дурдсан зохицуулагдах бодисыг агуулж байгаа нөхцөлд авна.

Хавсралт Е
Зохицуулах бодис

Бүлэг	Бодис	Озон задлах бодис
БҮЛЭГ		
CH ₃ Br	Бромт метил	0,7

III. ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

“УДААН ЗАДАРДАГ ОРГАНИК БОХИРДУУЛАГЧИЙН ТУХАЙ” ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

(Засгийн газрын 2006 оны 99 дүгээр тогтоолоор батлагдсан)

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Монгол Улс химийн бодисын аюулгүй байдлын олон улсын гэрээ хэлэлцээрүүдэд нэгдэн орж, тэдгээрийн шийдвэр, заалтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаануудыг авч хэрэгжүүлж байгаагийн нэг илрэл нь Удаан задардаг органик бохирдуулагчийн тухай Стокгольмын конвенцид 2004 онд нэгдэн орсон явдал юм.

Байгалийн гаралтай эсвэл хүний үйл ажиллагаагаар үүссэн, онцгой хортой шинж чанар бүхий байгаль дээр задралгүйгээр удаанаар хадгалагддаг онцлогтой органик бодисуудыг удаан задардаг органик бохирдуулагч (УЗОБ) гэж нэрлэдэг. Эдгээр бодис нь агаар, усаар дамжин үүссэн газраасаа хол тархаж, хөрс, усыг бохирдуулан улмаар ургамал, амьтдыг хордуулах ба уг ургамал, амьтдаар хооллосон хүн, амьтан хордох замаар байгаль дээр бохирдлын битүү хэлхээг үүсгэнэ.

Эдгээр бодис хүний биед орж биохуримтлал үүсгэх ба дотоод шүүрэл, дархлаа, дээд мэдрэл, үржлийн системд нөлөөлөн хорт хавдар, чихрийн шижин, үргүйдэл, дархлаа хомсдол, дотоод шүүрлийн системийн хямрал, арьсны өвчлөл, мэдрэлийн согог зэрэг өвчнүүдийг үүсгэнэ. Үүгээр ч зогсохгүй эхийн хэвлий дэх урагт нөлөөлж, эхийн сүүгээр дамжин үр удмыг хордуулдаг. Сүүлийн 50 жилд хөхний хорт хавдар 26%, чөмөгний хорт хавдар 3 дахин, тунгалагийн зангилгааны Хожкины бус хорт хавдар 3 дахин, хүүхдийн хорт хавдар 13%-иар өссөнийг эрдэмтэд УЗОБ-тай холбон тайлбарлаж байна.

УЗОБ-ийн тухай Стокгольмын конвенцийн хавсралтад доорхи 3 төрлийн бодисууд орно. Үүнд:

1. Хөдөө аж ахуйд хортон шавьж устгах зорилгоор хэрэглэдэг 9 төрлийн пестицид (альдрин, дильдрин, хлордан, гексахлорбензол, гептахлор, ДДТ (1.1.1-трихлор –2.2-бис (4-хлорфенил) этан), эндрин, мирекс, токсафен);
2. Цахилгаан тоног төхөөрөмжийн тос, будаг, лак, хуванцар болон

полимер гэх мэт материалуудад нэмэлт болгон хэрэглэдэг полихлорт бифенилүүд (ПХБ);

3. Төрөл бүрийн шаталтын процесс болон зарим үйлдвэрлэлийн үед завсрын бүтээгдэхүүн хэлбэрээр үүсдэг полихлорт дибензо-п-диоксинууд (диоксин) ба полихлорт дибензофуранууд (фуран).

УЗОБ-ийн хор нөлөөллөөс хүний эрүүл мэнд, байгаль орчныг хамгаалах зорилгоор конвенцид доорхи зорилтуудыг дэвшүүлсэн:

- УЗОБ пестицидүүдийн (ДДТ-ээс бусад) үйлдвэрлэл, хэрэглээг зогсоож, нөөц хаягдлыг устгах;
- ДДТ-ийн хэрэглээг хязгаарлан зөвхөн зөвшөөрөгдсөн зорилгоор хэрэглэх;
- Полихлорт бифенилийн хувьд хэрэглээг 2025 он гэхэд зогсоож, 2028 он гэхэд устгах
- Зориудын бус үйлдвэрлэлээс үүсэх диоксин ба фураны үүсэлтийг бууруулах, үүний тулд эх үүсвэрүүдэд тэргүүний технологи, байгаль орчинд ээлтэй арга ажиллагааг нэвтрүүлэх.

Монгол улс 1950-иад оны сүүлчээс мал аж ахуйд малын гадаад, дотоод шимэгч хорхой, өвчлөлтэй тэмцэх болон ургамал хамгаалал, ариутгал, устгалын чиглэлээр пестицидүүдийг хэрэглэж эхлэсэн ба УЗОБ пестицидүүдээс гексахлорбензол, хлордан, альдрин, дильдрин, гептахлорийг бага хэмжээгээр харин гексахлор циклогексан буюу линданыг их хэмжээгээр хэрэглэж байсан бөгөөд эдгээрийг нийтэд нь “дуст” гэж нэрлэж байжээ. Хэдийгээр эдгээр пестицидүүдийн нөөц, хаягдал Монгол Улсад байхгүй ч эдгээрээр бохирдсон газрууд нэлээд байгаа нь шинжилгээгээр тогтоогдсон юм.

Дэлхийн олон оронд 1990-ээд оны эхэн хүртэл ПХБ-ийг үйлдвэрлэн өргөнөөр хэрэглэж ирсэн бөгөөд Монгол Улсад 2005 оны байдлаар 5 500 тонн тос агуулсан 13 мянга гаруй тоног төхөөрөмж ашиглагдаж байгаагийн 90 гаруй хувь нь ОХУ-д 1990 оноос өмнө үйлдвэрлэгджээ. 2004-2005 онд явуулсан УЗОБ-ын урьдчилсан тооллогоор 500 гаруй тоног төхөөрөмжийг шинжилгээнд хамруулсны 10 гаруй хувь нь зөвшөөрөгдөх хэмжээнээс их полихлорт бифенил агуулж байлаа.

Диоксин, фуран нь хий байдлаар ялгарч, агаар орчныг бохирдуулахаас гадна үнс, торгог, фильтрийн тоос, лаг зэрэгт агуулагддаг. Монголд цахилгаан, дулааны станц, уурын зуух, гэрийн зуух, хог хаягдлын хяналтгүй шаталт, эмнэлгийн хог хаягдал шатаах зуух, ахуйн болон үйлдвэрийн бохир ус цэвэрлэх байгууламжийн лаг,

автомашин, бүх төрлийн түймэр, хаягдал төмөр боловсруулах үйлдвэр, тоосго, цемент, шохойн үйлдвэр, арьс шир, ноос ноолуур боловсруулах үйлдвэр зэрэг эх үүсвэрүүдээс диоксин, фуран үүсч байна.

Дээр дурьдсан нөхцөл байдлыг үндэслэн байгаль орчин болон ард иргэдийнхээ эрүүл мэндийг УЗОБ-ийн хор нөлөөллөөс хамгаалах, конвенцийн хүрээнд хүлээсэн үүргийн дагуу тэдгээрийн нөөц хаягдлыг байгаль орчинд халгүй арга, технологиор устгах, тэдгээрийн үүсэлтийг бууруулах, бохирдсон газрыг хоргүйжүүлэх, хяналт шинжилгээ, судалгаа явуулах чадавхийг бүрдүүлэхтэй холбогдсон үйл ажиллагааг үндэсний хөтөлбөрийн хэмжээнд авч хэрэгжүүлэх зайлшгүй шаардлага гарсан болно.

ХОЁР. ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО,

ЗОРИЛТУУД

ЗОРИЛГО

УЗОБ-ийн хор нөлөөллөөс байгаль орчин, хүний эрүүл мэндийг хамгаалах

ЗОРИЛТУУД

1. УЗОБ-ийн тухай Стокгольмын конвенцийг хэрэгжүүлэх механизм, эрхзүйн орчныг бүрдүүлэх
2. ПХБ агуулсан тоног төхөөрөмжийн хэрэглээг зогсоож, нөөц хаягдлыг 2020 он гэхэд устгаж дуусгах
3. Зориудын бус үйлдвэрлэлээс үүсэх диоксин ба фураны хэмжээг бууруулах
4. УЗОБ агуулсан пестицидүүдээр бохирдсон газруудыг олж тогтоон, хоргүйжүүлэх
5. УЗОБ-ийн талаархи ухуулга сургалт, сурталчилгаа, мэдээллийн үндэсний тогтолцоо бий болгох
6. УЗОБ-ийн хяналт-шинжилгээ ба судалгаа шинжилгээний чадавхийг бүрдүүлэх

ГУРАВ. ХӨТӨЛБӨРИЙН ҮНДСЭН ЗАРЧИМ, ЧИГЛЭЛ

1. УЗОБ-ийн тухай Стокгольмын конвенцийн үндсэн зарчим, чиглэлийг баримтлана

2. Монгол улсын хууль тогтоомж, төрөөс баримтлах бодлоготой уялдсан байна

ДӨРӨВ. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

УЗОБ-ийн тухай үндэсний хөтөлбөрийн зорилтыг хэрэгжүүлэх хугацааг 2 үе шаттай байхаар тодорхойлж байна.

I ҮЕ ШАТ /2007-2010 он/-нд хөтөлбөрийг хэрэгжүүлэх эрх зүйн орчныг сайжруулан, УЗОБ-ийн хэмжээ, эх үүсвэр, хаягдлын хэмжээ, бохирдсон газруудыг нарийвчлан тогтоож, түүнийг устгах, үүсэлтийг бууруулах, хоргуйжүүлэх үйл ажиллагааны бэлтгэлийг ханган, үндэсний чадавхийг бий болгоно.

II ҮЕ ШАТ /2011-2020 он/-нд УЗОБ-ийг агуулсан тоног төхөөрөмжийн хэрэглээг зогсоох, нөөц хаягдлыг устгах, бохирдсон газруудыг хоргуйжүүлэх, үүсэлтийг бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх

ТАВ. ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Нэгдүгээр зорилт. УЗОБ-ийн тухай Стокгольмын конвенцийг хэрэгжүүлэх механизм, эрхзүйн орчныг бүрдүүлэх

- 1.1 Монгол Улсад хэрэглэхийг хориглосон буюу хязгаарласан химийн бодисын жагсаалтанд нэмэлт өөрчлөлт оруулах
- 1.2 УЗОБ-ийн талаар мэдээлэл цуглуулах тухай журам боловсруулах
- 1.3 Мэдээллийн сан, сүлжээг хөгжүүлэх заавар, журам боловсруулах
- 1.4 “УЗОБ-ийн эх үүсвэрээс үүсэх хэмжээнд тавих шаардлага” стандартыг боловсруулах
- 1.5 УЗОБ бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээний стандартыг боловсруулах
- 1.6 Хөдөлмөрийн нөхцлийн ангиллын стандартад нэмэлт өөрчлөлт оруулах
- 1.7 УЗОБ агуулсан хаягдлыг цуглуулах, хадгалах, тээвэрлэх, устгах, хоргуйжүүлэх журам боловсруулах
- 1.8 Эмнэлгийн хог хаягдлыг устгах тухай эрх зүйн баримт бичгийг шинэчлэх
- 1.9 УЗОБ агуулсан үйлдвэрийн хог хаягдлыг булаах цэгт тавигдах шаардлага болон хяналт-шинжилгээ хийх аргачилсан заавар

боловсруулах

- 1.10 Тэргүүний технологи/байгаль орчинд ээлтэй арга ажиллагааг (ТТ/БОЭАА) хэрэгжүүлэхэд эдийн засгийн дэмжлэг, хөнгөлөлт үзүүлэх

Хоёрдугаар зорилт. ПХБ агуулсан тоног төхөөрөмжийн хэрэглээг зогсоож, нөөц хаягдлыг 2020 он гэхэд устгаж дуусгах

- 2.1 ПХБ агуулсан тоног төхөөрөмж, хаягдал, бохирдсон газрын тооллого явуулж, улсын нэгдсэн мэдээлийн санг бүрдүүлэн, тоног төхөөрөмжийг хаягжуулах
- 2.2 ПХБ-ийн талаар мэдээлэл цуглуулах, солилцох сүлжээг бий болгож, мэдээллийн санг шинэчилж байх
- 2.3 ПХБ агуулсан тоног төхөөрөмж, хаягдлыг цуглуулах, хадгалах, тээвэрлэх механизмыг бүрдүүлэх
- 2.4 ПХБ агуулсан тоног төхөөрөмжийн хэрэглээг доорхи хуваарийн дагуу зогсоож, бохирдсон тоног төхөөрөмжийг цэвэрлэх
- | | |
|---------|------|
| 2012 он | 20% |
| 2014 он | 40% |
| 2016 он | 60% |
| 2018 он | 80% |
| 2020 он | 100% |

2.5. ПХБ агуулсан хаягдлыг 2.4-д заасан хуваарийн дагуу устгах

Гуравдугаар зорилт. Зориудын бус үйлдвэрлэлээс үүсэх диоксин ба фураны хэмжээг бууруулах

- 3.1 Диоксин ба фуран үүсгэгч эх үүсвэрүүдийн зэрэглэлийг шинэчлэн тогтоож байх
- 3.2 Диоксин ба фураны гол эх үүсвэрүүд дээр хаягдлын коэффициентийг тогтоох, түүнийг техник, технологийн өөрчлөлт бүрийн дараа шинэчлэн тогтоож байх
- 3.3 Зориудын бус үйлдвэрлэлээс үүсэх УЗОБ-ийн мэдээллийн сан бий болгох
- 3.4 Диоксин ба фураны эх үүсвэрүүд дээр хэмжилт хийх
- 3.5 Диоксин ба фураны эх үүсвэрүүдээс байгаль орчинд үзүүлж буй нөлөөллийн үнэлгээ хийх
- 3.6 Диоксин ба фуран агуулсан хаягдал үүсдэг технологи үйл ажиллагаануудыг нарийвчлан тогтоох
- 7.7 Диоксин ба фуран үүсгэгч эх үүсвэрүүдэд ТТ/БОЭАА-г нэвтрүүлэх боломжийн үнэлгээ хийх
- 3.8 Диоксин ба фуран үүсгэгч эх үүсвэрүүдэд ТТ/БОЭАА-г

- нэвтрүүлэх
- 3.9 Диоксин ба фуран агуулсан хаягдлын менежментийг боловсронгуй болгох зааварчилгааг боловсруулах
- 3.10 УЗОБ агуулсан үйлдвэрийн хог хаягдлыг булаах цэгүүдэд үнэлгээ хийх

Дөрөвдүгээр зорилт. УЗОБ агуулсан пестицидүүдээр бохирдсон газруудыг олж тогтоон, хоргүйжүүлэх

- 4.1 УЗОБ-ийн пестицидээр бохирдсон газруудыг олж тогтоон хоргүйжүүлэх, нөхөн сэргээх
- 2.2 Хүнсний бүтээгдэхүүн дэх пестицидийн үлдэгдэл болон пестицидийн импортонд тавих хяналтыг сайжруулах механизмыг бүрдүүлэх
- 4.3 УЗОБ-аар бохирдсон газрын байршил, үүнийг хэрэглэгч аж ахуй нэгж байгууллагын эзэмшил, ашиглалтанд олгогдсон газар, уг бодисоос цэвэрлэгдсэн газруудыг кадастрын зурагт оруулж, 1-3 жилд газрын төлөв байдал, чанарын хянан баталгаанд оруулж байх

Тавдугаар зорилт. УЗОБ-ийн талаархи ухуулга сургалт, сурталчилгаа, мэдээллийн үндэсний тогтолцоо бий болгох

- 5.2 Оюутан, сурагчдад зориулсан УЗОБ-ийн тухай агууллагыг боловсруулж, албан ба албан бус сургалтын хөтөлбөрт оруулах
- 2.2 УЗОБ-ийн химийн бодистой шууд харьцаж ажилладаг эрсдэлтэй бүлэг болон хяналт шалгалтын байгууллагын ажиллагсдад зориулсан сургалтын хөтөлбөр боловсруулж, сургалтанд хамруулах
- 2.3 Диоксин ба фураны үүсэлт, байгаль орчин хүний эрүүл мэндэд үзүүлэх хор нөлөө, диоксин ба фураны үүсэлтийг бууруулах арга замын талаар сурталчилгааны материал бэлтгэж, радио, телевиз, сонин хэвлэлээр олон нийтэд тогтмол сурталчлах
- 2.4 УЗОБ-ийн чиглэлээр мэргэшсэн сургагч багш нарыг өндөр хөгжилтэй оронд урт ба богино хугацааны сургалтанд хамруулах

Зургадугаар зорилт. УЗОБ-ийн хяналт-шинжилгээ ба судалгаа шинжилгээний чадавхийг бүрдүүлэх

- 6.1 УЗОБ-ийн хяналт-шинжилгээ ба судалгаа шинжилгээг гүйцэтгэх чадавхи бүхий лабораторийг бий болгох
- 6.2 УЗОБ-ийн эх үүсвэрүүд төвлөрсөн болон бохирдолтой газруудад тэдгээрийн бохирдлын болон үүсэлтийн зэрэглэлийг ус, агаар, хөрс, хурдаст тогтоож, тэдгээрээс байгаль орчин хүний эрүүл мэндэд үзүүлж буй нөлөөллийн үнэлгээг хийх
- 6.3 УЗОБ-ийн эх үүсвэрт болон тэдгээрийг агуулсан тоног төхөөрөмж,

бүтээгдэхүүнтэй шууд харьцаж ажилладаг эрсдэлтэй бүлгийнхнийг хамруулан судалгаа хийж, өвчлөлийн нийтлэг хандлага, илрэлийг тогтоон, эрсдлийн үнэлгээ хийх

- 6.4 Нүүрсээр ажилладаг дулааны цахилгаан станц, уурын зуух болон гэр хорооллын айл өрхийн зуухнаас үүсэх диоксин ба фураны үүсэлтийн зэрэглэл ба түүнийг бууруулах боломжийн үнэлгээ хийх
- 6.5 УЗОБ-ийн хяналт-шинжилгээг агаар, ус, хөрс, хурдас, хүнсний бүтээгдэхүүнд хийх аргачлалыг боловсруулж, хяналт-шинжилгээний цэгүүд ба хэмжилт хийх хугацааг тогтоон, байнгын хяналт-шинжилгээний системийг бий болгох

ЗУРГАА. ХӨТӨЛБӨРИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, САНХҮҮЖИЛТ Удирдлага, зохион байгуулалт

Хөтөлбөрийн хэрэгжилтийг улсын хэмжээнд зохион байгуулах, зохицуулах, хяналт тавих үүргийг Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх Удаан задардаг органик бохирдуулагчийн асуудал эрхэлсэн орон тооны бус зөвлөл хэрэгжүүлнэ. Уг зөвлөл нь холбогдох яам, газар, эрдэм шинжилгээний болон төрийн бус байгууллагын төлөөллөөс бүрдэнэ.

Зөвлөл нь орон тооны нарийн бичгийн даргатай байж болно.

Хөтөлбөрийн санхүүжилт

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг дараахь эх үүсвэрээс бүрдүүлнэ:

а/ Даян Дэлхийн Байгаль Орчны Сангийн (ДДБОС) санхүүгийн туслалцаа;

б/ олон улсын байгууллага, хандивлагч орны санхүү, техникийн туслалцаа, технологи дамжуулалт;

в/ байгууллага, аж ахуйн нэгжийн хөрөнгө;

г/ улсын төвлөрсөн болон орон нутгийн төсөв;

д/ байгалийн нөөцийг хамгаалах зориулалтын сан;

е/ бусад.

ДОЛОО. ГАРАХ ҮР ДҮН, ТҮҮНИЙГ ТАЙЛАГНАХ

Гарах үр дүн

Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараахь үр дүнд хүрэх болно.

Үүнд:

1. УЗОБ-тай холбогдсон үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн орчин бүрдэнэ;
2. УЗОБ-ийн эх үүсвэрийн нэгдсэн бүртгэл, мэдээллийн сан, хяналт тавих хяналт-шинжилгээний систем бий болно;
3. ПХБ агуулсан тоног төхөөрөмжийн хэрэглээг зогсоож, нөөц хаягдлыг байгаль орчинд халгүй аргаар устгаж дуусна;
4. Дэвшилтэд технологи, байгаль орчинд ээлтэй арга ажиллагааг нэвтрүүлэх замаар эх үүсвэрүүдээс үүсэх диоксин ба фураны үүсэлтийг бууруулна;
5. УЗОБ-аар бохирдсон газруудыг хоргүйжүүлнэ;
6. УЗОБ химийн бодисын судалгаа, шинжилгээ, хяналт тавих лабораторийн чадавхи бүрдэнэ;
7. Аюултай хог хаягдлыг зайлуулах менежмент боловсронгуй болно;
8. Хүн амын эрүүл мэндэд онцгой аюултай эрсдлийг бууруулна.

Хөтөлбөрийн үр дүнг тайлагнах

Конвенцийн нарийн бичгийн дарга нарын газарт:

1. Үнэлгээний аргачлалын системийг бий болгож, 4 жил тутамд хөтөлбөрийн үр дүнг үнэлэн хүргүүлнэ;
2. ПХБ устгах үйл явцын талаар 5 жил тутамд тайлан гаргана;
3. УЗОБ-ийн бодисын хүрээлэн буй орчинд ялгарах болон хадгалагдаж байгаа хэмжээний өөрчлөлтийн талаархи тайланг хяналт-шинжилгээний дүнд үндэслэн 4 жил тутамд тайлагнана.

Монгол Улсын Засгийн газарт:

1. Хөтөлбөрийн үйл ажиллагааны биелэлтийн явцын тайланг жил бүр гаргана;
2. Хөтөлбөрийн үр дүнгийн тайланг үе шат бүрээр гаргаж тайлагнана.

**УДААН ЗАДАРДАГ ОРГАНИК БОХИРДУУЛАГЧИЙН ТУХАЙ”
ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Д /д	Үйл ажиллагаа	Харуцах байгууллага	Оролцох байгууллага	Хугацаа	Санхүүгийн эх үүсвэр	Шаардлагах зардал, сая төгрөг
<u>Нэг. Эрхзүйн орчин, хэрэгжүүлэх механизмыг бүрдүүлэх асуудлаар:</u>						
1	Монгол Улсад хэрэглэхийг хориглосон буюу хязгаарласан химийн бодисын жагсаалтанд нэмэлт өөрчлөлт оруулах	БОЯ		2006	Улсын төсөв (БО-ны сайдын төсвийн багцад)	0.5
2	УЗОБ-ийн талаар мэдээлэл цуглуулах тухай журам боловсруулах	БОЯ	ТЭХЯ, ҮХЯ, ХХААЯ	2006	Улсын төсөв (БО-ны сайдын төсвийн багцад)	1.0
3	Мэдээллийн сан, сүлжээг хөгжүүлэх заавар, журам боловсруулах	БОЯ	ТЭХЯ, ҮХЯ ХХААЯ	2007	Улсын төсөв (БО-ны сайдын төсвийн багцад)	1.0
4	“УЗОБ-ийн эх үүсвэрээс үүсэх хэмжээнд тавих шаардлага” стандартыг боловсруулах	БОЯ	СХҮТ	2007	Улсын төсөв (БО-ны сайдын төсвийн багцад)	1.5
5	УЗОБ химийн бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээний стандарт-ыг боловсруулах	БОЯ, СХҮТ	ТЭХЯ, ҮХЯ, ЭМЯ	2007	Улсын төсөв (БО-ны сайдын төсвийн багцад)	1.5

6	Хөдөлмөрийн нөхцөлийн ангиллын стандартад нэмэлт өөрчлөлт оруулах	БОЯ, ЭМЯ, НХХЯ	ТЭХЯ, ҮХЯ,	2007	Улсын төсөв (БО-ны сайдын төсвийн багцад)	0.8
7	УЗОБ агуулсан хаягдлыг цуглуулах, хадгалах, тээвэрлэх, устгах, хоргүйжүүлэх журам боловсруулах	БОЯ, ОБЕГ	ТЭХЯ, ҮХЯ, ХХААЯ, ЭМЯ,	2008	Улсын төсөв (БО-ны сайдын төсвийн багцад)	2.0
8	Эмнэлгийн хог хаягдлыг устгах тухай эрх зүйн баримт бичгийг шинэчлэх	БОЯ	ЭМЯ	2008	Улсын төсөв (БО-ны сайдын төсвийн багцад)	1.0
9	УЗОБ агуулсан үйлдвэрийн хог хаягдлыг булах цэгт тавигдах шаардлага болон хяналт-шинжилгээ хийх аргачилсан заавар боловсруулах	БОЯ	ТЭХЯ, ҮХЯ,	2009	Улсын төсөв (БО-ны сайдын төсвийн багцад)	1.5
10	Тэргүүний технологи /байгаль орчинд ээлтэй арга ажиллагааг (ТТ/ БОЭАА) хэрэгжүүлэхэд эдийн засгийн дэмжлэг, хөнгөлөлт үзүүлэх	СЯ, БОЯ	ТЭХЯ, ҮХЯ	2008-2020	-	-
<p>Хоёр. ПХБ-үүд агуулсан тоног төхөөрөмжийн импорт, хэрэглээ, хаягжуулалт, тээвэрлэлт, хадгалалт ба устгалтын асуудлаар:</p>						

1	ПХБ агуулсан тоног төхөөрөмж, хаягдал, бохирдсон газрын тооллого явуулж, улсын нэгдсэн мэдээлийн санг бүрдүүлэн, тоног төхөөрөмжийг хаягжуулах	БОЯ	ТЭХЯ, ҮХЯ	2007	ДДБОС, донорууд, ПХБ агуулсан тоног төхөөрөмж ашиглагч бай-гууллага, аж ахуйн нэгж	300.0
2	ПХБ-ийн талаар мэдээлэл цуглуулах, солилцох сүлжээг бий болгож, мэдээллийн санг шинэчилж байх	БОЯ	ТЭХЯ, ҮХЯ, УМХГ, ГЕГ	2007	ДДБОС, донорууд, ПХБ агуулсан тоног төхөөрөмж ашиглагч бай-гууллага, аж ахуйн нэгж	50.0
3	ПХБ агуулсан тоног төхөөрөмж, хаягдлыг цуглуулах, хадгалах, тээвэрлэх механизмыг бүрдүүлэх	БОЯ	ТЭХЯ, ҮХЯ, ЗТАЖЯ	2008	ДДБОС, донорууд, ПХБ агуулсан тоног төхөөрөмж ашиглагч бай-гууллага, аж ахуйн нэгж	200.0
4	ПХБ агуулсан тоног төхөөрөмжийн хэрэглээг доорхи хуваарийн дагуу зогсоож, бохирдсон тоног төхөөрөмжийг цэвэрлэх 2012 он 20% 2014 он 40% 2016 он 60% 2018 он 80% 2020 он 100%	БОЯ	ЭХЯ, ҮХЯ	2008-2020	ДДБОС, донорууд, ПХБ агуулсан тоног төхөөрөмж ашиглагч бай-гууллага, аж ахуйн нэгжүүд	500.0
5	ПХБ агуулсан хаягдлыг 2 дугаар зорилтын 4-т заасан хуваарийн дагуу устгах	БОЯ	БОЯ	2008-2020	ДДБОС, донорууд	1 000.0

Гурав. Зориудын бус үйлдвэрлэлээс үүсэх УЗОБ-ын хэмжээг бууруулах асуудлаар:						
1	Диоксин ба фуран үүсгэгч эх үүсвэрүүдийн зэрэглэлийг шинэчлэн тогтоох	БОЯ	ТЭХЯ, ҮХЯ	2009	ДДБОС, донорууд	12.0
2	Диоксин ба фураны гол эх үүсвэр бүр дээр хаягдлын коэффициентийг тогтоох, түүнийг техник технологийн өөрчлөлт бүрийн дараа шинэчлэн тогтоож байх	БОЯ	ТЭХЯ, ҮХЯ	Тухай бүр	ДДБОС, донорууд, Байгаль хамгаалах сан	10.0
3	Зориудын бус үйлдвэрлэлээс үүсэх УЗОБ-ийн мэдээллийн сан бий болгох	БОЯ	ТЭХЯ, ҮХЯ	2009	ДДБОС, донорууд	7.0
4	Диоксин ба фураны эх үүсвэрүүд дээр хэмжилт хийх	БОЯ		2010	ДДБОС, донорууд	150.0
5	Диоксин ба фуран үүсгэгч эх үүсвэрүүдэд ТТ/БОЭАА-г нэвтрүүлэх боломжийн үнэлгээ хийх	БОЯ		2010	ДДБОС, донорууд	20.0
6	Диоксин ба фураны эх үүсвэрүүдээс байгаль орчинд үзүүлж буй нөлөөллийн үнэлгээ хийх	БОЯ		2010	ДДБОС, донорууд	12.0
7	Диоксин ба фуран үүсгэгч эх үүсвэрүүдэд ТТ/БОЭАА-г нэвтрүүлэх	БОЯ	ТЭХЯ, ҮХЯ	2010-2020	ДДБОС, донорууд, үйлдвэр, аж ахуйн нэгж	500.0
8	УЗОБ агуулсан хаягдал үүсдэг технологи үйл ажиллагаануудыг нарийвчлан тогтоох	БОЯ		2009	ДДБОС, донорууд, Байгаль хамгаалах сан	30.0

9	Технологи үйл ажиллагааны явцад завсрын бүтээгдэхүүн хэлбэрээр үүсдэг УЗОБ агуулсан хаягдлын менежментийг боловсронгуй болгох зааварчилгааг боловсруулах	БОЯ		2010	ДДБОС, донорууд, Байгаль хамгаалах сан	5.0
10	УЗОБ агуулсан үйлдвэрийн хог хаягдлыг булах цэгт үнэлгээ хийх	БОЯ	ЭМЯ	2010	ДДБОС, донорууд, Байгаль хамгаалах сан	30.0
Дөрөв. УЗОБ пестицидүүдийн импорт, хэрэглээ, нөөц ба хаягдлын асуудлаар:						
1	УЗОБ-ийн пестицидээр бохирдсон газруудыг олж тогтоох	БОЯ	ХХААЯ, УМХГ	2009	ДДБОС, донорууд	100.0
2	УЗОБ-ийн пестицидээр бохирдсон газруудыг нөхөн сэргээх	БОЯ	Орон нутгийн засаг захиргаа	2011-2020	ДДБОС, донорууд, орон нутгийн төсөв	400.0
3	Хүнсний бүтээгдэхүүн дэх пестицидийн үлдэгдэл болон пестицидийн импортонд тавих хяналтыг сайжруулах механизм-ыг бүрдүүлэх	ХХААЯ, УМХГ	БОЯ	2008	Улсын төсөв (БО-ны сайдын төсвийн багцад)	1.5
4	УЗОБ-аар бохирдсон газрын байршил, үүнийг хэрэглэгч аж ахуйн нэгж байгууллагын эзэмшил, ашиглалтанд олгогдсон газар, уг бодисоос цэвэрлэгдсэн газруудыг кадастрын зурагт оруулж, 1-3 жилд газрын төлөв байдал, чанарын хянан баталгаанд оруулж байх	БХБЯ	БОЯ	2011-2020	ДДБОС, донорууд	100.0

Тав. УЗОБ-ын талаархи ухуулга сургалт, сурталчилгаа, мэдээллийг нэмэгдүүлэх асуудлаар:						
1	Оюутан, сурагчдад зориулсан УЗОБ-ийн тухай агууллагыг боловсруулж, албан ба албан бус сургалтын хөтөлбөрт оруулах	БОЯ	БСШУЯ	2008 -2009	Улсын төсөв (БО-ны сайдын төсвийн багцад)	5.0
2	Эрсдэлтэй бүлэг болон хяналт шалгалтын байгууллагын ажиллагсад зориулсан сургалтын хөтөлбөр боловсруулж, сургалтанд хамруулах	БОЯ		2007 –2008	ДДБОС, донорууд,	60.0
3	Диоксин ба фураны үүсэлт, байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлэх хор нөлөө, диоксин ба фураны үүсэлтийг бууруулах арга замын талаар сурталчилгааны материал бэлтгэж, радио, телевиз, сонин хэвлэлээр олон нийтэд тогтмол сурталчлах	БОЯ	ТББ-ууд	2007 –2010	ДДБОС, донорууд, Байгаль хамгаалал сан, ТББ	200.0
4	УЗОБ-ийн чиглэлээр мэргэшсэн сургагч багш нарыг өндөр хөгжилтэй оронд урт ба богино хугацааны сургалтанд хамруулах	БОЯ	БСШУЯ	2007-2010	ДДБОС, донорууд,	100.0
Зургаа. УЗОБ-ийн хяналт-шинжилгээ ба судалгаа шинжилгээний чадавхийг бүрдүүлэх талаар:						
1	УЗОБ-ийн хяналт-шинжилгээ ба судалгаа шинжилгээг гүйцэтгэх чадавхи бүхий лабораторийг бий болгох	БОЯ	СЯ	2008 –2010	ДДБОС, донорууд	1 000.0

2	УЗОБ-ийн эх үүсвэрүүд төвлөрсөн болон бохирдолтой газруудад тэдгээрийн бохирдлын болон үүсэлтийн зэрэглэлийг ус, агаар, хөрс, хурдаст тогтоож, тэдгээрээс байгаль орчин хүний эрүүл мэндэд үзүүлж буй нөлөөллийн үнэлгээг хийх	БОЯ	ЭМЯ	2010-2011	ДДБОС, донорууд, Байгаль хамгаалах сан	30.0
3	УЗОБ-ийн эх үүсвэрт болон тэдгээрийг агуулсан тоног төхөөрөмж, бүтээгдэхүүнтэй шууд харьцаж ажилладаг эрсдэлтэй бүлгийнхнийг хамруулан судалгаа хийж, өвчлөлийн нийтлэг хандлага, илрэлийг тогтоон, эрсдлийн үнэлгээ хийх	БОЯ, ЭМЯ	ТЭХЯ, ҮХЯ	2010-2012	ДДБОС, донорууд	60.0
4	Нүүрсээр ажилладаг цахилгаан дулааны станц, уурын зуух болон гэр хорооллын айл өрхийн зуухнаас үүсэх диоксин ба фураны үүсэлтийн зэрэглэл ба түүнийг бууруулах боломжийн үнэлгээ хийх	БОЯ	ШУА	2010-2012	ДДБОС, донорууд	50.0
5	УЗОБ-ийн хяналт-шинжилгээг агаар, ус, хөрс, хурдас, хүнсний бүтээгдэхүүнд хийх аргачлалыг боловсруулж, хяналт-шинжилгээний цэгүүд ба хэмжилт хийх хугацааг тогтоон байнгын хяналт-шинжилгээний системийг бий болгох	БОЯ	ШУА	2009-2011	ДДБОС, донорууд,	80.0

	НИЙТ					5015.7
--	------	--	--	--	--	--------

ОЗОНЫ ҮЕ ДАВХАРГЫГ ХАМГААЛАХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

(Засгийн газрын 1999 оны 129 дүгээр тогтоолоор батлагдсан)
Нэг. Нийтлэг үндэслэл

1. Хүн төрөлхтөн химийн олон төрлийн үйлдвэрлэл эрхэлж, химийн олон төрлийн бодисуудыг аж амьдралдаа хэрэглэх болсноор озон задалдаг бодисыг үлэмж хэмжээгээр ялгаруулан агаар мандал дахь озоны давхарга хомсдох, улмаар нарны хэт ягаан туяаны хор хөнөөлд дэлхийн шим мандлын амьтан, ургамал, хүн ам их хэмжээгээр нэрвэгдэх аюулд тулгараад байна.

2. Монгол улс хүн төрөлхтний хөгжлийн нийтлэг хандлага болсон тогтвортой хөгжлийн чиг баримжаагаар байгаль орчныг тэтгэх даацандаа нийцүүлэн нийгэм, эдийн засгаа хөгжүүлэх бодлого баримталж байна.

3. Озоны давхаргыг хамгаалах тухай Венийн Конвенци, Озоны үе давхаргыг задалдаг бодисын тухай Монреалын Протокол болон тэдгээрт оруулсан 1990 оны Лондонгийн, 1992 оны Копенгагений нэмэлтүүдэд монгол улс нэгдэн орсон тул манай улс дээрх Конвенци, Протоколын албан ёсны Тал болсон болно.

4. Монгол улс озон задалдаг бодисын хэрэглээг үе шаттай бууруулж, улмаар бүрэн хязгаарлах нь дэлхийн хүн амын эрүүл мэнд, байгаль орчны таатай нөхцөлийг хадгалан хамгаалах чухал үйл хэрэг болохыг хүлээн зөвшөөрч, түүнийг хэрэгжүүлэх олон улсын хүчин чармайлтыг бүрэн дэмжин хувь нэмрээ оруулах зорилт тавин ажиллаж байна.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго, үе шат

5. Зорилго

Хөтөлбөрийн зорилго нь озоны давхаргыг задалдаг бодисын хэрэглээг үе шаттай бууруулж улмаар бүрмөсөн хязгаарлах, ашиглагдаж буй озон задалдаг бодисыг озоны давхаргыг үл задлах бодисоор орлуулахад оршино.

Үндэсний хөтөлбөр нь Венийн Конвенци, Монреалын Протоколоор Монгол улсын хүлээсэн үүргийг биелүүлэхэд бүрэн чиглэгдэнэ.

6. Үе шат

Хөтөлбөрийг дор дурдсан үе шаттай хэрэгжүүлнэ:

а/ нэг дэх үе шат: 2005 оны 1 дүгээр сарын 1 хүртэл Монреалын Протоколын хавсралт А-ийн I бүлгийн хлорт фторт нүүрстөрөгчийн хэрэглээг 1997-1998 оны дундаж түвшнээс 50 хувь бууруулах;

б/ хоёр дахь үе шат: 2007 оны 1 дүгээр сарын 1 хүртэл Монреалын Протоколын хавсралт А-ийн I бүлгийн хлорт фторт нүүрстөрөгчийн хэрэглээг 85 хувь бууруулах;

в/ гурав дахь үе шат: 2010 оны 1 дүгээр сарын 1 хүртэл Монреалын Протоколын хавсралт А-ийн I бүлгийн хлорт фторт нүүрстөрөгчийн хэрэглээг бүрмөсөн хязгаарлах;

г/ дөрөв дэх үе шат: 2015 оны 1 дүгээр сарын 1 хүртэл Монреалын Протоколын хавсралт С-ийн I бүлгийн хлорт фторт нүүрстөрөгчийн хэрэглээг 1999 оны түвшнээс 90 хувь бууруулах;

д/ тав дахь үе шат: 2030 оны 1 дүгээр сарын 1 хүртэл Монреалын Протоколын хавсралт С-ийн I бүлгийн хлорт фторт нүүрстөрөгчийн хэрэглээг бүрмөсөн хязгаарлах.

Гурав. Удирдлага, зохион байгуулалт

7. Озоны давхаргыг хамгаалах асуудлыг Байгаль орчны сайдын дэргэд ажиллах озоны асуудлаархи Үндэсний хороо удирдан зохицуулна. Үндэсний хорооны бүрэлдэхүүнд нь Хөдөө аж ахуй, үйлдвэрийн, Дэд бүтцийн хөгжлийн болон, Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яам, Үндэсний статистикийн газар, Гаалийн ерөнхий газар, Шинжлэх ухааны академи зэрэг төр, олон нийтийн болон хувийн хэвшлийн байгууллагын төлөөлөгчид орно.

8. Озоны асуудлаархи үндэсний хороо нь озоны давхаргыг хамгаалах үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлж, озон задалдаг бодисын импорт, худалдаа, хэрэглээнд хяналт тавьж, тухайн асуудлаар

эрх бүхий байгууллагаас гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх арга хэмжээ авна.

9. Озоны асуудлаархи үндэсний хорооны ажлын алба доорхи үүргийг гүйцэтгэнэ:

а/ хөтөлбөрт заасан үйл ажиллагааг зохион байгуулж явуулах;

б/ үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх асуудлыг олон улсын эрх бүхий байгууллагад тавьж, түүнийг хэрэгжүүлэх талаар технологи, санхүүгийн дэмжлэг, тусламж авах;

в/ озоны давхаргын шинжилгээ судалгаа, ажиглалт, хэмжилтийн ажлын чиглэл, хүрээг тогтоох, тэдгээрийг хариуцан гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагааг дэмжих, хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих;

г/ озоны давхаргын өөрчлөлтөөс шалтгаалан хэт ягаан туяанаас шим мандалд үзүүлэх нөлөөллийг судлах ажлыг эрчимжүүлэх, энэ чиглэлийн байгууллагуудын ажлын уялдаа холбоог сайжруулах;

д/ озоны давхаргыг шинжлэн судлах, хамгаалахтай холбоотой шинжлэх ухаан, нийгэм, эдийн засаг, худалдааны болон эрх зүйн мэдээллийг олон улсын эрх бүхий байгууллага, гадаад улстай солилцох, дотоодын сонирхсон байгууллагуудад түгээх, сурталчлах;

е/ озоны үе давхаргын талаархи Конвенци, Протоколын болон үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан гаргаж улирал бүр эрхэлсэн сайдад, жил бүрийн 1 дүгээр сард Засгийн газарт, гэрээ, хэлэлцээрт заасан хугацаанд нь олон улсын байгууллагад тайлагнах;

ж/ озоны давхаргыг задалдаг бодис хэрэглэдэг үйлдвэрлэл, үйлчилгээний байгууллага болон салбарын хэрэглээг бууруулах, өөр бодисоор орлуулах төлөвлөгөө гарган хэрэгжүүлэхэд нь туслах, биелэлтэд хяналт тавих;

з/ озон задалдаг бодис хэрэглэдэг үйлдвэрлэл, үйлчилгээний ажилтнуудад зориулж сургалт семинар зохион байгуулах.

Дөрөв. Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

Хөтөлбөрийн зорилгыг дор дурдсан үйл ажиллагаагаар хэрэгжүүлнэ:

10. Зохион байгуулалтын талаар

а/ озоны давхаргыг хамгаалах эрх зүйн үндэс бүрдүүлэх;

б/ Монреалын Протоколын 1997 оны нэмэлтэд нэгдэн орох;

в/ Байгаль орчны сайдын дэргэд Озоны асуудлаархи үндэсний хороо болон түүний ажлын албыг байгуулж ажиллуулах;

г/ озоны давхаргыг задалдаг бодис импортлогч, ашиглагч нарын үндэсний нийгэмлэг болон бусад холбогдох төрийн бус байгууллагын

үйл ажиллагааг дэмжих, тэдгээртэй хамтран ажиллах;

д/ озоны давхаргыг шинжлэн судлах, хамгаалах төрийн болон төрийн бус байгууллагын чадавхийг нэмэгдүүлэх, хөтөлбөр хэрэгжүүлэх чиглэлээр төсөл боловсруулан олон улсын байгууллагад тавьж хэрэгжүүлэх;

е/ озоны давхаргыг судлах, хамгаалах болон озон задалдаг бодисыг импортлогч, ашиглагч байгууллагын мэргэжилтнүүдэд зориулсан сургалт, семинар зохион явуулах;

ж/ озоны давхаргыг задалдаг бодис ашиглан үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг байгууллагуудад олгох зөвшөөрлийн тогтолцоог боловсронгуй болгох;

з/ озон задалдаг бодисын хяналт-шинжилгээний үндэсний тогтолцоог бий болгох;

и/ озоны давхаргыг хамгаалах, озон задалдаг бодисын ялгаралтыг бууруулах, өөр бодис, технологиор орлуулах талаар олон нийтэд мэдээллийн бүх хэрэгслээр сурталчилгаа явуулах.

11. Судалгаа хэмжилтийн талаар

а/ хийн мандал дахь озоны ерөнхий агууламж, түүний босоо тархалтын орон зай, цаг хугацааны өөрчлөлтийг хэмжих байнгын харуул байгуулан ажиллуулах;

б/ газрын гадаргаас завсрын мандал, давхраат мандал хүртэлх агаарын температурын хуваарилалтыг нарийвчлан судлах;

в/ газрын гадаргад ирж байгаа нарны цацрагийн долгионы бүрэлдэхүүн хийгээд амьд организмд нөлөөлөх хэт ягаан туяаны хэмжилт, судалгааны ажлыг зохион байгуулах;

г/ цаг уурын ажиглалт хэмжилтийн өндөр нарийвчлалтай багаж төхөөрөмжөөр уур амьсгалын өөрчлөлтийг судлах хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж эхлэх.

12. Мэдээлэл солилцооны талаар

Озоны давхаргыг хамгаалах, озон задалдаг бодисын хэрэглээг багасгах, улмаар бүрмөсөн хязгаарлах зорилгоор олон улсын байгууллага, гадаад орон, дотоодын аж ахуйн нэгж, байгууллагатай дараахи мэдээлэл өгөгдлийг солилцоно:

а/ судалгаа явуулах шаардлага бүхий озоны давхаргыг задалдаг бодисын ялгарлын тухай өгөгдөл;

б/ озоны ерөнхий агууламж, түүний босоо чиглэл дэх хуваарилалтын тодорхой хугацааны өөрчлөлт хүний эрүүл мэнд,

байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн тухай шинжилгээ судалгааны үр дүн, мэдээлэл;

в/ шинжилгээ, судалгааны ажлын үр дүнгийн үнэлгээ, цаашдын судалгааны зөвлөмж;

г/ озон задалдаг бодисын ялгаралтыг бууруулах болон орлуулах бодис, технологийн талаархи судалгаа шинжилгээний ажлын мэдээлэл, тайлан;

д/ озон задалдаг бодисын үйлдвэрлэл, хэрэглээ, цаашдын хандлага, импорт, экспортын тухай мэдээлэл;

е/ озоны давхаргыг хамгаалахтай холбогдсон үндэсний хууль тогтоомж, удирдлага, зохицуулалтын талаархи мэдээлэл;

ж/ озоны давхаргыг хамгаалахтай холбогдсон лиценз, патент олгох нөхцөл, аргын тухай мэдээлэл.

13. Олон улсын хамтын ажиллагаа

Озоны давхаргыг хамгаалах, озон задалдаг бодисыг багасгах, бүрмөсөн хязгаарлах, озон хомсдуулдаг бодисын хэрэглээг өөр бодисоор орлуулан солих шинэ техник, технологи нэвтрүүлэх, озоны судалгаа шинжилгээ явуулах талаар олон улсын хамтын нийгэмлэгтэй харилцаа холбоогоо хөгжүүлж, түншлэлийн үр ашигтай хэлбэрээр хамтран ажиллана:

а/ ОХУ, АНУ, Канад, Австрали, Япон, ХБНГУ, БНХАУ, Франц зэрэг улс орнуудтай озоны давхаргын судалгаа шинжилгээ хамтран хийж, тандан судалгааны мэдээлэл хүлээн авах, солилцох, озон задалдаг бодисын мэдээлэл солилцох, орлуулагч бодисын мэдээлэл авах, шинэ технологи нэвтрүүлэх чиглэлээр хамтран ажиллах;

б/ озон задалдаг бодисын тооллого бүртгэл хийх, хөргөх системийн менежментийг сайжруулах зэрэг чиглэлээр НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөр, Хөгжлийн хөтөлбөр, Үйлдвэр, хөгжлийн байгууллага, Озоны асуудлаархи олон талын сан, Дэлхийн экологийн сан зэрэг байгууллагатай хамтран ажиллах;

в/ озоны давхаргыг шинжлэн судлах, байнгын хяналт-шинжилгээ хийх, мэдээллийн сан, сүлжээ байгуулах, боловсон хүчин бэлтгэх чиглэлээр Дэлхийн цаг уурын байгууллага, НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөр, Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагатай үр ашигтай хамтын ажиллагааг улам бүр хөгжүүлэх;

г/ гадаад орон, олон улсын байгууллагатай хамтран озон задалдаг бодисын хэрэглээг өөрчлөх, орлуулагчаар солих, байгууллага, аж ахуйн нэгжийн мэргэжлийн хүмүүст сургалт явуулах, сонирхсон

байгууллага, хүмүүст мэдээлэл сурталчилгаа явуулах төсөл боловсруулж хэрэгжүүлэх.

Тав. Хөтөлбөрийн санхүүжилт

14. Хөтөлбөрт заасан үйл ажиллагааг доорхи санхүүгийн эх үүсвэрээр хэрэгжүүлнэ:

а/ озон хомсдуулдаг бодисын тооллого болон хяналт шалгалтыг байгаль хамгаалахад зориулсан улсын төвлөрсөн болон орон нутгийн жил бүрийн төсвөөс санхүүжүүлнэ;

б/ үйлдвэр, үйлчилгээний хэвийн ажиллагааг хангах, байгаль орчинд халгүй технологи нэвтрүүлэх болон түүхий эд, материал ашиглахад зориулан үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагаас төлөвлөсөн хөрөнгө;

в/ хандивлагч орон, гадаад, дотоодын байгууллагын тусламжийн хөрөнгө.

Зургаа. Хөтөлбөрийн хэрэгжилтэд тавих хяналт, үр дүн

15. Хяналт шалгалт:

Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хяналт тавих ажлыг Озоны асуудлаархи үндэсний хороо эрхлэн гүйцэтгэнэ.

16. Үр дүн

Озоны давхаргыг задалдаг бодисыг бүрэн хязгаарлах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараахь үр дүнд хүрнэ:

а/ озоны асуудлыг эрхлэх үндэсний удирдлага, зохицуулалтын тогтолцоо бүрэлдэн тогтож, озоны шинжилгээ судалгаа, байнгын ажиглалт хэмжилтийн тогтолцоо бий болно;

б/ монголын хүн ам, байгаль орчныг хэт ягаан туяаны нөлөөллөөс хамгаалах стратеги боловсруулах үндэслэл бүрдэж эхэлнэ;

в/ озоны талаархи эрх зүй, шинжлэх ухаан, техник, технологийн чиглэлийн дотоод, гадаадын мэдээллийн солилцоо тогтмолжино;

г/ Монгол улс Венийн Конвенци, Монреалын Протоколоор хүлээсэн үүргээ хэрэгжүүлнэ;

д/ уур амьсгалын өөрчлөлт болон хэт ягаан туяаны нөлөөлд бага автах хүнс тэжээлийн болон техникийн ургамал, тэжээмэл амьтан

үржүүлэхэд шаардагдах мэдээллийн нэмэгдэл эх сурвалжтай болно;

е/ озоны давхаргыг үл задлах бодис хэрэглэх, байгаль орчинд халгүй технологи нэвтрүүлэхэд олон улсын дэмжлэг хүлээж, зохих тусламж авах бололцоо бүрдэнэ.

IV. ХИМИЙН ХОРТ БОЛОН АЮУЛТАЙ БОДИСЫН БОДЛГО ЗОХИЦУУЛАЛТЫН АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ

(Засгийн газрын 2006 оны 314 дүгээр тогтоолын 1 дүгээр
хавсралтаар батлагдсан)

ХИМИЙН ХОРТ БОЛОН АЮУЛТАЙ БОДИСЫН БОДЛОГО,ЗОХИЦУУЛАЛТЫН АСУУДЛААР МЭРГЭЖЛИЙН САНАЛ, ДУГНЭЛТ ГАРГАХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- Дарга
- Гишүүд:
- Байгаль орчны сайд
 - Үйлдвэр, худалдааны сайд
 - Эрүүл мэндийн сайд
 - Хүнс, хөдөө аж ахуйн сайд
 - Онцгой байдлын асуудал эрхэлсэн Монгол улсын сайд
 - Барилга, хот байгуулалтын дэд сайд
 - Батлан хамгаалахын дэд сайд
 - Боловсрол, соёл, шинжлэх ухааны дэд сайд
 - Зам, тээвэр, аялал жуулчлалын дэд сайд
 - Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн дэд сайд
 - Сангийн дэд сайд
 - Түлш, эрчим хүчний дэд сайд
 - Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч
 - Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга
 - Улсын гаалийн ерөнхий газрын дарга
 - Улсын мэргэжлийн хяналтын газрын дарга
 - Цагдаагийн ерөнхий газрын дарга
 - Тагнуулын ерөнхий газрын дарга
 - Стандартчилал, хэмжил зүйн төвийн дарга
 - Байгаль орчны яамны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн газрын дарга
 - Шинжлэх ухааны академийн Хими, хими-технологийн хүрээлэнгийн захирал
 - Монгол улсын их сургуулийн Химийн факультетийн декан
 - Химичдийн нийгэмлэгийн тэргүүн /тохиролцсоноор/
- Нарийн бичгийн дарга - Орон тооны

ХИМИЙН ХОРТ БОЛОН АЮУЛТАЙ БОДИСЫН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН АСУУДЛААР МЭРГЭЖЛИЙН САНАЛ,
ДҮГНЭЛТ ГАРГАХ ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ДҮРЭМ

(Засгийн газрын 2006 оны 314 дүгээр тогтоолын 2 дугаар тогтоолоор багтагдсан)

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Химийн хорт болон аюултай бодисын бодлого, зохицуулалтын асуудлаар Үндэсний зөвлөл нь /цаашид “Үндэсний зөвлөл” гэх/ химийн хорт болон аюултай бодисын бодлого, зохицуулалтын асуудлаар мэргэжлийн санал, дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус байгууллага мөн.

1.2. Үндэсний зөвлөл нь үйл ажиллагаандаа Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль, Аюултай хог хаягдлын импорт, хил дамжуулан тээвэрлэлтийг хориглох, экспортлох тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Аюултай хог хаягдлыг хил дамжуулан тээвэрлэхэд хяналт тавих тухай Базелийн конвенци /1996/, Аюултай зарим химийн бодис болон пестицидийг олон улсын хэмжээнд худалдаалахад хэрэглэх, урьдчилан мэдээлж зөвшилцөх журмын тухай Роттердамын конвенци /2000/, Удаан задардаг органик бохирдуулагчийн тухай Стокгольмын конвенци /2003/, бусад хууль тогтоомж болон мөн энэхүү дүрмийг дагаж мөрдөнө.

1.3. Үндэсний зөвлөл нь ажлаа Ерөнхий сайдад тайлагнана.

Хоёр. Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүн, зохион байгуулалт

2.1. Үндэсний зөвлөлийн дарга нь байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн байна.

2.2. Үндэсний зөвлөл нь орон тооны нарийн бичгийн даргатай байна.

2.3. Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнд холбогдох яам, агентлаг, эрдэм шинжилгээ болон мэргэжлийн байгууллагын зохих албан тушаалтан орох бөгөөд бүрэлдэхүүнийг Засгийн газар батална.

2.4. Үндэсний зөвлөл нь холбогдох яам, агентлаг, эрдэм шинжилгээ болон мэргэжлийн байгууллага болон химийн мэргэжилтний төлөөлөл бүхий шинжээчдийн багтай байна.

2.5. Шинжээчдийн багийн бүрэлдэхүүнийг холбогдох яам, агентлагаас санал авсны үндсэн дээр Үндэсний зөвлөлийн дарга батална.

2.6. Үндэсний зөвлөл нь төрийн захиргааны холбогдох төв байгууллага болон аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэд орон тооны бус салбар зөвлөлтэй байна.

2.7. Салбар зөвлөлийн дарга нь тухайн асуудлыг эрхэлсэн Засгийн газрын гишүүн, аймаг, нийслэлийн Засаг дарга байна. Салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг холбогдох Засгийн газрын гишүүн, аймаг нийслэлийн Засаг дарга батална.

2.8. Үндэсний зөвлөл 15-аас, салбар зөвлөл нь 7-гоос доошгүй гишүүнтэй байна. Үндэсний зөвлөлийн шинжээчдийн баг нь 9-өөс доошгүй гишүүнтэй байна.

2.9. Үндэсний зөвлөлийн үйл ажиллагааны зардлыг байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, салбар зөвлөлийн зардлыг төрийн захиргааны холбогдох төв байгууллага, аймаг, нийслэлийн Засаг дарга хариуцах бөгөөд тухайн жилийн төсөвтөө тусгаж санхүүжүүлнэ.

2.10. Үндэсний зөвлөл нь албан бичгийн хэвлэмэл хуудас, тэмдэгтэй байна. Салбар зөвлөл нь төрийн захиргааны холбогдох төв байгууллага болон аймаг, нийслэлийн Засаг даргын албан бичгийн хэвлэмэл хуудас, тамгыг хэрэглэнэ.

2.11. Шаардлагатай гэж үзвэл үндэсний зөвлөлийн шинжээчдийн багийн гишүүд, салбар зөвлөлийн дарга нарт Үндэсний зөвлөлийн даргын гарын үсэгтэй үнэмлэх олгож болно.

Гурав. Үндэсний зөвлөлийн ажиллах журам

3.1. Үндэсний зөвлөлийн үйл ажиллагааны хэлбэр нь Зөвлөлийн хурал байна.

3.2. Үндэсний зөвлөлийн хурлыг хагас жилд нэгээс доошгүй удаа хийх. Ээлжит бус хурлыг Үндэсний зөвлөлийн дарга зарлан хуралдуулж болно.

3.3. Үндэсний зөвлөлийн хурлыг Үндэсний зөвлөлийн дарга, түүний эзгүйд Үндэсний зөвлөлийн даргын үүрэг болгосноор Зөвлөлийн аль нэг гишүүн даргална.

3.4. Шинжээчдийн багийн болон салбар зөвлөлийн хурлыг шинжээчдийн багийн ахлагч, салбар зөвлөлийн дарга удирдана.

3.5. Үндэсний болон салбар зөвлөлийн хурлаар асуудал хэлэлцүүлэх байгууллага холбогдох материалаа зөвлөлийн нарийн бичгийн даргад хурал болохоос 7 хоногийн өмнө хүргүүлнэ. Хурлын материалыг хурал болохоос 5 хоногийн өмнө гишүүдэд тараана.

3.6. Үндэсний болон салбар зөвлөлийн хурлыг гишүүдийн олонхи ирсэн

тохиолдолд хуралдуулна.

3.7. Үндэсний зөвлөлийн хурлаар хэлэлцсэн асуудлыг гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэж, тогтоол гаргана. Тогтоолд үндэсний зөвлөлийн дарга болон нарийн бичгийн дарга гарын үсэг зурж баталгаажуулна.

3.8. Шинжээчдийн багийн болон салбар зөвлөлийн хурлаар хэлэлцсэн асуудлыг олонхийн саналаар шийдвэрлэж, дүгнэлт, зөвлөмж гаргана.

3.9. Хурлын тэмдэглэлийг нарийн бичгийн дарга хөтөлж, дарга гарын үсэг зурна.

3.10. Шаардлагатай тохиолдолд үндэсний болон салбар зөвлөл, шинжээчдийн багийн хуралдаанд мэргэжлийн хүмүүсийг оролцуулна.

3.11. Үндэсний зөвлөлийн ажлын албаны үүргийг Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга болон Үндэсний зөвлөлийн шинжээчдийн баг гүйцэтгэнэ.

Дөрөв. Үндэсний зөвлөл, шинжээчдийн багийн бүрэн эрх

4.1. Үндэсний зөвлөл дараахь үүрэгтэй байна:

4.1.1. химийн хорт болон аюултай бодисын аюулгүй байдлыг хангахтай холбогдсон бодлого тодорхойлох, холбогдох хууль тогтоомжийг боловсронгуй болгоход санал гаргах;

4.1.2. Монгол Улсын нэгдэн орсон химийн бодисын талаархи олон улсын гэрээ болон үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хангахад санал, зөвлөмж өгөх;

4.1.3. химийн хорт болон аюултай бодистой холбогдож үүссэн аюул, осол, онцгой тохиолдлын үед мэргэжлийн арга зүйгээр хангаж, дүгнэлт, зөвлөмж гаргах;

4.1.4. химийн хорт болон аюултай бодисоос хамгаалах, түүнийг ашиглах үйл ажиллагааг зохицуулах асуудлаар салбар зөвлөлийн ажилд арга зүйн туслалцаа, дэмжлэг үзүүлэх, нэгдсэн удирдлагаар хангах;

4.1.5. шинжээчдийн багийн болон салбар зөвлөлийн тайланг хэлэлцэх.

4.2. Үндэсний зөвлөл дараахь эрхтэй байна:

4.2.1. химийн хорт болон аюултай бодисын асуудлаар зөвлөмж, дүгнэлт гаргах, хяналт тавих ажлын хэсэгт холбогдох байгууллага, мэргэжилтэн, шинжээч, улсын байцаагч нарыг татан оролцуулах;

4.2.2. химийн хорт болон аюултай бодисын чиглэлээр аливаа байгууллагаас гаргасан шийдвэр, үйл ажиллагаа нь хууль тогтоомж, химийн хорт болон аюултай бодисын аюулгүй байдлыг хангах бодлогод нийцэхгүй байна гэж үзвэл хүчингүй болгох, зогсоох санал, дүгнэлтээ зохих байгууллагад гаргах;

4.2.3. химийн хорт болон аюултай бодистой холбоотой үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлаар иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас шаардлагатай мэдээлэл, тайлан, судалгаа, баримт материалыг үнэ төлбөргүйгээр гаргуулан авах.

4.3. Үндэсний зөвлөлийн шинжээчдийн баг дараахь үүрэгтэй байна:

4.3.1. химийн хорт болон аюултай бодисоос хамгаалах, түүнийг ашиглахтай холбогдсон үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, санал, дүгнэлт гаргах;

4.3.2. химийн хорт болон аюултай бодисыг импортлох, экспортлох, хил дамжуулан тээвэрлэх, үйлдвэрлэх, ашиглах, худалдах, хадгалах, тээвэрлэх, устгах үйл ажиллагааг зохицуулахтай холбогдсон дүрэм, журам, зааврын төслийг хэлэлцэж санал, зөвлөмж гаргах;

4.3.3. Монгол Улсад хэрэглэхийг хориглосон болон хязгаарласан химийн хорт болон аюултай бодисын жагсаалтыг шинэчлэх санал боловсруулах;

4.3.4. химийн хорт болон аюултай бодистой харьцаж ажиллагсдын мэдлэг, дадлага, иргэдийн химийн хорт болон аюултай бодисын талаархи мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор сургалт, суртчилгаа зохион байгуулах.

4.4. Үндэсний зөвлөлийн шинжээчдийн баг дараахь эрхтэй байна:

4.4.1. химийн хорт болон аюултай бодисыг экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх, үйлдвэрлэх, худалдах, ашиглах, устгах зөвшөөрөл авах хүсэлт гаргасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад дүгнэлт гаргаж өгөх;

4.4.2. химийн хорт болон аюултай бодисын ашиглалта д шалгалт, тооллого хийх, ажлын зураг авах, шинжилгээнд сорьц, дээж авах зорилгоор аж ахуйн нэгж, байгууллагад чөлөөтэй нэвтрэх;

4.4.3. санал, дүгнэлт гаргахад шаардлагатай лабораторийн шинжилгээг дотоод, гадаадын лабораторид хийлгэх.

Тав. Төрийн захиргааны холбогдох төв байгууллага болон аймаг, нийслэлийн салбар зөвлөлийн бүрэн эрх

5.1. Төрийн захиргааны холбогдох төв байгууллага болон аймаг, нийслэлийн салбар зөвлөл дараахь үүргийг хэрэгжүүлнэ:

5.1.1. тухайн салбар, орон нутгийн хэмжээнд энэ журмын 4.1.1-д заасан үүргийг хэрэгжүүлэх;

5.1.2. Монгол Улсын нэгдэн орсон химийн бодисын талаархи олон улсын гэрээ болон үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг тухайн салбар, нутаг дэвсгэрийн хэмжээнд удирдлага, зохион байгуулалтаар

хангаж, биелэлтэд хяналт тавих;

5.1.3. химийн хорт болон аюултай бодисыг импортлох, экспортлох, хил дамжуулан тээвэрлэх, үйлдвэрлэх, ашиглах, худалдах, хадгалах, тээвэрлэх, устгах үйл ажиллагаатай холбоотойгоор үүссэн зөрчил, маргааныг шийдвэрлэхэд мэргэжлийн зөвлөмж, дүгнэлт гаргах, шаардлагатай тохиолдолд Үндэсний зөвлөлд мэдэгдэх.

5.2. Төрийн захиргааны холбогдох төв байгууллага болон аймаг, нийслэлийн салбар зөвлөл энэ дүрмийн 4.2, 4.4.2, 4.4.3 дахь заалтад заасан эрхийг хэрэгжүүлнэ.

У. ЖУРАМ

ХИМИЙН ХОРТ БОЛОН АЮУЛТАЙ БОДИС ЭКСПОРТЛОХ, ИМПОРТЛОХ, ХИЛ ДАМЖУУЛАН ТЭЭВЭРЛЭХ БОЛОН ҮЙЛДВЭРЛЭХ, ХУДАЛДАХ ЖУРАМ

(Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Гадаад харилцааны сайдын
2009 оны 11 дүгээр сарын 16 -ны өдрийн 334/104 дүгээр
хамтарсан тушаал)

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. “Химийн хорт болон аюултай бодисын тухай” Монгол Улсын хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх заалт, 8,9,11,15,18 дугаар зүйлд заасан химийн хорт болон аюултай бодисыг экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх, үйлдвэрлэх, худалдахтай холбогдсон үйл ажиллагааг зохицуулахад энэхүү журмыг мөрдөнө.

1.2. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад химийн хорт болон аюултай бодисыг экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх, үйлдвэрлэх, худалдах зөвшөөрөл /цаашид зөвшөөрөл гэх/ олгох, тэдгээрт тавих шаардлага болон экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх, үйлдвэрлэх, худалдах үед химийн хорт болон аюултай бодисоос хамгаалах эрх зүйн хэм хэмжээг тогтоон зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

1.3. Озон задладаг бодисыг импортлох, худалдах, ашиглахтай холбогдсон үйл ажиллагааг Засгийн газрын “Озон задладаг бодисыг импортлох, ашиглах зөвшөөрөл олгох журам”-аар зохицуулна.

Хоёр. Химийн хорт болон аюултай бодисыг экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх, үйлдвэрлэх, худалдах зөвшөөрөл олгох

2.1. Ерөнхий зүйл

2.1.1. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага аж ахуйн нэгж, байгууллагын албан ёсны хүсэлт, иргэний өргөдлийг үндэслэн дараахь зөвшөөрлийг олгоно:

2.1.1.1. химийн хорт болон аюултай бодисыг экспортлох, импортлох,

хил дамжуулан тээвэрлэх, үйлдвэрлэх;

2.1.1.2. химийн хорт болон аюултай бодис импортлох, үйлдвэрлэх зөвшөөрөл бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллага импортлосон болон үйлдвэрлэсэн бодисоо дотоодын хэрэглэгчдэд худалдах;

2.1.1.3. химийн хорт болон аюултай бодис экспортлох, ашиглах зөвшөөрөл бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллага тодорхой шалтгааны улмаас тухайн зорилгоор ашиглахгүй болсон илүүдэл бодисыг худалдах.

2.1.2. Зөвшөөрөл авахыг хүссэн иргэн өргөдлөөр, аж ахуйн нэгж, байгууллага албан бичгээр хүсэлт гаргах бөгөөд үүндээ зөвшөөрөл хүссэн бодисын олон улсын болон монгол нэршил, химийн томъёо, олон улсын бүртгэлийн дугаар (CAS number), зөвшөөрөл хүссэн тоо хэмжээ, улсын хилээр нэвтрүүлэх боомт зэргийг тодорхой тусгасан байна.

2.1.3. Зөвшөөрөл авахыг хүссэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь Химийн хорт болон аюултай бодисоос хамгаалах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д заасан мэдээллээс гадна дараахь мэдээллийг агуулсан баримт бичгийг хавсаргасан байна:

2.1.3.1. аж ахуйн нэгжийн хувьд улсын бүртгэлийн гэрчилгээний, иргэний хувьд иргэний үнэмлэхийн нотриатаар баталгаажуулсан хуулбар;

2.1.3.2. тухайн бодисын дагалдах сертификат (англи, монгол, орос хэлийн аль нэг дээр)

2.1.3.3. үйлдвэрлэгч эсвэл албан ёсны борлуулагчаас тухайн химийн бодисыг дагалдуулан өгсөн англи эсвэл орос хэл дээрх хор, аюулын лавлах мэдээлэл, түүний монгол хэл дээрх албан ёсны орчуулга;

2.1.3.4. тухайн бодисыг гадаад болон дотооддоо тээвэрлэх байгууллагатай хийсэн гэрээ болон түүнтэй адилтгах баримт бичгийн хуулбар;

2.1.3.5. Зөвхөн шинжилгээ, судалгааны зориулалтаар ашиглагдах “Монгол улсад ашиглахыг хориглосон химийн хорт болон аюултай бодисын жагсаалт”-д орсон стандарт уусмал, бодис болон “Монгол улсад ашиглахыг хязгаарласан химийн хорт болон аюултай бодисын жагсаалт”-д орсон химийн бодисын хувьд Химийн хорт болон аюултай бодисын бодлого зохицуулалтын асуудал эрхэлсэн Үндэсний зөвлөлийн Шинжээчдийн багийн дүгнэлт;

2.1.3.6. Пестицидын хувьд хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас олгосон пестицид ашиглах, худалдах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл;

2.1.3.7. Ариутгал, халдваргүйтлийн бодисын хувьд эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас олгосон ариутгал, халдваргүйтлийн бодис ашиглах, худалдах үйл ажиллагаа

эрхлэх зөвшөөрөл.

2.1.4. Доорхи төрлийн химийн бодис, химийн бодис агуулсан бүтээгдэхүүнийг экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх, худалдахад энэхүү журам хамаарахгүй. Үүнд:

2.1.4.1. Судалгаа, шинжилгээний зориулалтаар ашиглах 1 литр эсвэл 1 кг-аас бага хэмжээтэй, “Монгол улсад ашиглахыг хориглосон химийн хорт болон аюултай бодисын жагсаалт” болон “Монгол улсад ашиглахыг хязгаарласан химийн хорт болон аюултай бодисын жагсаалт”-д ороогүй бодис, урвалжууд;

2.1.4.2. Барилгын будаг, цавуу;

2.1.4.3. Төрөл бүрийн савлагаатай галын хор;

2.1.4.4. Барилгын бүтээц, шугам хоолой, дулаалгын материал үйлдвэрлэх зориулалттай полимер түүхий эд;

2.1.4.5. Шахсан хий бүхий ахуйн зориулалттай асаагуур;

2.1.4.6. Жижиглэн борлуулах зориулалтаар савлагдсан ахуйн зориулалттай 500 мл, эсхүл 500 граммаас бага хэмжээтэй уусгагч, хэвлэлийн хор, фото зургийн хор;

2.1.4.7...Жижиглэн борлуулах зориулалтаар савлагдсан тээврийн хэрэгслэлийн тос, тосолгооны материал, шингэн;

2.1.4.8. Шохойн чулуу, боловсруулсан шохой, гипс, каолин, бентонит, кварц зэрэг боловсруулсан болон боловсруулаагүй эрдсүүд;

2.1.4.9. Бензин, дизель түлш, керосин;

2.1.4.10. Шингэрүүлсэн хийн түлш;

2.1.4.11. Жижиглэн борлуулах зориулалтаар савласан ахуйн болон гоо сайхны химийн бодис, шингэнүүд.

2.2. Экспортлох зөвшөөрөл олгох

2.2.1. Химийн хорт болон аюултай бодис экспортлох зөвшөөрөл авахыг хүссэн иргэн, аж ахуйн нэгж байгууллага энэ журмын 2.1.3-т зааснаас гадна дараахь материалыг нэмж бүрдүүлсэн байна:

2.2.1.1. тухайн бодисыг олон улсын хэмжээнд болон хоёр талын хооронд худалдаалж болох эрх зүйн үндэслэл, хортой, аюултай бүтээгдэхүүнийг хил дамжуулан тээвэрлэх олон улсын конвенци, гэрээ, хэлэлцээрийн шаардлагыг хангасан тухай танилцуулга;

2.2.1.2 нийлүүлэгч, хүлээн авагч, тээвэрлэгч талуудын хооронд хийсэн гэрээ, хэлэлцээрийн эх хувь, түүний монгол хэл дээрх албан ёсны

орчуулга болон бусад шаардлагатай бичиг баримт.

2.3. Импортлох зөвшөөрөл олгох

2.3.1. Химийн хорт болон аюултай бодис импортлох зөвшөөрөл авахыг хүссэн иргэн, аж ахуйн нэгж байгууллага энэ журмын 2.1.3-т заасан материалыг бүрдүүлэхээс гадна нийлүүлэгч талтай хийсэн гэрээ хэлэлцээрийн эх хувь, түүний англи, орос эсвэл монгол хэл дээрх албан ёсны орчуулгыг хавсаргана.

2.4. Хил дамжуулан тээвэрлэх зөвшөөрөл олгох

2.4.1. Химийн хорт болон аюултай бодис хил дамжуулан тээвэрлэх зөвшөөрөл авахыг хүссэн иргэн, аж ахуйн нэгж байгууллага энэ журмын 2.1.3-г заасан материалаас гадна нийлүүлэгч-хүлээн авагч-Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх асуудлыг хариуцсан этгээдийн хооронд эсхүл нийлүүлэгч-дамжин өнгөрүүлэгч, хүлээн авагч-дамжин өнгөрүүлэгчийн хооронд хийсэн гэрээ хэлэлцээрийн эх хувь болон түүний монгол, англи хэл дээрх албан ёсны орчуулгыг хавсаргана.

2.5. Үйлдвэрлэх зөвшөөрөл олгох

2.5.1. Химийн хорт болон аюултай бодис үйлдвэрлэх зөвшөөрөл авахыг хүссэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллага энэ журмын 2.1.3-г зааснаас гадна дараах материалыг нэмж бүрдүүлсэн байна:

2.5.1.1. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар баталгаажсан, химийн хорт болон аюултай бодисын эрсдлийн үнэлгээ бүхий “Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайлан”;

2.5.1.2. Үйлдвэрлэл эхлэхийг зөвшөөрсөн эрх бүхий байгууллагын зөвшөөрөл, хүлээн авсан улсын комиссын акт, дүгнэлтийн хуулбар;

2.5.1.3. Үйлдвэрлэх химийн бодисын хор, аюулын лавлах мэдээллийг боловсруулж, Химийн хорт болон аюултай бодисын бодлого зохицуулалтын асуудал эрхэлсэн Үндэсний зөвлөлөөр дүгнэлт гаргуулсан байна.

2.6. Худалдах зөвшөөрөл олгох

2.6.1. Химийн хорт болон аюултай бодис худалдах зөвшөөрөл авахыг

хүссэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллага энэ журмын 2.1.3-т заасан материалаас гадна химийн бодисыг хадгалах, худалдах үйл ажиллагаа явуулах агуулахын байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар баталгаажсан химийн хорт болон аюултай бодисын эрсдийн үнэлгээ бүхий “Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайлан”-г хавсаргасан байна.

Гурав. Химийн хорт болон аюултай бодисыг экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх, үйлдвэрлэх, худалдах зөвшөөрөл бүхий иргэн, аж ахуйн нэгж байгууллагад тавих шаардлага

3.1. Ерөнхий зүйл

3.1.1. Химийн хорт болон аюултай бодисыг экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх, үйлдвэрлэх, худалдах зөвшөөрөл бүхий иргэн, аж ахуйн нэгж байгууллага дараах шаардлагыг биелүүлнэ. Үүнд:

3.1.1.1. Химийн хорт ба аюултай бодис нь зориулалтын сав, баглаа боодол, стандартын шаардлага хангасан англи, орос, монгол хэл дээр үйлдэгдсэн хаяг, шошготой байна.

3.1.1.2. Химийн хорт ба аюултай бодисыг анхааруулах тэмдэг бүхий зориулалтын тээврийн хэрэгслэлээр тээвэрлэх бөгөөд тээвэрлэх, ачих, буулгах үеийн аюулгүй ажиллагааг химийн бодис импортлох, экспортлох, хил дамжуулан тээвэрлэх, худалдах үйл ажиллагаа эрхлэгч хариуцна.

3.1.1.3. Химийн хорт болон аюултай бодисыг экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх үйл ажиллагаа эрхлэгч нь тээвэрлэгч байгууллагатай гэрээ байгуулахдаа тухайн бодисын монгол хэл дээрх хор, аюулгүй байдлын лавлах мэдээлэл, аюулгүй ажиллагааны зааварчлага, болзошгүй ослын үед ажиллах төлөвлөгөө, тээвэрлэх маршрут зэргийг танилцуулж гарын үсэг зуруулна.

3.1.1.4. химийн хорт болон аюултай бодисыг экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх үйл ажиллагаа эрхлэгч нь энэ талаар гарсан олон улсын гэрээ, хэлэлцээрийг биелүүлэх үүрэгтэй бөгөөд тээвэрлэлт, ачилт, буулгалтын үед гарч болох осол, эрсдлээс урьдчилан сэргийлэх, осол, алдагдал гарсан тохиолдолд хор, аюулыг бууруулах арга хэмжээ авах нөхцлийг бүрдүүлсэн байна.

3.1.1.5. зөвшөөрөл бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь экспортлосон, импортлосон, хил дамжуулан тээвэрлэсэн, үйлдвэрлэсэн, худалдсан химийн хорт болон аюултай бодис бүрээр нийлүүлэлт,

зарцуулалтын хөдөлгөөний тухайн жилийн тайлан гаргаж, дараа жилийн 1 дүгээр сарын 25-ны дотор байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

3.2. Экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх үйл ажиллагаа эрхлэгчид тавих шаардлага

3.2.1. Химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх зөвшөөрөл бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллага энэ журмын 3.1-д заасан шаардлагыг биелүүлнэ.

3.3. Үйлдвэрлэгчид тавих шаардлага

3.3.1. Химийн хорт болон аюултай бодис үйлдвэрлэх зөвшөөрөл бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллага энэ журмын 3.1-т зааснаас гадна дараах шаардлагыг биелүүлнэ:

3.3.1.1. Химийн хорт болон аюултай бодис үйлдвэрлэгч нь эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны шаардлага хангасан байранд, технологийн горимыг нарийн чанд баримтлан ажиллана.

3.3.1.2. Үйлдвэрлэгч нь орчиндоо болон ажлын байранд зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтэрсэн бодис бүхий хорт хий, хог хаягдал гаргахгүй байх үүрэг хүлээх ба гаргасан тохиолдолд түүнийг бууруулах, саармагжуулах, байгаль орчинд халгүй аргаар устгах арга хэмжээг өөрийн хөрөнгөөр авч хэрэгжүүлнэ.

3.3.1.3. Үйлдвэрлэгч нь бүтээгдэхүүнээ борлуулахдаа тухайн бодисын хор, аюулгүй байдлын лавлах мэдээллийг заавал дагалдуулан өгнө.

3.4. Худалдахад тавих шаардлага

3.4.1. Химийн хорт болон аюултай бодис худалдах зөвшөөрөл бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллага энэ журмын 3.1-т зааснаас гадна дараах шаардлагыг биелүүлнэ:

3.4.1.1. химийн хорт болон аюултай бодис ашиглах зөвшөөрөлгүй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад химийн хорт болон аюултай бодисыг худалдахыг хориглоно.

3.4.1.2. химийн хорт болон аюултай бодисыг худалдахдаа худалдан авсан этгээдийн хаяг, бодисын нэр төрөл, хэмжээ, ашиглах зориулалтыг заасан баримтыг 2 хувь үйлдэн баталгаажуулж, нэг хувийг худалдан авагчид,

үлдсэн хувийг өөртөө хадгална.

3.4.1.3. Химийн хорт болон аюултай бодисыг худалдахдаа худалдан авагчид тухайн бодисын хор, аюулгүй ажиллагааны лавлах мэдээллийг заавал дагалдуулан өгнө.

3.4.1.4. Химийн хорт болон аюултай бодисыг жижиглэн худалдахдаа зориулалтын, тодорхой хаяг шошго бүхий саванд савласан байна.

* * * *

ХИМИЙН ХОРТ БОЛОН АЮУЛТАЙ БОДИС ХАДГАЛАХ, ТЭЭВЭРЛЭХ, АШИГЛАХ, УСТГАХ ЖУРАМ

(Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайд, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2009 оны 02 сарын 03-ны өдрийн 28/40/29 дүгээр хамтарсан тушаал)

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь “Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль”-ийн 6 дугаар зүйлийн 6.1.2 заалтын дагуу химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах харилцааг зохицуулахад оршино.

1.2. “Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль”-ийн 6.1.3, 6.1.7, 6.1.8 дахь заалт, 8, 10, 12, 13, 14 дүгээр зүйлд заасан химийн хорт болон аюултай бодисыг хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгахтай холбогдсон үйл ажиллагааг зохицуулахад энэхүү журмыг мөрдөнө.

1.3. Химийн бодисын олон улсын болон үндэсний ангилалд ороогүй химийн бүтээгдэхүүн, химийн материалыг хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах үйл ажиллагаа энэ журамд хамаарахгүй.

Хоёр. Химийн хорт болон аюултай бодисыг ашиглах,
устгах зөвшөөрөл олгох

2.1. Ерөнхий зүйл

2.1.1. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас тавьсан албан ёсны хүсэлттийг үндэслэн хорт болон аюултай химийн бодисыг ашиглах, устгах зөвшөөрлийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгоно.

2.1.2. Зөвшөөрөл авах тухай хүсэлтийг бичгээр гаргах бөгөөд тухайн химийн бодисын дагалдах сертификат, хор аюулын лавлах мэдээллийг (мөнгөл хэл дээр) хавсаргана.

2.2. Химийн хорт болон аюултай бодисыг ашиглах зөвшөөрөл олгох

2.2.1 Химийн хорт болон аюултай бодис ашиглах зөвшөөрөл авах тухай хүсэлт гаргасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь энэхүү журмын 2.1.2-г зааснаас гадна дараах материалыг хавсаргана:

2.2.1.1. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар баталгаажсан Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайлангийн баталгаат хэсэг болон уг тайлангийн “химийн бодисын эрсдлийн үнэлгээ” бүлгийн хуулбар;

2.2.1.2. “Монгол улсад ашиглахыг хязгаарласан химийн хорт болон аюултай бодис”-ын жагсаалтад орсон бодисын хувьд Химийн хорт болон аюултай бодисын бодлого зохицуулалтын асуудал эрхэлсэн үндэсний зөвлөлийн Шинжээчдийн багийн дүгнэлт.

2.2.2 Химийн бодисыг тээвэрлэх гэрээ, түүнтэй адилтгах баримт бичгийн хуулбар.

2.3. Химийн хорт болон аюултай бодисыг устгах зөвшөөрөл олгох

2.3.1. Химийн хорт болон аюултай бодис устгах зөвшөөрөл авах тухай хүсэлт гаргасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь энэхүү журмын 2.1.2-г зааснаас гадна дараах материалыг хавсаргасан байна:

2.3.1.1. устгах зөвшөөрөл хүссэн химийн хорт болон аюултай бодис, тэдгээрийн хаягдлын нэр төрөл, тоо хэмжээ, устгах болсон шалтгааныг тусгасан албан ёсны хүсэлт;

2.3.1.2. хэрэв устгах химийн хорт болон аюултай бодисын нэр төрөл нь тодорхой бус байвал түүний найрлага, бүтцийг тогтоосон улсын итгэмжлэгдсэн лабораторийн дүгнэлт.

2.3.1.3. химийн хорт болон аюултай бодис устгах аргачлал, устгах цэгийн талаар гаргасан Химийн хорт болон аюултай бодисын бодлого зохицуулалтын асуудал эрхэлсэн үндэсний зөвлөлийн Шинжээчдийн багийн дүгнэлт.

2.3.1.4. Химийн хорт болон аюултай бодисын эзэнгүй хог, хаягдал, химийн хорт болон аюултай бодистой холбоотой осол, түүнчлэн хүний эрүүл мэнд, мал, эд хөрөнгө, байгаль орчныг хордуулж, алан хядах, хорлон сүйтгэх зорилгоор санаатайгаар хэрэглэсэн химийн хорт болон аюултай бодисыг устгахдаа онцгой байдлын асуудал хариуцсан байгууллагын гаргасан саналын дагуу Химийн хорт болон аюултай бодисын асуудал эрхэлсэн үндэсний зөвлөлийн шинжээчдийн багийн дүгнэлтийг үндэслэнэ.

Гурав. Химийн хорт болон аюултай бодисыг хадгалах, тээвэрлэх,

ашиглах, устгахад тавих шаардлага

3.1. Ерөнхий зүйл

3.1.1. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь химийн хорт болон аюултай бодисыг хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах үйл ажиллагаа явуулахдаа “Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль”- ийн 8, 10, 12, 13, 14, 17 дугаар зүйлд зааснаас гадна дараах шаардлагыг биелүүлнэ:

3.1.1.1. химийн хорт болон аюултай бодис нь зориулалтын сав, баглаа боодол, стандартын шаардлага хангасан хаяг, шошготой байна;

3.1.1.2. үйлдвэрлэгчээс гаргасан хор аюулын лавлах мэдээллийг үндэслэн бодис нэг бүрээр боловсруулсан аюулгүй ажиллагааны зааварчилгааг байгаль орчны болон гамшгаас урьдчилан сэргийлэх хяналтын улсын байцаагчаар хянуулж, өөрийн байгууллагын даргаар баталгаажуулсан байна;

3.1.1.3. химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах үйл ажиллагаатай холбоотойгоор гарч болзошгүй ослын үед ажиллах төлөвлөгөө боловсруулж, аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар, хэлтсээр батлуулсан байна;

3.1.1.4. химийн хорт болон аюултай бодистой харьцаж ажиллагсдыг сургалтанд (бодис бүрийн хор аюулын лавлах мэдээлэл, аюулгүй ажиллагааны зааварчилгаа, болзошгүй ослын үед ажиллах төлөвлөгөө гэх мэт) хамруулж, гарын үсэг зуруулсны дараа ажиллуулах ба сургалтанд хамрагдаагүй тохиолдолд химийн бодистой харьцаж ажиллахыг хориглоно;

3.1.1.5. болзошгүй аюул, ослын үед ашиглах зориулалтын, бүрэн ажиллагаатай гал унтраах анхан шатны багаж, хэрэгсэл, хор саармагжуулах бодис, уусмалыг ажлын байранд байрлуулах ба химийн бодистой харьцаж ажиллагсдыг арьс, нүд болон амьсгал хамгаалах зориулалт бүхий, стандартын шаардлага хангасан хүн нэг бүрийн хамгаалалтын хэрэгслэлээр хангасан байна;

3.1.1.6. Энэхүү журмын 1 дүгээр хүснэгтийн А баганад хамаарагдах химийн бодисыг Б баганад хамаарах химийн бодистой хамт хадгалах, тээвэрлэхийг хориглоно;

Журмын 1 дүгээр хүснэгт

Хамт хадгалах, тээвэрлэхийг хориглосон химийн бодис:

А багана	Б багана
Азидууд	Хүчлүүд, хүнд металлууд ба түүний давсууд, исэлдүүлэгчид
Азотын хүчил / концентрацитай/	Цууны хүчил, ацетон, спирт, анилин, хромын хүчил, гидроцианын хүчил, хүхэрт устөрөгч, шатамхай шингэнүүд, шатамхай хийнүүд, зэс, гууль, бүх хүнд металлууд
Аммони /усгүй/	Мөнгөн ус, галогенүүд, кальцийн гипохлорид, хайлууруу хүчил
Аммонийн нитрат	Хүчлүүд, металлын нунтагууд, шатамхай шингэнүүд, хлоридууд, нитритүүд, хүхэр, нарийн жижиглэсэн органик ба шатамхай материалууд
Анилин	Азотын хүчил, устөрөгчийн хэт исэл
Ацетон	Концентрацитай азотын ба хүхрийн хүчлийн хольцууд, устөрөгчийн хэт исэл
Ацетилен	Хлор, бром, зэс, фтор, мөнгө, мөнгөн ус
Гидрид	Ус
Гипохлоридууд	Хүчлүүд, идэвхижүүлсэн нүүрс
Дөрвөн хлорт нүүрстөрөгч	Натри
Идэвхижүүлсэн нүүрс	Бүх исэлдүүлэгчид, кальцийн гипохлорид
Иод	Ацетилен, аммони /шингэн ба усгүй/, устөрөгч
Кальцийн оксид	Ус
Хүнцэл агуулсан материалууд	Бүх ангижруулагчид
Хлоратууд	Аммонийн давсууд, хүчлүүд, металлын нунтагууд, хүхэр, нарийн жижиглэсэн органик ба шатамхай материалууд
Хлорын давхар исэл	Аммони, метан, фосфин, хүхэрт устөрөгч
Хромын хүчил ба хромын гуравч исэл	Цууны хүчил, спирт, камфор, глицерин, нафтаген, шатамхай шингэнүүд
Зэс	Ацетилен, устөрөгчийн хэт исэл
Кали	Дөрвөн хлорт нүүрстөрөгч, нүүрстөрөгчийн давхар исэл, ус
Калийн хлорид	Хүхрийн болон бусад хүчлүүд, аммонийн давсууд, металлын нунтагууд, хүхэр, нарийн жижиглэсэн органик нэгдлүүд ба шатамхай материалууд
Калийн перхлорат / хлоратуудыг үз/	Хүхрийн болон бусад хүчлүүд
Калийн перманганат	Глицерин, этилен гликоль, бензальдегид, хүхрийн хүчил

Кумин устөрөгчийн хэт исэл	Хүчлүүд /органик ба органик бус/
Металл устөрөгчид	Хүчлүүд, ус
Мөнгөн ус	Ацетилен, тэсрэмтгий хүчил, аммони
Мөнгө ба түүний давсууд	Ацетилен, хурган чихний хүчил, дарсны хүчил, аммонийн нэгдлүүд, тэсрэмтгий хүчил
Натри	4 хлорт нүүрстөрөгч, нүүрсхүчлийн хий, бусад хлорт нүүрсустөрөгчид, ус
Натрийн нитрат	Аммонийн нитрат, бусад аммонийн давсууд
Натрийн хэт исэл	Этилийн ба метилийн спирт, мөсөн цууны хүчил, цууны ангидрид, бензальдегид, нүүрстөрөгчийн дисульфид глицерин, этилен гликоль, этил ацетат, метил ацетат, фурфурол
Нитратууд	Хүчлүүд
Нитритүүд	Хүчлүүд
Нитропарафинууд	Органик бус сууриуд, аминууд
Нүүрсустөрөгч /бутан, пропан, бензол гэх мэт/	Фтор, хлор, бром, хромын хүчил, хэт ислүүд
Органик хэт ислүүд	Хүчлүүд /органик ба эрдсийн/, үрэлт үүсэхээс зайлсхийх, хүйтэн газар хадгалах
Перхлорын хүчил	Цууны ангидрид, спирт, висмут, цаас, мод, өөх, тос
Перманганатууд	Концентрацитай хүхрийн хүчил, глицерол, этилен гликоль, бензальдегид
Сульфидүүд	Хүчлүүд
Устөрөгчийн хэт исэл	Зэс, хром, төмөр, ихэнх металл ба түүний давсууд, бүх шатамхай шингэн /спирт, ацетон гэм мэт/, шатамхай, материалууд, анилин, нитрометан
Фтор	Бүх химийн бодис
Фторт устөрөгчийн хүчил, усгүй /хайлуур хүчил/	Аммони /шингэн ба усгүй/
Хурган чихний хүчил	Мөнгөн ус ба мөнгө, тэдгээрийн давсууд
Хүхэрт устөрөгч	Дэгдэмхий азотын хүчил, исэлдүүлэгч хийнүүд
Хүчилтөрөгч	Тос, өөх тос, устөрөгч, шатамхай шингэн, шатамхай хатуу бодис, шатамхай хий
Хүхрийн хүчил	Хлоратууд, перхлоратууд, перманганатууд
Цагаан фосфор	Агаар, хүчилтөрөгч, шүлтүүд, ангижруулагчид
Цианидууд	Хүчлүүд
Цианын хүчил	Азотын хүчил, шүлтүүд
Цууны хүчил	Хромын хүчил, азотын хүчил, гидроксил нэгдлүүд, этилен гликол, перхлорын хүчил, хэт ислүүд, перманганатууд
Цууны ангидрид	Этилен гликоль гэх мэт гидрокселийн бүлэг агуулсан нэгдлүүд, перхлорын хүчил

Шатамхай шингэн	Аммонийн нитрат, хромын хүчил, устөрөгчийн хэт исэл, азотын хүчил, натрийн хэт исэл, галогенууд, бусад исэлдүүлэгч нэгдлүүд
Шүлт ба газрын шүлтийн металлууд / магни, натри, калийн нунтгууд гэх мэт/	Ус, дөрвөн хлорт нүүрстөрөгч, хлорт нүүрс устөрөгчид, нүүрсхүчлийн хий, галогенүүд
Дээр заагдаагүй бүлэг, шинэ төрлийн бодисын хувьд	Тухайн бодис нэг бүрийн хор, аюулын лавлахад заасан шинж чанарыг харгалзан аюулгүй байдлыг хангасан нөхцөлд тээвэрлэж, хадгална.

3.1.1.7 химийн хорт болон аюултай бодисыг ашиглах, устгах зөвшөөрөл бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь ашигласан, устгасан химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүн бүрээр жил бүр тайлан гаргаж, дараа жилийн 1 дүгээр сарын 25-ны дотор Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон сум, дүүргийн Засаг даргад тус тус хүргүүлнэ.

3.1.1.8. Химийн хорт болон аюултай бодисын эзэнгүй хог, хаягдал, химийн хорт болон аюултай бодистой холбоотой осол, түүнчлэн хүний эрүүл мэнд, мал, эд хөрөнгө, байгаль орчныг хордуулж, алан хядах, хорлон сүйтгэх зорилгоор санаатайгаар хэрэглэсэн химийн хорт болон аюултай бодисыг устгах арга хэмжээг Гамшгаас хамгаалах тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасны дагуу шуурхай бүлэг удирдан зохицуулна.

3.2. Химийн хорт болон аюултай бодисыг хадгалахад тавих шаардлага

3.2.1. Химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох, худалдах, ашиглах, үйлдвэрлэх, устгах зөвшөөрөл бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь химийн хорт болон аюултай бодисыг хадгалахдаа энэ журмын 3.1-д зааснаас гадна дараах шаардлагыг биелүүлсэн байна:

3.2.1.1. химийн хорт болон аюултай химийн бодисыг зориулалтын агуулахад, хор аюулын лавлах мэдээлэлд заасан нөхцөлд хадгална;

3.2.1.2. химийн хорт болон аюултай бодисын агуулахыг хүн ам оршин суугаа газраас 300-аас доошгүй метрийн зайд, үер усанд автахааргүй байрлалд байрлуулах ба агуулах нь галд тэсвэршилтийн зэргийг хангахуйц материал, хийцтэй, болзошгүй ослын үед хөрсөнд болон гадагш бодис алдагдахааргүй шал (цементэн болон плитан), бат бэх хамгаалалт бүхий цонх, хаалга, үерийн далан, хамгаалалтын сувагтай байна.

3.2.1.3. хорт болон аюултай химийн бодисыг шинж чанар, үзүүлэх хор нөлөөллөөс нь хамаарч энэ журмын 2 дугаар хүснэгтэд заасан нөхцлийн дагуу тусгаарлан хадгална.

Журмын 2 дугаар хүснэгт

Хорт болон аюултай химийн бодисыг шинж чанар, үзүүлэх хор нөлөөллөөр тусгаарлан хадгалах нөхцөл:

Х и м и й н бодисын төрөл	Хадгалах нөхцөл	Жишээ	Хамтад нь х а д г а л а х ы г хориглосон бодис
Шатамхай шахсан хий	Сэрүүн, хуурай газар исэлдүүлэгч хийнүүдээс тусад нь хадгална. Аюулгүйн үүднээс хий агуулсан савнуудыг хана эсвэл тавиуртай уяж бэхэлнэ	Устөрөгч, метан, ацетилен, пропан	Исэлдүүлэгч ба хортой шахсан хий, исэлдүүлэгч хатуу бодисууд
Исэлдүүлэгч шахсан хий	Сэрүүн, хуурай газар шатамхай хийнүүдээс тусад нь хадгална. Аюулгүйн үүднээс хий агуулсан савнуудыг хана эсвэл тавиуртай уяж бэхэлнэ	Хүчилтөрөгч, хлор, бром	Шатамхай хийнүүд
Хортой шахсан хий	Сэрүүн, хуурай газар шатамхай хий ба шингэнүүдээс тусад нь хадгална. Аюулгүйн үүднээс хий агуулсан савнуудыг хана эсвэл тавиуртай уяж бэхэлнэ	Нүүрстөрөгчийн дан исэл, хүхэрт устөрөгч, азотын давхар исэл	Шатамхай хийнүүд, исэлдүүлэгч хийнүүд
Идэмхий хүчлүүд	Хүчилд тэсвэртэй материалаар доторлогдсон агуулахад (өрөөнд) хадгална. Исэлдүүлэгч хүчлүүдийг (хром, азот, хүхэр, перхлорын хүчлүүд) органик хүчлүүдээс тусад нь хадгална	Цууны хүчил, фенол, хүхрийн хүчил, хромпик, азотын хүчил, перхлорын хүчил, хромын хүчил, давсны хүчил	Шатамхай шингэн, шатамхай хатуу бодис, суурь, исэлдүүлэгч

Идэмхий гидроксид-дууд	Идэмхий бодист тэсвэртэй материалаар доторлогдсон агуулахад (өрөөнд) хадгална. Органик бус гидроксидуудыг хаяг шошготой, полиэтиленин саванд хадгална	Аммонийн гидроксид, натрийн гидроксид, кальцийн гидроксид	Шатамхай шингэнүүд, исэлдүүлэгч, хүчлүүд
Шатамхай шингэ-нүүд	Галд тэсвэртэй материалаар баригдсан агуулахад (өрөөнд) галын эх үүсвэрээс хол хадгална. Онцгой шатамхай шингэнүүдийг тэсрэлт даах баг бөх хөргөгчид хадгална.	Ацетон, бензол, диэтилийн эфир, метанол, этанол, толуол, мөсөн цууны хүчил	Хүчлүүд, гидроксидууд, исэлдүүлэгчид, хортой бодисууд
Шатамхай хатуу бодис	Сэрүүн, хуурай газар исэлдүүлэгч, идэмхий, шатамхай шингэнүүдээс тусад нь хадгална	Фосфор (шар), кальцийн карбид, пикринийн хүчил, бензолын хэт исэл	Хүчлүүд, гидроксидууд, исэлдүүлэгчид, хортой бодисууд
Ердийн химийн бодисууд (урвалын идэвхитэй биш)	Ердийн агуулахад хадгална.	Агар, натри хлорид, натрийн бикарбонат, ихэнх урвалын идэвхигүй давсууд	Онцлог шаард- лагуудыг хор аюулын лавлах мэдээллээс хар
Исэлдүү- лэгчид	Химийн бодисын агуулахад ил задгай асгарахаас болгоомжил. Өөрөө шатамхай ба шатамхай бодис, материалаас тусад нь хадгална.	Аммонийн персуль-фат, төмрийн хлорид, иод, натрийн гипохлорид, бензолийн хэт исэл , калийн перманганат, калийн дихромат (исэлдүү- лэгчдэд хэт ислүүд, перхлоратууд, хлоратууд, нитратууд, броматууд, супероксидууд орно)	Ангижруулаг-чид болон шатамхай бодисуудаас тусад нь хадгална

Хортой химийн бодисууд	Агааржуулалтай, сэрүүн, хуурай агуулахад хадгална. Тухайн химийн бодист тэсвэртэй, хагарч эвдэрдэггүй саванд давхар савлагдсан байвал зохино	Анилин, 4 хлорт нүүрс-төрөгч, хлорформ, цианидууд, хүнд металлын нэгдлүүд (кадьми, мөнгөн ус, осми гэх мэт), хурган чихний хүчил, фенол, шоргоолжны хүчил	Шагамхай шингэнүүд, хүчлүүд, гидроксидууд ба исэлдүүлэгчид Хор аюулын лавлах мэдээллийг үз
Устай хүчтэй урвалд ордог бодисууд	Хуурай, сэрүүн орчинд, уснаас хол хадгална.	Металл натри, металл кали, металл лити, лити хөнгөн цагааны гидрид	Бүх усан уусмал болон исэлдүүлэгчдээс тусад нь хадгална
Хорт хавдар үүсгэгч бодисууд	Шошгон дээр “Хавдар үүсгэнэ” гэсэн анхааруулгыг заавал бичнэ. Зөвхөн зайлшгүй шаардлагатай тохиолдолд хэрэглэх бөгөөд тухайн бодисын хор аюулын лавлах мэдээлэлд заасан нөхцөлд хадгална.	Бензидин, бета-нафтиламин, бензол, метилен хлорид, бета-пропиолактон	Хор аюулын лавлах мэдээллийг үз
Нөхөн үржлийн системд хортой бодисууд	Шошгон дээр “Нөхөн үржлийн эрхтэн болон урагт сөрөг нөлөө үзүүлнэ” гэсэн анхааруулгыг заавал бичнэ. Зөвхөн зайлшгүй шаардлагатай тохиолдолд хэрэглэх бөгөөд тухайн бодисын хор аюулын лавлах мэдээлэлд заасан нөхцөлд хадгална.	Хартугалга ба мөнгөн усны нэгдлүүд, бензол, анилин	Хор аюулын лавлах мэдээллийг үз
Хэт исэл үүсгэгч бодисууд	Агаар үл нэвтрэх саванд харанхуй, сэрүүн, хуурай орчинд хадгална.	Дизтилийн эфир, ацетальдегид, акрилонитрил	Хор аюулын лавлах мэдээллийг үз

Хүчтэй ангижруулагч бодисууд	Хуурай, сэрүүн, сайн агааржуулалттай орчинд бүх химийн бодисоос тусад нь хадгална. Устай урвалд орно	Ацетил хлорид, тионил хлорид, бөөрөлзгөний (малиновын) хүчил, төмрийн сульфид	Хор аюулын лавлах мэдээллийг үз
Дээр дурдаагүй бодисын бусад нэр төрлийн хувьд	Тухайн бодис нэг бүрийн хор, аюулын лавлах мэдээллийг заавал олж үз	Хор, мэдээллийн лавлагаанаас ямар бодисууд болохыг тодорхойлох	Хор аюулын лавлах мэдээллийг заавал үз

3.2.1.4. химийн бодисын агуулах нь хэд хэдэн хэсгээс бүрдсэн тохиолдолд тэдгээрийг хадгалах бодисын хэмжээнээс хамаарч гал тархах боломжийг хязгаарласан зайд байрлуулах ба хэсэг бүр нь дотроо хамт хадгалж болох бүлэг бодисыг тусад нь хадгалах зориулалт бүхий өөр хоорондоо битүү тусгаарлагдсан өрөө тасалгаатай байна;

3.2.1.5. химийн бодисын нэг агуулахад 500 тонноос, агуулахын доторхи нэг тасалгаанд 50 тонноос ихгүй бодис хадгална;

3.2.1.6. эрдэм шинжилгээний болон лаборатори, үйлдвэрлэлийн зориулалтаар хэрэглэх бага хэмжээний /50 кг хүртэл/ химийн хорт болон аюултай бодисыг тухайн хэрэглэгчийн байранд тусгайлан бэлдсэн өрөөнд хадгална. Өрөө нь агааржуулах төхөөрөмжтэй байх ба цэвэр, бохир усны системд холбогдсон байна;

3.2.1.7. химийн бодисыг хүний нүдний түвшингээс дээш түвшинд байрлах тавиур дээр тавихыг хориглох бөгөөд химийн бодисын тавиур нь гулсаж унахаас хамгаалсан хаалт, саадтай байна;

3.2.1.8. химийн бодисыг шалан дээр хурааж хадгалах тохиолдолд хүн явах зам гарган байрлуулах ба гарцыг хааж болохгүй;

3.2.1.9. шингэн химийн бодисыг хагардаггүй эсвэл бат бөх хагардаггүй давхар савалгаатай саванд хадгалах ба хадгалах агуулахын температур нь тухайн бодисын хадгалах нөхцөлд тохирсон байвал зохино;

3.2.1.10. дэгдэмхий эсвэл хурц үнэртэй химийн бодисыг шаардлага хангахуйц агааржуулалын системээр тоноглогдсон агуулахад хадгална;

3.2.1.11. бүх химийн бодис, ялангуяа шатамхай шингэнийг халаалтын хэрэгсэл, системээс хол, шууд нарны гэрэл тусахааргүй нөхцөлд хадгална.

3.2.1.12. химийн бодисын агуулахад асгарч гойжсон эсвэл эвдэрхий сав, баглаа боодолтой химийн бодисыг хадгалахыг хориглоно;

3.2.1.13. химийн бодисын агуулахад ил гал гаргах, чүдэнз зурахыг хориглоно;

3.2.1.14. химийн хорт болон аюултай бодисыг юүлэх, савнаас нь хэсэгчлэн авахдаа зөвхөн тусгай тоноглосон /салхивч, агааржуулалтын систем, шингэний шахуурга гэх мэт/ агуулахад гүйцэтгэнэ;

3.2.1.15. химийн бодисын агуулах нь ажиллагсдын гар угаах, усанд орох, хувцас солих нөхцлөөр хангагдсан байна;

3.2.1.16. агуулахад хадгалж буй химийн бодисын хор, аюулын шинж чанараас хамааруулан зохих анхааруулах тэмдэг, дохио үг, аюулын тухай тэмдэглэгээг агуулахын гадна болон дотор харагдахуйц байрлалд тодоор зурж, бичиж байрлуулна /Жишээлбэл: галын аюултай, хортой гэх мэтийг анхааруулсан тэмдэг, “Шатамхай шингэн”, “Хортой”, “Идэмхий” гэх мэт дохио үг/;

3.2.1.17. химийн бодисын агуулах нь гаднын хүн үл нэвтрэх хаалт, цоожтой байх ба онцгой хортой, аюултай бодис хадгалах агуулах нь зөвхөн хариуцагч этгээдийн хувийн тэмдэг бүхий лацаар битүүмжлэгдсэн байна;

3.2.1.18. агуулах нь хадгалж буй бодисын ангилал, нэр төрөл, тоо хэмжээг тусгасан байнгын бүртгэлтэй байна;

3.2.1.19. химийн бодисын агуулахад хүнсний зүйл хадгалах, хэрэглэхийг хориглоно.

3.3. Химийн хорт болон аюултай бодисыг тээвэрлэхэд тавих шаардлага

3.3.1. Химийн хорт болон аюултай бодисыг анхааруулах аюулын шинж чанарын тухай санамж байрлуулсан, техникийн болон аюулгүйн шаардлага хангасан зориулалтын буюу тухайн ачааг тээвэрлэхэд тусгайлан бэлтгэсэн тээврийн хэрэгслээр зөвхөн тогтоосон маршрутын дагуу тээвэрлэнэ.

3.3.2. Тээвэрлэх, ачих, буулгах үеийн аюулгүй ажиллагааг химийн хорт болон аюултай бодисыг тээвэрлэх, ашиглах, устгах үйл ажиллагааг гүйцэтгэгч хариуцна.

3.3.3. Химийн хорт болон аюултай бодисыг тухайн бодисын хор

аюулын лавлах мэдээлэлд заасан зааврын дагуу тээвэрлэнэ.

3.3.4. Тээвэрлэлтийн үед ачаа унах, сав баглаа боодол гэмтэх, холилдохоос урьдчилан сэргийлж тэдгээрийг зөв байрлуулж, хөдөлгөөнгүй сайтар бэхэлж ачих ба шингэн бодисын хувьд савны амыг дээш харуулан босоогоор байрлуулна.

3.3.5. Химийн хорт болон аюултай бодисын ангиллын “А” зэрэглэлийн бодисыг зөвхөн өдрийн цагаар ачиж буулгах ба энэ үед хор аюулын лавлах мэдээлэлд заасан зааврыг хатуу сахина.

3.3.6. Химийн хорт болон аюултай ачаа тээвэрлэх тээврийн хэрэгслийн хурд 25-30 км/цаг-аас хэтрэхгүй, 2 тээврийн хэрэгслийн хоорондын зай 50 метрээс багагүй байвал зохино.

3.3.7. Химийн хорт болон аюултай бодисын хайрцаг, сав нь гэмтэлтэй, тээврийн хэрэгслэл бүрэн бус, баримт бичиг зөрчилтэй, анхааруулга, тэмдэг тэмдэглээгүй байвал тээвэрлэлт хийхийг хориглоно.

3.3.8. Химийн хорт болон аюултай бодисыг тээвэрлэх тээврийн хэрэгслэлийн жолооч болон түүнийг дагалдан явах ажилтанд химийн бодис бүрийн хор аюулын лавлах мэдээлэл, аюулгүй ажиллагааны зааварчилгаа, болзошгүй ослын үед ажиллах төлөвлөгөө, тээвэрлэх маршрут зэргийг танилцуулж, гарын үсэг зуруулна.

3.3.9. Тээвэрлэх үед бодисын сав баглаа, боодлын битүүмжлэл алдагдах, ачаа нурах зэрэг зогсох шаардлага гарсан тохиолдолд уг аюултай ачааг тээвэрлэж яваа тээврийн хэрэгслээс хоёр тийш 100 м зайд “Орохыг хориглоно” тэмдгийг байрлуулна.

3.3.10. Тээвэрлэлтийн явцад болзошгүй аюул учирсан тохиолдолд хэрэглэх хор уршгийг арилгах зориулалтын багаж, хэрэгсэл /галын хор, хүрз, лоом, сүх зэрэг багаж хэрэгсэл, шуудайтай элс, хувин гэх мэт/, хор саармагжуулах бодис, уусмалаар тээврийн хэрэгсэл бүр хангагдсан байна. Тээврийн хэрэгслийн утааны янданг радиоторын тал руу байрлуулна.

3.3.11. Химийн хорт болон аюултай бодис тээвэрлэх маршрутыг аль болох хөдөлгөөн багатай, тэгш сайн байхаар сонгож, хэзээ, хаанаас тээвэрлэх талаархи мэдээллийг тухайн орон нутгийн онцгой байдлын асуудал эрхэлсэн болон замын цагдаагийн байгууллагад урьдчилан мэдэгдэж зөвшөөрөл авах ба аюулгүй байдлыг хангуулсан байна.

3.3.12. Химийн хорт болон аюултай бодис тээвэрлэсэн тээврийн хэрэгслийг хот, суурин газрын дотор болон ойролцоо удаан хугацаагаар зогсоохыг хориглоно.

3.3.13. Химийн хорт болон аюултай бодис тээвэрлэсэн тээврийн

хэрэгслэлийг сайтар цэвэрлэж, хоргүйжүүлнэ.

3.3.14. Химийн хорт болон аюултай бодис тэвэрлэх бусад шаардлагыг шаардлагыг аюултай ачаа тэвэрлэх техникийн нөхцөл, стандартад тусгана.

3.3.15. Ашиглах, устгах үйл ажиллагаа эрхлэгч нь химийн хорт болон аюултай бодисыг тэвэрлэх үйл ажиллагааг 2 талын хооронд байгуулсан гэрээний дагуу өөр байгууллагаар гүйцэтгүүлж болно. Тэвэрлэгч нь энэхүү журамд заасан шаардлагыг биелүүлж, тэвэрлэлтийн үеийн аюулгүй ажиллагааг хангаж ажиллах үүрэг хүлээнэ.

3.3.16. Химийн хорт болон аюултай бодисыг хүн, мал, амьтан болон өөр бүтээгдэхүүнтэй хамт тэвэрлэхийг хориглоно.

3.3.17. Химийн хорт болон аюултай бодисыг цуваагаар тэвэрлэх үед дараахь шаардлагыг биелүүлнэ:

3.3.17.1. тэвэрлэлтийн аюулгүй байдлыг хариуцахаар томилогдсон ажилтан (цувааны ахлагч) цувааг зохион байгуулж, зөвшөөрөгдсөн маршрутын дагуу замын хөдөлгөөний дүрмийг баримтлан, химийн хорт болон аюултай бодисыг тэвэрлэх үйл ажиллагааг удирдана;

3.3.17.2. цувааны ахлагч цувааны эхний машинд явах бөгөөд тэвэрлэж буй ачаа, цаг агаарын нөхцөл, цуваанд яваа техник хэрэгслийн байдал зэргийг харгалзан бүх төрлийн замд хурд ба машин хоорондын зайг тохируулж явах үүрэгтэй;

3.3.17.3. цувааны эхний болон сүүлчийн тээврийн хэрэгсэл “цуваа” гэсэн тод бичлэгтэй байх ба цуваанд эзлэх дугаарыг тээврийн хэрэгсэл бүрийн урд болон ард талд харагдахуйцаар жигд байрлуулна;

3.3.17.4. химийн хорт болон аюултай бодис тэвэрлэх цувааны эхэнд хамгаалалтын машин, төгсгөлд нөөц тээврийн хэрэгсэл явах ба өдрийн цагт ойрын гэрлээ асааж явна.

3.3.18. Шатамхай шингэн болон шахсан хийг тэвэрлэхэд доорхи шаардлагыг биелүүлнэ:

3.3.18.1. Их хэмжээний шатамхай шингэн, шахсан хийг зориулалтын автосистернээр тэвэрлэх ба механик аргаар цэнэглэхэд зориулалтын түлш цэнэглэгч автоцистерн ашиглана. Автоцистерн нь чиргүүл торх, хагас чиргүүл торхтой ажиллаж болох бөгөөд автоцистерн болон чиргүүлийн торхны баруун, зүүн талд “Галын аюултай” гэсэн бичилтийг хурц ялгарах өнгөөр заавал бичсэн байна.

3.3.18.2. бага хэмжээний шатамхай шингэнийг төмөр торхонд, шахсан хийг баллонд тэвэрлэнэ.

3.3.18.3. шингэрүүлсэн шатдаг хийг бага хэмжээгээр хотын дотор тээвэрлэхэд аль болох хөдөлгөөн багатай маршрут, цагийг сонгож гүйцэтгэнэ. Энэ тохиолдолд өмнөх сарын тээвэрлэлтийн тайлан, дараа сарын тээвэрлэлтийн талаарх мэдээллийг тухайн орон нутгийн онцгой байдлын асуудал эрхэлсэн болон замын цагдаагийн байгууллагад мэдэгдэж, зөвшөөрлийг авсан байна.

3.3.18.4. Тээвэрлэхэд хүлээн авах шахсан хийтэй болон хоосон баллон нь баталгаажуулах эрх бүхий бйагууллагаар баталгаажсан байх ба цэнхэр өнгөөр будагдсан, дээр нь хар өнгийн тосон будгаар ачааны нэрийг нь бичиж, түүний мөрөн дээр заводын марк, үйлдвэрлэсэн он, баллоны дугаар, даралтын хэмжээ, дахин шалгах хугацааг заасан байна.

3.3.18.5. Баллонтой шахсан хийг тээвэрлэхэд хоногтой, хоног нь дотроо резинэн зөөлөвчтэй хөндөл дэр мод 2-3-ыг тэвшний уртааш байрлуулж, тэдгээрийн хоногонд баллоныг тагийг нь нэг тийш харуулан ачина. Үе хооронд резинэн зөөлөвч бүхий хоёр талдаа хоногтой модон хөндлөөр таглана. Баллонууд нь аль болох холхихгүй, хөдөлгөөнгүй байх шаардлагатай.

3.3.18.6. Баллоныг босоо байрлалд эргүүлэн хаалтуудыг нэг зүгрүү харуулж байрлуулан хооронд нь жийрэг тавьж ачиж болно. Баллонд жийргийн зориулалтаар баллон тавих ховил гарган хийсэн хөндөл мод, мөн 25 мм-ээс багагүй зузаантай олс буюу резинэн цагираг /нэг баллонд хоёр цагираг/ хэрэглэж эсвэл баллонууд өөр хоорондоо мөргөлдөхөөс сэргийлсэн бусад жийрэг хэрэглэж болно.

3.3.18.7. Баллонтой хийг хэт халахаас урьдчилан сэргийлэх ба баллон ачсан тээврийн хэрэгслийн тэвшинд тосой алчуур , торхтой шатахуун , тослох материал ачихыг хориглоно.

3.3.18.8. Хоосон баллонд үлдэгдэл даралт байх тул түүний тээвэрлэлт нь цэнэглэсэн баллоныг тээвэрлэхтэй адил шаардлагыг хангасан байна.

3.3.19. Хүчил, шүлт зэрэг идэмхий шингэн химийн бодисыг тээвэрлэхэд тусгай шилэн сав хэрэглэнэ. Шилэн сав нь гадуураа модон хайрцаг, шүлжсэн шээзгий, давхар савтай байна. Тээврийн хэрэгслийн тэвшинд шилэн савны хоолой /таг/-г дээш харуулж босоогоор хөдөлгөөнгүй байхаар бэхэлж ачина.

3.4. Химийн хорт болон аюултай бодисыг ашиглахад тавих шаардлага

3.4.1. Химийн хорт болон аюултай бодис ашиглах зөвшөөрөл

бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь химийн хорт болон аюултай бодисыг хадгалахдаа энэ журмын 3.1-д зааснаас гадна дараахь шаардлагыг биелүүлсэн байна:

3.4.1.1. химийн хорт болон аюултай бодисыг ашиглан үйл ажиллагаа явуулах ажлын байр, талбай нь хөдөлмөр хамгааллын нөхцөл, аюулгүй ажиллагааг бүрэн хангасан байна;

3.4.1.2. химийн хорт болон аюултай бодис ашиглагч нь технологийн горимыг нарийн чанд мөрдөж ажиллан, орчиндоо болон ажлын байранд зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтэрсэн хог хаягдал гаргахгүй байх үүрэг хүлээх ба гаргасан тохиолдолд түүнийг бууруулах, саармагжуулах, байгаль орчинд халгүй аргаар устгах арга хэмжээг өөрийн хөрөнгөөр авч хэрэгжүүлнэ;

3.4.1.3. ашиглаж буй химийн бодисын хор, аюулын шинж чанарыг анхааруулсан анхааруулах тэмдэг, дохио үг, аюулын тухай тэмдэглэгээг ажлын байранд харагдахуйц байрлалд тодоор зурж, бичиж байрлуулсан байна.

3.4.1.4. химийн хорт болон аюултай химийн бодис ашиглагч аж ахуйн нэгж, байгууллага нь хими-технологич эсвэл химич мэргэжилтэй химийн бодисын асуудал хариуцсан ажилтантай байна.

3.5. Химийн хорт болон аюултай бодисыг устгахад тавих шаардлага

3.5.1. химийн хорт болон аюултай бодисын хаягдал, ашиглалтын хугацаа дууссан, чанарын шаардлага хангахгүй болсон бодис, хольц болон сав баглаа боодлыг энэхүү журмын 2.3.1.2-т заасан аргачлалын дагуу байгаль орчин, эрүүл ахуй болон гамшгаас урьдчилан сэргийлэх улсын байцаагч нарыг байлцуулж зориулалтын цэгт устгана.

3.5.2. химийн хорт болон аюултай бодисыг устгахтай холбогдон гарах зардлыг тухайн байгууллага, аж ахуйн нэгж, иргэн хариуцна.

3.5.3. Химийн бодисын хаягдал устгасан тухай нотломжийг дэлгэрэнгүй бичиж, устгал хийхэд оролцсон хүмүүс гарын үсэг зурж баталгаажуулна.

3.5.4. Химийн хорт болон аюултай бодисын сав баглаа, боодлыг ахуйн зориулалтаар ашиглахыг хориглоно.

3.5.5. Химийн бодисын хаягдал устгах цэг талбайн байршлыг тухайн орон нутгийн хөгжлийн хэтийн төлөв, төв суурин газрын ерөнхий төлөвлөгөөтөй уялдуулан нутаг дэвсгэрийн суурь нөхцөл байдлыг үндэслэн тогтоох ба байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийгдсэн байна.

3.5.6. Устгал хийх цэг талбайн эргэн тойрон хүн, мал орохооргүй

хашаа хайс хийж, хил хязгаар тогтоон, хамгаалалтын суваг, далан байгуулах ба таних тэмдэг санамж байрлуулна.

3.5.7. Химийн хорт болон аюултай бодисын эзэнгүй хог, хаягдал, химийн хорт болон аюултай бодистой холбоотой осол, түүнчлэн хүний эрүүл мэнд, мал, эд хөрөнгө, байгаль орчныг хордуулж, алан хядах, хорлон сүйтгэх зорилгоор санаатайгаар хэрэглэсэн химийн хорт болон аюултай бодисыг устгахтай холбогдон гарах зардлыг Гамшгаас хамгаалах тухай хуулийн 35 дугаар зүйлд заасны дагуу шийдвэрлэнэ.

ПЕСТИЦИД, ХИМИЙН БОРДОО, АХУЙН ХОРТОН ШАВЖ, МЭРЭГЧ УСТГАЛЫН БОЛОН АРИУТГАЛ, ХАЛДВАРГҮЙТГЭЛИЙН БОДИСЫГ ТУРШИХ, АШИГЛАХ ЖУРАМ

(Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2009 оны 03 дугаар сарын 18 - ны өдрийн 63/67/87 дугаар тушаал)

Нэг.Ерөнхий зүйл

НҮБ-ын туршилт, шалгуурын гарын авлага - “НҮБ-ын Аюултай ачаа тээвэрлэх зөвлөмж. Туршилт, шалгуурын гарын авлага” НҮБ (Женев, Нью-Йорк), 1999, 3-р хэвлэл

НҮБ-ын аргачилсан заавар- “НҮБ-ын Аюултай ачаа тээвэрлэх зөвлөмж, аргачилсан заавар” НҮБ (Женев, Нью-Йорк), 1999

Туршилт- “НҮБ-ын туршилтийн болон шалгуур үзүүлэлт тогтоох аргачилсан зөвлөмж”-ийн дагуу хийсэн нэг болон түүнээс дээш тооны туршилт.

Хий -

1. 20⁰С-ийн температур ба 101,3 кПа абсолют даралтад хийн төлөвт орших бодис
2. 50⁰С-ийн температурт 300 кПа-аас дээш абсолют даралтад уурын даралт үзүүлдэг бодис.

Хатуу бодис - Шингэн болон хий төлвөөс бусад төлөвт оршиж буй бодис

Шингэн бодис -

1. 101,3 кПа абсолют даралтад 20⁰С-тэй тэнцүү болон түүнээс бага температурт хайлдаг бодис
2. Тодорхой хайлах цэггүй зууралдамхай бодис

5. ТЭСРЭМТГИЙ БОДИС

5.1. Тэсрэмтгий шинж чанартай бодисонд тавигдах ерөнхий шалгуур үзүүлэлтүүд

Тэсрэмтгий шинж чанартай бодисонд тавигдах ерөнхий шалгуур үзүүлэлтүүдийг 1999 онд НҮБ-аас гаргасан “НҮБ-ын аюултай ачаа тээвэрлэх зөвлөмж, аргачилсан заавар” (11 дэх хэвлэл), түүний дагалдах боть болох “НҮБ-ын аюултай ачаа тээвэрлэх зөвлөмж. Туршилт, шалгуурын гарын авлага” НҮБ (Женев, Нью-Йорк.1999. 3 дахь хэвлэл)-аас иш татан ашигласан болно. Мөн эдгээр гарын авлага материалыг НҮБ-ын вэб хуудсанд www.un.org/Pubs/sales.htm холбоосоор орж худалдан авч болно.

5.2. Тэсрэмтгий бодис

Тэсрэмтгий бодис гэж орчны юмсыг гэмтээх хэмжээний хурд, даралт, температур бүхий хий ялгаруулдаг химийн урвалд өөрөө орох чадвар бүхий хатуу, шингэн бодисыг (эсвэл бодисын хольц) хэлнэ. Пиротехникийн бодис нь хий ялгаруулахгүй байсан ч энэхүү ангилалд хамаарна.

Пиротехникийн бодис (эсвэл хольц) гэж аяндаа экзотермийн урвалд орон, тэсрэлтгүйгээр дулаан, гал, авиа, утаа эсвэл эдгээрийн цогцыг үзүүлбэр маягаар гаргах зориулалттай бодисыг хэлнэ.

Тэсрэмтгий бүтээгдэхүүн гэж нэг болон хэд хэдэн тэсрэх бодис агуулсан бүтээгдэхүүнийг хэлнэ.

Пиротехникийн бүтээгдэхүүн гэж нэг буюу түүнээс дээш пиротехникийн бодис эсвэл тэдгээрийн хольцыг агуулсан бүтээгдэхүүнийг хэлнэ.

5.3. Тэсрэмтгий бодисын ангилал

Тэсрэмтгий бодисыг дараахь шинж чанараар нь ангилна. Үүнд:

- Гадны үйлчлэлд үзүүлэх мэдрэмтгий чанар
- Тэсрэмтгий шинж чанарын төрөл
- Тэсрэмтгий шинж чанарын үзүүлэх нөлөөллийн түвшин, хэмжээ

Тэсрэмтгий бодисын дэд ангилал

Тэсрэмтгий бодис, хольцыг учруулах аюулын хэмжээ, хэлбэр болон мэдрэмтгий чанараас хамааруулж дараахь дэд ангилалд хуваана. Үүнд:

Дэд ангилал 1.1. “Онцгой тэсрэмтгий” бодис, хольц;

Дэд ангилал 1.2. “Цохилтын хүч үүсгэх аюултай” боловч хүчтэй тэсрэлт үүсгэдэггүй бодис, хольц;

Дэд ангилал 1.3. “Галын болон бага хэмжээгээр тэсрэх, цохилтын хүч үүсгэх аюултай” гэхдээ хүчтэй тэсрэлт үүсгэдэггүй бодис, хольц;

Дэд ангилал 1.4. “Бага хэмжээний тэсрэх, цохилтын хүч үүсгэх аюултай” бодис, хольц, бүтээгдэхүүн. Энэхүү дэд ангилалд гал авалцах эсвэл өдөөх үед бага зэрэг дэлбэрэх аюул учруулдаг бодис, хольц багтана.

Дэд ангилал 1.5. “Өдөөлтийн дараа онцгой тэсрэмтгий” бодис. Энэхүү дэд ангилалд хамаарах бодис нь ердийн нөхцөлд өдөөлт болон гал авалцснаас дэлбэрэлт үүсэх магадлал маш багатай боловч хэрэв тэсрэлт үүсвэл хүчтэй тэсрэлт үүсгэх аюултай бодис, хольц хамрагдана.

Дэд ангилал 1.6. “Өдөөлтийн дараа тэсрэмтгий” бодис, хольц. Энэхүү дэд ангилалд хамаарах бодис, хольц нь тэсрэлтэд туйлын мэдрэмж муутай бодис агуулах бөгөөд өдөөгдөх, дэлбэрэлт үүсгэх магадлал маш багатай.

5.4. Тэсрэмтгий бодисын ангиллын зэрэглэл

Бие биетэйгээ ойр байснаас эсвэл гадны нөлөөллийн улмаас зориудын бус тэсрэлт үүсгэдэг, гал авалцдаг бодис, бүтээгдэхүүнийг тэсрэлтийн төрөл, шинж чанараар нь зэрэглэлийг тогтооно. Үүнд:

Зэрэглэл А: Дулааны үйлчлэл, үрэлтэд онцгой мэдрэмтгий эсвэл хоёрдогч тэслэгч тэсрэмтгий бодисын тэсрэлт, галын өдөөгч үүсвэр болох боломжтой анхдагч тэсрэмтгий бодисууд.

Зэрэглэл В: Анхдагч тэсрэмтгий бодис агуулсан боловч 2 болон түүнээс дээш хамгаалалтын бодис агуулаагүй анхдагч тэсрэмтгий бодис, тэслүүр, тэслүүрт гал дамжуулагчид.

Зэрэглэл С: Тэсрэлтийг эрчимжүүлэгч бодис буюу бусад дүрсхийн шатдаг тэсрэх бодис, ийм төрлийн тэсрэмтгий бодис агуулсан хольц.

Зэрэглэл D: Анхдагч тэсрэмтгий бодисоос бага, харин Зэрэглэл N–д хамаарах бодисоос /хар дарь г.м/ их мэдрэх чадвартай хоёрдогч тэслэгч тэсрэмтгий бодис, ийм төрлийн бодис агуулсан хольц. Эдгээр нь тэсрэлт үүсгэдэггүй, эрчимжүүлдэггүй. Мөн энэ зэрэглэлд анхдагч тэсрэмтгий бодис ба 2 болон түүнээс дээш хамгаалалтын бодис агуулсан хольц хамаарна.

Зэрэглэл E: Тэсрэлт үүсгэдэггүй боловч тэсрэлтийг эрчимжүүлдэг хоёрдогч тэслэгч тэсрэмтгий бодис агуулсан хольц (исэлдүүлэгчтэй харилцан үйлчлэх үед өөрөө шатдаг шатамхай шингэн, гель, шаталт тэсрэлтийг эрчимжүүлэгч (гипергол) шингэн агуулснаас бусад).

Зэрэглэл F: Тэсрэлт үүсгэдэг боловч тэсрэлтийг эрчимжүүлдэггүй хоёрдогч тэслэгч тэсрэмтгий бодис агуулсан хольц (шатамхай шингэн, гель, шаталт тэсрэлтийг эрчимжүүлэгч (гипергол) шингэн агуулсанаас бусад).

Зэрэглэл G: Пиротехникийн бодис, пиротехникийн бодис агуулсан хольц эсвэл тэсрэмтгий ба гэрэл цацруулагч бодис агуулсан хольц, гал өдөөгч, нулимс асгаруулагч, утаа үүсгэгч бодис (усаар идэвхждэг цагаан фосфор, фосфидууд, пирофор бодис, шатамхай шингэн ба гель, шаталт тэсрэлтийг эрчимжүүлэгч (гипергол) шингэн агуулсан материал, хольцоос бусад).

Зэрэглэл H: Тэсрэмтгий бодис болон цагаан фосфорыг хамтад нь агуулсан хольц (утаа үүсгэдэг, агаартай харилцан үйлчилж хүрэлцсэнээр эрчимтэй шаталт үүсгэдэг галын аюултай).

Зэрэглэл J: Тэсрэмтгий бодис болон шатамхай шингэн эсвэл гелийг хамт агуулсан хольц.

Зэрэглэл K: Тэсрэх бодис болон онцгой хортой бодисыг (6.1A, 6.1B, 6.1C ангилалд орсон) хамт агуулсан хольц.

Зэрэглэл L: Тэсрэх бодис болон агаар, ус, исэлдүүлэгчид, шатамхай бодистай харилцан үйлчилснээр өөрөө шатдаг, тэсэрдэг, дүрсхийн шатдаг бодисуудыг хамт агуулсан хольц, мөн агаар, устай харилцан үйлчилснээр өөрөө шатдаг, тэсэрдэг, дүрсхийн шатдаг бодис ялгаруулдаг бодис.

Зэрэглэл N: Мэдрэмтгий чанар муутай тэслүүр (дэд ангилал 1.6-д хамаарах маш бага мэдрэмтгий бодисууд) агуулсан хольц.

Зэрэглэл S: Осол, гэмтэлд өртөх үед аюул учруулах чадвар нь нэмэгддэг боловч түүнийг агуулж буй сав, баглаа боодол нь хязгаарладаг, мөн сав, баглаа боодол нь галд шатах үед үүссэн тэсрэлт, цохилтын хүч нь хязгаарлагдмал, 5 метрийн дотор хүний биед аюул учруулдаггүй, мөн

сав, баглаа боодол нь түүний аюулыг маш сайн хязгаарладаг бодис буюу хольц.

Тэсрэмтгий бодисын төрөл, шинж чанарыг тэсрэлтээс үүсэх аюулын төрөл, түвшинтэй хамааруулан ангилсан ангиллыг 2-р хүснэгтэд харуулав.

Тэсрэмтгий бодисын ангилал

2-р хүснэгт

Зэрэглэл	Тэсрэх аюулын төрөл					
	1.1 Онцгой тэсрэмтгий	1.2 Цохилтын хүч үүсгэх аюултай	1.3 Галын болон бага хэмжээгээр тэсэрч, цохилтын хүч үүсгэх аюултай	1.4 Бага хэмжээтэй галын болон тарааж цацах аюултай	1.5 Өдөөлтийн дараа онцгой тэсрэмтгий	1.6 Өдөөлтийн дараа тэсрэмтгий
A	1.1A					
B	1.1B	1.2B		1.4B		
C	1.1C	1.2C	1.3C	1.4C		
D	1.1D	1.2D		1.4D	1.5D	
E	1.1E	1.2E		1.4E		
F	1.1F	1.2F	1.3F	1.4F		
G	1.1G	1.2G	1.3G	1.4G		
H		1.2H	1.3H			
J	1.1J	1.2J	1.3J			
K		1.2K	1.3K			
L	1.1L	1.2L	1.3L			
N						1.6N
S				1.4S		

5.5. Нэр томъёо

Анхдагч тэсрэмтгий бодис -

1. Дулааны үйлчлэл, үрэлтэд онцгой мэдрэмтгий эсвэл хоёрдогч тэсрэгч тэсрэмтгий бодис, хольцын өдөөгч үүсвэр болох боломжтой бодис
2. Тэсрэх бодис, тэслүүрээс бүрдэх хольцыг хэлнэ.

Пиротехникийн бодис - аяндаа экзотермийн урвалд орон, тэсрэлтгүйгээр

дулаан, гал, авиа, утаа эсвэл эдгээрийн цогцыг үзүүлбэр маягаар гаргах зориулалттай бодис

Тэсрэлтийг эрчимжүүлэх бодис – дүрсхийн шатдаг бодис

Хамгаалалтын бодис - Ашиглалт, хадгалалт, тээвэрлэлтийн хэвийн нөхцөлд аюул ослоос хамгаалах, урьдчилан сэргийлэх зорилгоор тэсрэмтгий хольцод нэмсэн нэмэлт бодис

Хоёрдогч тэсрэгч тэсрэмтгий бодис – анхдагч тэсрэмтгий бодисын өдөөлт тэсрэлтээр идэвхижин тэсрэлт өгдөг бодис, хольц.

6. ШАТАМХАЙ БОДИС

6.1. Шатамхай шинж чанартай бодисонд тавигдах ерөнхий шалгуур үзүүлэлтүүд

Энэхүү шатамхай бодисын ангиллын шалгуур үзүүлэлтүүдийг “НҮБ-ын аюултай ачаа тээвэрлэх зөвлөмж, аргачилсан заавар”, түүний дагалдах боть болох “НҮБ-ын аюултай ачаа тээвэрлэх зөвлөмж. Туршилт, шалгуурын гарын авлага” –аас ашигласан болно.

6.2. Шатамхай бодисын ангилал

Шатамхай бодисыг доорхи 9 дэд ангилалд хуваана. Үүнд:

- а. Шатамхай хий (дэд ангилал 2.1.1)
- б. Шатамхай аэрозоль (дэд ангилал 2.1.2)
- в. Шатамхий шингэн (дэд ангилал 3.1)
- г. Сулруулсан шингэн тэсрэх бодис (дэд ангилал 3.2)
- д. Шатамхай хатуу бодис. Шатамхай хатуу бодист:
 - 1/ Шатамхай хатуу бодис (хялбар шатамхай хатуу бодис болон үрэлтийн улмаас хялбархан шатдаг хатуу бодис) (дэд ангилал 4.1.1)
 - 2/ Өөрөө идэвхиждэг шатамхай хатуу бодис (дэд ангилал 4.1.2)
 - 3/ Сулруулсан хатуу тэсрэмтгий бодис (дэд ангилал 4.1.3)
 - 4/ Агаарт өөрөө шатдаг, пирофор бодис болон өөрөө халдаг бодис (дэд ангилал 4.2)
 - 5/ Норвол шатамхай бодис (дэд ангилал 4.3)

6.1. Шатамхай бодисын тодорхойлолт

Шатамхай хий (дэд ангилал 2.1.1) - 20⁰С-ийн температур, 101,3 кПа-ийн ердийн даралтанд агаартай харилцан үйлчилснээр гал авалцдаг хий.

Шатамхай аэрозоль (дэд ангилал 2.1.2) - энэхүү дэд ангилалд шахсан болон шингэрүүлсэн хий, шингэнд уусгасан хий, эсвэл өтгөн зуурмаг, нунтагтай хольсон болон холиогүй хийг даралтаар шахаж савласан, нийт

жингийн 45%-иас багагүй нь шатамхай материал агуулсан, агуулсан зүйлээ хатуу, шингэн, нунтаг, зуурмаг хэлбэрээр эсвэл хий хэлбэрээр цацах төхөөрөмж бүхий, нэг удаагийн хэрэглээтэй металл, хуванцар, шилээр хийгдсэн сав багтана.

Дээр дурьдсан шатамхай материал гэдэгт шатамхай хий, шатамхай шингэн, шатамхай хатуу бодис болон эдгээрийн холимог орно.

Шатамхай шингэн (дэд ангилал 3.1) - 93⁰С-ээс дээшгүй температурт гал авалцдаг шингэн.

Сулруулсан шингэн тэсрэх бодис (дэд ангилал 3.2) - шатамхай бодисыг ус болон ямар нэг шингэнд уусгаж эсвэл хольж, нэг төрлийн хольц үүсгэн шатамхай чанарыг нь бууруулсан шингэн.

Шатамхай хатуу бодис (дэд ангилал 4.1.1 1) - хялбар шатдаг эсвэл үрэлтийн улмаас өөрөө шатдаг эсвэл шатаалтыг тэтгэдэг хатуу бодис.

Өөрөө идэвхждэг шатамхай хатуу бодис (дэд ангилал 4.1.2) - Хүчилтөрөгчийн (агаарын) оролцоогүйгээр экзотермийн эрчимтэй задралд ордог, дулаанд тэсвэргүй бодисууд энэ дэд ангилалд орно. Уг дэд ангилалд тэсрэмтгий бодис болон органик хэт исэл, исэлдүүлэгч бодисууд хамаарахгүй.

1/ 75⁰С болон түүнээс бага температурт 50 кг бодис дээр туршилт явуулахад өөрөө шатдаг бодис

2/ Задралын дулаан нь 300 Дж/г-аас их бодис

Сулруулсан хатуу тэсрэх бодис (дэд ангилал 4.1.3)

Сулруулсан хатуу тэсрэх бодисонд доорхи төрлийн бодис орно. Үүнд:

1/ тэсрэмтгий шинж чанарыг бууруулсан бодис;

2/ мэдрэмтгий шинж чанарыг бууруулснаар цохилтын хүч, гал, утаа, дулааны болон дуу чимээ ялгаруулдаггүй бодис;

3/ исэлдүүлэгч болон өөрөө урвалд орох шинж чанаргүй бодисууд эсвэл

4/ тэсрэмтгий бодисыг ус, спирт болон бусад бодисоор шингэрүүлж, норгон нэг төрлийн хольц үүсгэн тэсрэмтгий шинж чанарыг бууруулсан бодис, хольц эсвэл

5/ доорхи төрлийн бодисууд:

- 5-терт-бутил-2,4,6-тринитро-м-ксилол (UN 2956);
- 2-бromo-2-нитропропан-1,2-дио́л (UN 3241);
- Азодикарбонамид (UN 3242);
- Изо-сорбид-5-мононитрат (UN 3251) зэрэг бодис

орно.

Агаарт өөрөө шатдаг бодис (дэд ангилал 4.2)

Агаарт шатдаг бодисонд:

1/ Хатуу нунтаг төлөвт байгаа бодисыг шатамхай бус гадаргуу дээр 5 минутын турш байлгах эсвэл 1 метрийн өндрөөс асгахад өөрөө гал авалцдаг бодис (6 туршилтын 1-ээс илүү тохиолдолд)

2/ 5 мл шингэн бодисыг:

- идэвхигүй нунтаг хатуу бодис агуулсан идэвхигүй сав руу гоожуулахад агаарт 5 минутын дотор гал авалцдаг бодис (6 туршилтын 1-ээс илүү тохиолдолд)

- 25°C-ын температурт хуурай шүүлтүүрийн цаасан дээр асгахад шүүлтүүрийн цаас 5 минутанд шатах буюу нүүрсждэг бодис (6 туршилтын 1-ээс илүү тохиолдолд)

3/ 100 мм тал бүхий шоо дөрвөлжин хэлбэртэй бодисыг 140°C хүртэл халаахад эсвэл 24 цагийн хугацаанд 60°C-аар температурыг нэмэгдүүлэхэд өөрөө шатдаг бодис.

Норвол шатамхай бодис (дэд ангилал 4.3)

Устай харилцан үйлчилж шатамхай хий ялгаруулдаг бодис энэ дэд ангилалд хамаарна. Энэхүү ангилалд :

1/ ердийн температурт устай урвалд орон агаарт идэвхтэй шатдаг хий ялгаруулдаг

2/ устай харилцан үйлчилж нэг цагт 1 кг бодисоос 1л хий ялгаруулдаг бодис орно.

6.4. Нэр томьёо

Ноцох цэг – шатамхай шингэнээс ялгарсан уур агаарт шатамхай хольц үүсгэж шатах хамгийн бага температур.

Сулруулагч бодис - ангилал 1, дэд ангилал 4.1.2 ба 5.2 –д хамаарах бодистой хольж аюултай шинж чанарыг бууруулдаг бодис

Шатамхай чанар – агаарт 20°C-ийн температур, 101.3 кПа абсолют даралтанд бодисын шатах боломж

Шатах хязгаар - шатамхай хий эсвэл уурыг агаартай харьцуулсан харьцаа. Жишээлбэл: Тухайн шатамхай бодис агаар их байвал агаар тэнд бага байх бөгөөд энэ нь шаталт явагдах боломжтой гэж ойлгоно.

Шатамхай уур – шингэн болон хатуу бодисын хийн төлөвт орших хэлбэр бөгөөд энэ уур нь шатамхай.

Шатамхай бодисын ангилал

3-р хүснэгт

Зэрлэл	2.1.1 Шатамхай хий	2.1.2 Шатамхай аэрозоль	3.1 Шатамхай шингэн	3.2 Сулруулсан шингэн тэсрэх бодис	4.1.1 Шатамхай хатуу бодис	4.1.2 Өөрөө идэвхдэг шатамхай хатуу бодис	4.1.3 Сулруулсан хатуу тэсрэх бодис	4.2 Агаарт өөрөө шатамхай	4.3 Норговол шатамхай
A	Агаарт $\leq 13\%$ / эзлэхүүн/ үед шатагч эсвэл шатагч хязгаар нь агаарт $\geq 12\%$	$> 100\text{Па}$ даралтад шахсан, шатамхай бүрэлдэхүүн нь $\geq 45\%$ /масс/ шингэрүүлсэн хий, даралтаар уусгагсан хий агуулсан хольц	Ноцох цэг / битүү саванд / $< 23^\circ\text{C}$ ба буцлах температур нь $\leq 35^\circ\text{C}$	НУБ-ын I бүлгийн савалгааны ангилалд хамаарах бодис	НУБ-ын II бүлгийн савалгааны ангилалд хамаарах бодис	4.1.2A	НУБ-ын I бүлгийн савалгааны ангилалд хамаарах бодис	НУБ-ын I бүлгийн савалгааны ангилалд хамаарах бодис	НУБ-ын I бүлгийн савалгааны ангилалд хамаарах бодис
B	A эзрэлдэлд заснаас бусад шатагч хязгаартай		Ноцох цэг / битүү саванд / $< 23^\circ\text{C}$ ба буцлах температур нь $> 35^\circ\text{C}$	НУБ-ын II бүлгийн савалгааны ангилалд хамаарах бодис	НУБ-ын III бүлгийн савалгааны ангилалд хамаарах бодис	4.1.2B	НУБ-ын II бүлгийн савалгааны ангилалд хамаарах бодис	НУБ-ын II бүлгийн савалгааны ангилалд хамаарах бодис	НУБ-ын II бүлгийн савалгааны ангилалд хамаарах бодис
C			Ноцох цэг / битүү саванд / $\geq 23^\circ\text{C}$ ба буцлах температур нь $\leq 60^\circ\text{C}$	НУБ-ын III бүлгийн савалгааны ангилалд хамаарах бодис		4.1.2C	НУБ-ын III бүлгийн савалгааны ангилалд хамаарах бодис	НУБ-ын III бүлгийн савалгааны ангилалд хамаарах бодис	НУБ-ын III бүлгийн савалгааны ангилалд хамаарах бодис
D			Ноцох цэг / битүү саванд / $> 60^\circ\text{C}$ ба буцлах температур нь $\leq 93^\circ\text{C}$			4.1.2D			
E						4.1.2E			
F						4.1.2F			
G						4.1.2G			

7. ИСЭЛДҮҮЛЭГЧ БОДИС

1.1. Исэлдүүлэгч шинж чанартай бодисонд тавигдах ерөнхий шалгуур үзүүлэлт

Энэхүү исэлдүүлэгч бодисын ангиллын шалгуур үзүүлэлтийг “НҮБ-ын аюултай ачаа тээвэрлэх зөвлөмж, аргачилсан заавар”, түүний дагалдах боть болох “НҮБ-ын аюултай ачаа тээвэрлэх зөвлөмж. Туршилт, шалгуурын гарын авлага” –аас ашигласан болно.

1.2. Исэлдүүлэгч бодис

Исэлдүүлэгч хий - хүчилтөрөгч ялгаруулан агаараас илүүтэйгээр гал авалцуулах, эсвэл бусад материалын шаталтыг өдөөх чадвартай хий.

Исэлдүүлэгч шингэн - өөрөө шатамхай бус боловч ихэвчлэн хүчилтөрөгч ялгаруулах замаар гал авалцуулах, эсвэл бусад материалын шаталтыг өдөөх чадвартай шингэн.

Исэлдүүлэгч хатуу бодис - өөрөө шатамхай бус боловч ихэвчлэн хүчилтөрөгч ялгаруулах замаар гал авалцуулах, эсвэл бусад материалын шаталтыг өдөөх чадвартай хатуу бодис.

Органик хэт исэл - нэг, эсвэл хоёр устөрөгчийн атом нь органик радикалаар халагдсан устөрөгчийн хэт ислийн уламжлал гэж үзэж болох,

-0-0- гэсэн хоёр валенттай бүлэг агуулсан шингэн, эсвэл хатуу төлөвт байдаг органик бодисуудыг хэлнэ. Органик хэт исэл гэсэн нэр томъёонд органик хэт ислүүдийн хольцыг хамруулдаг. Органик хэт ислүүд нь аяндаа хурдсан экзотермийн задралд ордог дулаанд тогтворгүй бодис буюу хольц байх бөгөөд эдгээр нь доор дурьдсан шинж чанаруудын нэг эсвэл хэд хэдийг агуулсан байж болно. Үүнд:

- а) задрахдаа тэсрэлт үүсгэдэг;
- б) хурдан шатдаг;
- в) доргилт, эсвэл үрэлтэнд мэдрэмтгий;
- г) бусад бодистой аюул үүсгэх урвалд орох чадвартай;

1.3. Исэлдүүлэгч бодисын ангилал

Исэлдүүлэгч бодисыг дараахь байдлаар ангилна. Үүнд:

- Органик хэт ислээс бусад исэлдүүлэгч бодис
- Органик хэт исэл

Исэлдүүлэгч бодисыг 3 дэд ангилалд хувааж, тэдгээрийг учруулах аюулын хэмжээгээр нь зэрэглэл тогтооно.

Дэд ангилал 5.1.1-д исэлдүүлэгч шингэн болон хатуу бодис, 5.1.2-д исэлдүүлэгч хий, 5.2-т органик хэт ислийг хамааруулна.

Исэлдүүлэгч бодисын ангилал

4-р хүснэгт

Аюулын зэрэглэл	Исэлдүүлэгч бодисын төрөл		
	Исэлдүүлэгч /шингэн болон хатуу бодис/ 5.1.1	Исэлдүүлэгч хий ¹ 5.1.2	Органик хэт исэл 5.2
A	НҮБ-ын I бүлгийн савалгааны ангилалд хамаарах бодис	Агаараас илүү шаталтыг тэтгэдэг	5.2A
B	НҮБ-ын II бүлгийн савалгааны ангилалд хамаарах бодис		5.2B
C	НҮБ-ын III бүлгийн савалгааны ангилалд хамаарах бодис		5.2C
D			5.2D
E			5.2E
F			5.2F
G			5.2G

8. ИДЭМХИЙ БОДИС

8.1. Идэмхий бодисын ангилал

Идэмхий шинж чанартай бодисыг доорхи 3 дэд ангилалд хуваана. Үүнд:

Дэд ангилал 8.1 – Металлийг зэврүүлдэгч

Дэд ангилал 8.2 – Арьс гэмтээгч

Дэд ангилал 8.3 – Нүд гэмтээгч

Металлийг зэврүүлдэгч бодис - химийн урвалын нөлөөгөөр металлыг мэдэгдэхүйц хэмжээгээр гэмтээдэг эсвэл бүр устгадаг бодис буюу хольцыг хэлнэ. Ган болон хөнгөнцагаан гадаргууг туршилтын нөхцөл 55⁰C-д жилд 6.25 мм-ээс дээш хэмжээгээр зэврүүлж байвал металл эврүүлдэгч бодис гэж үзнэ.

. Арьс өрөвсүүлэгч бодисонд:

1. рН нь ≤ 2 эсвэл ≥ 11.5 эсвэл
2. 1 цагаас их, 4 цагаас бага хугацаагаар арьстай шүргэлцэхэд арьсанд ноцтой, үл сэргээгдэх гэмтэл үзүүлдэг бодис орно.

Арьсны идэгдэлт - арьсанд учирсан үл сэргээгдэх гэмтэл бөгөөд өөрөөр хэлвэл 4 цагаас илүүгүй хугацаагаар үйлчилсэн туршилтын дүнд арьсны гүн рүү орсон илэрхий үхжилийг үүсгэхийг хэлнэ.

Арьсны цочролт - 4 цагаас илүүгүй хугацаагаар үйлчилсэн туршилтаар арьсанд үүссэн нөхөн төлжих гэмтэл.

Нүд өрөвсүүлэгч бодисонд:

1. рН нь ≤ 2 эсвэл ≥ 11.5 эсвэл
2. Драйзийн хэмжээ (Draize score) нь нүдэнд цагаа унахад ≥ 3 , нүдний солонгон бүрхүүлийн өрөвсөлд ≥ 1.5
3. Нүдний гадаад хэсэгтэй харилцан үйлчлэлсэнээс хойш 21 өдрийн туршид харааг бүрэн сэргээгдэхгүйгээр гэмтээгч бодис

Нүдний ноцтой гэмтэл - нүдний эдийн гэмтэл буюу ноцтой харааны муудалт болно. Хараа муудалт гэж нүдний гадаад хэсэгтэй харилцан үйлчлэлсэнээс хойш 21 өдрийн туршид хараа бүрэн сэргээгдэхгүй байхыг хэлнэ.

Нүдний цочрол - туршилтын бодис нүдний гадаад гадаргуутай харилцан үйлчлэлцснээс хойш хараа нэг өдрийн хугацаанд бүрэн сэргээгдэхгүй байхыг хэлнэ.

Идэмхий бодисын ангилал

5-р хүснэгт

Аюулын зэрэглэл	Идэмхий бодисын төрөл		
	Металл зэврүүлэгч 8.1	Арьс өрөвсүүлэгч 8.2	Нүд өрөвсүүлэгч 8.3
А	рН ≤ 2 эсвэл рН ≥ 11.5 ; металлын гадаргууг жилд 6.25мм-ээс дээш хэмжээ-тэй зэврүүлдэг	рН ≤ 2 эсвэл рН ≥ 11.5 ; 3 минутаас ихгүй хугацаагаар харилцан үйлчлэхэд 1 цагийн туршид үл сэргээгдэх гэмтэл учруулдаг	рН ≤ 2 эсвэл рН ≥ 11.5 ; үл сэргээгдэх нө-лөөлөл үзүүлдэг,
В		3 минутаас их 1 цагаас бага хугацаагаар харилцан үйлчлэхэд 14 хоно-гийн туршид үл сэргээгдэх гэмтэл учруулдаг	
С		1 их 4 цагаас бага хугацаагаар харил-цан үйлчлэхэд 14 цагийн туршид үл сэргээгдэх гэмтэл учруулдаг	

9. ХОРТОЙ БОДИС

9.1. Хортой бодисын ангилал

Хортой химийн бодисыг доорхи дэд ангилалд хуваана. Үүнд:

Дэд ангилал 6.1 – Онцгой хортой

Дэд ангилал 6.3 – Арьс өрөвсүүлэгч

- Дэд ангилал 6.4 – Нүд өрөвсүүлэгч
- Дэд ангилал 6.5 – Харшил өдөөгч
- Дэд ангилал 6.6 – Үр удамд нөлөөлөгч
- Дэд ангилал 6.7 – Хавдар үүсгэгч
- Дэд ангилал 6.8 – Нөхөн үржихүй /өсөлт хөгжилтөнд нөлөөлөгч
- Дэд ангилал 6.9 – Тодорхой эрхтэн системийг хордуулагч

9.2. Онцгой хортой бодис

Онцгой хортой бодис - нэг тунг нэг удаа эсвэл хэд хэдэн тунг 24 цагийн туршид уух болон арьсаар, аль эсвэл 4 цагийн турш амьсгалах замаар биед орсны дараа хурц хордлого өгч, хортой үр дагавар үүсгэдэг бодис.

Онцгой хортой бодисын түвшин

1. Амаар болон арьсаар LD_{50} нь ≤ 5000 мг/кг (биеийн жин)
2. Амаар болон арьсаар LD_{50} нь ≤ 2000 мг/кг (биеийн жин) ба үхэлд хүргэх болон бусад клиник шинж тэмдэг илрэх
3. Амьсгалын замаар (хий) LC_{50} нь агаарт ≤ 5000 ppm
4. Амьсгалын замаар (уур) LC_{50} нь агаарт ≤ 20 мг/л
5. Амьсгалын замаар (тоос, манан) LC_{50} нь агаарт ≤ 5 мг/л

9.3. Арьс өрөвсүүлэгч

Улайж, цэврүү үүсэх Драйзийн хэмжээ (Draize score) нь ≥ 1.5 .

9.4. Нүд өрөвсүүлэгч

Нүдэнд цагаа унах Драйзийн хэмжээ (Draize score) нь ≥ 1 , нүдний солонгон бүрхүүлийн өрөвсөл үүсэх Драйзийн хэмжээ (Draize score) нь ≥ 2 .

9.5. Харшил өдөөгч

Харшил өдөөгч бодис нь амьсгалын замын эрхтэн систем болон арьсанд харшил өгнө.

Амьсгалын харшил - химийн аливаа бодисыг амьсгалсны дараа амьсгалын замын хэт мэдрэгшил өгөх.

Арьсны харшил - арьстай харилцан үйлчилсний дараа харшлийн урвал өгөх.

9.6. Үр удамд нөлөөлөгч

Үр удамд нөлөөлөгч бодис- үр хөврөлийн эсэд удам дамжин хувьсал,

өөрчлөлт оруулдаг химийн бодис. In vitro нөхцөлд генийн өөрчлөлт/ генийн хордлого дээр болон in vivo нөхцөлд сүүн тэжээлтний бие махбодын эсэд тавьсан туршилтын үр дүнг үндэслэн бодис ба хольцыг энэ ангилалд хамруулж ангилна.

9.7. Хавдар үүсгэгч

Хавдар үүсгэгч- хорт хавдар үүсгэдэг, эсвэл түүний тархалтыг нэмэгдүүлдэг бодис, хольц.

9.8. Нөхөн үржихүй /өсөлт хөгжилтөнд нөлөөлөгч

Нөхөн үржихүйн хордлого нь нөхөн үржихүйн эрхтний үйл ажиллагаа болон насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хүний урагшилд үзүүлэх сөрөг нөлөөлөл, мөн түүнчлэн удам угсааны хөгжлийн хордлого зэргийг багтаана.

Нөхөн үржихүй / өсөлт хөгжилтөнд нөлөөгч бодис нь дараахь 2 төрлийн сөрөг нөлөөллийг үзүүлнэ. Үүнд:

- Нөхөн үржихүйн чадвар, эсвэл чадавхид үзүүлэх сөрөг нөлөөлөл;
- Үр хөврөлийн хөгжилд үзүүлэх сөрөг нөлөөлөл.

9.9. Тодорхой эрхтэн системийг хордуулагч

Тодорхой эрхтэн системийг хордуулагч бодисыг:

- 1 удаагийн нөлөөллөөр тодорхой эрхтэн системийг хордуулдаг

- хэд хэдэн удаагийн нөлөөллөөр тодорхой эрхтэн системийг хордуулдаг гэж хуваана.

Нэг удаагийн нөлөөллөөр тодорхой эрхтэн системийг хордуулдаг бодис - 1 удаагийн нөлөөллийн үр дүнд тодорхой эрхтний аль нэгэнд үхлийн бус тогтолцооны хордлого өгдөг бодис. Энэ хордлогын нөлөөгөөр эрхтнийг, цаашилбал организмын үйл ажиллагааг сэргээгдэх, эсвэл үл сэргээгдэхээр гэмтээж болно.

Хэд хэдэн удаагийн нөлөөллөөр тодорхой эрхтэн системийг хордуулдаг бодис -хэд хэдэн удаагийн үйлчлэлээр онцгой өртөмтгий эрхтэн/тогтолцоонд хорт нөлөө учруулдаг бодис. Эрхтэн системийн үйл ажиллагаа хэсэг хугацааны дараа сэргээгдэх эсвэл сэргээгдэхгүйгээр гэмтээж болно.

9.10. Нэр томъёо

Драйзийн хэмжээ (Draize score) – амьтан дээр хийсэн 3 туршилтын 2-т

арсны цочрол үүсгэж байгаа хэмжээ.

LC_{50} (үхлийн дундаж концентраци) – тодорхой тооны амьтан дээр хийсэн туршилтаар хордуулснаас хойш тодорхой хугацаанд туршилтанд орсон амьтны 50% нь үхэлд хүрсэн нэг удаагийн концентраци

LD_{50} (үхлийн дундаж тун) – тодорхой тооны амьтан дээр хийсэн туршилтаар амаар болон арьсаар хордуулснаас хойш тодорхой хугацаанд туршилтанд орсон амьтны 50% нь үхэлд хүрсэн нэг удаагийн тун.

10. БАЙГАЛЬ ОРЧИНД ХОРТОЙ БОДИС

10.1. Байгаль орчинд хортой бодисын ангилал

Байгаль орчинд нөлөөлөх байдлаар нь химийн бодисыг доорхи дэд ангилалд хуваана. Үүнд:

1. Усны амьд организмд хортой бодис (дэд анги 9.1)
2. Хөрсний амьд организмд хортой бодис (дэд анги 9.2)
3. Сээр нуруутан амьтанд хортой бодис (дэд анги 9.3)
4. Сээр нуруугүй амьтанд хортой бодис (дэд анги 9.4)

10.2. Усны амьд организмд хортой бодис

1/ Загасанд (96 цаг) : $LD_{50} \leq 100$ мг/л

Нялцгай биетэнд (48/96 цаг) : $EC_{50} \leq 100$ мг/л

Замагт (72/96 цаг) : $EC_{50} \leq 100$ мг/л

2/ загас, нялцгай биетэн, усны ургамалд мэдэгдэхүйц нөлөө үзүүлэхгүй концентраци (МНҮК) нь ≤ 1 мг/л

3/ МНҮК нь тогтоогдоогүй боловч удаан задардаг, био хуримтлал үүсгэдэг

10.3. Хөрсний амьд организмд хортой бодис

1/ Ургамал болон хөрсний сээр нуруугүй амьтанд: $EC_{50} \leq 100$ мг/кг(хуурай хөрсний жин)

2/ микро организмын исэлдэх болон азотжих процессыг 25% бууруулдаг

10.4. Сээр нуруутан амьтанд хортой бодис

1/ Шувуу болон сээр нуруутанд: $LD_{50} \leq 2000$ мг/кг(биеийн жин) эсвэл $LC_{50} \leq 5000$ ppm

2/ Шувуу болон сээр нуруутанд зөвшөөрөгдөх дээд хэмжээ (ЗДХ) ≤ 100 ppm

10.5. Сээр нуруугүй амьтанд хортой бодис

Амаар болон арьсаар хүрэлцэх үед: $LD_{50} \leq 25$ мкг/сээр нуруугүй амьтан

10.6. Нэр томъёо

Био хуримтлал- Био концентрацийн үзүүлэлт (БКҮ) нь ≤ 500 эсвэл БКҮ нь тогтоогдоогүй боловч $\log K_{ow} \geq 4$

K_{ow} – бодисын октанолд уусах чанарыг усанд уусах чанарт харьцуулсан

харьцаа

ЕС₅₀ – Усны организмын 50%-д сөрөг нөлөө үзүүлж, өсөлт хөгжилтийг бууруулдаг тухайн бодисын усан дахь концентраци

МНҮК- тухайн бодисын хүн болон амьтанд биологийн ямар нэг нөлөө үзүүлэхгүй байх дээд концентраци. Энэ хэмжээнээс дээш гарсан тохиолдолд биологийн нөлөөлөл үзүүлнэ.

Удаан задардаг бодис

Усанд:

1/ тухайн бодисыг уусгасан уусмал 28 хоногийн дараа бичил биетний биед орох

2/ уусмалд ууссан органик нүүрстөрөгчийг 70% бууруулдаг

3/ уусмал дахь тухайн бодис бүрэн задрах үед буурах хүчилтөрөгчийн хэмжээг хамгийн их гэж үзвэл, түүний 60%-тай тэнцэх хэмжээний хүчилтөрөгч буурдаг

4/ уусмал дахь тухайн бодис бүрэн задрах үед үүсэх нүүрсхүчлийн хийн хэмжээг хамгийн их гэж үзвэл, түүний 60%-тай тэнцэх хэмжээний нүүрсхүчлийн хий үүсгэдэг

5/уусмалдахь тухайн бодис бүрэн задрах үед үүсэх нүүрсхүчлийн хийн хэмжээг хамгийн их гэж үзвэл, түүний 60% нь үүсэх

6/ БХХТ-ийг ХХХТ-д харьцуулсан харьцаа $\geq 0.5:1$

7/ 28 хоногт усан орчинд 70%-иас бага хэсэг нь биологийн болон биологийн бус задралаар задардаг

БХХТ (биологийн хэрэгцээт хүчилтөрөгч) – 5 хоногийн туршид усан дахь бодис бичил биетнээр исэлдэхэд зарцуулагдах хүчилтөрөгчийн хэмжээ, нэгж нь [мгО/мгБодис]

ХХХТ (химийн хэрэгцээт хүчилтөрөгч) – усан дахь тухайн бодисыг исэлдүүлэхэд шаардагдах хүчилтөрөгчийн хэмжээ бөгөөд энэ нь калийн перманганат эсвэл калийн дихроматыг исэлдүүлэхэд зарцуулагдах хүчилтөрөгчийн хэмжээтэй тэнцүү. Нэгж нь [мгО/мгБодис]

Хурц хордлого – загасанд 96 цагийн LD₅₀, нялцгай биетэнд 48, 96 цагийн ЕС₅₀, замганд 72, 96 цагийн ЕС₅₀-ийн хамгийн доод хэмжээ, (нэгж нь [мг бодис/л ус])

Архаг хордлого – загас, нялцгай биетэн, замагт мэдэгдэхүйц нөлөө үзүүлэхгүй концентрацийн (МНҮК) хамгийн доод хэмжээ, (нэгж нь [мг бодис/л ус])

Хөрсний амьд организмд хортой хэмжээ – ургамал болон хөрсний сээр нуруугүй амьтанд 14 хоногийн өртөлтийн дараахь ЕС₅₀-ийн хэмжээ эсвэл хөрсний бичил биетний оролцоотойгоор исэлдэх, азотжих процесс 25% хүртэл хэмжээгээр буурах хамгийн бага хэмжээ (нэгж нь [мг бодис/

кг хуурай хөрс])

DT_{50} – хөрсөнд тухайн бодисын конценттраци 50% хүртэл буурах хугацаа

Сээр нуруугүй амьтанд хортой хэмжээ – өртөлтөөс хойш 48 цагийн дараахь LD_{50} –ийн хамгийн бага хэмжээ [мкг бодис/сээр нуруугүй амьтан])

БАЙГАЛЬ ОРЧИНД ХОРТОЙ БОДИСУУДЫН АНГИЛАЛ

7-р хүснэгт

Зэрэг-лэл	Байгаль орчинд аюултай бодисын төрөл			
	Усны амьд организмд хортой 9.1	Хөрсний амьд организмд хортой 9.2	Сээр нуруутан амьтанд хортой 9.3	Сээр нуруугүй амьтанд хортой 9.4
A	Онцгой хортой ≤ 1 мг/л	Хөрсний амьд организмд хортой ≤ 1 мг/кг	$<LD_{50}$ нь 50 мг/кг(биеийн жин) эсвэл LC_{50} (хоол тэжээлээр) ≤ 500 мг/кг(хүнс)	Сээр нуруугүй амьтанд хортой ≤ 2 мкг/зөгий
B	$1.0 < \text{Онцгой хортой} \leq 10$ мг/л ба удаан задардаг ба био хуримтлал үүсгэдэг; (МНҮК > 1.0 мг/л)	$1 < \text{Хөрсний амьд организмд хортой} \leq 10$ мг/кг	$50 < LD_{50} \leq 500$ мг/кг(биеийн жин) эсвэл $500 < LC_{50}$ (хоол тэжээлээр) ≤ 1000 мг/кг(хүнс)	$2 < \text{Сээр нуруугүй амьтанд хортой} < 11$ мкг/зөгий
C	$10.0 < \text{Онцгой хортой} \leq 100$ мг/л ба удаан задардаг ба био хуримтлал үүсгэдэг; (МНҮК > 1.0 мг/л)	$10 < \text{Хөрсний амьд организмд хортой} \leq 100$ мг/кг ба Хөрсний $DT_{50} > 30$ өдөр	$500 < LC_{50}$ (хоол тэжээлээр) ≤ 2000 мг/кг(хүнс) эсвэл $1000 < LC_{50}$ (хоол тэжээлээр) ≤ 5000 мг/кг(хүнс) эсвэл буюу хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ нь 100 ppm-ээс бага байх, 9.3А болон 9.3В-ийн шалгуурт орохгүй байх	$11 \leq \text{Сээр нуруугүй амьтанд хортой} < 25$ мкг/зөгий
D	$1.0 < \text{Онцгой хортой} \leq 100$ мг/л ба дээрх 2 зэрэглэлд хамаарахгүй; Тогтвортой биш, био хуримтлал үүсгэдэггүй; Буюу амьд организмыг хөнөөх чадвартай ба дээрх А,В,С зэрэглэлд хамаарахгүй;	$10 < \text{Хөрсний амьд организмд хортой} \leq 100$ мг/кг ба Хөрсний $DT_{50} > 30$ өдөр		

ХИМИЙН ХОРТ БОЛОН АЮУЛТАЙ БОДИСЫН АНГИЛЛЫН ЖАГСААЛТ

(Энэхүү жагсаалтад шинэ бодис нэмэгдэж шинчлэгдэж байх тулд нэмэлтийг www.mne.mn/chemical вебсайт дахь Химийн хорт болон аюултай бодис гэсэн хуудасны Химийн бодисын ангиллын жагсаалтаас үзнэ үү)

1. Шагамхай хий (өөр төрлийн аюул үзүүлэхгүй)

№	Олон улсын нэршил	Монгол нэр	Химийн томъёо	CAS дугаар	НУБ –ын дугаар	Хортой болон аюултай бодисын ангилал
1	1-Butene (butylene)	Бутилен, бутен-1	C_4H_8	25167-67-3	1012	2.1.1A
2	1-Propene, 2-methyl- (isobutene)	2-метил пропин-1 (изобутилен)	$CH_3CH_2=C-CH_3$	115-11-7	1055	2.1.1A
3	Butane	Бутан	C_4H_{10}	106-97-8	1011	2.1.1A
4	Cyclopropane	Циклопропан	C_3H_6	75-19-4	1027	2.1.1A
5	Deuterium	Дейтерий	D_2	7782-39-0	1957	2.1.1A
6	Ethane	Этан	C_2H_6	74-84-0	1035	2.1.1A
7	Ethane, 1-chloro-1,1difluoro-	1-хлор 1,1-дифтор этан	$C_2H_3ClF_2$	75-68-3	2517	2.1.1A
8	Ethane, 1,1-difluoro- (Refrigerant gas R152A)	1,1-дифтор этан (Хөргөлтийн хий R152A)	$F_2 - HC - CH_3$	75-37-6	1030	2.1.1A
9	Ethane, 1,1,1-trifluoro- (Refrigerant gas R143A)	1,1,1-трифтор этан (Хөргөлтийн хий R143A)	$C_2H_3F_3$	420-46-2	2035	2.1.1A
10	Ethene (ethylene)	Этилен (этен)	$CH_2=CH_2$	74-85-1	1962	2.1.1A
11	Ethyne (acetylene)	Ацетилен, (этин)	$CH\equiv CH$	74-86-2	1001	2.1.1A
12	Hydrogen	Устөрөгч	H_2	1333-74-0	1049	2.1.1A
13	LPG (liquefied petroleum gas)	Шингэрүүлсэн хийн түлш	$C_3H_6 - C_3H_6 - C_4H_{10}$ (хольц)	68476-85-7	1075	2.1.1A

14	Methane or natural gas (excluding refrigerated liquid methane or natural gas)	Метан ба байгалийн хий (хөргөж шингэрүүлсэн метан болон байгалийн хий орохгүй)	CH ₄	74-82-8	1971	2.1.1A
15	Methane, difluoro-	Дифтор метан	CH ₂ F ₂	75-10-5	3252	2.1.1A
16	Methane, fluoro- (Refrigerant gas R41)	Фтор метан (Хөргөлтийн хий R41)	CH ₃ F	593-53-3	2454	2.1.1A
17	Propane, 2-methyl- (isobutane)	2-метил пропан (изобутан)	CH ₃ CH (CH ₃) ₂	75-28-5	1969	2.1.1A
18	Propane, 2,2-dimethyl- (neopentane)	2,2-диметил пропан	CH ₃ C (CH ₃) ₂ CH ₃	463-82-1	2044	2.1.1A
19	Propylene	Пропилен	C ₃ H ₆	115-07-1	1077	2.1.1A

2. Исэлдүүлэгч, хоргүй хий

№	Олон улсын нэршил	Монгол нэр	Химийн томъёо	CAS дугаар	НУБ –ын дугаар	Хортой болон аюултай бодисын ангилал
1	Carbon dioxide and oxygen mixture, compressed (>23% oxygen)	Нүүрсхүчлийн хий ба хүчилтөрөгчийн холимог, өндөр даралтад шахсан (хүчилтөрөгч>23%)	CO ₂ +O ₂	8063-77-2	3261	5.1.2A
2	Oxygen	Хүчилтөрөгч	O ₂	7782-44-7	1072 , 1073	5.1.2A

3. Исэлдүүлэгч, хортой хий

№	Олон улсын нэршил	Монгол нэр	Химийн томъёо	CAS дугаар	НУБ –ын дугаар	Хортой болон аюултай бодисын ангилал
1	1,3-Butadiene	Бутандиен-1,3	H ₂ C=CHCH=CH ₂	106-99-0	1010	2.1.1A, 6.4A, 6.6A, 6.7A, 6.8B, 6.9A, 9.1D

2	2-Propanone, 1,1,1,3,3,3- hexafluoro- (hexafluoro acetone)	Гексафтор ацетон, (1,1,1,3,3,3- Гексафтор пропанон-2)	$\text{CF}_3\text{-CO-CF}_3$	684-16-2	2420	6.1B, 6.8A, 6.9A, [8.2B], 8.3A
3	Ammonia, anhydrous	Аммиак, усгүй	NH_3	7664- 41-7	1005	2.1.1B, 6.1C, 8.2B, 8.3A, 9.1A
4	Ammonia, >50% aqueous solution	Аммикийн усан уусмал, >50%	NH_4OH	1336- 21-6	3318	2.1.1B, 6.1D, 8.1A, 8.2B, 8.3A, 9.1A, 9.3B
5	Ammonia, 35-50% aqueous solution	Аммиак усан уусмал, 35-50%	NH_4OH	1336- 21-6	2073	6.1D, 8.1A, 8.2B, 8.3A, 9.1A, 9.3B
6	Borane, trichloro-	3 хлорт бор	BCl_3	10294- 34-5	1741	6.1C, 6.9A, 8.1A, [8.2C], 8.3A, 9.1D, 9.3C
7	Borane, trifluoro-	3 фторт бор	BF_3	7637- 07-2	1008	6.1A, 6.9A, 8.1A, 8.2A, 8.3A, 9.1D
8	Carbon monoxide	Нүүрстөрөгчийн дугуу исэл (угаарын хий)	CO	630-08-0	1016	2.1.1A, 6.1C, 6.8A, 6.9A, 9.1D
9	Carbon oxide sulphide (carbonyl sulphide)	Нүүрстөрөгчийн оксидын сульфид (Карбонил сульфид)	O=C=S	463-58-1	2204	2.1.1A, 6.1C, 6.3A, 6.4A, 6.9A, 9.1D
10	Chlorine	Хлор	Cl_2	7782- 50-5	1017	5.1.2A, 6.1A, 8.2A, 8.3A, 6.9A, 9.1A, 9.2A, 8.1A
11	Dinitrogen tetroxide [nitrogen dioxide]	Ди азотын дөрөвч исэл (Азотын давхар исэл)	N_2O_4 (NO_2)	10544- 72-6 [10102- 44-0]	1067	5.1.2A, 6.1A, 6.9A, 8.1A, [8.2B], 8.3A, 9.1D
12	Dinitrogen tetroxide and nitric oxide mixture [nitrogen dioxide and nitric oxide mixture]	Ди азотын дөрөвч исэл ба азотын ислийн хольц	$\text{N}_2\text{O}_4 + \text{NO}$	63907- 41-5	1975	5.1.2A, 6.1A, 6.9A, 8.1A, [8.2B], 8.3A, 9.1D
13	Ethanamine, anhydrous (ethylamine)	Этанамиин, усгүй (Этиламин)	$\text{C}_2\text{H}_5\text{N}$	75-04-7	1036	2.1.1A, 6.1C, 6.9A, [8.2B], 8.3A, 9.1D, 9.3B
14	Ethane, chloro- (chloroethane)	Хлорэтан	$\text{C}_2\text{H}_5\text{Cl}$	75-00-3	1037	2.1.1A, 6.4A, 6.5B, 6.7B, 6.8B, 9.1C, 9.2B,
15	Ethene, bromo- (vinyl bromide)	Бромт этен (Винил бромид)	$\text{C}_2\text{H}_3\text{Br}$	593-60-2	1085	2.1.1A, 6.1D, 6.4A, 6.6A, 6.7A, 6.9A, 9.3B

16	Ethene, chloro- (vinyl chloride)	Хлорт этен (Винил хлорид)	$\text{CH}_2=\text{CHCl}$	75-01-4	1086	2.1.1A, 6.1D, 6.5B, 6.6A, 6.7A, 6.9A, 9.3B
17	Ethylene oxide and carbon dioxide mixture, >87% ethylene oxide	Этилен оксид ба нүүрсхүчлийн хийн холимог, (этилен оксид>87%)	$\text{C}_2\text{H}_4\text{O} + \text{CO}_2$		3300	2.1.1A, 6.1C, 6.3A, 6.4A, 6.5A, 6.5B, 6.6A, 6.7A, 6.8A, 6.9A, 9.1D, 9.2D
18	Hydrogen sulphide	Хүхэрт устөрөгч	H_2S	7783- 06-4	1053	2.1.1A, 6.1B, 6.3B, 6.4A, 6.9A, 9.1A
19	Methanamine (methylamine)	Метиламин	CH_3NH_2	74-89-5	1061	2.1.1A, 6.1C, 6.8B, 6.9B, 8.2B, 8.3A, 9.2D, 9.3B
20	Methanamine, N- methyl-, anhydrous (dimethylamine)	Диметиламин, усгүй	$(\text{CH}_3)_2\text{NH}$	124-40-3	1032	2.1.1A, 6.1C, 6.3A, 6.4A, 6.5B, 6.9A, 9.1D
21	Methane, chloro- (methyl chloride)	Хлорметан (метилхлорид)	CH_3Cl	74-87-3	1063	2.1.1A, 6.1D, 6.6B, 6.8B, 6.9A, 9.3C
22	Methane, oxybis (dimethyl ether)	Окисибс метан (диметиллийн эфир)	$(\text{CH}_3)_2\text{O}$	115-10-6	1033	2.1.1A, 6.4A
23	Methanethiol (methyl mercaptan)	Метантиол, (метил меркаптан)	CH_3SH	74-93-1	1064	2.1.1A, 6.1C, 6.9A, 8.2C, 8.3A, 9.1A
24	Nitrous oxide	Азотын оксид (I) (азотлог хий)	N_2O	10024- 97-2	1070	5.1.2A, 6.8B, 6.9B
25	Nitric oxide	Азотын оксид (II)	NO	10102- 43-9	1660	5.1.2A, 6.1B, 6.9A, 8.1A, 8.2A, 8.3A
26	Nitrosyl chloride	Нитрозил хлорид	$\text{O}=\text{N}(\text{Cl})$	2696- 92-6	1069	6.1A, 8.1A, 8.2B, 8.3A, 9.3A
27	Oxirane (ethylene oxide)	Оксиран (этилен оксид)	$\text{O}=\text{N}(\text{Cl})$	75-21-8	1040	2.1.1A, 6.1C, 6.3A, 6.4A, 6.5A, 6.5B, 6.6A, 6.7A, 6.8A, 6.9A, 9.1D, 9.2D
28	Phosgene	Фосген	CCl_2O	75-44-5	1076	6.1A, 6.9A, 8.1A, 8.2B, 8.3A
29	Silane	Силан	SiH_4	7803- 62-5	2203	2.1.1A, 6.1D, 6.3B, 6.4A, 6.9B, 9.3C
30	Silane, tetrafluoro-	Тетрафтор силан	SiF_4	7783- 61-1	1859	6.1C, 8.1A, 8.2B, 8.3A, 9.4A
31	Sulphur dioxide	Хүхрийн давхар исэл	SO_2	7446- 09-5	1079	6.1C, 6.3B, 6.4A, 6.5A, 6.8B, 6.9A, 8.1A, 9.1A

32	Sulphuryl fluoride	Фторт сульфурил	SO ₂ F ₂	2699-79-8	2191	6.1C, 6.3B, 6.4A, 6.8B, 6.9A, 9.3B
33	Trimethylamine, anhydrous	Триметил амин, усгүй	(CH ₃) ₃ N	75-50-3	1083	2.1.1A, 6.1C, 6.3A, 8.3A, 9.1D, 9.3B

4. Аюултай шинж чанаргүй даралтад савласан хий

№	Олон улсын нэршил	Монгол нэр	Химийн томъёо	CAS дугаар	НУБ-ын дугаар	Хортой болон аюултай бодисын ангилал
1	1,1,1,2-Tetrafluoroethane (Refrigerant gas R134A)	1,1,1,2-тетрафтор этан (Хөргөлтийн хий R41)	CH ₂ FCF ₃	811-97-2	3159	-
2	Argon	Аргон	Ar	7440-37-1	1006	-
3	Carbon dioxide	Нүүрсхүчлийн хий	CO ₂	124-38-9	1013	-
4	Chloropentafluoroethane (Refrigerant gas R115)	Хлорпентафтор этан (5 фторт хлор этан) (Хөргөлтийн хий R115)	C ₂ ClF ₅	76-15-3	1020	-
5	Compressed air	Шахсан агаар			1002	-
6	Ethane, 1,2-dichloro-1,1,2,2-tetrafluoro- (Refrigerant gas R114)	1,2-дихлор 1,1,2,2-тетрафтор этан (Хөргөлтийн хий R114)	ClF ₂ CCF ₂ Cl	76-14-2	1958	-
7	Ethane, 2-chloro-1,1,1,2-tetrafluoro- (Refrigerant gas 124)	2-хлор 1,1,1,2-тетрафтор этан (Хөргөлтийн хий R41)	CHClF-CF ₃	2837-89-0	1021	-
8	Ethane, hexafluoro- (Refrigerant gas R116)	Гексафтор этан (Хөргөлтийн хий R116)	CF ₃ CF ₃	76-16-4	2193	-
9	Helium	Гелий	He	7440-59-7	1046	-
10	Methane, chlorodifluoro- (Refrigerant gas R22)	Хлор дифтор метан (Хөргөлтийн хий R22)	CHClF ₂	75-45-6	1018	-

11	Methane, chlorotrifluoro- (Refrigerant gas R13)	Хлор трифтор метан (Хөргөлтийн хий R13)	CClF_3	75-72-9	1022	-
12	Methane, tetrafluoro- (Refrigerant gas R14)	Хлор тетрафтор метан (Хөргөлтийн хий R14)	CF_4	75-73-0	1982	-
13	Methane, trifluoro- (Refrigerant gas R23)	Трифтор метан (Хөргөлтийн хий R23)	CHF_3	75-46-7	1984	-
14	Neon	Неон	Ne	7440-01-9	1065	-
15	Nitrogen gas	Азот	N_2	7727-37-9	1066	-
16	Propane, 1,1,1,3,3-pentafluoro	1,1,1,3,3-Пентафтор пропан	$\text{C}_3\text{H}_3\text{F}_5$	460-73-1		-
17	Propane, heptafluoro, 1H-	1H-гептафтор пропан	$\text{C}_3\text{HF}_7\text{O}$	2252-84-8	3296	-
18	Propane, heptafluoro, 2H-	2H-гептафтор пропан	C_3HF_7	431-89-0	3296	-
19	Propane, octafluoro-	Октафтор пропан	C_3F_8	76-19-7	2424	-
20	Refrigerant gas R409A	Хөргөлтийн хий R409A			3163	-
21	Refrigerant gas R503	Хөргөлтийн хий R503	$\text{CClF}_3 + \text{CHF}_3$		2599	-
22	Refrigerant gas R404A	Хөргөлтийн хий R404A	CF_3CHF_2 , R-125 + CF_3CH_3 , R-143A + CH_2FCF_3 , R-134A		3337	-
23	Refrigerant gas R407C	Хөргөлтийн хий R407C	$\text{CH}_2\text{F}_2 + \text{CH}_3\text{CF}_3 + \text{CF}_3\text{CH}_2\text{F}$		3340	-
24	Refrigerant gas R500	Хөргөлтийн хий R500	$\text{CCl}_2\text{F}_2 + \text{C}_2\text{H}_4\text{F}_2$	420-46-2	2602	-
25	Refrigerant gas R502 (mixture of chlorodifluoromethane and chloropentafluoroethane)	Хөргөлтийн хий R502 (хлор дифтор метан ба хлор пентафтор этаны холимог)	$\text{CHClF}_2 + \text{C}_2\text{ClF}_5$		1973	-
26	Sulphur hexafluoride	Гексафторт хүхэр (6 фторт хүхэр)	SF_6	2551-62-4	1080	-
27	Xenon	Ксенон	Xe	7440-63-3	2036	-

5. Хортой ба аюултай химийн бодис

№	Олон улсын нэршил	Монгол нэр	Химийн томъёо	CAS дугаар	НҮБ –ын дугаар	Хортой болон аюултай бодисын ангилал
1	1,2-Ethanediamine, N,N,N',N'-tetramethyl-	N,N,N',N'-тетраметил этандиамин-1,2	$C_6H_{16}N_2$	110-18-9	2372	3.1B, 6.1C, 8.2B, 8.3A, 9.1C, 9.3B
2	1,2-Ethanol, diacetate	Диацетат этандиол-1,2	$C_6H_{10}O_4$	111-55-7	3272	3.1D, 6.1E, 6.3B, 6.4A, 9.1D
3	1,3,5,7-Tetraazatricyclo [3.3.1.1(3,7)]decane	1,3,5,7-тетрааза трицикло [3.3.1.1(3,7)] декан	$C_6H_{12}N_4$	100-97-0	1328	4.1.1B, 6.1D, 6.3B, 6.4A, 6.5A, 6.5B, 9.3C
4	1,3,5-Triazine-2,4,6(1H,3H,5H)-trione, 1,3,5-trichloro-	1,3,5-трихлор-2,4,6(1H,3H,5H) трион-1,3,5-триазин	$C_3C_3N_3O_3$	87-90-1	2468	5.1.1B, 6.1D, 6.3A, 8.3A, 9.1A, 9.2D, 9.3B
5	1,3,5-Triazine-2,4,6(1H,3H,5H)-trione, 1,3-dichloro-, sodium salt	1,3-дихлор 2,4,6(1H,3H,5H)- трион-1,3,5-триазинийн натрийн давс	$C_3HCl_2N_3O_3.Na$	2893-78-9	2465	5.1.1B, 6.1D, 6.3A, 6.4A, 9.1A, 9.2A, 9.3C
6	1,3,5-Trioxane, 2,4,6-trimethyl-	2,4,6-триметил 1,3,5-триоксан	$C_6H_{12}O_3$	123-63-7	1264	3.1C, 6.1D, 6.3B, 6.4A, 9.3C
7	1,3-Butadiene, 2-chloro-	2-хлор 1,3-бутадиен	C_4H_3Cl	126-99-8	1991	3.1B, 6.1C, 6.3A, 6.4A, 6.7B, 6.8B, 6.9A, 9.1D, 9.3B
8	1,3-Butadiene, 2-methyl-	2-метил 1,3 бутадиен	$C_4H_5CH_3$	78-79-5	1218	3.1A, 6.1E, 6.3B, 6.4A, 6.6B, 6.7B, 6.8B, 6.9B, 9.1C
9	1,3-Dioxolane	Диоксалан-1,3	$C_3H_6O_2$	646-06-0	1166	3.1B, 6.1D, 6.3B, 6.4A, 6.6B, 6.9B
10	1,4-Dioxane	Диоксан-1,4	$C_4H_8O_2$	123-91-1	1165	3.1B, 6.1D, 6.3B, 6.4A, 6.7A, 6.9B, 9.3C
11	1,5-Cyclooctadiene	1,5- циклооктадиен	C_8H_{14}	111-78-4	2520	3.1C, 6.1E, 6.3A, 6.4A, 6.5B, 9.1A
12	1,6-Octadiene, 7-methyl-3-methylene-	3-метилен -7-метил-1,6- октадиен	$C_{10}H_{16}$	123-35-3	2319	3.1C, 6.3A, 6.4A, 6.8B, 9.1A

13	1-Butanamine	Бутанамин-1	$C_4H_{11}N$	109-73-9	1125	3.1B, 6.1B, 8.1A, [8.2B], 8.3A, 9.1D, 9.3B
14	1-Butanol	Бутанол-1	$C_4H_{10}O$	71-36-3	1120	3.1C, 6.1D, 6.3A, 8.3A, 9.3C
15	1-Butanol, 3-methoxy-, acetate	3-метокси, 1-бутанол ацетат	$C_7H_{14}O_3$	4435-53-4	2708	3.1D, 6.1E, 9.1D
16	1-Butanol, 3-methoxy-3-methyl-	3-метокси-3-метил 1-бутанол		56539-66-3		3.1D
17	1-Butanol, 3-methyl-	3-метил 1-бутанол	$C_6H_{14}O_2$	123-51-3	1105	3.1C, 6.1D, 6.3B, 8.3A, 9.3C
18	1-Butanol, 3-methyl-, acetate	3-метил, 1-бутанол ацетат	$CH_3CO_2CH_2CH_2CH(CH_3)$	123-92-2	1104	3.1C, 6.3B, 6.4A, 9.1D
19	1-Decanol	Деканол-1	$CH_3(CH_2)_8CH_2OH$	112-30-1		3.1D, 6.1C, 6.3A, 6.4A, 9.1B
20	1-Heptanol	Гептанол-1	$CH_3(CH_2)_6OH$	111-70-6		3.1D, 6.4A, 9.1D
21	1-Heptene	Гептен-1	C_7H_{14}	592-76-7	2278	3.1B
22	1-Hexanamine, 2-ethyl-	2-этил, 1-гексамин	$C_8H_{19}N$	104-75-6	2276	3.1C, 6.1B, 8.2C, 8.3A, 9.1B, 9.3B
23	1-Hexanol	Гексанол-1	$CH_3(CH_2)_5OH$	111-27-3	2282	3.1C, 6.1D, 6.3B, 6.4A, 9.1D, 9.3C
24	1-Hexanol, 2-ethyl-	2-этил 1-гексанол	$C_8H_{18}O$	104-76-7		3.1D, 6.1D, 6.3A, 6.4A, 9.1D, 9.3C
25	1-Hexanol, 2-ethyl-, titanium (4+) salt	2-этил, 1-гексанол титан (IV)-ын давс	$Ti[(OCH_2CH(C_2H_5)(CH_2)_2CH_3)_4]$	1070-10-6		3.1D, 9.1B
26	1-Hexene	Гексен-1	C_6H_{12}	592-41-6	2370	3.1B, 6.3B, 9.1B
27	1H-Pyrrole	1H-Пиррол	C_4H_5N	109-97-7	1993	3.1C, 6.1D, 6.3B, 6.4A, 6.9B
28	1-Nonanol	Нонанол-1	$CH_3(CH_2)_8OH$	143-08-8	1987	3.1D, 6.1C, 6.3A, 6.4A, 9.1A
29	1-Octanol	Октанол-1	$CH_3(CH_2)_7OH$	111-87-5		3.1D, 6.1D, 6.3A, 6.4A, 9.1D, 9.3C
30	1-Pentanamine, N-pentyl-	N-пентил пентамин-1	$C_{10}H_{23}N$	2050-92-2	2841	3.1C, 6.1B, 8.2C, 8.3A, 9.1A, 9.3B

31	1-Pentanol	Пентанол-1	$\text{CH}_3(\text{CH}_2)_4\text{OH}$	71-41-0	1105	3.1C, 6.1C, 6.3A, 6.4A, 9.1D, 9.2B, 9.3B
32	1-Propanamine	Пропан амин-1	$\text{CH}_3\text{CH}_2\text{CH}_2\text{NH}_2$	107-10-8	1277	3.1B, 6.1C, 6.3A, 8.3A, 9.3C
33	1-Propanamine, 2-methyl-N-(2- methylpropyl)-	2-метил-N- 2метилпропил пропанамин-1	$\text{C}_8\text{H}_{19}\text{N}$	110-96-3	2361	3.1C, 6.1C, 8.2C, 8.3A, 9.1D, 9.3B
34	1-Propanamine, N- propyl-	N-пропил пропанамин-1	$\text{C}_6\text{H}_{15}\text{N}$	142-84-7	2383	3.1B, 6.1C, 8.1A, [8.2B], 8.3A, 9.1D, 9.3B
35	1-Propanethiol	Пропантиол-1	$\text{CH}_3\text{CH}_2\text{CH}_2\text{SH}$	107-03-9	2402	3.1B, 6.1B, 6.3A, 6.4A, 9.1A, 9.3C
36	1-Propanol	Пропанол-1	$\text{C}_3\text{H}_8\text{O}$	71-23-8	1274	3.1B, 6.1D, 6.4A, 9.3C
37	1-Propanol, 2-methyl-	2-метил, 1- пропанол	$(\text{CH}_3)_2\text{CHCH}_2\text{OH}$	78-83-1	1212	3.1C, 6.1E, 6.3B, 6.4A
38	1-Propene, 1,3- dichloro-	1,3-дихлор 1- пропен	$\text{ClCH}_2\text{CH}=\text{CHCl}$	542-75-6	2047	3.1B, 6.1C, 6.3A, 6.4A, 6.5B, 6.6B, 6.7B, 6.9B, 9.1A, 9.2D, 9.3B, [9.4B]
39	2,3-Butanedione	2,3-Бутандион	$\text{C}_4\text{H}_6\text{O}_2$	431-03-8	2346	3.1B, 6.1D, 6.3A, 6.4A, 9.1D, 9.3C
40	2,4-Heptanedione, 6-methyl-	6-метил,2,4- гептандион	$\text{C}_8\text{H}_{14}\text{O}_2$	3002- 23-1	1993	3.1C, 9.1C
41	2,4-Pentanedione	Пентандион-2,4	$\text{C}_5\text{H}_8\text{O}_2$	123-54-6	2310	3.1C, 6.1C, 6.3B, 6.4A, 6.9B, 9.1D, 9.3B
42	2,4-Pentanedione, peroxide, 35% in dipropylene glycol	2,4- пентандион пероксид, 35%-ийн дипропилен гликол	$\text{C}_{10}\text{H}_{14}\text{O}_6$	37187- 22-7	3105	5.2D, 6.3B, 8.3A
43	2-Butanol	Бутанол-2	$\text{CH}_3(\text{CH}_2)_2\text{CH}_2\text{OH}$	78-92-2	1120	3.1C, 6.1E, 6.4A
44	2-Butanone	Бутанон-2	$\text{CH}_3\text{COCH}_2\text{CH}_3$	78-93-3	1193	3.1B, 6.1E, 6.3B, 6.4A, 6.9B
45	2-Butanone, 3- hydroxy-	3-гидрокси, 2 -бутанон	$\text{C}_4\text{H}_8\text{O}_2$	513-86-0	2621	3.1C, 6.3A, 6.4A

46	2-Butanone, oxime	2- бутанон, оксим	C_4H_9NO	96-29-7	1993	3.1C, 6.1D, 6.3B, 6.4A, 6.5B, 6.7B, 6.9B, 9.1C, 9.2A, 9.3B
47	2-Butanone, peroxide, 33-40% in dimethyl phthalate + 1-10% methyl ethyl ketone,	2-бутанон, пероксид, 33-40%-ийн диметил фталат + 1-10% метил этил кетонд	$C_8H_{16}O_4$	1338-23-4	3107	3.1D, 5.2E, 6.1D, 8.2B, 8.3A, 9.1B, 9.3C
48	2-Butene, 2-methyl-	2-метил 2-бутен	C_5H_{10}	513-35-9	2460	3.1B, 6.1D, 6.3B, 9.1C, 9.3C
49	2-Cyclohexen-1-one, 3,5,5-trimethyl-	3,5,5-триметил 1-он-2-циклогексен	$C_9H_{14}O$	78-59-1		3.1D, 6.1D, 6.3B, 6.4A, 6.9B, 9.1C, 9.2A, 9.3C
50	2-Furanmethanol, tetrahydro-	Тетрагидро 2-фуранметанол	$C_5H_{10}O_2$	97-99-4	1987	3.1D, 6.1D, 6.3B, 6.4A, 9.3C
51	2-Heptanone	Гептанон-2	$C_7H_{14}O$	110-43-0	1110	3.1C, 6.1D, 6.3B, 6.4A, 9.3C
52	2-Hexanol	Гексанол-2	$C_6H_{13}O$	626-93-7	2282	3.1C, 6.3B, 6.9B, 9.1D
53	2-Hexanone	Гексанон-2	$C_6H_{12}O$	591-78-6	1224	3.1C, 6.1E, 6.3B, 6.4A, 6.8B, 6.9A
54	2-Hexanone, 5-methyl-	5-метил 2-гексанон	$C_7H_{14}O$	110-12-3	2302	3.1C, 6.1D, 6.3B, 6.4A
55	2H-Pyran, 3,4-dihydro-	3,4-дигидро, 2H-пиран	C_5H_8O	110-87-2	2376	3.1B, 6.1D, 6.3A, 9.1C
56	2H-Pyran-2-carboxaldehyde, 3,4-dihydro-	3,4-дигидро, 2-карбоксияльдегид 2H- пиран	$C_6H_8O_2$	100-73-2	2607	3.1C, 6.1E, 6.3A, 6.4A, 6.6B, 9.1C
57	2-Octanol	Октанол-2	$CH_3(CH_2)_7OH$	123-96-6		3.1D, 6.3B, 6.4A, 6.9B, 9.1C
58	2-Pentanol	Пентанол-2	$CH_3(CH_2)_4OH$	6032-29-7	1105	3.1C, 6.1D, 6.3A, 6.4A, 9.1D
59	2-Pentanol, 2-methyl-	2-метил 2-пентанол	$C_6H_{14}O$	590-36-3	2560	3.1C, 9.1D
60	2-Pentanol, 4-methyl-	4-метил , 2-пентанол	$C_6H_{14}O$	108-11-2	2053	3.1C, 6.1C, 6.3B, 6.4A, 6.9B, 9.1D, 9.3C
61	2-Pentanol, acetate	2-пентанол, ацетат	$C_7H_{14}O_2$	626-38-0	1104	3.1C, 6.3B, 6.4A, 9.1D

62	2-Pentanone	2-пентанон	$\text{CH}_3\text{O}(\text{CH}_2)_4$	107-87-9	1249	3.1B, 6.1D, 6.3B, 6.4A, 9.2D, 9.3C
63	2-Pentanone, 4-hydroxy-4-methyl-	4-гидрокси-4-метил 2-пентанон	$\text{C}_6\text{H}_{12}\text{O}_2$	123-42-2	1148	3.1C, 6.1E, 6.3B, 6.4A,
64	2-Pentanone, 4-methyl-	4-метил 2-пентанон	$\text{C}_6\text{H}_{12}\text{O}$	108-10-1	1245	3.1B, 6.1D, 6.3B, 6.4A, 9.3B
65	2-Propanamine	Пропанамин-2	$\text{C}_3\text{H}_9\text{N}$	75-31-0	1221	3.1A, 6.1C, 6.9B, 8.1A, 8.2C, 8.3A, 9.1D, 9.2B, 9.3B
66	2-Propanamine, N-(1-methylethyl)-	N-(1-метилэтил)- 2-пропанамин	$\text{C}_6\text{H}_{15}\text{N}$	108-18-9	1158	3.1B, 6.1D, 6.9A, 8.1A, 8.2B, 8.3A, 9.1B, 9.3B
67	2-Propanethiol	2-пропантиол	$\text{C}_3\text{H}_8\text{S}$	75-33-2	2402	3.1B, 6.1D, 6.3A, 6.4A, 9.1A, 9.3C
68	2-Propanethiol, 2-methyl-	2-метил 2-пропантиол	$\text{C}_4\text{H}_{10}\text{S}$	75-66-1	2347	3.1B, 6.1C, 6.9B, 9.1A
69	2-Propanol	2-пропанол	$(\text{CH}_3)_2\text{CHOH}$	67-63-0	1219	3.1B, 6.1E, 6.3B, 6.4A
70	2-Propanol, 1-(1,1-dimethylethoxy)-	1-(1,1- диметилэтокси) 2-пропанол	$\text{C}_7\text{H}_{16}\text{O}_2$	57018- 52-7	1993	3.1C, 6.1E, 8.3A
71	2-Propanol, 1-butoxy-	1-бутоксид 2-пропанол	$\text{C}_7\text{H}_{16}\text{O}_2$	5131- 66-8	1993	3.1C, 6.1D, 6.3A, 6.4A, 9.3C
72	2-Propanol, 1-ethoxy-	1-этоксид 2-пропанол	$\text{C}_5\text{H}_{12}\text{O}_2$	1569- 02-4		3.1C, 6.1E, 6.3B, 6.4A
73	2-Propanol, 1-methoxy-	1-метоксид 2-пропанол	$\text{C}_4\text{H}_{10}\text{O}_2$	107-98-2	3092	3.1C, 6.1E, 6.3B, 6.4A
74	2-Propanol, 1-methoxy-, acetate	1-метоксид 2-пропанол ацетат	$\text{C}_6\text{H}_{12}\text{O}_3$	108-65-6	3272	3.1C, 6.4A
75	2-Propanol, 1-propoxy-	1-пропоксид 2-пропанол	$\text{C}_6\text{H}_{14}\text{O}_2$	1569- 01-3		3.1C, 6.1E, 6.3B, 6.4A
76	2-Propanol, 2-methyl-	2-метил 2-пропанол	$\text{C}_4\text{H}_{10}\text{O}$	75-65-0	1120	3.1B, 6.1E, 6.3B, 6.4A
77	2-Propanol, 2-methyl-, aluminium salt	2-метил 2-пропанол хөнгөнцагааны давс	$\text{C}_{12}\text{H}_{27}\text{AlO}_3$	556-91-2	1325	4.1.2B, 9.1C
78	2-Propanone	2-Пропанон	$\text{C}_3\text{H}_6\text{O}$	67-64-1	1090	3.1B, 6.1E, 6.3B, 6.4A
79	2-Propenenitrile	2-пропеннитрил	$\text{C}_3\text{H}_3\text{N}$	107-13-1	1093	3.1B, 6.1B, 6.3A, 6.4A, 6.5B, 6.7A, 6.8B, 6.9A, 9.1B, 9.2A, 9.3A

80	2-Propenoic acid, 2-ethylhexyl ester	2-Пропенийн хүчлийн 2-этилгексилийн эфир	$C_{11}H_{20}O_2$	103-11-7		3.1D, 6.1E, 6.3A, [6.4A], 6.5B, 6.9A, 9.1C
81	2-Propenoic acid, 2-methyl-, 2-(diethylamino) ethyl ester	2-пропенийн хүчлийн 2-метил-2-(диэтил амин) этилийн эфир	$C_{10}H_{19}NO_2$	105-16-8	1993	3.1D, 6.1D, 6.3A, 6.4A, 9.1D
82	2-Propenoic acid, 2-methyl-, 2,2,2-trifluoroethyl ester	2-пропенийн хүчлийн 2-метил-2,2,2-трифтор этилийн эфир	$C_6H_7F_3O_2$	352-87-4		3.1C, 6.3B, 6.4A, 9.1C
83	2-Propenoic acid, 2-methyl-, 2-ethoxyethyl ester	2- пропенийн хүчлийн 2-метил 2-этоксигэтилийн эфир	$C_8H_{14}O_3$	2370-63-0		3.1D, 9.1D
84	2-Propenoic acid, 2-methyl-, 2-methylpropyl ester	2- пропенийн хүчлийн 2-метил 2-метилпропилын эфир	$C_9H_{14}O_2$	97-86-9	2283	3.1C, 6.3B, 6.4A, 9.1A
85	2-Propenoic acid, 2-methyl-, 2-propenyl ester	2- пропенийн хүчлийн 2-метил 2-пропенилийн эфир	$C_7H_{10}O_2$	96-05-9	1992	3.1C, 6.1B, 6.3B, 6.4A, 9.1A, 9.3B
86	2-Propenoic acid, 2-methyl-, butyl ester	2- пропенийн хүчлийн 2-метил 2-бутилын эфир	$C_8H_{14}O_2$	97-88-1	2227	3.1C, 6.3A, 6.4A, 6.5B, 6.9B, 9.1C
87	2-Propenoic acid, 2-methyl-, ethyl ester	2-пропенийн хүчлийн 2-метил 2-этилийн эфир	$C_6H_{10}O_2$	97-63-2	2277	3.1B, 6.3B, 6.5B, 9.1D
88	2-Propenoic acid, 2-methyl-, methyl ester	2- пропенийн хүчлийн 2-метил 2-метилийн эфир	$C_5H_8O_2$	80-62-6	1247	3.1B, 6.1D, 6.3B, 6.4A, 6.5B, 6.9B, 9.1D
89	2-Propenoic acid, 2-methylpropyl ester	2-пропенийн хүчлийн 2-метилпропилийн эфир	$C_7H_{12}O_2$	106-63-8	2527	3.1C, 6.1C, 6.3A, 6.4A, 6.5B, 9.1D
90	2-Propenoic acid, butyl ester	2-пропенийн хүчлийн бутилийн эфир	$C_7H_{12}O_2$	141-32-2	2348	3.1C, 6.1C, 6.3A, 6.4A, 6.5B, 6.8B, 6.9B, 9.1D, 9.3C
91	2-Propenoic acid, ethyl ester	2-пропенийн хүчлийн этилийн эфир	$C_5H_8O_2$	140-88-5	1917	3.1B, 6.1C, [6.3A, 6.4A], 6.5B, 6.9B, 9.1D, 9.2B, 9.3B

92	2-Propenoic acid, methyl ester	2-пропенийн хүчлийн метилийн эфир	$C_4H_6O_2$	96-33-3	1919	3.1B, 6.1C, 6.3A, 6.4A, 6.5B, 6.9B, 9.1D, 9.2B, 9.3B
